

Уран бүтээлийг нь уиших дуртай зохиолчдын маань нэг болох Б.Шүүдэрцэцэг эгчийн “Шүрэн бугуйвч” зохиолыг танд хүргэж байна.

Хавсралт. (Бонус ☺)

Б.Баасанжаргал : Улиралын онцлох өнгө

Б.Шүүдэрцэцэг: Шүрэн бугуйвч

Намуун найз охин Жавхаагаа хвлээн тв-нийхээ сувгуудыг солин буйдан дээр хэвтэж байлаа. Нээлттэй гэгээвчээр намрын халуун оройн зееден сэвшээ салхи үлээн цонхны сиймгэр шаргал хөшгийг сэм сэмхэн хөвөлзүүлэн үлээх нь цаана нь нэгэн үл үзэгдэх шидтэн нуугдчихаад тоглоом хийгээд байгаа ч юм шиг. Намуун багадаа салхинд ийнхүү хөшиг сэвэлзэн хөдлөх тоолонд их айдаг, цаана нь хорон санаатан байгаа гэдэгт чин сэтгэлээсээ итгэдэг байж билээ.

Гэвч одоо юун тэр ид шидтэн энээ тэрээ манатай. Найз залуугийнх нь зурагтай сонин өмнөх ширээн дээр нь хэвтэж байлаа. Аав ээж 2 нь мөд ирэхгүй гэдэг бол ойлгомжтой. Ирээд ч Терийн өмчийн хорооны хурлыг гэртээ үргэжлүүлэх шахам ажлаа ярьж гардаг тул Намуун бушуухан өрөө рүүгээ зугтдаг сан. Намуун өмнөх сониныг ширээн дээрээс шүүрэн авч өгөө мэдээг дахин уншаад шидчихлээ. "Томоохон businessman-ий ирээдүйн хүргэн Хасар өсөх ирээдүйтэй загвар өмсөгч Энхэрмаатай явдаг уу?" гэнэ шүү. Гүтгэлэг гэхээр яах аргагүй гэрэл зурагтай нь тавьчихаж ээ. Энхэрмаа гэдэг нь шүүрэнхэн салхинд хийсчихмээр черийсэн өндөр туранхай охин харагдана. Хасар, Намуун хоёр 8-н настайгаасаа бие биенээ мэднэ. Ээжийнх нь найз хүүхэн Эсэлмаагийнх Германд байж байгаад Монголд буцаж ирсэн цагаас хойш л Намуун тэр 2-ын үерхэл эхэлсэн. Бодоод байхнаа өрөө л тэр өөрийгөө Хасарт хайртай байх ёстой гээд итгэчихсэн байсан юм шиг ээ. Ямар ч гэсэн ээж, аавууд нь "Энэ 2-ыгөө том болохоор нь суулгана аа" гэж ярьцгаахад нь нэг бодлын ичмээр, өгөө бодлын тэгэх л ёстой мэт санагддаг байсан. Тийнхүү 2 гэрийнхнийх нь нөхөө, үргэлж ойр дотно байснаас болж л Намуун Хасартай үерхсэн, дараа нь сууна гэж бодсоор өдий хүрсэн болохоос дүрэлзэн шатсан гал халуун хайр тэдний дунд байсангүй.

Гэтэл сүүлийн үед Хасар нэг л хачин болоод байсан нь ийм учиртай байж. Өнгөрсөн Валентиний өдрөөр алга болж болж бүүр орой шөнө болчихсон хойно үнгэгдсэн ганц сарнайтай ирсэнийг нь саналаа. Бас халааснаас нь Кензо анхилуулсан ганган алчуур гарч ирсэнийг юу гэлээ дээ байз? Ангирмаагийнх гээд л өнгөрөөсөн шүү дээ. Ангирмаа гэдэг нь Хасарийн дүү. Ангирмаа шиг 10 настай жаахан хүүхэд юу гэж Кензо түрхэх билээ дээ. Одоо бодоод байхад тэр хоёрын явдал их эрт эхэлсэн бололтой. Арай ч дээ. Ингээд бодоод байхад ёстой галзуурмаар л юм. Тэр харандаа аваад Хасарын нүүрийг танигдахгүй болтол нь эрээчиж орхив. Яг одоо тэр хоёрыг хамт байж байхад нь очоод тэр өөдгүй амьтны хацрыг нь халцарч улайтал нь алгадаад авах юм сан. Үгүй ээ, алгадаад дэмий юм байна. Аавынхаа бие хамгаалагчтай хамт очоод тэр охиных нь нүдэн дээр Хасарыг буланд шахаж байгаад... Үгүй ээ, Шал тэнэг юм бодож байх юм.

Хасар танай аавын хөрөнгөнд л болж чамтай үерхдэг шдээ гэсэн энэ үгийг ангийнхаа нэг охиноос 3 жилийн өмнө сонсоод таг мартаж гэж их л зовсонсон. Тэгэхэд Намуун яг АНУ явах гээд билетээ хүртэл авчихсан байсан. Охин АНУ-д очсон хойноо ч тэр гашуун үгийг бодон бодон удаан шаналж билээ. Харин тэгэхэд Хасараас үргэлж e-mail ирж байсны хүчинд " тэр үг худлаа ч юм болов уу " хэмээн мартаж орхисонсон.

Ер нь аав нь том компаний эзэн гэдгээс болж Намууны амьдралд үргэлж төвөг учирна. Ганцхан манай сонинд ярилцлага өгчих гээд сурвалжлагч нар утасдахаас өгсүүлээд багш нар нэг л өөрөөр ханлах гээд, эсвэл баян айлын хүүхдэд долигонодоггүй хүн болж чангалах гээд л, ангийнхан нь бол байнгын мөнгө зээлдүүлчих гэж гуйна.

Жаахан байхад ямар сайхан байж вэ? Зун Шарга Моритын зусланд гарч өдөржин хүүхдүүдтэй ухаангүй тоглосоор зусдагсан. Борооны дараа ойд явж, тослог шар мөөг түүнэ. Сод өвс зулгаан бондгор толгойгоор нь сум хийн буудалцана. Эсвэл хэн нэгнийдээ цуглаад кекс хийх гэж байгаа нь энэ гээд баахан гурил түлж хаяна. Ирис, чихэр хийнэ гэж цөцгийн тос, элсэн чихэртэй хутган түлэнхий шар юм болгоод хувааж иднэ. Халуун өдөр гол дээр очиж хөвгүүд жараахай шүүрдэн охид усаар байлдацгаана. Намууныг 8-тай байхад зуслангийнх нь хөрш айлын охин Уранаа гэж нэг залдаг хүүхэд байв. Тэр нэг удаа голын усанд шумбаад, усан дотор нүдээ анихгүй харж чадвал үсэндээ алтан титэмтэй, загасан хөлтэй лусын дагина харагддаг гэж ярьж билээ. Намуун тэр лусын дагиныг харах гэж хэдэн өдөр голд зогсон усан дотор нүдээ анихгүй харах гэж хичээгээд чадаагүйсэн. Ингэж тэгсээр нэг л мэдэхэд орой 6 болж ажилчдын автобусаар аав ээжүүд нь ирцгээгээд хүүхдүүд бүгдээрээ тосон гүйлдэнэ. Хармсалтай тэр олон дотор Намуун л айлын ганц хүүхэд байсан. Бусад айлын хүүхдүүд аав, ээжээ тосохоор том нь жижгээ хөтлөн гүйцгээхэд Намуун л гав ганцаараа торойн зогсдогсон. Айлууд доод тал нь 3 хүүхэдтэй байхад тэднийх л ганц охинтой айл байсан. Гэтэл том болно гэдэг нялх бага насандаа айлын хүүхэдтэй муудалцаад мөрөөддөг байсан шиг тийм ч сайхан юм биш байжээ. Хорин насанд нь тохирсон зовлонг бурхан түүнд бэлдчихсэн байдаг байжээ. Үе үехэн сэвэлзэх салхин хөшгөөр сэм сэмхэн наадсаар л.

Бүсгүй нэг том санаа алдаад хөргөгчнөөс хүйтэн цэвэр ус авчирч залгилав. Цэв хүйтэн ус хоолойг нь цочроон, цээж цэлмээхэд нь сэтгэл сэргэх шиг. Усаа ууж дуусаад сувгаа солив. Тв-ийн бүх сувгуудаар Мянганы замын бүтээн босголт үргэлжилж байна. Ерөнхий сайд орон нутагт айлчлав хэмээн тоть шиг давтах тул залхсандаа MTV Asia дээр тавин F4-ийн ярилцлагыг үзэнгээ эмээ рүүгээ залгав. Эмээ нь хөдөө явах гээд их л сэтгэл хөөрүү байсан тул зээ охинийхоо хоолойд илрээ байгаа гунигтай өнгийг анзаарсангүй.

Түүнээс биш миний охин яагаад хусмаа голсон хүүхэн шиг унжийчихаа вэ гээд л утасны цаанаас түүнийг нэвт мэдчихдэг айхтар хүн билээ. Гадаа хаалганы хонх дуугарах чимээнээр Мiki хав нь буйдан доороос гарч ирэн сүүлээ сөхөж байгаад боргож гарлаа. Энэ бол мэдээж Жавхаа. Тэдний гэрийн үйлчлэгч Дооёо эгч амралтаа авсан тул Намуун өөрөө хаалга тайлж өгөхөөр бослоо. Намуун хашааныхаа хаалгыг онгойлгоод НИ гэж найзтайгаа мэндлээд сүүлний ормоо модгонуулан хуцсаар байгаа нохойгоо авч " Энэ одоо чамайг таньсан мөртлөө мундаг нохой болох гэж хуцсаар байгаан байх даа. " гээд хаваа тэвэрсээр гэр рүүгээ түрүүлэн алхав. Хав эзнийхээ суганд наалдан шургаад чимээгүй болов. Жавхаа чихэвчний хөгжмөө унтраагаад " Ёхх, халууцаж үхлээ. Микронд суусан чинь яг буузны жигнүүр л гэсэн үг. Ядахдаа танай Мiki ямар ядаргаатай юм бэ " хэмээн үглэсээр араас нь дагав. Энэ халуунд биеэ зовоолгүй таксидах мөнгөтэй мөртлөө албатай юм шиг микронд суучихаад дараа нь ийнхүү гомдол тавьж байгаад нь Намуун инээд нь хүрч явлаа.

Хаалгаар оронгуут сэрүү татсан саруулхан зочны өрөө угтсан нь Жавхаад их таатай байгаа бололтой. Углаашаа тайлж үүдний өрөөнд орхиод памбагар зөөлөн буйдан дээр хадуулсан өвс мэт навсхийн уналаа. Тэгээд " Алив хүйтэн юм өгөөч " хэмээн гараа сарвайхад нь Намуун – Хүйтэн юм одоохон аваад ирье. Харин чи энийг хараач, гээд нөгөө сонинг гар дээр нь шидчихлээ. Тэр өнөөх гайтай зургийг харангуутаа " Хүүшээ, алчхийн байна л даа. Энэ чинь

тэгээд үнэн юм уу? " хэмээн шигшроод дуугүй болов. Тэр уншиж дуусаад урдаа байгаа сэтгүүлийн ширээн дээр сонинг тавьснаа

- Энэ чинь тэдний сургуулийн нэг л маягтай амьтан байна шдээ. " Хаврын Гоёл " –оор миний нэг гоёлын даашинзыг өмсөж байсан юм. Тэврэлдчихсэн байгааг бодоход үнэн юм болов уу? Цаадах чинь Бээжингээс ирсэн үү? Ингэж пакталснаа мэдэхгүй л яваа даа гэлээ. Намуун түүнд ус хийж өгөх зуураа:

- Харин тийм, ичихгүй өчигдөр утсаар ярихдаа чамайг санаж байна энээ тэрээ гээд байгаа юм даа. Ёстой шог юм гээд хоолой нь зангираад явчихлаа. Тэгснээ нүүрээ дарж байгаад асгартал уйлчихлаа. " Жавхаа, Тэр муу яагаад намайг ингэж доромжилж байгаа юм бэ, яагаад? Би ямар гэм хийсийн бэ? Би энэ муу загвар өмсөгчөөс нь юугаараа дутуу юм? Хэмээн хашгиарн уйлж байснаа гэнэт таг дуугүй болж, нүүрээ угаахаар угаалгын өрөө рүүгээ орлоо. Хана дүүрэн том толинд туссан дүрээ хараад тэр цочих шиг болов. Сэгсийсэн үс, бүлцийсэн нүд... хамгийн гол нь нүд нь ямар уйтгартай юм бэ? Толинд харахдаа дандаа инээж бай, тэгвэл сайн энерги шингээж аваад дараа нь түүнийгээ эргээд цацдаг гэж нэг сэтгүүлээс хэзээ ч юм уншсанаа санажээ.

Тэр нүүр цэвэрлэдэг хөвөнгөөр зовхио арчаад таиур дээрээс хавчаар авч үсээ боочоод инээмсэглэв. Гэвч нүднийх нь харц гунигтай хэвээрээ үлдэв. Яг тэрхэн м^oчид " Өнөө орой зад шоудвал яасан юм" гэсэн бодол тархинд нь харван орж ирлээ. Тэгээд Жавхаад уруу дорой харагдахгүйн тулд Хаа ч явсан цуг гэж мэдээрэй хэмээн амандаа дуу аялсаар инээмсэглэн гарч ирэв.

Хэдхэн хормын өмнө уйлан хайлан угаалгын өрөөндөө орсон хүн инээмсэглэн гарч ирсэнд найз нь огтхон ч гайхсангүй. Минут тутамд хэд хэд хувирдаг хаврын тэнгэр шиг аашийг нь Жавхаа шиг сайн мэдэх хүн байхгүй юм чинь.

Цаадах чинь чамаас холдож чадахгүй дээ хэмээн тайтгаруулах санаатай хэлсэн үгэнд нь Намуун их л эгдүүцэж

---Холдвол холдоно л биз дээ. Би Хасараар дутах ч үгүй. Хоёулаа өнөө орой гоё дискодох уу? Гээд ширээн дээрээс утас шүүрэн авч ээж рүүгээ залгав.

---Ээж, Би Жавхаатай хамт Палас явж дискодлоо. Тэгээд эмээгийн хонноно шүү. Та 2 мэдээж мөд ирэхгүй л биз дээ? Гэхэд ээж нь утасны цаанаас " Битгий оройтоорой. Самбууг явуулчих уу? Өөрөө машинаа барих юм уу? Гэхчлэн далан долоон юм асууснаа Төв аймаг орох зам дээр байдаг benzin klonk маргааш дуудлага худалдаанд орох гээд аав, ээж 2 нь авчих санаатай нэг хүнтэй уулзаж байна. Хэмээн нөгөө дуусдаггүй ажлаа ярих гэхээр нь Намуун бушуухан

---За, за, Санасан бүхнээ бүтээж, сарвайсан бүхнээ аваарай. Би өөрөө таксидаад явчихна" гээд утсаа тавив. Үнэндээ ч ээж нь сарвайсан бүхнээ авах гэдэг хүүхэн билээ. Харин НИК-ийг хувьчилж авах гээд чадаагүй юм. Тэрэнд ч Намуун их баярладаг юм. Ямар сайндаа аав, ээж 2-ыгөө НИК-ийн хувьчлалд ялагдаад ирэхэд нь " Хүссэн бүхнээ авч чадахгүй байна гэдэг заримдаа гайхмашигтай аз байдгийг сана" гэж Далай лам сургасан байдаг юм гээд хэлчихсэн чинь ээж нь их гомдож билээ. Түүнээс хойш Намуун ээждээ " Сарвайсан бүхнээ аваарай " гэж тоглоомоор хэлдэг болжээ.

--- Мэдээж дискодох санал шууд таалагдаж хань болох банди нар дуудах гэж утас руу ухас хийхэд нь Намуун болиулав. Олон хүнтэй мэнд ус мэдэлцэх, ямар нэг сэдвээр ярилцахаас Намуун залхаж байв. Ингээд тэр 2 зуны амралт дуусаж байгааг тэмдэглэх, Хасараас болж хямарсан Намууны сэтгэлийг тайтгаруулах зорилгоор дискодох болов. 2 найз хувцасаа сонгохоор Намууны хувцасны өрөө рүү оров. Хүн байхгүй юмаа мөрөөдөх дуртай мөртлөө өөртөө байгаа юмыг юман чинээнд бодохоо больдог амьтан билээ. Намууны хувцасны өрөө

гэж 20 настай охидын жинхэнэ мөрөөдлийн орон билээ. Элбэг 10-н охиныг гоёхоор тэр олон хувцас харамсалтай нь эзэндээ огтхон ч сонин санагддаггүй тул өлгүүрийн нэг захаас таарсанг нь шууд татан гаргаж ирвэл Nina Reiss-ийн гоёмсог үүлэн цэнхэр даашинз байлаа. Энэ даашинзыг Намуун өнгөрсөн жил ээжтэйгээ Парист амрахдаа их л шохоорхон 200 еврогоор хэдалдан авсан мөртлөө ганц ч өмсөөгүй өлгүүрт өлгөн мартжээ.

---Жавхаа гутлын тавиур дээрээс тэр даашинзтай өнгө таарах ганган цэнхэр сандал авч наад даашинзтай чинь энэ сандал яг зохих юм байна гэхэд Намуун зүгээр дискодоход ингэж гангалаад ч яахав гээд нөгөө даашинзаа буцаан өлгөв. Тэгээд "Levis"-ийн нарийхан жийнсээ даруухан хар майктай өмсөөд үсээ ардаа шуун уруулаа өнгөлөөд за боллоо гэхэд нь Жавхаа --
-Тэгвэл би чиний энэ гоё даашинзыг чинь өмслөө шүү гээд нөгөө өд шиг хөнгөн үүл мэт сиймгэр эдээр урласан цэнхэр даашинзыг шүүрэн авч углав. Тэгээд Намууны өрөөнд орж гоёлын хайрцгийг нь өөрийн юм шиг дураараа уудлан өнгө хослох оюу ээмэг зүүлт гарган зүүж PUPA-ийн тэниэр зовхио будан удган мод шиг дэгжин амьтан болон хувирав. Харин Намуун утсаа гаргаж мэссэж бичсэн шиг суув.

Тэр 2-ийг гарахад намрын оройн бүрий тасарч өдрийн халуун нилээд намджээ. Мики хав нь эзнээ даган боргосоор үлдэв. Наран авхай үүлийн цаагуур час улаан туяа татуулан жаргаж байлаа. Одоо бол өндөр гоолиг биетэй Жавхаа алдартай фирмийн ганган хувцасны хүчээр жинхэнэ хатагтай шиг л харагдана. Харин Намуун түүнээс арай намханг хэлэхүү, даруухан хувцас өмссөнг хэлэх үү зүгээр л нэг сургуулийн годгор охин мэт доожоо муутайхан харагдаж байгаадаа өөрөө их л инээд нь хүрч байв. Намуун бол дунд зэргийн нуруутай нүдээрээ инээсэн цэвэрхэн охин билээ. Царайг нь зэрвэсхэн харахад онцгой юм үгүй мэт атал хараад байх тусам улам хөөрхөн санагддаг билээ. Ялангуяа давхраагүй мөртлөө урт сормуустай нүд, өргөн дух, түүний царайд нэг л ухаалаг шинж оруулна. Тэр 2-ийг таксигаар Паласт ирэхэд дисконд нилээд хүн цөөтэй байлаа. Мань 2 ч хүн цөөтэйг нь ашиглан нилээд бүжиглэн нэг нэг лааз ундаа авч сууцгаав. Намуун халууцсандаа жийнсэн хүрмээ тайлан сандлын түшлэг дээрээ тавиад ундаагаа уунгаа дэвэн дэлхийн юмыг хаман ярьж суулаа.

---Тэр 2-ын яриа нэг л мэдэхэд загвар өмсөгч охинтой явж Намууныг араар нь тавьсан өөдгүй муу Хасарын тухай болов. Жавхаа бол хаягдахын зовлонг үзсэн хүн. Түүний үерхэж байсан хайрын хүү Ганаа нь Герман явж сураг алдарсан билээ. Энэ муу залуучууд ямар хогийн байдгийг би мэднээ, зохиолд гардаг шиг үнэнч дурладаг залуу байдаг юмуу гэж Жавхааг ярихад Намуун нүд рүү нь эгцлэн ширтээд

----Жавхаа манай төгсөлтийн үдэшлэг дээр Хасар согтоод – Би Намууны аавын хөрөнгөнд болж охинтой нь үерхдэг юм гэж хэлсэн нь үнэн юм уу? Хэмээн ноцтой асуулаа. Жавхаа энэ гэнэтийн асуултад эхлээд тулгамдаснаа уг нь үнэн шдээ, хэлсэн хүн нь л нөгөө муу Номин болохоос ер нь Хасар муу санаатай өөдгүй амьтан шдээ гэхэд Намуун --Манай ангийхан надаас мөнгө зээлэх гэж л сүйд болох юм. Ёстой зэвүүн. Би ямар банк биш дээ. Хасар ч гэсэн надтай биш, аавын түрийвчтэй үерхэж байсан юм байна. Аав ээж нь мөнгөтэй гэж мэдэхгүй зүгээр л намайг хайрлах залуу тааралдвал гоё гээд Намуун бугуйвчаараа оролдов. Тэрхүү бугуйвч бол эмээгийнх нь түүнд өгсөн бугуйвч билээ. Индиан яагаан шүр хэлхэж хийсэн энэ бугуйвч бүүр өндөр эмээгийнх нь эрх бийжээ.

--Намууны эмээ Дулмаа шүтлэггүй, өөрийнхөө хэлдгээр "улаан хувьсгалч" хүн тул ээжийнхээ эрхийг таслан шүрийг нь гээсээр бүр богинохон юм болгочихоод бугуйвч хийсэн нь энэ. Намууныг 16 нас хүрэхэд эмээ нь энэ бугуйвчийг бэлэглэн, дүнчүүр маань уншсан эрхний үлдэгдэл юм болохоор охинд минь ээлтэй шүү зүүж яваарай гэж билээ. Энэ үеэр нь тэр 2-ийн ширээнээс холгүй суусан 4-н залуу, нэг охин нирхийтэл инээлдэв. Тэд бол "М-4" компанийн 4-

н залуу байлаа. Үсээ гелдэж Дизел фирмийн хувцас өмссөн, дүрэлзсэн нүдтэй, өтгөн хөмсөгтэй ганган залууг Итгэл гэнэ. Компьютерийн мэргэжлээр 3-р курсэд сурдаг мань эр хүүхэмсэгээрээ, ганган дэгжнээрээ, бас хичээлдээ сайнаараа Технийкийн Их Сургуульдаа толгой цохидог оюутнуудын нэг. Түүний найз Жаргалан буюу Жака бол Итгэлээс дутахгүй ганган хувцасладаг, аятайхан харагдсан охидыг эргүүлчихдэг, салхин сэнс мэт хөнгөмсөг, бадарчингийн үлгэрт гардаг "Бэлэн Сэнгэ" мэт хэзээ ч ам хуурай байдаггүй нүүрэмгий амьтан. Харин Батбаяр нь нүд хөмсөг болсон царайлаг мөртлөө хүүхэлдэйн киноны баатар сайхан сэтгэлт баавгай шиг номхон, бас ичэмхий залуу. Аянга бол Ня-Бо-ийн мэргэжлээр сурдаг болоод ч тэр үү, тооны машин мэт дандаа тооцоо хийж, юм бүхнийг тоолж, бүртгэж явдаг хүн. Харин түүний дэргэд суугаа нилээд сэрэмжилсэн харцтай, шингэхэн үстэй, урт сормуустай, алаг нүдтэй жижигхэн охин бол Аяндын найз охин Заяа. Энэ 4-н залуугаас ганцаараа найз охинтой буюу, хайрын охин тэнгэртэйгээ учирсан нь Аянга билээ. Хамгийн инээдтэй нь түүний тэр тооцоотой нарийн харамч зан нь ганцхан Заяагийн өмнө бууж өгдөг юм. Түүний өөрөөсөө харамлан харамлан цуглуулсан мөнгөө Заяатай хамт 3-р хорооллын дэлгүүрээр хэсэн ганцхан цагийн дотор хаврын цас хайлах мэт амархан үрчихээд урвуу царайлан ирэхэд нь нөгөө 3 хөхрөлдөн "чиний хорголоо тоолсон нарийн занг хашраах гэж бурхан Заяаг чам руу илгээсэн байхаа" хэмээн явуулдаг билээ.

----Тэр 4 нэгэн шинэ дэлгүүрийн компьютерийн системд тооцооны шинэ програм суулгах захиалга авснаа тэмдэглэхээр ирсэн нь энэ. Бүхэл бүтэн супермаркетийн компьютеруудыг сүлжээнд холбон програм суулгах захиалга гэдэг бол мань 4-н оюутанд тэнгэрийн умдаг атгана л гэсэн үг. Тэгээд хүн бүрд сая таван зуун мянган төгрөг оногдохоор гэрээ хийсэн нь гавьятан Аянга, Итгэл 2 байлаа. "М-4" гэж компаниа нэрлэсэн нь учиртай. Тэр 4-ийн шүтээн нь яг адилхан Bill Gates байлаа. Тэгээд ирээдүйд түүний байгуулсан алдарт Microsoft шиг агуу том компани болохыг бэлгэдэн эхний үсгийг нь авч 4-н гишүүн гэдгээ багтаан тэр нэрийг сонгожээ. Disco танхимын хүн нь нэмэгдсээр зөгийн үүр мэт шуугиантай боллоо. 4-н найзын ам халж, хажуудаа байгаа Заяаг бараг мартчихсан эрчүүдийн ярианы мөнхийн сэдэвт шилжив. Хаа явсан газраа аятайхан охин харж өлөн нүдэлж явдаг Жака аль хэдийн Намуун, Жавхаа 2-ыг олоод харчихсан байжээ.

----Хүүш, тэр ширээнд 2 аятайхан охин сууж байгааг хараач, таминээ гэж түүнийг хэлэхэд бүгд тийшээ харцгаав. Гэтэл Заяа их л эгдүүцэн,

----Чи юун ч хэрэгт дуртай юм бэ? Хүн хажууд нь улаан цайм харж байхад эд нартай нийлчихээд охин хүүхэн гөлрөөд байхдаа яадаг юм. Намайг байхгүй бол бүүр дагаад гүйх нь ээ. Хүүш, наад нүд чинь аяганаасаа бүлтэрлээ хэмээн Аяндыг нударснаар хайртай 2-ийн ээлжит хэрүүл дэгдэв.

----Би хаашаа харахаа чамаар заалгах уу? Гэж Аяндын уурлахад Итгэл өлгөж аваад

----яг зөв. Өдий 20-тойдоо авгайнхаа атганд орвол эр хүн болсны хэрэг байхгүй шүү гэхэд Заяа

---Чи нэртэйгээр нь тэр 2-ийн хажууд наад Жакатайгаа хамт очоод гөлрөөд суухгүй юу хэмээн тас ширвэлээ. Аянга ч мөчөөгөө өгсөнгүй

----Чи тэр 2 охиныг очиж харж болно гэж өөрөө надад зөвшөөрсөн шүү гэхэд нь Заяа уурлан босоод явчихав. Аянга тэссэнгүй араас нь очин аргадах гэхэд Жака гараас нь татан суулгаад

---Хэрэггүй ээ, цаадах чинь чамайг араас нь очихгүй бол шараа болно. Тэгээд маргааш доошоо орчихсон амьтан өөрөө гүйгээд л ирнэ гэж мэд. Хүүхнүүд аргадах тусам давардаг юм. Эмэгтэйчүүдийн сэтгэл зүйг нэвтэрхий мэдэх хэрэгтэй. Миний найз ганц удаа Заяагүйгээр эрх чөлөөгөө эдэл л дээ гэхэд Итгэл

---Чи одоо энэ Заяагийн юунд нь болдог байна аа? Ядаж тэрнийх нь ааштай гэдэг нь гэв.

---Би Заяагийн юунд нь болсон нь чамд ямар хамаатай юм? Хэмээн Аянга уурсахад Итгэл

---За юундаа уурласан юм. Чиний төлөө л сайн санаад л хэллээдэг. Ер нь үнэнч хайр майр, Romeo, Juliat-ийн домог энэ тэр чинь аль дундад зууны ойлголт юм биш үү? Гэхэд Жака шилэн аягатай пивоо нэг амьсгаагаар залгилаад дахин нөгөө 2-ийн ширээ рүү харснаа

---Тэнд 2 хөөрхөн охин суугаад байх юм. Тэр цэнхэр даашинзтай нь илүү хөөрхөн юм уу? Ингэхэд Аянгаа, ямар ч охиныг панаалдах их амархан шдээ. Чи цаад Заягаа давруулах хэрэггүй. Хөөрхөн охид хааяагүй л байна шүү, намайг алдчихав аа гэж айлгавал л зүгээр байдаг юм шиг. Жишээ нь би чамд тэр ширээний 2 охины цэнхэр хувцастайг нь хөтлөөд ирэх үү? Гээд Намуун, Жавхаа 2-ийн ширээ рүү алхлаа.

---Түүрүүнээс хойш нирхийтэл инээлдээд байн байн харцгаагаад байсан залуучуудын нэг нь тэднийг чиглэн ирж явааг харсан Намуун " нөгөө арзаганасан юмнуудын чинь нэг нь хүрээд ирлээ. За 2-уулаа явъя" гээд бослоо. Жака ч ширээнд нь хүрч ирээд Жавхаагийн бугуйнаас барин " хөөе охион, танилцах уу? Гэтэл Намуун нэг гараараа хүрмээ барин нөгөө гараараа найзынхаа гараас татан " Чи одоо яах гээд байгаа амьтан бэ?" гээд ухасхийн гарлаа. Харин сандрахдаа бугуйвчаа мултран унахыг тэр мэдсэнгүй. Яг энэ мөчид Итгэл, Намуун 2-ийн харц тулгарч билээ. Үргэсэн янзаганых шиг айсан, цочсон, өмгөөлөл хамгаалал эрсэн мэт харц нь Итгэлийн зүрхийг тэрхэн мөчид аргамжаад авах шиг санагджээ. Гэвч залууг сэхээ авахын зуургүй нөгөө 2 охин танхимаас гараад явчихлаа. Бардам ам, шалдан гуя болон хоцорсон Жака л харин мөрөө хавчин инээсээр ширээндээ хүрч ирэв. Бүгд түүнийг дооглон угтахад ганцхан Итгэл л мөчийн өмнө харц тулгарсан хар майк, жийнсэн өмдтэй турьхан охин нэг юмаа унагачих шиг болохыг тэр анзаарчээ.

---Нээрээ л сандал доогуур Намууны шүрэн бугуйвч хэвтэж байлаа. Тэр бугуйвчийг авлаа. Жижигхэн жижигхэн ягаан шүрнүүд нь саяхан зүүж байсан эзнийхээ гарын дулаан илчийг дамжуулах мэт бүлээхнээрээ байлаа. Итгэл тэр бугуйвчийг хэсэг зуур барьж зогссоноо 2 охины хойноос ухасхийн гарлаа. Намрын шөнийн тэнгэрт аальгүй одод жирвэлзэн байлаа. Хойноос нь Батбаяр бас гараад ирэв. Харамсалтай нь Намуун, Жавхаа 2-ийн суусан такси яг хөдөлж байлаа. Итгэл ч машинаа асаан араас нь дагав. Тэр охины даруухан төрх, айсан юм шиг сортолзсон нүд нь сэтгэлээс нь гарахгүй л байлаа. Хэдхэн хормын өмнө үнэнч дурлал дундад зууны үед л байсан юм биш үү энэ тэр гээд бүлтэрч байсан нь ч яалаа. Шар таксины хойноос өсгий даран давхиж явахдаа Итгэл тэр л харцыг нь санан санасаар явав. Аз болоход бараг цохиод авсан ч амнаасаа үг унагадаггүй Батбаяр хамт яваа нь яамай. Тэгээгүй бол өнөө хагархай амт Жака, хорон үгт Аянга 2 бол элдвээр баалаад амар заяа үзүүлэхгүй нь ойлгомжтой. Ээ халаг, 4-н замын уулзвар дээр осол гарснаас түгжрэнд орсон 2 өнөөх шар таксиг гүйцэхээ дөхөөд бараагүй хоцорчихов. Цагдаагийн шүглийн дуугаар хурдаа саан зогссон Итгэл машиныхаа жолоог дэрлэн унав. Алганд нь тэр охины шүрэн бугуйвч бүв бүлээнээрээ атгаастай байж байлаа. Харин эзнийг нь хаанаас олж уулзах юм бүү мэд. Тэр жолоон дээрээсээ толгой өндийлгөн

---Чи нээрээ битгий шоолоорой. Би тэр охинтой л яг одоо танилцмаар байна гээд гүнзгий санаа алдав.

---Би таксинийх нь дугаарыг тэмдэглээд авчихсан л даа.

--Нээрээ, дугаар нь хэд байсан бэ? Би ердөө ч анзаараагүй байгаа юм байна. Баагий ч ёстой чика залуу шүү.

--Баярлаж хөөрөх яахав. Чи утсаа өгөөдөх. Би City taxi руу яриад тэр жолоочийн утсыг олоодохье.

--Май, ийм найзтай байх сайхан юмаа. Чи ёстой алт шиг сайн залуу шүү.
--Батбаяр такси компаний жижүүртэй яриад өнөө жолоочийн утсыг олсноор барахгүй, 2 охины хаана буусныг нь мэдээд авчээ.
Өнөөх 2 охин Их Дэлгүүрийн урд талд байдаг 40 мянгатын нэгэн байрны дэргэд буужээ. Манай 2-ыг тэр байрны дэргэд очих үеэр Аянга, Жака 2 ч гүйцэж ирэв.
---Та нар чинь хэл чимээгүй хааччихдаг байнаа гэсээр Жака машинаасаа бууж ирэв. Харин Аянга Заяа руугаа мэссэж бичээд машинд үлджээ. Гудамжны гэрэл, сарны мөнгөн туяатай сүлэлдсэн сайхан үдэш байлаа. Намрын эхэн сарын дулаахан үдэш. Ихэнх айлууд унтсан тул гэрэлтэй цонх хэдхэн үлджээ. Итгэл ташаа тулан зогсоод гэрэл нь асаалттай цөөхөн айлуудын цонх руу горьдлого тээсэн нүдээр харсаар. Жака хүүхдийн тоглоомний талбайн элсний хашлага дээр суугаа Батбаяраас
---Цаадхи чинь яачаа вэ? Гэж хэрэгт дурлахаас илүү гайхан асуув.
---Дурлачихсан юм байгаа биз.
---Юу?? За худлаа байлгүй дээ. Тэгээд хэнд?
---Нөгөө дискон дээрээс чамаас зугтаадаг 2 охины нэгд нь биз.
---Та 2 тэгээд араас нь хөөгөө юу? Шал балай юм. Харьж унтацгааяа, хөөе
---Түүрүүнээс хойш ганц ч үг амнаасаа унагаагүй Итгэл сая эргэн хараад
---Чи өөрөө харьж унтахгүй юу. Чамайг энд бариад, Жака Чи минь битгий яваач гээд байгаа хүн хэн байгаан бэ?
---Хүүе, хүүе, Хараач чи чинь ёстой дурласан Romeo болоо шивдээ. Нүд мүд чинь бүр шаналчихсан харцтай гээд тас тас хөхөрснөө хэн ч дагаж инээхгүй болохоор үсээ илээд машин руугаа алхав. Тэгээд машиндаа суухийн өмнө
---За тоглосон шүү гэхэд Итгэл бас машиндаа суугаад
---Та нар юу гэх нь хамаагүй. Би тэр охиныг л олмоор байна гээд ухасхийн давхин одлоо.

- Жака Аянга 2 өөд өөдөөсөө хараад мөрөө хавчицгаав. Харин тэднийг Намуун цонхоороо харсаар зогслоо. Тэр өнөөдөр эмээгийн дээ хонохоор иржээ. Дискон дээрээс сандран гарахдаа бугуйвчаа хаясанаа бүүр таксинаас буусан хойноо л мэджээ. Тэгээд эмээгийнхээ өгсөн нандин бэлгийг хаясандаа харамсах, араас нь даган давхисан залуугаас бултаж чадсандаа баярлах 2 нь зэрэгцэж билээ.

Гэтэл шүршүүрт орчихоод гарч ирээд санамсаргүй хөшигний завсраар шагайтал нөгөө айхтар цоргисон харцтай нүдээрээ өөрийг нь хараад байсан өндөр залуу нь байрны гадаа ирчихсэн найзтайгаа хоюулаа айлуудын цонх руу хараад зогсож байх нь тэр.

- "Бурхан минь, ямар сонин залуу бэ? надаар яах гээд байгаа юм бол? ямар азаар гэртээ харилгүй эмээгийн дээ ирэв ээ. хэрвээ гэртээ очсон бол манайхыг мэдэж авчихаад яах ч гээд байх юм билээ. Эмээгийн эндээс бол намайг олтлоо л өдий биз. Шөнө дунд болчоод байхад яасан явдаггүй амьтан бэ?" гэсэн юм бодон харж зогстол дахиад 2 найз нь машинтайгаа хүрээд ирэв. Бүсгүй буйдан дээр суугаад өрөөний гэрлийг унтраав. Харанхуйд юм бодож суух сайхан. Өдөр бүр заавал ганцаараа байж юм бодож бай гэсэн Далай ламын сургаалыг тэр давтах дуртай. "Юун залуу бэ? ер нь яагаад тэр дискон дээр намайг өдөх гээд байсан юм бол?" тэр утсаа авч Жавхаа руу залган дискон дээр маяглаад байсан залуучууд танай гадаа очоогүй биз гэж асуув. Тэднийх эмээгийнх нь хажуугийн байранд байдаг билээ. Шал нойрмог Жавхаа "чи нойр сэргээчихлээ. өдийд унтахгүй юугаа хийж байгаа юм бэ?" гэж

үглэсээр цонхоороо хараад "хэн ч алга л байна даа. Танай гадаа тэд нар байгаа юмуу, хаашаа юм?" хэмээн уцаартай гэгч нь асуув.

- Харин тийм. Манай гадаа 4-үүлээ байж бна. Эмээгийнхийг яаж олж ирэв ээ

-за ингэсгээд явчих байлгүй дээ.

- явах нь ч явах л байх л да. За за, чи сайхан нойрсоорой. Намуун утсаа ширээн дээр тавиад босч цонхоор харав. Нөгөө хэд ашгүй машинд хуваагдан суугаад хөдөлж байгаа харагдав. Цаг харвал шөнийн 2 цаг болчихжээ. Бүсгүй өвөөгийнхөө зургийн өмнө зул асаагаад орондоо орлоо.

Харин Итгэл гэртээ хариад хоолоо хүйтнээр нь идчихээд, зочны өрөөнийхөө буйдан дээр бодолд автан үүр цайтал суужээ. Анхны харцаар дурлана гэдэгт тэр урьд нь хэзээ ч итгэдэггүй байсан нь үнэн. Тэр 21 нас хүртлээ хэд хэдэн охинтой үерхэж, дажгүй гоё охидыг уйлуулж уяраан өвөртөө оруулж явсан ч, хангал зүрх нь хайр амсаагүй яваа билээ. Түүнтэй хэдэн сараар үерхсэн, уулзаж учирдаг, амрагийн жаргал эдэлж явсан олон олон охид, хүүхнүүдээс хэн нь ч өнөөдрийн сортолзсон нүдтэй охин шиг сэтгэл зүрхийг нь донсолгож явсангүй.

Хайр гэдэг түүний төсөөлж байсан шиг дэмий ч эд биш, бас шүлэг зохиолд гардаг шиг, хосгүй сайхан ч мэдрэмж бас биш бололтой. Нэрийг нь хэн гэдэг юм бол? Лав л гоё нэртэй охин байгаа даа. Сонин юм даа. Би яагаад тэр охиныг мартаж чадахгүй байна аа? Заа байз маргааш гэрийнх нь тэнд очоод сураглавал олдох бол уу? Хайр майр гэдэг чинь дундад зууны юм гээд томроод байсан чинь өөрө ингээд дурлачихдаг байж ээ.

- Тэгээд тэр охин намайг тоох бол уу? Энэ бол Итгэлийн хувьд өөрөө өөртөө эргэлзсэн анхны тохиолдол байлаа. Урьд нь тэр ямар ч охинтой танилцахдаа өөртөө итгэлтэй байж чаддаг, хараад өөрт нь таалагдсан л бол ирлээ, үзлээ, яллаа гэдэг шиг ямар ч зовлонгүй гартаа оруулаад авдаг байсан билээ. Итгэлийн эргүүлсэн ганц ч охин түүнд татгалзаж байсан удаагүй. Эр хүнд амархан хүүхнүүд үнэгүй санагддаг болхоор Итгэл ч тэдний хэнд нь ч сэтгэл алдарч явсангүй. Өнөөдөр сайхан харагдаад, шохоорхоод, маргааш нь танилцан хоолонд ороод, хэд хоног амраглаад л түүний хувьд бүх юм төгсдөг байв. Түүнийг ийнхүү бодолд автан амьдралдаа анх удаа эмэгтэй хүнээс болж харанхуй өрөөнд буйдан дээр хэвтэж байх энэ мөчид Намуун ч бас түүний тухай бодон үүр цайлгаж байлаа.

- Тэр ийнхүү оройтож ирэх бүрдээ ээжийгээ сэрээхгүйн тулд өлмий дээрээ гишгэн гэт сээр гэртээ ордог ч ээж нь заавал сэрчихсэн байдаг юм.

Энэ удаа ч гэсэн ээж нь унталгын хувцсан дээрээ нимгэн шөнийн халад нөмөрчихсөн зочний өрөөний үүдэнд -"Миний хүү унтахгүй яагаав? Гэчихсэн зогсож байв. –Ээж та яагаад сэрээ вэ?

-Чамайг унтаж уу гүй юу, гээд өрөөг нь шагайсан чинь ор нь хоосон байхаар нь

-Нойр хүрдэггүй ээ, та унт л даа, өглөө хар үүрээр босдог байж.

-Миний хүү хоолоо идсэн үү? -Идсэн. Гоё хуушуур байна лээ. –Одоо миний хүү орондоо очиж унт даа гэж ээж нь хүүгийнхээ дэргэд суун үсийг нь илэнгээ хэлэв. – За ээжээ. Ээж хүү 2 өрөө өрөө рүүгээ очиж ор орондоо оров. Тэр охин зүүдэнд ороосой гэж Итгэл орондоо орон бурханаас ингэж гуйх шахав. Гэвч зүүдэнд нь өнөөх охин орсонгүй харин ээж охин дүү 2тойгоо нил их нэлийсэн усан дундуур туучаад явна. Тэгснээ ойд гав ганцаараа төөрчихсөн байна гэхчлэн утга учиргүй юм зүүдлэн их л муу унтаад сэржээ. Намууны хувьд өглөө нойрноосоо их л сэргэлэн сэрэв. Эмээг нь онгоцны буудал хүргэж өгөхөөр аав ээж 2 нь хүрээд иржээ. Ээж нь гал тогооны өрөөнд цай ууж сууснаа охиноо хараад – Хүүе миний охин ээж нь үнсье хэмээн нялуурахыг бодвол өчигдрийн ажлаа бүтээн сарвайснаа авч чадсан

боллолтой. – За над шиг хөгшин юмыг үнсэж мүнсээд байхдаа яадгийн. Ээж зүгээр дахиж нэг жоохон хүүхэд гаргаад тэгэж нялуурахгүй юу гэлээ. – Хүүхэд том болохоороо дэмий юмаа, тийм ээ өвгөөн. – Намуун ингээд л аав ээж 2-ыгоо үгээр идээд байдаг шдээ. өнөө нохой чинь чамайг ирэхгүй болохоор шөнөжин худлаа боргоод, хаалга сахиж хононолээ гэж аав нь янзгүй хэллээ.

- Мики юу? Тэр чинь Америк яваад ирэхэд ээжийн нохой болчихсон байсан муу урвагч, худлаа тэгэж байгаа юм. Миний Чука байсан бол тэгэхгүй л дээ. Чука гэдэг нь түүний багадаа тэжээж байсан овчарка нохой. Хэдэн жилийн өмнө гудрага тусаад үхчихсэн юм. Хээ цэсс... Нохойд хүний нэр өгчихсөн болохоор ямар олиг байдаг юм, нэр нь хүнддээ биз гэж Самбуу хэлдэг юм. – Ортой л байх гэж аав нь хэллээ. Гэтэл мухрынхаа өрөөнд түнтэгнэж байсан эмээ нь орж ирэн – Алив хөдлөө, хүүхдүүд минь. Онгоцноос хоцрох нь гэсээр тэдний яриаг таслав. Эмээгээ гаргаж өгчихөөд Намуун гэрийг нь янзлахаар буцаж ирэв. Эмээгийнх нь хөрш байранд суудаг болохоор Жавхаа ч ороод ирлээ. 2 охин ч өчигдрийн залуусын тухай яриа дэлгэж байгаад санамсаргүй цонхоор харгал өнөө өндөр залуу бас л ирчихсэн тоглоомны талбайн сүүдрэвчинд байгаа хэсэг жаалуудыг шалгааж байгаа харагдав. – Хөөе, нөгөө зөдуу чинь ирчихэж, хэмээн дуу алдахад Жавхаа ч нээлтэй цонхоор хараад нүдээ бүлтийлгэн мөрөө хавчив. – Энэ одоо яах гээд энүүгээр эргэлдээд байгаа юм бол? – Чи л таалагдсан юм байгаа биз дээ. – Ямар сонин залуу вэ? Өчигдөр шөнө энэ чинь бас энд байж байж явсан шдээ.. хэмээн Намууныг хэлээд буйдан дээр суухад Жавхаа – Хөөрхий амьтан, чамд дурлачихсан ч юм билүү, юундаа маяглаад байгаан, танилцал даа, таалагдахгүй бол танилцахгүй гэнэ биз хэмээн цонхоор харан зогссоноо би өчигдөр нээх сайхан унтаж байсан чинь эд нараас болоод чи намайг сэрээчихсэн биз дээ, тэгээд миний нойр сэрчихээд баахан хэвтсэн гээч.

- Чөтгөр өө, нөгөө манай ширээнд хүрч ирээд намайг татаад байсан урт үстэй нь бас тэр гулсуурын хажууд зогсож байна гээд хажуу тийш үсрэн, хөшигний араар орсоноо эсвэл энэ залуу нь бас намайг эргээд байгаан бол уу? Би ерөөсөө гараад байдлыг нь үзчихээд ирэх үү? Гээд Намууны юу хэлэхийг ч хүлээлгүй үүд рүү гүйлээ.

Жавхаа, чи байж бай л даа. Чамайг тэр 2 чинь хараад л танина. Чи юу гэж хэлэх гээд байгаа хүн бэ? Яах санаатай ч яваад байгаа юм билээ? – За яав л гэж гээд тэр углаашандаа хөлөө шургуулав. – Хоёулаа цаад хоёртой чинь муур хулгана болж тоглочихвол яаж байна? Тэр 2 чамайг хараад шууд л танилцъя энэ тэр гэнэ биз. ЧИ нэрээ хэлнэ үү, байна уу өөрөө л мэд. ХАрин намайг асуувал битгий хэлээрэй. – Мэдээж чамайг асууж л таараа шдээ. Тэгээд би улайм цайм хамт явж байсан найзынхаа нэрийг мэдэхгүй гэх юм уу? – Намайг Алтаа гэдэг. Энд ахындаа түр байсан юм. Гэр нь биш гэд л хэлчихгүй юу. Жинхэнэ гэр нь хашаанд байдаг юмаа, хөөрхий гэвэл цаадах чинь дахиж наашаа зүглэхгүй биз. – Тэгээд л хэлчихвэл наашаа зүглэхээ больчихно гэж чи яаж мэдсэн юм бэ? Ер нь би тэгэж худлаа хэлж чадахгүй ээ. Дараа нь тэр чинь үнэнийг нь мэдчихвэл би л худалч болж таарна, зүгээр. Чи юундаа тэгэж нуугаад бариад байгаа юм? – Хасараас болж хангалттай шаналлаа. Одоо энэ ч бас юу билээ дээ. Чи миний найз л юм бол тэгээд л хэлчих л дээ. Энэ чинь хэрэв манай гэрийг мэдчихвэл бүр салахгүй. Углаашаа өмсч байсан Жавхаагийн нүдэнд дүрсгүй инээмсэглэл тодорч – Хүүшээ, энэ чинь харин тэр залууг чамд дурласан юм уу, үгүй юм уу гэдгийг мэдэх гоё арга биш үү? Чамайг гэрт байдаг гэж надаас сонсоод яахыг нь үзье, тэгэх үү? Хэрэв чамд жинхэнээсээ сайн л юм бол гэр хороололд хаана байдгийг чинь бас асууна ш дээ. Тэгвэл яах юм? – Ямар яршигтай юм бэ? Би сайн танихгүй. Эмнэлэгт ажил хийдэг гэнэ лээ гээд л хэлчих. Энэ үеэр үнэндээ Намууны сэтгэлд Хасарын өөдгүй явдал бодогдоод байсан тул Жавхаагийн сэдсэн

зугаатай тоглоомонд оролцох, Итгэлийг сонирхох сөхөө ч байсангүй. Намрын нар илчтэйгээ ээсэн сайхан өглөө абйлаа. Бага үд дөхөж гудамж хүн машины дуу чмээнд умбаж байлаа. Хүүхдийн тоглоомны талбайн модон сүүдрэвчэн доор суусан Жака ийш тийш залхуутай гэгч нь хараачилж байснаа Жавхааг олоод харчихлаа. Тэр найзыгаа нудран – Хараач, нөгөө өчигдрийн цэнхэр даашинзтай охин явж байна гээд үсрэн босож – Хөөе охион, юм асууя гэсээр гүйж очоод – За сайн уу? Өчигдөр найзтайгаа хоёулаа нээх мангасаас зугтаж байгаа юм шиг гүйлдээд гарсан охин мөн биз дээ? – Тэгээд яах гээд байгаа юм? – Танилцъя, болдоггүй юм уу? – Болдоггүй юм гээд бүсгүй яарч байгаа хүн болж явахаар зүтгэв. Сүүдрэвчийн доороос Итгэл ч хүрээд ирлээ. - Өчигдөр хамт явж байсан найз охинтой чинь танилцах гэсэн юм. Намайг Итгэл гэдэг. Чи гэрийг нь заагаад өгчих л дөө гэж тэр Жавхаагийн нүд рүү ширтэж байгаад шаардангуй хэллээ. Тэр шаардангуй дуу, нухацтай харц нь түүнийг бүүр балмагдуулчихав. – 1-рт тэр чинь миний найз биш. Зүгээр л танил охин. 2-рт тэднийх энд байдаггүй юм. Тэгэхээр та 2 энүүгээр битгий эргэлдээд бай. Жавхаа биеэ барьж чадалгүй нэгэн амьсгаагаар энэ хэдэн үгийг хэлчихээд явах гэсэн хүн болж урагшаа зүтгэв. Ер нь шалтаг л гарвал маргачих гээд байдаг нь түүний зан билээ. Итгэл түүний урдуур нь хэрж зогсоод – Тэгвэл чи танил охиныхоо нэрийг нь хэлчих л дээ гэж нөгөө л шаардангуй өнгөөрөө асуулаа. – Алтан зул гэдгийн. – Гэр нь хаана байдаг юм бэ? – Мэдэхгүй ээ, Гэр хороололд л байдаг ш дээ. Хайлаастанд бил үү, Толгойтод билүү. – Тэгвэл яагаад өчигдөр энд буусан юм бэ? – Аан юу л даа. Алтаа энд айлын хүүхэд хардаг байсан юм аа. Одоогоор гэртээ харчихсан. Ажилдаа орно л гэж байсан. Сургалтын төлбөрөө дийлдэггүй болохоор сургуулиасаа гарчихсан юм. Аа тийм, нэг хувийн эмнэлэгт асрагчаар орох гэж байгаа гэсэн. Заа би явъя хөөе. Жавхаа цүнхээ савласаар Их дэлгүүр рүү гунхлан одлоо. 2 залуу араас нь өөд өөдөөсөө харалцан мөрөө хавчаад машин руугаа алхав. Араас нь Итгэл – Хөөе, чи өөрийнхөө утсыг өгөөч гэсэн ч тэр сонсоогүй юм шиг хурдлан алга болов. Намуун тэднийг цонхоороо харсаар зогсов. Өөрийнх нь хувьд харь танихгүй ертөнц мэт санагдах тэр өндөр залуу хэн юм бол? Үнэхээр Намуунд дурлачихаад хөөцөлдөөд байгаа юм уу? Аль эсвэл аавыг нь баян гэдгийг мэдчихээд хүргэн орох гэсэн амьтан уу? Хэн мэдэх билээ? Хар багаасаа үерхсэн Хасар тийм хогийн зан гаргаж байхад дөнгөж өчигдөр дискон дээр л бараагийг нь халти хасан залуугийн юунд нь итгэх билээ. Энэ бодол нь Хасараас болж зүрхийг нь базсан шархыг нь сэдрээчихэв. Хэдийгээр унан тусан дурлаагүй ч зуны бороонд норон алхаж, өвлийн цастай үдэш хөтлөлцөн гүйлдэж, 4-н жил үерхсэн Хасар нь шүү дээ. Анхны болзоо, анхны үнсэлт, анхны шөнө гээд л ер нь түүний хувьд анхны юм бүхэн нь Хасартай холбоотой. Эмэгтэй хүн дасч хайрладаг гэдэг үнэн. Ямар ч гэсэн Намуун түүнд өөрийнхөөрөө л хайртай байсан. Гэтэл өөрийнх нь хажуугаар загвар өмсөгч охинтой... Энэ тухай бодохоос л дургүй нь хүрсэн тул тэр цонхноосоо холдон буйдан дээрээ суулаа. Маргааш Хасар Бээжингээс ирнэ. Ямар нүүрээрээ өөртэй нь уулзаж яаж хуурамч зан гаргах бол? Гэж бодохоос дургүй нь хүрнэ.

Гэхдээ нэг л юм түүнийг тайвшруулж байлаа. Хэдийгээр Хасартай олон жил үерхсэн ч тэр Намууны жинхэнэ мөрөөдлийн залуу биш юм байна гэдгийг өчигдөр л ойлгожээ. Тийм ээ, тэр Хасарт хайргүй. Тийм болохоор хэд хоног шаналаад л мартана гэсэн үг. Тэгэхээр жинхэнэ гал халуун дурлалтай хэзээ нэгэн цагт учирна шүү дээ. Харин тэр хайрын эзэн нь Намууны аавын хөрөнгөнд биш зөвхөн өөрт нь дурласан байгаасай гэж бүсгүй чин сэтгэлээсээ хүсч байлаа.

Хаалганы хонх тасхийхэд тэр бондгосхийн цочив. Эмээ нь өөрөө ямагт цочин уулга алдаж

суудаг хэрнээ энэ чанга дуутай дээр үеийн Орос хонхоо солих тун дургүй байдаг хүн. Энэ хуучны байр, энэ орилоо дуутай хонх, энэ том хүрэн номын шүүгээ нь бүгд өнгөрсөн амьдралынх нь гэрэл гэгээтэй дурсамж, талийгаач өвгөнтэй нь мөнхөд холбогдож байдаг болохоор тэр биз. Хонх орилуулсан хүн бол мэдээж Жавхаа байлаа. Тэр мөрнөөсөө цүнхээ мултлаад инээд алдсаар орж ирэв. Нөгөө 2 залууг яаж хуурсанаа бодохоос л инээд нь хүрээд байгаа бололтой. – Ёстой гоё юм боллоо. Тэр өндөр залууг нь Итгэл гэдэг юм байна. Чамтай таницах гээд л эргэлдээд байгаа юм гэнээ. Найзынхаа нэрийг хэлчих, гэрийг нь заагаад өгчих гээд л намайг өчнөөн хоргоолоо. Тэгэхээр нь чамайг Алтанзул гэдэг. Гэр хороололд байдаг гээд буудаж гарсан. Бас чамайг сургуулийн төлбөрөө төлж чадахгүй ажил хийдэг, хувийн эмнэлэгт ажилладаг гээд л хэлчихсэн шүү гээд тэр жингэнэтэл инээсээр ширээн дээрх цүндгэр шилтэй уснаас аяганд хийж авлаа. Түүний яриаг нэг их анзааралгүй шал өөр юм бодож суусан Намуун сая л сэхээ орж – Аан, тэгэж ярихаар чинь яаж байна? Гэж урмыг нь бодож л асуужээ. – Нөгөө урт үстэй нь сонин болоод явчихсан. Харин тэр Итгэл нь гайхаад л байна лээ. Тэр залуу чамайг үнэхээр сонирхоод байсан. Анхны харцаар дурлачихсан юм биш үү?

- Тийм юм кинон дээр л гардаг байх. – Чи анхны харцаар дурлана гэдэгт итгэдэггүй юм уу? – Үгүй ээ, Яаж хүнийг огт мэдэхгүй байж ганц хараад л дурлах юм бэ? Гэмт хэрэгтэн ч юм билүү? Аавын өрсөлдөгчийн явууллага ч юм билүү? Тийм биз дээ? - За боль доо, чи юм болгоныг тэгэж хардаж сэжиглээд байж болохгүй шдээ. Чи ямар Жэмс Бонд биш дээ. Тэр залуу жинхэнэ хайр чинь байсан бол яахийн? Би л байсан бол танилцах л байсан. Надад бол ямар тийм юм байх биш. НЭг бодлын ядуу аав ээжтэй байх сайхан ч юм уу? Даанч гэрт орохоор мөнгөний хэрүүл болж байдаг нь хогийн. 2 бүсгүйг ийн яриа дэлгэж суух үед Итгэл бодолд дарагдан жолоо барьж явлаа. – Сонин л юм даа. Тэр охин тийм боломжгүй айлын хүүхэд юм байх даа. Өчигдөр анх дискон дээр харахад тийм ч ядуу хүний шинжгүй л байсан шдээ. Ер нь ядуу байсан ч ямар хамаатай юм. Хотын бүх эмнэлгээр эрж хайж байгаад ч хамаагүй түүнийг олохдоо л олно хэмээн шийдэв. Харин дөнгөж саяхан энэ мэдээг сонсоод Жакагийн хэлсэн үг юу билээ.

За боль боль, чи хэзээ тийм дурламтгай болчихсон юм бэ? Хашааны охиноор яах гэсэн юм? Өчигдөрхөн л дурлал мурлалд итгэдэггүй гээд бүлтрээд байсан биш үү гэж билээ. Хэдийгээр найз нь үнэн үг хэлсэн боловч *Үнэн үг хэлсэн хүнд хүн өшөөтэй, үхэр унасан хүнд нохой өшөөтэй* гэгчээр – Солиор, чамд ямар хамаатай юм? Гэгчхээд машиндаа суусан билээ. Уг нь тэр 2 жилдээ ганц хоёроос илүү ам муруйж байсангүй. Ялангуяа Итгэл охид хүүхнүүдээс болж ингэж найз нартаа үг хаяж байсан явдал хэзээ ч байгаагүй билээ. Жака бол өнгөн дээрээ хөнгөн, саваагүй зантай юм шиг харагддаг болохоос цаагуураа найз нараа хулхидаад байдаггүй, юмыг нухацтай боддог хүүхэд. Үүнийг ч Итгэл үнэлдэгтээ л 4,5-н жил салахгүй найзалж байгаа билээ. * Алтанзул, Алтаа чи одоо хаана явна вэ? Би чамайг олж уулзахгүй бол* залуу өврөөсөө нөгөө шүрэн бугуйвчийг гарган үзлээ. Япон хийцийн мөнгөн мэлхий түгжээтэй энэ бугуйвч эзнийхээ бүх нууцийг өөрийнхөө хэлээр хүүрнээд ч байгаа юм шиг. Гэр хорооллийн охинд мэлхий түгжээтэй шүрэн бугуйвч байх гэж үү? Тэр цочсон мөртлөө цаанаа л нэг бардам харц, тэр даруухан мөртлөө чансаатай хувцас, энэ хөөрхөн бугуйвч хайрыг нь булаасан тэр нэгэн охины тухай саяхан сонссон нь шал өөр охины дүрийг сэтгэлд нь дүрслээд байлаа. Тэр сэтгэл дотроо бугуйвчны эзнийг Янзага гэж нэрлэхээр шийдлээ. Ямар ч гэсэн түүнийг Алтаа гэдэг нэртэй баймааргүй юм шиг санагдаадбайлаа. Хэрэв энэ тухай найзууддаа хэлбэл Батбаяраас бусад нь шоолно. Ер нь ч тэр Батбаярт ч хэлэхгүй нь

мэдээж л дээ. Гэтэл нь утас нь дуугарч энэ уянгын бодлыг нь сэргээчихэв. – Татварын хэлтэст очоод үйл ажиллагаагаа эхлээгүй гээд 0 тайлан гаргаад тамгалаад өгчихлөө шүү гэж байна. Татвар, тайлан, тамга. Ажил хэргийн энэ яриа түүнийг хайрын гэгээн ертөнцөөс нь хүчээр бодит хорвоо дэлхийн амьдралд буулгаад ирэв. Залуу өдөржин ажлаа хөөцөлдөж яваад орой гэртээ хариад лавлах утаснууд руу ёстой утаа гаргал залгаж байгаад 30 гаруй хүвийн эмнэлгийн хаяг олж аваад унтахаар хэвтжээ.

Нэг л мэдэхэд 9 сарын 1-н болчихсон байлаа. Намуун, Итгэл 2-ыг учруулсан тэр нэгэн үдшээс хойш 10-аад хоног урсан оджээ.

Хичээл эхэлж зунжин уулзаагүй ангийнхан нь Итгэлийн санаашрангуй, томоотой болж урьдынх шигээ шинэ курсын хөөрхөн охидыг ангуучлахгүй байгаад хамгийн их гайхав. Харин Жака яаж тэсэх билээ. Ангийнхаа охидын тунд орчихсон Итгэлийн домогт дурлалын богинохон түүхийг нэмж хачирлан ёстой *Титаник*-ийн Роза, Жэк 2-ийнх шиг болгон өнгөтөөр яричихжээ. Тэдний ангийн охидын дунд Итгэлийг нүдээ хөхөртөл харж явдаг ч харцыг нь булаахгүйдээ сэтгэлээр унасан охин нэг биш байдаг юм хойно. Тэр дурлаад унаад байгаа охин нь хэн юм бол? Гэж хэд хоног хэл амаа билүүдээд чимээгүй болцгоосон юм. Итгэл урьд нь дандаа л мисс юм уу, загвар өмсөгчидтэй яюдаг байсан ч хэнд нь ч хайраа өгөөгүй болохоор галзуурсан дурлалын эзэн нь хэн бэ гэдэг ганцхан тэдний ангийнхан ч биш, сургууль даяар охидын ярианы сэдэв болсоор байв. Эцэст нь эрэл мухардаж зэргэлдээ ангийх нь бас нэгэн фэн охиных нь өгсөн дурласан Шэкспир гэсэн хоч л үлдэж билээ. Харин Итгэл энэ бүгдийг нь тоосон ч үгүй. Дискон дээр харц тулгаран хайраа өгсөн тормон нүдтэй охиноо бодсоор л явлаа. Ёстой л нөгөө дээр үеийн нэг зохиолын дуунд гардаг шиг *Хаана яваа болдоо тэр минь хаана яваа боол?* хэмээн дуулж, зурагт фм-ээр зарлуулах нь дутаад байв. Найзууд нь түүнийг шоолж ханажээ. Одоо түүний хувьд Аянга, Заяа 2-ын нэг бол нялуурч, нэг бол хэрэлдэх нь урьдынх шиг яршигтай биш харин ч атаархмаар харагдах болжээ. М4-ынхны хувьд хамгийн анхны том захиалгат ажил нь амжилттай байлаа. Хүнсний супермаркетын сүлжээний программаа хийсээр мань 3 хэд хэдэн шөнө нойргүй хоносных урьдчилгаандаа гайгүй мөнгө авчээ. Урьд нь бол Итгэл үүнд хамгийн их баярлах байсан. Гэтэл мөнгөө хуваагаад уламжлал ёсоор найзуудынхаа наргианд оролцох ч сонирхол төрсөнгүй. Жака – За манай *дурласан Шэкспир* өнөө орой паласын шоунд очихгүй юм биш биз дээ? Гэхэд дуугарсан ч үгүй. Урьд нь бол тэгэж хочилсонд дүрэлзтэл уурлах байсан нь мэдээж. Тэгээд очиж очиж Жака өөрийг нь хочлох юм бол зүгээр өнгөрүүлэх ч үгүй байсан юм. Одоо бол тийм юмыг тоохоо больж, түүнийг нь ч Жака ашиглан сэм сэм давраад байх болсон нь энэ. Харин Аянга энэ үеэр Заяа руугаа мэссэж бичиж дуусаад инээмсэглэн босож – Манай захирал хайртыгаа олохгүй мөн хэцүүдэж байнаа хэмээн тоглох шоглохийн хооронд долигоноод авав. Тэгээд өөртөө оногдсон мөнгөнөөсөө Заяад өгөх, өнөө оройн шоунд үрэхийгээ ялган тоолж гарав. Харин *Командо* тоглоод ухаангүй байсан Батбаяр л компьютерийн дэлгэцнээсээ түр хөндийрөн эргэж хараад – Итгэл ээ, чи Ачлал ч гэнэ үү, Ачтан ч гэнэ үү тэр эмнэлэг дээр очиж үзэв үү? Хэмээн санаа тавилаа. Харин Намуун өнгөрсөн хэд хоногт сэтгэлийн дарамтнаасаа салсангүй. Хасар Бээжингээс ирээд өнөөх сонин дээр гарсан хов живнээс мултрах санаатай Намуунтай уулзах гэж өдөр бүр гэрт нь ирнэ. Харин бүсгүй өрөөндөө шигдчихээд гэрийн үйлчлэгчээрээ байхгүй гэж хэлүүлнэ. Тэгээд залууг явсны дараа цонхоороо харж тэсэхгүй уйлна. Ингэсээр хичээл эхэлж өдөр хоног овоо хөгжилтэй өнгөрөх болж Хасарыг ч бодох нь багасав. Гэвч 4-н жилийн үерхлийг ул мөргүй сэтгэлээсээ авч хаяхад амар байсангүй. НЭг удаа Хасарын сургууль дээр

очив. Тэдний ангийнхан тарж байв. Намуун яг бие даалттай өдөр нь очиж таарчээ. Ангийн онгорхой хаалгаар тэр сэмхэн шагайлаа. Хасар сонин дээр гарсан нөгөө өндөр охинтойгоо тэврэлдэн сууж байв. Тэр охины намирсан урт задгай үсийг илэн хүзүүнд нь уруулаа нааснаа – Миний хайр яагаад анги руу ороод ирээв? – Чамайг санаад л ...- гэхдээ манай ангийнхан намайг Намуунтай үерхдэг гэж мэднэ ш дээ. – Та 2 муудалцчихсан биз дээ? – ЧИ бид 2-ийн зураг сонин монинд гарснаас болоод л жаахан тар түр хийчихсэн. Эвлэрэхгүй бол ээж мээж бөөн юм болно. - Өө, чи ямар өөдгүй амьтан бэ? Тэр Намуунаасаа больно гэж надад амлаа биз дээ? – Шууд больчихож болохгүй байна. Манай аавын компани тэднийхээс баахан зээл авчихсан. Бас манай ээж тэдний ээж 2 найз. Ээж намайг баян айлын охинтой суугаарай гэдэг юм. Тэрнээс биш би чамд л хайртай юм чинь.

Намуун үүнээс цааш сонсож чадсангүй... Шатаар ухаангүй юм шиг салхи татуулан уруудлаа.

Уур гомдол 2 нь цээжинд нь багтахгүй дэлбэ үсрэх гэж байгаа юм шиг л санагдана. Охин хонгор сэтгэлдээ хайрлаж явсан энэ залууг ийм адгийн амьтан гэж тэр өдий хүртэл даанч бодож явсангүй. *Юу гэнэ үү? Ааваас зээл авах гэж өөртэй нь үерхдэг байсан байх нээ? Даанч өчигдөр Хасарын ээж утасдаад худлаа манжлаад байсан юм. Намуун гэдэг хүн тэднийхний хувьд дүүрэн мөнгөтэй алтан карт юмуу, хаашаа юм...* Тэр шуугилдаж, шаагилдсан олон оюутан дундуур хага зүсэн зүтгэсээр гадаа гарч гүнзгий амьсгаа аваад машиндаа суулаа. Түлхүүрдээд араагаа залгах гэтэл гар нь чичрээд байв. Хорондоо тэр өөдгүй амьтны төлөө уйлахгүй юмсан гэж тэр шүд зууж байв. Тэгээд ухасхийн хөдлөв. Бурхан хүн бүхэнд таарсан таарсан зовлонг нь бодоод олчих юм даа. Түүн шиг зуун охины лав 99 % нь тэдний аав шиг баян аавтай байхыг мөрөөдөх биз. Гэтэл Намуунд тэр баян аав нь ингээд л зовлон авчирч байдаг. Чимэд гэдэг хүний хөрөнгийг биш өөрийг нь, Намуун гэдэг нэртэй бол нэртэй, шартай бол шартай, хэнд ч гологдохооргүй царай зүстэй, өөрийн бодолтой охинд л дурлах залуу байдаггүй юм уу? Жавхаа яг энэ үеэр мэссэж бичэв. 2 найз байнга очдог кафедаа очиж мухрын жижиг ширээнд суув. Намуун ганц аяга кофе захиалаад цонх руу ширтэн чимээгүй боллоо. Тэгснээ хоолны цэс шүүрэн авч мөөгний зутан шөл, нарийн махан хуурга захиалав. Түүрүүнээс хойш найзыгаа дуугүйхэн ажиглаж суусан Жавхаа үйлчлэгчийг явангуут Намууны нүүр рүү анхааралтай ширтээд – Чи чинь юу болоо вэ? Хэзээдээ шөл мөл идэх дуртай болчихоов? Гэж асуухад – Яахав дээ, хүн өөрчлөгдөж болно биз дээ? – ЧИ Хасартай өнөөдөр уулзаа юу? Намуун шанаа тулан сууснаа толгойгоо базлан чохарсан хоолойгоор – Тааралдсан юм. Нөгөө нэг юмтайгаа тэврэлдчихсэн явж байналээ. 2 нүүртэй балиар амьтан. Жавхаа кофе уунгаа – Ер нь Хасар баян хадамтай болох гэж л чамтай үерхдэг нь үнэн байхаа гээд царай руу нь сэм харснаа – Хүүшээ нөгөө Итгэл гэдэг залуу, яагаав дээр дискон дээр явж байсан 4-ийн нэг өндөр нь... Өнөөдөр надтай тааралдаад бас чамайг асуугаад байналээ. Тэгээд чамайг нээрээ тийм ядуу айлын хүүхэд юм уу? Аль эмнэлэгт ажилладгийг нь хэлээд өгчих энэ тэр гэж шалаад л байсан. Тэр чамд ёстой дурлачихсан юм шигээ. Кофегоо ганц нэг балган хажуугийн ширээн дээрх савтай цэцгийг л хараад байна уу гэмээр гөлөрч суусан Намуун тас тас хөхөрч- Ямар амьтан хүнийг ганц хараад л дурлаж байсан юм? Тэгээд ч би ямар Синди Крофорд биш. Жавхаа чи байсан бол тэр залууд итгэх үү? Гэлээ. – Итгэнээ. Чи тэрний нүдийг харсан бол, хүүш ээ, чи аавийнхаа нөгөө найзын эмнэлэгт түр ажилд орчихооч. Тэгээд Итгэлтэй үерхээд үз л д ээ. Хорондоо Хасараас гоё залуутай үерхэхгүй юу. – Эмнэлэгт ажилд ордог нь яаж байгаан? – Юу яаж байгаан гэж? Тэрэнд чамайг эмнэлэгт ажилладаг гээд хэлчихсэн юм чинь. Чи жинхэнээсээ эмнэлэгт ажиллахгүй юу. Тэгээд Итгэлтэй үерхээд үз. Үнэхээр чамд сайн уу, үгүй юу гэдгийг нь шалгахгүй юу. – Нээрээ

тэгвэл сонин ч юм уу? Ямар нэг юм хийхээр шийдсэн л бол тэр дороо хөдөлж эхэлдэг нь Намууны зан. Ээж нь ч бас тийм зантай. Харин аав нь их л удаан бодож ёстой л дотроо бодолтой, дороо суурьтай хөдөлдөг хүн билээ. Намуун ээжээсээ шийдэмгий ч гэмээр, адгуу ч гэмээр занг нь авч төржээ. Бүсгүй Хасарын тэр зэвүү хүргэм яриаг санахаар л дургүй нь хүрээд чөтгөртэй ч үерхсэн бэлэн байв. Тэгээд ч Жавхаагийн хэлснээр тэр үнэхээр өөрт нь сайн болчихсон ч юм билүү? Байз, ямархуу залуу байлаа даа, тэр Итгэл? 10-аад хоногийн өмнөх дүр зургийг тодруулах гэж тэр оролдов. Өндөр нуруу, омголон харцтай гоё нүд нь юуны түрүүнд санаанд нь бууж байлаа. Тийм ээ, өндөр залуучууд НАмуунд үргэлж таалагддаг билээ. Нээрээ түүнтэй үерхээд үзэхэд яагаад болохгүй гэж?

Намуун гэртээ харингуутаа Ачлал хувийн эмнэлгийн ерөнхий эмч хийдэг аавынхаа найз руу ярьж – Танай эмнэлэгт асрагч хийж үзмээр байна, аавын компанид ажилласнаас илүү амьдрал ойлгох байх гэж бодсон юм. Харин та аав, ээж 2-т битгий хэлээрэй хэмээн ятгалаа. Мэдээж ийм гэгээн хүсэлд хэн тагталзах билээ. Маргаашнаас нь эхлэн НАмуун хичээл тараад л эмнэлэг рүү гүйх боллоо.

Эхний үед ажил нь тийм ч амар байсангүй. Гэртээ аягаа угаахаас өөрөөр гараа усанд хүргэж үзээгүй шахам танхил амьтан резинэн бээлий хийгээд гар шазрам халуун усаар шал угаана. Тоос арчина. Ууртай хүмүүс өрөө удаан цэвэрлэлээ гэж загнана. Хамт ажилладаг хүүхнүүдтэйгээ ярих ч юм үл олдоно. Ялангуяа ажилд орсон эхний өдрөөс л шууд дайсантай болсон нь сувилагч Сараа хэмээх шингэн үстэй, нүд нь нүүрэндээ томдчихсон гэмээр харагддаг, туранхай өөнтөгч хүүхэн. Намуун эмнэлэг дээр хамгийн даруухан хувцасаа өмсдөг ч тэр анх уулзаад л түүний өмссөн зүүснийг сонжсон харцаар хөлөөс нь толгой хүртэл нь харснаа – За шинэ асрагч эхлээд 00 цэвэрлэнэ шүү гэжээ. – Намайг тасаг цэвэрлэ гэсэн ш дээ. – Тэгвэл би чамайг 00 цэвэрлэ гэж байна гэхэд нь Намуун – Би тасгийн эрхлэгчид хэлнэ гээд гараад явчихжээ. Мэдээж тасгийн эрхлэгч нь Сааа сувилагчийг дуудаж загнаа биз. Түүнээс хойш тэр хүүхэн Намууныг харахаараа тас ширвэдэг болсон билээ. Тэгээд ч Сараа түүнийг өөрөөсөө илүү гэдгийг анх уулзахдаа л мэдэрчээ. Харин Хажид гэдэг бага эмч авгай Намуунд их сайн. Өөрөө охингүй болохоор охидод хайртай гэж ярьна. Түүнд гэрээсээ авчирсан боорцогоо өгөх гэж дуудах ч юм уу, өчигдрийнхөө үзсэн солонгос киноны тухай хууч хөөрөх дуртай билээ. Намуун энэ эмнэлэгт ажиллах болсноосоо хойш л амьдрал гэдэг ихэнх хүмүүсийн хувьд ямар хатуухан боорцог байдгийг, өчүүхэн бага цалинтай, ядуу зүдүү байхын зовлонг ойлгож эхэлсэн билээ. Үргэлж мөнгөөр дутагдсан, хоосон нойтон явахын зовлон ямар байдгийг тэр урьд нь үнэхээр төсөөлдөг ч үгүй байжээ. Гэтэл өөрөө жаргалдаа ташуурсан амьтан өөхөнд ороосон бөөр мэт энхрий өсгөсөнд нь аавдаа талархах гэгчийг мэддэг ч үгүй явсандаа үнэхээр ичих болжээ. Тийм ээ, Намуун дутагдах гачигдахын зовлонг төсөөлдөг ч үгүй байсан. 50-60 мянгын цалин. Хүн чихэлдсэн автобус, муухай үнэртэй хуушуур, хямдхан хувцастай ийм хүмүүс Монголд ямар олон байдаг юм бэ? Хэмээн гайхаж билээ. Намуун ажил дээрээ ирэхээрээ гар утсаа унтраачихна. Тасагт нь гадагшаа ярьж болдоггүй битүү аппараттай ганц утас л бий. Тэгээд л ертөнцөөс тасраа. НАмуун хэдий хүртэл эмнэлэгт Алтанзул гэдэг асрагчийн дүрд тоглохоо мэдэхгүй л байв. Ямар ч гэсэн Хасараас болж шархалсан сэтгэл нь энд маш амархан тайтгарч байлаа. Бас урьд нь түүний амьдрал усны тогтуун мандал дээрх бадам цэцэг мэт нэгэн хэвийн, санаа зовох юмгүй өнгөрч байжээ. Одоо бол өдөржин шал угаагаад ядарсан ч амьдралыг шинээр харах болсондоо их л урамтай явах болсноос гадна нэг л мэдэхэд Итгэлийг боддог, хүрээд ирээсэй хэмээн сэм сэм

харуулддаг болсноо өөрөө ч анзаарсангүй.

Хандаа ямар гоё гуталтай болоо вэ? – Захаас 70-аар авсан гэсэн – За байз, энэ цалин дээрээсээ ганц гутал авмаар байдаг. Утасны карт авчихаар мөнгө гуталд хүрэхгүй болох нь ээ. Чи найздаа 20 мянгыг зээлэхгүй юм уу? – Чамд зээлдүүлэх нь битгий хэл өөрөө хамаг өрөө дараад хоосон хоцрох нь – Баян нөхөртэй л болох юм сан. – Баян нь бидэн шиг юмыг нь тоогоо ч уу, үгүй ч үү. Ядаж байртай залуу тааралддаг бол ч ... Хувцас солих өрөөнд өглөө бүхэн л тийм яриа болно. Үдээс хойш хичээлийнхээ дараа ирээд л ажилдаа түүртэн шал угааж байгаад л алга болчихдог, юу санаж боддог, гэр орон нь хаана байдаг тухайгаа ганц ч үг цухуйлгахгүй болохоор нь хүүхнүүд түүнд нэг л хөндий хандана. Харин Отгоо гэдэг жаахан охин л Намуунд дотно ханддаг юм. Намууны ажилд орсны дараагийн долоо хоног байлаа. Аянгын найз бүсгүй Заяа ээжийнхээ шинжилгээний хариуг авах гэж яваад түүнтэй эмнэлгийн хонгилд яг мөргөлдчихлөө. Хувинтай юм барьчихсан тэр охиныг нэг л үзсэн юм шиг санагдахад Заяа түр бодосхийснээ нөгөө Итгэлийн хайгаад байсан охиныг гэнэт саналаа. Тэгээд угийн хашир зангаараа шалгахаар шийдэв. – Хүүе охион, шинжилгээний хариу хаанаас авдаг юм бэ? Гэсээр тэр хойноос нь гүйцэж очив. Нөгөө бүсгүй эргэж харав. Яг мөн. Эмнэлгийн ногоон хувцас л өмсчихсөн болохоос. Өндөр ч биш, намхан ч биш дунд зэргийн нуруутай, сортолзсон нүдтэй цагаан охин байв. – Доод давхарт 101 номероос авдаг юмаа. – Баярлалаа гээд эргэхдээ Заяа энэ охинд ямар нэгэн сэтгэл татах увидас байгааг мэдэрчээ. Манай Итгэлийг тэгэж сэтгэлээр унагачихаад мэдээ ч үгүй явдаг. Урьд нь загвар өмсөгч, бүжигчин гоё гоё охидыг бээлий шигээ л сольдог байсан Итгэл энэ охины юунд нь болсон юм болоо? Тийм ч хөөрхөн биш мөртлөө нэг л аятайхан охин юм гээч. Аймар ихэмсэг харцтай. Тэгсэн мөртлөө асрагч хийдэг. За ямар ч гэсэн өнөөдөр Итгэлд ёстой сурприз барина даа гэж бодсоор тэр шатаар урууджээ.

Намууныг эрж хувийн эмнэлгүүдээр гүйсэн энэ хэдэн хоногт Итгэл ёстой шаналж гүйцэв. Нөгөө шүрэн бугуйвчийг үргэлж халаасандаа авч явна. Эзэн нь олдохгүй л байлаа. Найз нар нь яаж ч хэлээд тоосонгүй. Эцэст нь Заяа – Чи дэндүү олон охин гомдоосны чинь шийтгэл болж дээ гэхэд ч дуугараагүй билээ. Итгэл ийнхүү дурлалын боол болсонд Жака л маш их харамсч байлаа. Хүүхэн эргүүлэхдээ хань татах хүнгүй болсон болохоор тэр. Урьд нь бол тэр 2 хамт л явах юм бол хажуу хавиргаараа өнгөрсөн гоё охидод нүд унагавал найралгүй өнгөрдөггүйсэн. Харин Итгэлийн ийнхүү хүмүүжсэнд хамгийн их баярласан хүн бол Заяа билээ. Бүсгүй эхлээд Итгэлийг хүүхэн эргүүлэхээ болиод хайртыг нь уруу татчих вий гэж айх юмгүй болсонд баярласандаа инээд нь хүрээд л сууж байсан юм. Гэвч сүүлдээ Итгэлд тэр охиныг нь олоход туслах юмсан гэж үнэн сэтгэлээсээ бодох болсон билээ. Гэтэл найзынх нь нөгөө өдрийн бодол шөнийн зүүд болсон охин ингээд явж байдаг. Гэвч хашир нь дээрээ. Заяа жижүүр сувилагчаас лавлаж байж Алтанзул гэдэг сувилагч энд ажилладагийг лавтай мэдэж аваад эмнэлгээс сэтгэл тэнэгэр гарч одлоо. Итгэл нэгэн сонинд компьютер дуудлагаар засна гэсэн зар өгснөөсөө болж татварын байцаагчид дуудагджээ. Ширээгээрээ дүүрэн цаас хөглөрүүлсэн муухай ааштай хүүхэн сууж байв. Байцаагч гэдгийг хүн байцаахийн нэр гээд шууд утгаар нь ойлгочихсон бололтой. Залууг хөлөөс нь толгой хүртэл ширтсэнээ – Миний дүү оюутан хүн татвар төлдөггүй гээд ойлгочихсон юм биш биз дээ? Гэснээ дуу нь албархуу ширүүн болж – Та нар үйл ажиллагаагаа эхлээгүй гээд байсан. Данс руу чинь мөнгө орсон байна лээ. Өнөөдөр энэ сонинд зар гарчихсан байна. Төрөх нь үнэн, татвар хураалгах нь үнэн гэж дуулсан уу? Балансаа гаргаад ирээрэй. Тэгэхгүй бол өөрөөр ярина шүү хэмээн тачигнав. Тэр хэл амтай айхтар байцаагчийн өмнөөс А гэж дугарч ч амжсангүй гарч ирээд хөлсөө

арчсанаа дансанд бас юун хөдөлгөөн орчихов оо? Хэмээн гайхав. Утсаа авах гээд энгэрээ тэмтрэхэд нь нөгөө шүрэн бугуйвч гарт нь өртжээ. Тэр бугуйвчийг гарган гартаа атгаж зогсохдоо сэтгэл нь үүлтэй тэнгэр онгойх шиг гэнэтхэн цэлмээд явчихлаа. Урьд нь бурхан шашин, ямар нэгэн сүсэг бишрэлийн тухай ярих нь гарахад хөх инээд нь хүрдэг байсан Итгэл одоо энэ бугуйвчтай ярих нь халаг болж сэтгэл санаа тайвшруулж, ажил үйлс бүтээдэг ид шидтэйд нь эргэлзэхээ больсон билээ. Бугуйвчийг харах бүрд эзнийх нь нөгөө л харц усных шиг мэлтэлзсэн нүд санаанд нь орж тэр хайрын цэнхэр ертөнцөд оччихдог билээ. Гэтэл гэнэт утас нь дуугарахад утасныхаа клипээ харвал дүү охин нь залгаж байна. Энэ Навчаа одоо яах гээд дандаа над руу дохиж байдаг байнаа хэмээн төвөгшөөн үглэсээр эргэж залгавал – Ах аа, Сэни гэнэ үү хэн гэнэ бэ? Тийм хүүхэн таньдаг юм уу? Над руу баахан мэссэж явуулаад ахтайгаа яриулаад өгөөч ч гэх шиг. Гэр рүү ч дандаа залгаж байх юм. Ямар яршигтай юм бэ? Хэмээн дуржигануулав. Тэгснээ – би тэгэхээр нь ёстой горьдвоо. Чам шиг хүүхнүүдийг манай ах тоодоггүй гээд мэссэж явуулчихсан. Зөв биз дээ? Хүүшээ, ахаа миний нэгж дуусчихлаа. Одоо би ажил дээр чинь очоод картны мөнгө авчихъя тэгэх үү? Хэмээн панаалдлаа. Итгэл зальтай амьтан гээд за за өөрийгөө Сэни гээд байдаг өнөөх нойтон хамуу шиг хүүхнийг бодохоос дургүй нь хүрэв. Тэр бол сарын өмнө Жакатай жуулчны бааз явж байгаад танилцсан бүсгүй. Ээжийнхээ найзын бааз дээр гар компьютерийг нь засахаар залагдаж очсон 2 ажлаа хийчихээд шөнө нь говийн тэнгэрт гялалзах саатай хоргой шиг хээнцэр тодхон оддыг шохоорхон хэвтэж байтал- Гал байна уу? 2-оо гэсээр нэг бүсгүй дөхөж ирсэн нь Сэлэнгэ байсан юм. Богинохон шорт, бариуй майк өмссөн, урт хөлтэй өндөр нуруутай Сэлэнгээ эль хуль жуулчны бааз дээр ёстой согоо гэхээс аргагүй байснаас гадна ойр хавьд нь бүсгүй шингэн дуут харагдахгүйд уйтгарлаж хэвтсэн мань 2-т ийм бүсгүйтэй танилцсан нь бөөн аз байлаа. Гал байна уу? Гэдэг ч эрчүүдийг өөрөө өддөг хүүхнүүдийн дэндүү улиг болсон арга байсан ч тэр 2 чихэр харсан нусгай жаалууд шиг халаас руугаа зэрэг гараа явуулж билээ. Мэдээж тэр шөнө мань 3 говийн тэнгэрт гялалзах тодхон, гоёхон оддыг удаан шохоорхсон ч гүй. 2 залуугийн компьютер засаад олсон мөнгө нь тэр чигээрээ ч эргээд эзнийхээ санд орж билээ. Харин дараа нь Сэлэнгээ гуйлгаж барьсан ч үгүй, Итгэлийн өвөрт шурган орсонсон. Монгол бүсгүй гэхэд Холливудын шаргал үст, урт хөлт хүүхнүүдээс дутахгүй гоолиг биетэй тэр хүүхэн өөрийгөө Сэни гэж дуудуулах, хэтэвч зузаантай эрчүүдийг сэгсрэх, ууж наргиад л, бодож санах юмгүй хөнгөхөн амьдрах нүгэлгүй дуртай, бас хааяахан жижиг шоунд загвар өмсчихдөг, хамгийн гол нь таалагдсан эрийнхээ өвөрт эрээлж цээрлэх юмгүй шуудхан гулсаад орчихдогийг нь Итгэл танилцсан шөнөө л мэдсэн ч сурсан зангаараа хагас сар үерхсэн юм. Хэдийгээр Сэлэнгээ түүнээс салах бодолгүй байсан ч Итгэлийн хувьд тэр муужгайтай түүнээс илүү удаан зууралдах сонирхол төрөөгүй юм. Хамгийн сүүлд хамт хоноод өглөө нь яаж өөрөөс нь төвөг багатайхан шиг салдаг билээ гэж бодож хэвтэхэд нь тэр муур мэт суганд нь шигдэн хоёулаа маргааш уулзах юм уу? Хэмээн нялуурахад амнаас нь ханхийсэн тамхины үнэрт дургүй нь хүрсэн Итгэл нөгөөдөр нөгөөдөр гэж хэлээд л тэр чигээрээ бултчихжээ.

Тэр өдрөөс хойш Сэни залуу руу залхтал залгасан ч Итгэл ганц ч хариу өгсөнгүй. Дараа нь хувь тавилан түүнийг үйлийн үрт дурлалтай нь учруулснаас хойш бол мэдээж Сэниг ор тас мартсан билээ. Тэр татварын хэлтсийн шатаар уруудахдаа ядаж байхад бас юун Сэни мэни вэ? Хэмээн бухимдсаар машиндаа оров.

Түүнийг галзуу юм шиг давхисаар жижигхэн өрөөндөө очтол Батбаяр, Жака 2 нь хуучин компьютертэй ноцолдчихсон дүү нь утасныхаа тоглоомоор зугаацаж суулаа. Буланд байдаг ширээндээ суугаад л урьдынх шигээ овоорсон бичиг цаасийг нь зайчилсан ч үгүй шуудхан Аянга хаачваа, татвар матвараас дуудаад байхад алга болчих юм гээд хэтэвчээ гарган дүүдээ мөнгө гаргаж өгөв. Охин ч манай ах ийм сайн гэсээр гарч одлоо. Жака засч байсан компьютерийнхээ цаанаас цухуйн доогтой хараад – Манай захирал яасан ууртай байхийн? Тэгээд татварын байцаагч юу гэж байна? Хэмээн хэрэгт дурлахад Батбаяр хийж байгаа юмнаасаа харц салгалгүйгээр – Чи данснаас мөнгө авах гэж байгаагаа Итгэлд хэлээгүй юм биш биз дээ? Аягүй бол тэгээд л татвараас дуудаа биз хэмээхэд Жака браьж байсан дискээ унаган толгойгоо барьж – Ээжийг гуйгаад байхаар нь компаны дансыг өгчихсөн юм байна ш дээ. Таг мартчихаж. Тэгээд мөнгө орчихсон байна уу? Би чамд хэлэх гэж байгаад мартчихжээ хэмээн гаслав. Сая л ширээн дээрхи эмх замбараагүй цаасыг анзаарсан Итгэл түргэн түргэн нэг тийш нь овоолох зуур – Дансанд хөдөлгөөн оруулахгүй байсан бол татвараас дуудахгүй ганц улирал болох байсан юм. Чамаас болж байгаа юм, чи өөрөө учрыг нь олоорой гээд тооны машин шүүрч авлаа. Гаднаас Аянга, Заяа 2 ч ороод ирлээ. Аянга цүнхээ Итгэлийн ширээн дээр шидээд – Хэн дансанд мөнгө хийсэн бэ? Одоо татвараас.. гэж хэлж дуусаагүй байхад Заяа – Хүүш ээ, Итгэл ээ Чи аан гээд уун гэж бай. Татвар матвар ёстой сонин биш байна. Би чамд жинхэнэ сурприз барих гэж байна гээд учиртайхан инээмсэглэж Итгэлийн өмнө очиж – Хайртыг чинь олоод өгвөл намайг юугаар шагнах вэ? Гэлээ. Итгэлийн харцанд найдварын гэрэл асаж – Дуртай юмыг чинь өгье. Нээрээ чи тэр охинтой тааралдсан юм уу? Эсвэл худлаа яриад байгаа юм уу? Гээд босоод ирэв. Аянга хажуунаас нь – Чи эхлээд Заяаг юугаар шагнахаа хэл. Юм баталгаатай нь дээр гэхэд Батбаяр ёжтой инээмсэглэн – Наад Аянга чинь аягүй бол Заяатай чамайг гэрээ хий гэх нь шивдээ, бушуухан нэг юм амлаж байгаад хэлүүлчихдэг байгаа гэлээ. Итгэл ч нүд нь сэргэчихсэн – За Заяа тэгээд чи юу авах юм бэ? – Үнэртэй ус гээд Заяа тас тас хөхрөн - - Би чамд тэгвэл янзын гоё Босс авч өгье – Үгүй ээ, Christian Dior л гоё. – За за тэгье ээ, тэр эмнэлгийг нь бушуухан хэлээд өгчих гээд Итгэлийг Заяагийн мөрөөр тэврэн дотночилоход Заяа – Тоголсон юмаа. Чамаас юу гэж үнэртэй ус мус авч байх юм. Тэр охин чинь Ачлал эмнэлэгт ажилладаг юм билээ. Асрагч гэсэн. Би өнөөдөр ээжийн шинжилгээний хариуг авах гэж яваад тааралдсан. Яг мөн л байна лээ. Чамайг хүүхэн эргүүлэхдээ манай Аянгыг уруу татахаа больсоныг бодохоор харин би л чамайг шагнамаар байна гэлээ. Татварын тайлангийн хүснэгт шагайж суусан Аянга – Заяа ямар тэнэг юм бэ? Хүн юм авч өгье гэж байхад Итгэл ээ, Заяа өөрөө хэрэггүй гэсэн ч чи нэгэнт эмэгтэй хүнд амалсан юм чинь тэр үнэртэй усыг нь авч өгөөрэй. Хэдэн мянган төгрөг хэмнэгдчихлээ надад сайхан л байна гэж хэлэхээ мартсангүй. Тэгэхэд нь Заяа - Өөдгүй амьтан чинь чи надад үнэртэй ус авч өгөхөөсөө нарийлаад байгаа юм уу хаашаа юм? Хэмээн хэрэлдэж эхлэхэд Итгэл машинийхаа түлхүүрийг шүүрч аваад үгийн солиогүй ухасхийн гарахад үнэнчээрээ Батбаяр хойноос нь хүрмээ сугавчлан гарлаа. Ажил тарах дөхөж, бараг алхам бүрд зам бөглөрөх нь залуугийн яарсан сэтгэлээр даажин хийх шиг...

Тэгэж бөглөрөн зогсч байхдаа Итгэл – Баагий, мань нь та нарт шал тэнэг харагдаж байгаа байхдаа , чи яг үнэнийг нь хэлээч гэж зуур зам товчлох санаатай хашлага даван харайлгав. Гэтэл тээр тэнд замын нөгөө талд халуунд нозоорон зогссон цагдаа яг энэ мөчид шүгэл тачигнуулан хүрээд ирлээ. – Хүлээж л байхгүй, ингэж байгаа хүн чинь тэнэг харагдахгүй ядаг юм гэж Батбаяр үглэв. Энэ бол түүний хувьд дээд зэргээр бухимдсаны илрэл билээ. Ингээд

мань 2 торгуулчихав. Ийн мунгинасаар эмнэлэг дээр очиход нь өнөө мөрөөдлийн бүсгүй нь аль хэдийн тараад явчихсан байсанд Итгэл золтой л уйлсангүй. Ядаж байхад өнөө жуулчны бааз дээр танилцсан Сэни утасдсанд Итгэл - Итгэл утсаа сольчихсон. Битгий утастаад бай, мэдэв үү гээд машиндаа сууж хаазаа гишгэлээ.

Энэ өдөр Итгэлийн хувьд хайртай бүсгүйнхээ сургийг гаргаж баярласан ч ам мөлтөс зөрж, бас татварын байцаагчид дуудагдан уураа барсан сонин өдөр болж өнгөрөв. Тэр 2-ийг урам муутайхан буцаж явтал Аянга залгалаа. – Итгэл ээ, манай данс руу энэ Жака гэдэг юм чинь 560 мянган төгрөг оруулчихсан байнашдээ. Одоо ирэх сард тайлангаа татварт гаргаж өгөх боллоо. – Тэгээд хэдэн төгрөгний татвар төлнө гэсэн үг вэ? – Энэ 560-аас 10% нь гэж үзэхэд 56 мянга, тэгээд нэгэнт үйл ажиллагаа эхэлчихсэн гэж үзээд бид 4-ын цалингаас хүн амын орлогын 10% төлнө. – За за больё, намайг машин барьж явахад муу мэдээ дуулгаж байхаа болиоч гээд Итгэл утсаа хажуу тийш нь шидчихлээ.

Харин Намуун ажлаа тараад эмээгийн дээ очлоо. Ажилдаа орсноосоо хойш тэр эмээгийн дээ байгаа билээ. Тэр аав ээж 2-тоо ажил хийж байгаагаа хэлэлгүй тас нуужээ. Түүнийг ороход өдрийн сонин гарчиглан суусан эмээ нь – Миний охин тараад ирэв үү? Эмээ нь будаатай цай чанасан, суу даа гээд гал тогооныхоо өрөө рүү оров. Намууныг гараа угаагаад ирэхэд эмээ нь цай аягалчихсан сууж байснаа – Охин минь, царай чинь ядрангүй харагдана. Хичээлээ л сайн хийхгүй ажилд орох хэрэг байсан юм уу даа? Эмээ нь чамтай хуйвалдсанаараа дараа нь хэрэгт орохвийдээ. Ээж чинь өдөр утасдаад л байна лээ. Чамайг өдөр утсаа салгачихдаг боллоо. Ээж та Намууны юу хийгээд явааг мэдэж байгаа юм уу энэ тэр гээд л байналээ. Сэжиг авчихсан байж магадгүй шүү. Охин минь ээждээ үнэнээ хэлчихгүй юм уу? Эмээ нь зээ охиныхоо нүд рүү нэг талаар хуйвалдагчийн, нөгөө талаар үнэнээ хэлчихээч гэж гуйсан харцаар харан байж хэлэв. – Эмээ, ингээд хуйвалдсан шиг хуйвалдчихаж чадахгүй нууц алдах гээд байдаг шдээ гэж бүсгүйг тунирхуу хэлэхэд эмгэн инээмсэглэн өөрийнхөө аяганд цай хийнгээ – Энэ хөгшин толгой худлаа хэлж сурахгүй юм аа, хүүе хүүхээ эмээгийнхээ өгсөн бугуйвчийг яагаад зүүж харагдахаа болио вэ? Дүнчүүр маани уишсан эрхний үлдэгдэл миний охинд сайн л байх учиртай гээд гар руу нь харжээ. Баларсаан гэж Намуун бодоод – Ажил хийж байгаад хаячих байх гэж бодоод л гэсэнээ яриаг нь дүйвүүлэн – Эмээ, та манайд очоод бид 3-тай байж болдоггүй юм уу? Хасаа эгчийнхийг бодвол манайх хамаагүй зайтай юм чинь, танийг ганцаараа болохоор би санаа зовоод байх юм. Тэгээд дандаа таньтай байгаал байхаа ээж, аав 2 бас гомдчих юм. Ээж зүгээр ядаж 2 хүүхэд гаргачихгүй...- Танайх ч үнэхээр сайхан том байшинтай л даа гэсэнээ эмгэн санаа алдан цайгаа тавьж – Гэхдээ миний хүү, хар гэртээ хаан, бор гэртээ богд гэдэг. Өвгөн бид 2 энэ байранд насаа элээсэн. Галийгаачаас хойш ганцаараа ч гэсэн өөрийн гэсэн гэр орондоо дураараа байх нь эмээд нь сайхан байдаг юм. Ээж чинь хүргэн ч бас намайг хамт байя гэдэг. Яхав, эмээ нь танагаа тасраагүй дээр гэртээ л байя. Энэ гадаа өвөөгийн чинь тарьсан мод хүртэл байж байна. Тэрийг нь би л услах юм хэмээн хуучилснаа гэнэт ухаан орсон мэт аяганд нь дахин цай аягалж толгойг нь илжээ. Намууны ээж Наран энэ яриаг дуулбал * Ээж зөнөж байна. Өвгөний тарьсан мод ч гэх шиг. Аавын чинь өөрөө авчирсан хонх гээд энэ аймар орос хонхоо ч солихгүй. Бас элэг муутай хүн хуурсан хйарсан тостой юм идэж болохгүй гээд байхад будаатай цай уугаад л . Үгэнд ерөөсөө орохгүй юм. * гээд л үглэх байсан билээ. Үнэндээ эмээгийн нь элэг муутай болохоор будаатай цай чанаж уухийг эмч тас хориглосон ч ийнхүү сэм сэмхэн чанаж уудаг хэвээрээ. Түүнийг нь Намуун болиулахын оронд хуваагаад л уучихна. Хариуд нь эмгэн зээ охиныхоо элдэв нууцыг хадгалах үүрэг хүлээнэ.

Бүсгүй өрөөндөө нэг мэдэхэд Итгэлийн тухай бодчихсон хэвтэж байлаа. Уг нь аагүйнхаа

зөвлөснөөр банк-нд дадлага хийж байх ёстой хүн ингээд эмнэлэгт худлаа нэрээр асрагч хийгээд ээж, ааваасаа бүх үнэнээ нуудаг нь юу билээ? Арай тэр залууд сайн болчихсон юм биш биз дээ? тэгээд л түүнтэй танилцах гээд тэр эмнэлэгт асрагч хийж жүжиглээд түүнийг ирэхийг сэтгэлдээ харуулдаад... за за больё шал тэнэг юм. Ер нь хэд хоногоос ажлаасаа гардаг ч юм бил үү? харин хайран бугуйвч Жавхаагаас л болж байгаа юм гэж элдвийг хаман бодож хэвтсэн чинь өвөөгийнх нь өнөө орилоо хонх тасхийн бодол нь тасарчихлаа. Эмээтэй нь мэндэлж байгаа дуу Жавхаа мөөн.

- Алтаа, юу хийж байна гэсээр тэр инээчихсэн орж ирэв. - яахав дээ. Пушкиний *тариачин авхай* болох гэж үйлээ үзэж байна. чи бид 2 шал тэнэг юм хийчихсэн ч юм шиг. ээж гайхаад л байгаа. би ч худлаа хэлэхээс залхаж гүйцлээ зүгээр. - Нараа эгч чамайг эмнэлэгт асрагч хийж байхийг харах юм бол шууд ухаан алдаад унана даа гээд Жавхаа тас тас инээснээ буйдангийн хажууд тавиастай хөгжим рүү ухасхийн долгионийг нь тааруулах зуураа - сонин ихтэй. одоо сонс доо гээд ФМ-ийн хотлогч залуугийн ялдамхан мөртлөө нялуун мэндчилгээ хөвөрлөө - за энэ биш, одоо яг гэж Жавхаа үглэн долгионийг нь солино. *Хамгаас хайрт, олноос онцгой хөөрхөн найз бүсгүй Намуундаа намайгаа уучлаач, би чинийхээ наргүй өдрийн нар нь, саргүй шөнийн сар нь болж явъя* гээд Х гэдэг нэгэн залуугаас цаг тутамд *намайг битгий уучил* дуугаар мэндчилгээ хургэж байна гэх нь тэр.. Хасар Намуунийг зүгээр орхихийг хүсэхгүй байгаа бололтой. Намууний дургүй хүрч хөгжмийнхөө товчлуурийг таг хийгээд нь дарлаа..

Жавхаа найзийнхаа дургүйцлийг мартагнуулах санаатай - за тэгээд ажил хийх ямар байна даа? Нөгөө ууртай сувилагч чамайг хорлож байна уу? гэхэд - яахав дээ, аймаар хэцүү юм аа. Энэ сараа дуусгаад больё гэж бодож байна. Бодоод байсан чинь би одоо тэр нэг юмтай / Итгэлийг хэлж байгаа бололтой/ танилцах гээд л аягүй баярлачихсан тэнд асрагч хийгээд байгаа юмуу хаашаа юм. - за яадаг юм бэ, Хасараас сайхан залуутай яваад шээсийг нь гоожуулах хэрэгтэй ш дээ. тийм биз дээ? цаадах чинь өнөө маргаашгүй л чамайг олоод очно харж л байгаарай. Надад тийм залуу дурладаг ч болоосой. За за больё, найддаа атаархсан болох нь. Чи надад энэ сэтгүүлийн материалыг орчуулаад өгөөч - Алив үзье, хэзээ хэрэгтэй юм бэ? - Маргааш найз нь эдийн засаг дээр рефераттай. - Чи дандаа цагийг нь тулгаж байх юм - чи мундаг юм чинь ганцхан цагт л орчуулчихна даа...

Жавхаа нэгэн хувийн дээд сургуульд дэзайн загвар зохион бүтээгчийн мэргэжлээр сурдаг билээ. Тэр таараар нэхсэн чамин цүнхнээсээ "Far eastern economic review" сэтгүүлийн нэг дугаар гарган сарвайлаа. Тэр Намууний занг дэндүү сайн мэднэ. Намуун өөрөөс нь мөнгө зээлдүүлэхийг гуйсан хүүхдүүдэд маш их уурлан *би ямар бнак юмуу* гэдгийг нь мэддэг болохоороо үе үе иймэрхүү тусламж гуйчихна. Намуун сэтгүүлийг аув зүүн өмнөд Азийн эдийн засгийн сэргэлтийн тухай өгүүллийг гүйлгэн хараад - Хүнд хүнд үгтэй л юм байна. За яйхав, би орой л суухаас. Хариуд нь чи надтай хамт бассэйн явна даа гээд залхинаар инээлээ. Энэ үеэр Намууний гар утас дуугарав. Харвал ээж нь дугаар нь гардаггүй утаснаас залгаж байлаа. - За баларсаан. Ээж намайг сэжиглэж байгаа юм гэсээр Намуун утсаа авлаа. Ээж нь миний охин юу хийж байна хэмээн өнгөн дээрээ их л зөөлөн дуугарсан ч цаанаа нилээд шүд зууж байгаа бололтой. Тэр охинтойгоо харилцахдаа дандаа 2-дмол ааш гаргана. Нэг талаар угийн хатуу зан нь илрэн Намуунийг тас барих гээд байдаг мөртлөө, нөгөө талаар хорвоо дээр төрүүлсэн ганц үр гэсэн халуун хайраа дийлдэггүй юм. Тийм зан нь хөдлөхөөрөө гадаад яваад ирэхдээ нэртэй том том фирмийн үнэтэй хувцаснуудийг бөөн бөөнөөр нь авчирч өгнө. Тэгснээ л гарч орохийг нь цагдаад л сар бүр картанд нь хийж өгдөг мөнгөө багасгаад, юунд

зарцуулснийг нь байцааж багахан галзуураарай гэж байгаад загнаж гарна. Намуун харин ажилд орсон энэ хэдхэн хоногт картнаасаа ганц ч төгрөг авсангүй. Тэр мөнгөний үнэ цэнийг урьдийнхаасаа илүү ойлгодог болжээ. Түүний нэг л орой найзуудтайгаа үрчихдэг мөнгийг бусад хүмүүс бүтэн сар шал угааж, ээлжинд гарч байж олдгийг мэдэх болсон юм чинь. - Ээж би Жавхаатай хамт бассэйнд орох л гэж байна. - Утсаа яагаад салгачихаад байна? – Юу, манайх сэминартай байсан юм. - За боль боль. Би Оргилийг явуулсан чинь танай анги тарчихсан л байх чинь билээ. Хэрэг бишдээд ирэв. Намуун найз руугаа нүд ирмээд – Ээж ээ, 2-уулаа орой тухтай ярья тэгэх үү? Та битгий бухимд л даа, ядарчихна. Би орой хариад танд мөөгтэй хуурга хийгээд тавьчихнаа. Ээж нь энэ үгэнд нэлээд зөөлрөв бололтой. Инээд алдаад - Эмээгийн дээд бүгчихээд л юу л хийгээд байна даа.

Санаа зовоочих юм. 5-6 настай байхдаа л ямар сайхан байсан юм бэ? Элдэв хэл ам татлахгүй. За орой гэртээ ирээрэй гээд утсаа тавьлаа. Намуун бүр багаасаа ээжийнхээ дуртай мөөгтэй хуургийг янзын сайхан хийдэг юм. Цонхоор харахад Богд уулийн мод шав шарлаад нэг л уйтгартай. Эмээгийнх нь байрны урдахь хөгшин улиас том том шар навчаар уйлж байна уу даа гэмээр харагдана. Намуун хөнгөн санаа алдаад цонхноосоо холдов.

Тэр 2 Намууний 2 хаалгатай машинд суун хөдлөв. Жавхаа машинд суух зууртаа хэдэн том навч түүчихжээ. - 2-уулаа маргааш парк орж навч түүнэ шүү. Би дан навчаар чимэглэсэн нэг авангард загвар хийх гэж байгаа юм. Харин нэр олдоггүй ээ. Ээждээ худлаа хэлээд тэр дороо ёстой л газар дээрээ баригдсандаа сэтгэл нь шаналсаар явсан Намуун найзийнхаа навч түүснийг анзаарсан ч үгүй. Тэр сая л Жавхаагийн гар дахь навчийг харж - Тийм үү, сайхан л санаа байна. Даанч би ажилтай ш дээ... - Өө тийм, мартчихаж. Тэр 2 багадаа 2-уулаа зургийн дугуйланд явдаг байж билээ. Тэдний ангид зургийн хичээл заадаг Ганаа гэж залуухан багш мань 2 охинийг зурганд дуртай болгочихсон юм. Ялангуяа Намуунийг дугуйлангийнх нь багш ч, Ганаа багш нь ч *гартаа хоосонгүй, өнгөнд нүдтэй* гэж магтдаг байсан тул зураач болохийг мөрөөддөг хүүхэд байсан юм. Даанч ээж нь эрс дургүйцэн 8-р ангиас нь эхлээд дугуйлангаас нь гаргачихаж билээ. Ээжийнх нь бодлогоор зураач нар бүгд дампуу, бас мангар улс. Энд тэнд уншсан, сонссоноосоо өөртөө хэрэгтэйг нь марталгүй үлдээж чаддаг ээж нь Орост сурч байхдаа Гойя, Ван Гог гээд лав 2 зураач галзуурсан юм гэнэ лээ гэж тогтоожээ. Түүнийхээр бол охин нь элдэв хачин хувцас өмссөн бийр будаг үүрч явдаг зураач лав болох ёсгүй бөгөөд өөртэй нь адилхан эдийн засагч эсвэл бараа судлаач байх ёстой. Одоо Намуунд Шишкин, Пэпинний зургийн албум, хатсан гуаш л үлдсэн. Гэхдээ үе үе уйтгартай байхдаа ганц нэг таталбар хийчихдэг нь хэвээрээ. Харин Жавхаа нь дугуйландаа явсаар хувцас загварийн ангид орсон. Өөрөө ч урьд нь зураг сонирхож явсан болохоор Намуун найзийнхаа элдэв загвар зохиоход нь туслах дуртай. Тэр шөнө Итгэл нойргүй хоножээ. Сарын турш сэтгэлд нь уяатай байж, анхны хайрын гэгээн тамлалыг амсуулсан тэр охинтой маргааш уулзана гэхээс л цурам хийсэнгүй. Шөнийн 3 хүртэл хөл бөмбөг үзэж суугаад орондоо орсон ч эргэж хөрвөөсоор өглөө 6 болгочихов. Өглөө яагаа ч үгүй босоод хувцасны шүүгээгээ ухаж гарахад нь ээж нь шагайлаа. Уг нь нойронд янзын сайн хүү нь ойрд ийнхүү яагаа ч үгүй босчихдог болсонд ээж нь нэлээд гайхаж байлаа. Нэг бодлын өглөө бүр татуулж чангаалган бараг л ус цацуулах шахаж байж арай гэж босдог хүн ингэж хүмүүжсэнд баярламаар ч , найз охинтой болж, нэг л өдөр авгай авна гэх вий гэхээс санаа зовмоор. Тэр нь ямаршуу айлын хүүхэд байгаа бол доо? Нөгөө загвар магвар өмсдөг айхтар охидуудын нэг байвал яанаа гээд ээжийнх нь санаа зовохгүй юм гэж үгүй... - Миний хүү настай эмээ шиг өглөө яагаа ч үгүй

босчихдог болоо юу? - Би өглөө эрт жаахан юм хийх санаатай гээд Итгэл янз бүрийн цамц гарган үзсээр зогсов. - За за, ганган хүний үхэл хавар намартаа гэгчээр дулаахан л явж үзээрэй гээд хаалгыг нь зөөлхөн хаагаад охиноо сэрээхээр нөгөө өрөө рүүгээ орохдоо *яг л нэг охинтой болсноос зайлахгүй, дүүгээс нь асуувал мэдэх бол уу* гэсэн бодол орж ирэв. Гэвч нойрмог нүдэлсэн охин нь ахынхаа найзын тухай юу ч мэдэхгүй байлаа. Итгэл ч ээжийнхээ хэрэгт дуртай зан хөдөлснийг анзаарсан ч үгүй. Дүүгээ өрөөндөө дуудан - Ах нь өнөөдөр нэг охинтой уулзах юм. Яаж хувцаслах бэ? хэмээн асуув. Охин дүү нь - Ааа, ах найз охинтой болчихож. Тэгээд хөөрхөн юмуу? хэмээн хэрэгт дурлахад - За за ээжид битгий хэлээрэй дээ, хурдхан шиг нэг цамц сонгоод өг хэмээн шавдуулав. Гэвч охин дүүгийнх нь сонгож өгсөн цамц нэг л сэтгэлд нь таалагдсангүй тул өөртөө таалагдсан нэг улаан цамц гарган өмсөөд тольдож тольдож гэрээсээ гарчээ. Өглөө гэрээсээ гарахаасаа эхлээд л тэр охинтой уулзаад юу гэж хэлэхээ бодсоор явжээ. Урьд нь хүүхнүүдтэй үг хэлээ ололцож ядах юмгүй л байсан санагдах боловч одоо тэр бүсгүйтэй уулзаад яриагаа яаж хэлэхээ бодоод бодоод олсонгүй. Сайн байна уу, би бугуйвчийг чинь өгөх гэсэн юм. Үгүй ээ, сайн байна уу, намайг Итгэл гэдэг, 2-уулаа танилцъя. Үгүй ээ, ингэж лав хэлэхгүй. Жака хажууд байвал яаж татаж унах болоо. Сургууль дээр очоод 3-н паар хичээл яаж өнгөрснийг ч мэдсэнгүй. Англи хэл, мэргэжлийн хичээл орсон, цаг өнгөрч өгөхгүй зовсоноо л санаж байлаа. Байн байн нөгөө шүрэн бугуйвчийг хийсэн энгэрийнхээ халаасыг тэмтэрсээр байгааг нь Жака аль хэдийн харчихсан - Хайр майр гэж байдаггүй гэж олны өмнө ам гарчихгүй л юм сан. Манай Итгэлийг дурлалын бурхан хашрааж байгаа бололтой хэмээн ангийнхандаа ярьж байлаа. Хичээл тараад тэр 3-ийг гарч явтал Аянга ярив. Бүүр Адам, Ева, Юндэн Нансалмаагийн үеэс л эрчүүдийг зовоож ирсэн түгшүүрт аз жаргал. Сэтгэлээ нээнэ гэдэг нууцхан даваа Итгэлийн өмнө дунхийж байлаа. Ихэнх эрчүүд хайрын үгээ хэлэхдээ зүрх алдан найз нараа хань татан дагуулдаг бичэгдээгүй хуультай байдгийг мань эр ч зөрчсөнгүй. Үнэнч дагуул Баагийгаа дагуулан эмнэлэг рүү хөдлөв. Ингээд сэтгэлийнх нь шүтээн болсон тэх охинтой уулзах мөч тулаад ирэхээр дэндүү барьц алдаж байгаагаа л мэдэрч байв. Хайр гэж үнэхээр сонин эд бололтой. Замын 2 талаар эрээлжлэх сурталчилгааны самбарууд дээрхи будмал солонгос хүүхнүүд бүгдээр зөвхөн түүнд зориулан ялдамхнаар инээгээд ч байгаа юм шиг, сэтгэлд нь багтаж ядсан баяр хөөр бялхан нэг ирснээ, яаж ногоо халуун үгийг хэлнэ дээ гэж бодохоос хэдэн мянган хүний өмнө нүцгэн гарах гэж байгаа юм шиг зурх нь цээжиндээ багтахгүй цовхчин дэлсээд л явтал нэг мэдэхэд нөгөө эмнэлгийн гадаа ирчихжээ. Өглөө гэрээсээ гарахдаа ямар хувцас өмсөхөө мэдэхгүй гайхаж гайхаж сүүлдээ Дизэл фирмийн шинэ цамц угласан билээ. Гэтэл одоо анзаарсан чинь час улаан цамц сонгоод өмсчихсөн нь нэг л тэнэг санагдана. Харамсалтай нь шүрэн бугуйвчны эзний булбарай гарыг атгах аз бас л дутах ёстой байжээ. Эмнэлэг дээр очоод яхир зантай нь харваас л илт жижүүр өвгөнөөс Алтаа асрагчийг асууж байхад Намуун аавийнхаа туслах Оргилийн хамт шив шинэхэн Форд Экспэдишн тэрэгний арын суудалд хөмсөг зангидан сууж явлаа. Түүнийг хичээл тараад эмнэлэг рүүгээ гарах гэтэл ээж нь утасдан яаралтай ирж уулзах лүндэн буулгаж аавийнх нь туслахыг илгээсэн нь энэ. Өөртэй нь насаар ойролцоо, хэнтэй ч эвлэгхэн харилцаж чаддаг болохоор Намуун Оргилоос асууя гэсэн юмаа асуучихдаг билээ. - Оргил оо, ээж яах гэж намайг дуудсан юм бол? гэж бүсгүй нухацтай асуув. Жолоочийн хажууд суугаад гар компьютерээ шагайж явсан Оргил толгой өндийлгөн нүдний шилээ зассанаа - за би ч нарийн мэдэхгүй л байна. Наран захирал ойрдоо чамайг их анхаардаг болоод байгааг л сайн мэдэж байна. - Ээжийн ямар зан хөдөлсөн юм бол доо. Эсвэл миний тухай ямар нэг юм сонссон юм болов уу? Чамайг сургууль руу явуулахдаа юу гэж байна? гэж Намуун улам хэрэгт дурлав. -

Мэдэхгүй ээ, Намууныг олоод ир гэснээс өөр юм хэлээгүй. Ер нь ч юм хэллээ гэхэд амаа цоожтой л байлгах үүрэгтэй хүн шүү дээ би. Залуу үүгээр яриа дууссаны тэмдэг болгон компьютерээ шагайв. Тэр бол өөрийнхөө ажил хэрэгч хүн гэдгийг байнга батлахыг оролддог зантай хүн. Хамгийн сүүлийн үеийн Сони маркийн гар компьютерээсээ сална гэж үгүй. Компаний бүх ажил хэргийг зохицуулах, Намууны аав, ээж 2-ийн өдөр тутмын ажлын хуваарийг гаргах, захирлийн туслахын ажлаасаа гадна маркетингийн төлөвлөлтийн хэлтсийг давхар удирдах гээд түүний хүрэлцэхгүй, оролцохгүй юм гэж үгүй. Насаар Намуунаас 2-3 ах мөртлөө костюм, зангианаас сална гэж байхгүй, үргэлж ажил ярьж явдаг, үнэтэй шилнийхээ цаанаас бүх юмыг гярхай нүдээр ажиглаж, өрөмдөх мэт цоо ширтэж явдаг энэ залууг компанийн захирлийн сүүдэр гэж далдуур хочилно. Харин Намуунд бол тэр юу бодоод байгаа нь мэдэгдэхгүй, наснаасаа эрт муу санаа суучихсан залуу шиг санагддаг. Оргил түүнтэй захирлын охин учраас л овоо нэг залуу шиг элэн далангүй ярилцдагаас биш толгойд нь дандаа л компаний ажлын хүснэгт зураастай мэт санагддаг билээ. Намуун ажил руугаа залган шүд өвдөөд өнөөдөр очиж чадахгүй болсон тухайгаа хэлж чөлөө авч амжлаа. Тэгээд л аавынхаа компаний шинэхэн саарал байшингийн гадаа ирчихсэн байв. Намуунийг энд ирэхэд үүдний харуулаас эхлээд л бүгд захирлын охин, ирээдүйн эзэн гэж биширсэн, зарим нь атаархсан нүдээр харцгаадаг тул бүсгүй энд ирэх төдийлөн дуртай байдаггүй билээ. Яг түүний ард чив чимээгүй явж байсан Оргил ээжийнх нь өрөөний үүдэнд ирээд хаалгыг нь онгойлгон шагайж - Намуун ирчихлээ гээд түүнд зам тавьж өгөв. Гэтэл ээжийнх нь өрөөнд хэн хүлээж байсан гэж бодно. - Хасарын ээж Нансалмаа тамхи татан сууж байснаа Намууныг хараад тамхиа үнсний саванд шидчихээд нүднийх нь харцанд илрээд байгаа хүйтэн гялбааг хүчээр арилган инээмсэглэн - За, Намуунаа охин сайн уу? гэж мэндлэв. Намууныг хариу мэндэлж амжаа ч үгүй байхад ээж нь утсаар ярьж байснаа тасалчихаад охин руугаа ширүүн дуугаар харж - Хасар та 2 муудалцаа юу? Нансаа та 2-ыг эвлэрүүлэх гээд гуйж явдаг нь ямар учиртай юм? гэлээ. Хамаг учир Хасар тэр 2-ын муудалцсанд ч биш, өөрөөс нь нууцаар нэг хачин юм хийгээд яваад байгаад л ундууцсандаа ингэж Оргилоор дуудуулж барьж сүржигнэж байгааг нь бүсгүй сайн ойлгож байлаа. Мэдээж Хасарын ээж хүүгээ буруутган баахан үглэж, - Охин минь, цаадах чинь гэнэхэн амьтан. Та 2 хар нялхаасаа үерхэж бараг л нэг гэрт орох дөхсөн улс. Учраа ололц хэмээн ятгачихаад явав. Харин Намууны сэтгэл нэгэнт эзэндээ захирагдахаас өнгөрснийг яг тэр мөчид л тэр ойлгож билээ. Ээж нь ч бас баахан лекц уншаад Хасартай эргэж үерх, хичээлийн дараа утсаа таслаад хачин юм хийхээ болихыг шаардав. Ээж нь дургүйгээ хүрэхээр хачин юм гэдэг үгийг хэлдэг зантай. Аавыг нь заримдаа компанийхаа залуухан хүүхнүүдтэй хардахаараа тэр хачин юмаа маргааш гэхэд зайлуулаарай гэнэ. Тэгээд л маргааш нь хөөрхий тэр хүүхэн ажилгүй болж байсан удаа нэг биш гарсан билээ. Үнэндээ ч баян нөхөртэй болчих далдын санаатай тэдний компанид шургалаад аавд нь сээтэн хаяж байсан хүүхэн нэгээр тогтоогүй гэлцдэг юм. Бүсгүй ээжийнхээ өрөөнөөс гараад сургуулийнхаа номын санд очиж рефератаа бичиж баахан суув. Хачирхалтай нь сэтгэл зүрх нь дэнслээд нэг л сонин байлаа. Үнэхээр далдын нөлөө, зөн совин гэж байдаг бол Итгэл ч бас түүнийг бодон компьютерийнхаа ард дүнхийж суусаар өдрийг өнгөрөөсөн билээ. Тэр 2-ын учралыг бурхан яагаад хойшлуулаад байгааг чөтгөр л мэдэх биз ээ. Намууныг номын сангаас ирэхэд гайхалтай юм болов. Юу гэвэл ээж нь аль эрт ирчихсэн гал тогооны өрөөндөө салат хийчихсэн сууж байв. Ээж гэртээ ирээд гарын салатаа хийнэ гэдэг түүний хувьд эрт багын дурсамжинд л байсан явдал билээ. Ээж нь өнөөдөр гэрийн үйчлэгчээ явуулчихаад өөрөө хормогч зүүчихсэн будаа агшаагаад зогсч байхыг харсан Намуун эхлээд нүдэндээ ч итгэмээргүй санагдаж - Юу вэ энэ чинь, та мөн үү? Арай аав бас ирчихсэн юм биш биз дээ?

хэмээн хөгжилтэй байгаа дүр үзүүлэхийг оролдов. Ээж нь хормогчоо тайлан том хүнхэр тавганд хийгээд - Гараа угаагаад хоолоо ид. Аау чинь нутгийн зөвлөлийн хуралд явсан ээжид нь чамтай ярих юм байна гэв. Хэдийгээр тэр хоол идмээргүй байсан ч ээжийнхээ урмыг бодоод алимтай, загастай салатнаас ганц тавгийг цааш нь хийж дөнгөв. Түүнийг салатаа идэж дуусангуут ээж нь нүд рүү нь цоргитол ширтэж - Хасартай яагаад муудаа вэ? Өдөр Нансалмаагийн хажууд хамаагүй юм ярихаасаа санаа зовоод л дуугүй өнгөрсөн шүү гэлээ. Намуунд хэлэх үг олдсонгүй. Ширээний цасан цагаан бүтээлэгний нэг буланг имрэн хэсэг сууснаа - Энэ тухай мэдэх хэрэг байгаа юмуу? Би яримааргүй байна гээд бослоо. - Суу, эхтэйгээ хэдэн үг солиодох. Намуун ээжийгээ ингэж аашлахийг их л ховор үзсэн билээ. Тэгээд ширээний дэргэд хөшөө мэт хөдөлгөөнгүй зогсон юу ярихыг нь хүлээлээ. - Чи Хасартай хар нялхаасаа нэг дор шахуу өссөн биз дээ? Одоо тэгээд юу нь болохоо боличихоод байгаа юм? Тэр хүүхдээс зугтах гээд л утсаа тасалж алга болоод байгаа юмуу? хэмээн асууснаа хариуг нь хүлээлгүй - Удам судраар нь мэдэхгүй ч гэсэн эцэг эхтэй нь сайн танил, нялхаас нь мэдэх болохоор би Хасарыг чамд таарах хань чинь болчихно гэж боддог. Аавыгаа дууриагаад эмэгтэй хүнд халамжтай, элдэв зангүй сайн л хүү шдээ. Эсвэл өөр хүүхэдтэй үерхээд байгаа юмуу, миний охин? гэж дуугаа зөөлрүүлэн ганцаараа яриад байгаа ч юм шиг асуухад нь Намуун - Ээж ээ, та миний амьдралд оролцох хэрэггүй юм биш үү? Тэгээд ч Хасар чинь шал хүүхэмсэг амьтан. Бас мөнгөнд дуртай гэснээ уурандаа хоолой нь зангирангуут угаалгын өрөө рүү алхчихлаа.

Уг нь ээждээ бүхнийг яричихвал дотор нь онгоймоор л байв. Даанч сүүлийн хэдэн жилд ээж охин 2-ийн хооронд боссон хана хэрмийг нураагаад сэтгэлээ онгойтол яричихаж чадсангүй. Аавынх нь хөрөнгөөс болж өөрийнх нь амьдралд бий болоод байгаа зовлонг ярьлаа гэхэд ээж нь яагаад ч ойлгохгүй. *чиний төлөө гэж хуруу хумсаа хуйхлан явж энэ бүхнийг босгосон нь гай болоо юу* гэж л хэлнэ.

Түүнээс биш баян айлын охин гэж эргэн тойрных нь хүмүүс нэг бол улыг нь долоох шахан долгиноод л, эсвэл атаархсандаа маргааш л эндхийх дампуураад модоо баричихаасай гэх шиг хүйтэн харцаар харж, багш нар ганц удаа даалгавраа хийхээ мартчихаад ирэхэд нь чамд мөнгөноос гадна мэдлэг хэрэгтэй л байх шүү гэх мэтээр хорон үг хэлэхэд хичнээн хэцүү байдгийг ээж нь ойлгоно гэж үү. Бүсгүй дээд давхарт гарч өөрийнхоо угаалгын өрөөнд ороод түгжчихэв. Тас хар гялалзсан хавтангаар өнгөлсөн хана, шал босоо хүний өндөртэй ханын толь, 3-н том хүнийг элбэг багтаах банн, душ бүхий энэ угаалгын өрөө түүний хувьд сэтгэл тавгүй үедээ хоргодох орон л гэсэн үг. Намуун бүүр 6-н настайдаа л ээжтэйгээ муудалцахаараа угаалгын өрөөндөө ороод түгжчихдэг хүүхэд байж билээ. Тэгэхэд нь ээж нь түүнийг угаалгын өрөөнөөс гаргахын тулд гэрлийг нь унтраачихдаг байсан юм. Охин харанхуйгаас их айдаг хүүхэд байсан болохоор хэсэг зөрүүдлэж байгаад айхын эрхэнд гараад ирдэг байж билээ. Сүүлдээ нилээн том болж 2,3-р ангид орсноосоо хойш Намуун угаалгын өрөөндөө гар чийдэн, лаа гэрэл аваачиж тавих болсонг ээж нь удтал мэдээгүй билээ. Тэгээд угаалгын өрөөндөө дотроос нь түгжээд гар чийдэнгийн гэрэлд зураг зураад суучихдаг байсан юм. Охиноо харанхуй өрөөнд удаад гарч ирэхгүй болохоор ээж нь сүүлдээ аргаа барж, миний хөөрхөн охин гараад ир, ээж нь сникерс өгнө шүү гэх мэтээр өөрөө аргадаж эхэлдэгсэн. Ер нь ээж нь хэзээ ч охиндоо гар хүрч байсангүй. Гэхдээ ганц охиноо ангийнхан дотор нь бүх юмаараа тэргүүлдэг мундаг онц сурлагатан байлгахыг хүснэ. Намуун 1-р ангиасаа хойш

дахин онц гарч чадсангүй ээжийнхээ урмыг их хугалсан билээ. Бүсгүй том босоо толинд өөрийгөө зэрвэс хараад онгоцонд ус дүүрэхийг хүлээн эвхмэл сандал дэлгэн суулаа. Өнөөдөр тэр Хасарын ээж Нансалмаа авгай яах гэж ээж дээр очдог байна аа? Шал хийх юмаа олж ядсан юм. Баян худтай болох мөрөөдөл нь замхарахаас айсан юм байх даа. Тэр Хасар гэж шог амьтан ээжийгээ явуулаад байхдаа яахав дээ. Бага байхын л хөвгүүд зодолдох болохоор ээжийнхээ араар ордог хулчгар амьтан байсан одоо ч хэвээрээ л байгаа юм. Намуун бол бүх талаараа биеэ даасан хүнийг л үнэлдэг. Харин тэр Итгэл ямархуу залуу бол? Арай Хасар шиг аав, ээжийнхээ араар ордог, дараа нь баян хадмын хаяа бараадах хүсэлтэй амьтан биш байгаа даа. Анх харахад хөлөөсөө толгой хүртлээ фирмийн хувцас өмссөн ганган амьтан байсан, бас мобикомын дугаартай. Үгүй ээ, хэрвээ Итгэл тийм байсан бол хувийн эмнэлэгт асрагч хийдэг ядуу охинтой танилцах гэж хөл алдан гүйх байсан гэж үү? Намуун бүлээн ус дүүргэсэн хөөстэй онгоцонд ийнхүү бодолд автан хэвтсээр нилээн уджээ. Түүнийг уснаас гарахад аау нь ирчихсэн зочны том өрөөндөө хэвтэж байж. Аав ирнэ гэдэг охины хувьд орой бүхэн сюрприз болдог байу. Одоо ч хэвээрээ. Тэр аавдаа үнсүүлээд хажууд нь суулаа. Ээж нь нүүрэндээ бигнүүр тавьж байгаа бололтой таг чиг. Аау нь чамд бэлэг авчирсан гээд - нүдээ ань даа гэв. Аав нь Намууны алган дээр юуг нь таахад хэцүү хүйтэн юм алган дээр нь тавьлаа. Нүдээ нээгээд харвал бяцхан саарал чулуу байв. Түүнийг аавынхаа царай руу асуунгүй харцаар харахад

- Дотроо устай чулуу, миний охин эргүүлээд үз, хол хол гэж дуугарна гээд аау нь инээлээ.

Нээрээ дотроо устай чулуу байлаа. - Баярлалаа аав аа. Аав нь буйдангаас өндийгөөд хуйвалдагчдын харцаар охин руугаа харж - Аав нь чиний нууцыг мэдсэн сайн байна, гэхдээ энэ сарыг дуусгаад ажлаасаа гараарай, ээж чинь мэдвэл бөөн юм болно шүү хэмээн шивнэх шахам хэлэв. Яг энэ мөчид ээж нь ороод ирэв. - Та 2 юугаа нуугаад надаас шивнэлдээд байна аа гэхэд аав охин 2 нүдээ ирмэлдэв. Энэ нь нууцаа хадгална шүү гэсэн дохио байлаа. Намууны аав Чимэд бол насаараа хангалуун элбэг дэлбэг амьдрах зураг төөрөгтэй төрсөн хүний нэг. Зах зээлээс л өмнө ганц хүүхэдтэй мөртлөө 3-н өрөө байранд тохилог амьдардаг нилээн овжин залуу байсан. Авгайтайгаа 2-уулаа нэг нэг яаманд ажилладаг тул цалин хангалттай хүрдэг. Гадаад яваад ирэхээрээ хөөрхөн наймаа хийнэ. Амьдралаас авахыгаа авч, хэрэглэхийгээ хэрэглэж үзээд л дуусна гэсэн хатуу үзэлтэй. Бурхан ч нэг их шүтээд байдаггүй. Энэ хүнд ганц шүтээн байдаг нь Намуун. Ганц охин үрийнхээ өмнө л түүний нугаршгүй хатуу зан хайлсан тугалга мэт зөөлөрч эхэлдэг юм. Ээж нь энэ орой охиноосоо ганц үг алдуулж чадсангүй. Гэхдээ үргэлж ажилтай гээд оройтож ирдэг аав ээж 2 нь урьдныхаасаа эрт ирж охин ч эмээгийнх рүүгээ гүйлгүй, халуун ам бүлээрээ сайхан байлаа. Бүсгүй унтахаар хэвтэхдээ аавынхаа өгсөн устай чулууг дэрнийхээ дэргэд тавиад гэрлээ унтраав. Зүүдэнд нь Итгэл оров. Тэр 2 өөд өдөөсөө гүйсээр яг уулзах гэтэл дундуур нь гал тэрэгний уртаас урт цуваа ороод ирэх юм. Ачааны галт тэрэгнүүд тасралтгүй явсаар л. Салхи татуулан явах тэр цувааны 2 талаас бие бие рүүгээ тэмүүлсээр арай гэж цуваа дуусахад Итгэл алга болчихсон байв. Ингээд уулзаж чадаагүйдээ харамсан зогссоор байна хэмээн зүүдэлжээ. Хачирхалтай нь тэр шөнө Итгэл ч яг тийм зүүд зүүдэлжээ. Намуун маргааш өглөө нь нэг л тавгүй сэрэв. Тэр дэрнийхээ хажууд байсан устай чулууг нэг хараад орноосоо үсрэн босов. Тагтан дээрээ гарахад Мики хав нь хаалга самардан орж ирээд тэврүүлэв. Цаг 8 өнгөрч байв. Тэдний хашаандаа тарьсан сахлаг өвсийг мөнгөн хяруу тарж, 2 жилийн өмнө ойгоос авчирч суулгасан залуу улиаснууд навчаа гөвж цаанаа л нэг уйтгартай харагдана. Нимгэн халат нөмөрсөн болохоор, намрын өглөө, эртийн сэрүүнд хүйтэн байсан ч бүсгүй нохойгоо тэврэн

зогссоор байв. Өглөөний тунгалаг агаарт ийнхүү зогсохдоо тэр өдрийнхөө хийх ажлын тухай бодож амждаг билээ. Гэвч энэ өглөө тэгэж чадсангүй. Сэтгэл нь нэг л тогтож өгөхгүй үймрээд, урьд шөнийн зүүдэнд нь харагдсан өндөр сайхан залуу бодлоос нь гарч өгөхгүй байв. Тийнхүү зогссоор ээжийгээ дуудахад л сая сэхээ оров.

- Миний охин сэрчихээ юу? Доошоо бууж цайгаа уухгүй юмуу? Дооёо эгч нь гоё өглөөний цай бэлтгэсэн байна гээд ээж нь араас нь тагтан дээр гарч ирэв. Мики хав нь тагтны хаалга онгойх чимээнээр Намууны гараас мулт үсрэн бууж өрөө рүү хурдлан гүйлээ.

- Нохойгоо гадаа гаргахгүй, юу гэж тагтан дээр тэвэрч зогссийн одоо наадах чинь хивсэн дээр шээчихнэ гэж ээжийг нь хэлж дуусаагүй байхад Мики Намууны өрөөний хивсэн дээр шээчихээд доошоо зугтав.

- Энэ муу золиг ингээд гэрт шээгээд байх юм гэж ээж нь үглэв. Тэр 2-ыг доошоо бууж хоолны өрөөндөө ороход хэрэг тарьсан хав нохой нь буйдан доогуур орж нуугдаж амжив. Ээж охин 2-ыг дөнгөж ширээнд суутал гэрийн эзэн дээрээс бууж ирэв. Чимэд ихэвчлэн орой болтол ажилладаг болохоор өглөө их л орой босдог билээ.

- Ооё, аав өглөө яасан эрт босоо вэ гэж охин нь түүнийг цаашлуулав. Ингэж халуун ам бүлээрээ цайлсан нь бүсгүйн сэтгэлийг сэргээж өглөөний нөгөө тавгүй сэтгэгдлийг нь баллуурдах мэт арилгачихав. Аав, ээж 2 нь гаалийн татвар төлөхгүй бол гааль дээр АУ95 саатсан, авч чадахгүй, тэгвэл нөөцгүй болох нь ч гэх шиг ажлаа ярилцсаар хамтдаа гарч одов. Намуун хичээлийн 4-н цаг яаж өнгөрснийг ч мэдсэнгүй нэг л мэдэхэд тарах болчихжээ. Гэтэл сургуулийнх нь гадаа түүнийг Хасар хүлээж байв. Гэмшсэн царай гаргах гэж оролдоод байгаа нь илт санагдсан тул бүсгүй зэвүү нь улам хүрч танихгүй хүн шиг хажуугаар нь дээгүүр харан өнгөрөх гэтэл ханцуй дээрээс нь бариад авчээ.

Тавьчих.

- Намуунаа, хүлээж бай л даа. 2-уулаа учраа ололцъё.

- Ямар учир? Би яараад байна. Тавихийг гуйя.

- Би чамаас яаж гуйвал чи хүлээж авах юм бэ?

- Яаж гуйгаад ч хэрэггүй. Ялангуяа ээжийгээ дахиж битгий явуулаарай. Чиний хулчгар зан хэвээрээ шив дээ. Намуун сургуулийнхаа гаднаас такси бариад ажилдаа очлоо. Түүнийг хувцасаа солих өрөөнөөс дөнгөж гарч иртэл Сараа сувилагч дуудуулжээ.

- За баян айлын охин ямар зорилгоор эмнэлгийн шал угааж яваагаа сонирхуулаач.

- Юу яриад байгаа юм бэ?

- Битгий жүжиглээд бай. Чамайг баян айлын хүүхэд гэдгийгчинь энд мэдэх хүн байхгүй гэж бодоо юу?

- Миний хэн байх нь танд ямар хамаатай юм бэ? гээд Намуун хаалгыг нь саван гарчээ. Тэгээд давхрын шалаа угааж байхдаа *энэ хүүхэн миний тухай яаж мэддэг байна аа?* хэмээн гайхсаар байлаа. Түүнийг уртаас урт хонгилийн шалыг угааж дуусаад резинэн бээлийгээ тайлах гэтэл яг ард нь

- Сайн уу? гэх танил ч юм шиг дуу гарав. Эргээд хартал Итгэл, сүүлийн үед зүүд нойрноос нь салахаа болиод байсан, өндөр залуу зогсч байв. Намуун балмагдсандаа дуугарч ч чадсангүй доош харчихав. Одоо юугаа хэлнээ. Намайг олоод ирж шүү, олоод ирж. Үнэхээр хайртай юм байна. Тэр бээлийтэйгээ ноцолдох зуур ингэж бодож амжив. Сандраад мэндийн хариуд нь сайн гээд ганц үг ч хэлчихэж чадсангүй доошоо харан зогссоор байлаа.

- Бугуйвчийг чинь өгөх гэсэн юм.

- Баярлалаа. Намуун ороосон бээлийгээ яагаад ч тайлж чадсангүй. Нойтон гарт нь резинэн бээлий зууралдаад салах шинжгүй. Бээлийгүй гараа сунган нөгөө дискон дээр гээчихсэн гэж бодож явсан шүрэн бугуйвчаа авлаа. Итгэл ч бас балмагдаад хэдэн өдрийн турш бодсон, бэлдсэн үгнүүдээ ганцыг нь ч хэлж чадсангүй. Эмнэлгийн цайвар ногоон хувцастай энэ турьхан бүсгүй, сар гаруйн турш эрж хайж, гээсэн бугуйвчийг нь энгэрийнхээ халаасанд хийчихээд уулзах сан, дууг нь сонсож, үргэсэн янзагынх шиг нүд рүү нь ширтэх сэн гэж мөрөөдөж явсан тэр мөрөөдлийн охин нь байлаа.

Гэтэл хайртай хүнтэйгээ тулаад уулзана гэдэг нүүр рүүгээ халуун уураар үлээлгэх мэт халуухан юм байдгийг тэр тооцоолоогүй байжээ. Юун бэлтгэсэн үг, юун хайраа илчлэх байхав. Тэр нэгэн орой диско баарний анивчсан гэрэл, үсчиж цовхчсон адтай хөгжим хангинасан шуугиант танхимд ганцхан удаа харсан оч мэт 2 хөөрхөн нүд... Ердөө энэ нүдийг нь хараад л зогсоод баймаар болж нөгөө хэлэх үг, болзоонд урих зоригтой мөрөөдлөө ор тас мартчихжээ.

- Миний бугуйвч мөн байна, баярлалаа.

- Зүгээр зүгээр.. чи дискон дээр унагачихсан гараад явчихсан ш дээ..

- Би дахиад олдохгүй л байх гэж бодсон..

- Алтанзул аа, юу.. би чамайг зөндөө эрээд, арай гэж л оллоо.. Бугуйвчийг чинь өгөх гэтэл чи нөгөө охинтой хамт таксинд суугаад явчихсан байсан..

- Харин тийм, бид 2 яараад л.. - 2-уулаа түр гарах уу? - Юу, миний ажил тарах болоогүй байна л даа. Намуун ингэж хэлээд Итгэл рүү харав. Өтгөн тод хөмсөг, өндөр шулуун хамартай, урт ургуулсан дэгжин үстэй, шулуухан үнэнч харцтай гоё нүд... Итгэл үнэхээр сайхан залуу юм гэж бодчихоод ичсэндээ үснийхээ угийг хүртэл улайж харцаа түргэхэн шиг буруулав.

- Алтаа, чамайг тарианы өрөө цэвэрлэ гэнээ гэх дуунаар бүсгүй давхийн цочиж дөнгөж сая тайлж гүйцсэн 2 бээлийгээ мушгин байж: - Намайг дуудаад байна, би 6-гаагаас нааш тарахгүй байх аа, за баяртай гээд хувингаа авлаа. - Би тэгвэл 6 гээд хүрээд ирэх үү? Итгэл эмнэлгийн чулуун шатаар нисэх мэт үсрэн бууж гадаа түүнийг хүлээн цаашаа харан зогсож байсан Батбаярыг араас нь тэврэн авч: - Ёоох, уулзчихлаа, ёстой халуун байдаг юм байна. Жака макаг дагуулж ирсэн бол насны онигоонд орох байсан байх. Яг нөгөө охинтойгоо уулзсан чин толгойд юу ч орж ирдэггүй. - Манай Жака ч марзаганахдаа л сайн юм чинь.. за тэгээд юу гэж байна? - Би уулзангуутаа тэнэг юм шиг бугуйвчийг чинь өгөх гэсэн юм гэхчхэн юм чинь.. баярлалаа л гэж бна лээ. Тэгээд сүүлдээ овоо нүүр хагараад ирсэн чинь цаанаас нь дуудаад. Орой 6-д тарна гэсэн. - Тэгвэл 2-уулаа хамт ирий.. - Тэгий. Ямар гоё юм бэ? Тэр дуу аялсаар машиндаа суулаа. Одоо түүнд тэнгэрт гэрэлтэн байгаа нар зөвхөн өөрт нь зориулан мишилзээд байгаа ч юм шиг замын голд зогсоо цувтай цагдааг тэврээд үнсчихмээр ч юм шиг, хажууд нь хань болон суугаа Батбаярыгаа үүрээд гүймээр ч юм шиг цээжинд нь баяр хөөр багтаж ядан байлаа. Итгэлийг явангуут бүсгүй сая л нэг тайвширлаа. Сэхээ оронгуутаа, би сая түүнд ямаршуу харагдсан бол гэсэн бодол орж ирэн тарианы өрөөний толинд өөрийгөө харав. Нүүрнийх нь энгэсэг бараг арилчихаж. Ажил хийхэд саадтай гээд санд мэнд шуучихсан үс нь хэсэг хэсгээрээ унжиж, хамар дээр нь хөлс бөнжигнөж, нүд нь харин баяртай гэгч нь гялалзаж байлаа. Шал тэнэг харагдсан байна. Итгэл миний юунд нь болсон юм бол оо. Гаргууд хөөрхөн царайтай ч биш, нэг их гоё биетэй ч биш. Тэгээд ядарсан нэг асрагч охинд шүү. Нэр нь хүртэл Алтанзул шүү дээ гэж бодсоноо өөрийн эрхгүй цаг руугаа харав. Залууг явснаас

хойш дөнгөж 5 минут л өнгөрчээ. Хаячихаад дахин олдоно гэж зүүдлээ ч үгүй шүрэн бугуйвчаа гарган үзээд буцааж далд хийв. Бүсгүй тарианы өрөө цэвэрлэж, күарцийн гэрлээр өрөөнүүдийг ариутган, хонгилын цонх арчиж тасралтгүй ажиллах зуураа хэдэн ч удаа цагаа харсныг бүү мэд. Урд нь нисэх мэт өнгөрдөг байсан цаг хугацаа л харин өнөөдөр тийнхүү яст мэлхий мөлхөж байгаа мэт явж өгсөнгүй. 6 цаг болов уу үгүй юу 2 хаалгатай жижиг улаан Тоёота джип эмнэлгийн гадаа ирчихсэн зогсож байв. Намуун цонхоор Итгэлийн машиныг хармагц зүрх нь дэлбэ үсрэх дөхөн цохилоход хувцасны өрөө рүү сандран гүйлээ. Асрагчийн ногоон хувцсаа санд мэнд тайчиж байхдаа л Алтаагийн дүрд тоглох ёстойгоо санав. Одоо тэр урьдын адил их дэлгүүрийн урд 40н мянгатад буух биш, зайсан толгойн өвөрт байх аавынхаа тансаг байшинд ч бус, Хайлааст руу явах ёстой. Алтанзул бол гэр хороололд амьдардаг асрагч охин шүү дээ. Ашгүй Хажид эгчийнхийг өөрийнхөө гэр гээд заагаад өгчий гэж дор нь сэтгэв. Хувцаслаж дуусаад тарианы өрөө рүү шагайж хүнд дусал хийж байсан Хажид авгайгаас: - Танайх Хайлаастын яг хаана байдаг билээ гэж сандчин асуув. - Хуучин эцэс дээр. Миний охин бүтэн сайнд очоорой. - За за. Тэр яаран гүйсээр гол хаалган дээр очвол Итгэл хүлээн зогсож байв. Тэнэг юм шиг яах гэж гүйв ээ. Өдрийнх шиг хөлрөөд шал тэнэг харагдаж байгаа байх даа гэж бүсгүй түүнтэй яг уулзахдаа өөртөө уур нь хүрэв. - Ашгүй найзаа дагуулалгүй ганцаараа ирээ юу? - Харин тийм, манай 3 сумо үзэж байгаа л даа. Итгэл өдөр өмссөн байсан улаан цамцаа сольж өөрт нь илүү зохьсон, захтай саарал цамц өмсөн улам л гангалчихсан иржээ. Тэр 2 машинд орж суугаад юу ярихаа мэдэхгүй таг болцгоов. Намуун өөрөө машин бариагүй үедээ хэзээ ч жолоочийн хажуу дахь "хадмын" суудалд суудаггүй зантай. Энэ удаа ч хойд суудал дээр нь суучихлаа. Энэ нь залууд их л таалагджээ. Урьд нь элдэв хөнгөн охид эзэгнэж байсан урд суудалд хайртай бүсгүйгээ суулгахаас тэр бяцхан эвгүйцэж байжээ. Ялангуяа нөгөө Сэни жуулчны баазаас буцахдаа л энэ суудлыг тавтай гэгч нь эзэгнэн Батбаярын хэлснээр тэргүүн хатагтай мэт эрхэмсэгээр суугаад авсан билээ. Сэни гэснээс сүүлийн үед гар руу нь ч, гэр рүү нь ч байнга утасдан нойтон хамуу шиг наалдсаар байгаа тэр хүүхнийг өөр рүү нь залгах вий гэж айсан залуу яг энэ мөчид утсаа яаран салгаад хөдөллөө. Үе үе шаргал, хүрэн хавчис хийснэ. Модод хавчсаар уйлан, буцах цагийн зэвэргэн салхи үлээсэн энэ орой шиг жаргалтай өдөр амьдралд нь байгаагүй мэт санагдана. Гайхалтай нь өнөөдөр энэ охинтой уулзсанаас хойш уурлах уцаарлахыг ч мэдэхээ больж, хүнд нэр хоч өгөх донтой Жакагаас инээмтгий хүн гэсэн шинэ нэр сонсоод нэг их тоогоогүй билээ. Одоо ингээд Намууныгаа суулган явахдаа ч гарцгүй газраар зам хөндлөн гарсан хүмүүсд урьдын адил уурласан ч үгүй. Бараг л машинаа зогсоон "гар гар" гээд инээх нь холгүй сайхан ааштай амьтан явж байлаа. Тэр 2 нэг мэдэхэд хотын төв рүү ороод иржээ. Энэ таагүй нам гүмийг эвдэн "2-уулаа нэг газар хоол идэх үү, хаана очих уу" гэсэн Итгэлийн асуултанд бүсгүй шууд хариулчихаж чадсангүй. Намуун бол ийрэмхүү үед Сити ч юмуу Вэнэрц-д орж хөнгөн зууш, мөхөөлдөс захиалдаг байсан. Гэтэл тэр бол сарын 50н мянгын цалинтай, Хайлаастанд амьдардаг, Алтаагийн дүрд тоглох ёстой шүү дээ. Алтаа эмнэлэгт хамт ажилладаг хүүхнүүдийнхээ бишрэн ярьцгаадгийг нь санаад бушуухан шиг л Берлин бургэр гэж хэлээд дотроо инээд нь хүрлээ. Тэдний хувьд Бэрлин бургэрт орно гэдэг мөрөөдлийн тансаглал байдаг аж. Энэ удаа бол Итгэлийн инээд хүрэх дөхөв. Одоо ажил тарах цаг, Бэрлинд хүн ихтэй байгаа л даа. 2-уулаа жаахан ярьж суух нам гүм газар очъё, Сити кафед суух уу? Тэр бас Сити-д дуртай юм байна гэж Намуун бодоод үүргэвчнээсээ уруул өнгөлөгч гарган инээдээ барьж ядан нуух гэж оролдов. Хэдий болтол ингэж жүжиглэх юм бэ, эрт орой хэзээ нэгэн цагт Итгэл үүнийг мэдэх л болно. Тэр энэ үед бүх жүжиг сайн дурын уран сайханчийн тоглолтоо юу гэж тайлбарлах бол. Ядаж л кафэ-д сууж байхад нь таньдаг хүн тааралдах юм

бол жинхэнэ онигоо болно ш дээ. Би харилаа гээд Намуун бууж зугтах гэв. - Алтаа би чамайг хүргээд өгье л дөө гэж Итгэл гуйлаа. Түүнийг буух гэж хаалганы бариулд хүрэхэд нь Итгэл шүрэн бугуйвчаа зүүснийг нь ажиглажээ. Анх танилцахдаа л нэрийг нь асууж чадахгүй хоцорчихоод энэ бугуйвчаас эзнийх нь тухай бүхнийг мэдэх гэж явсан тэр өдрүүдэд Итгэл оддын зурхайн ном хүртэл уншиж шүрний тухай судалж билээ. Тэгээд шүр хилэнцийн ордод ээлтэй гэж мэдээд түүнийг хилэнцийн орд юм болов уу гэж хүртэл бодсон. Шүр муу санаа, аянгын аюулыг зайлуулж, ад зэтгэрийг тонилгож, элдэвт хорхойсох сэтгэлийг дарна. Ой ухааныг бэхжүүлнэ. Мэрэгч төлөгчдийн сайн сахиус болдог гэж тэр номонд бичсэн байсан. Зүүж явсан эзнээ орлон сэтгэлийг нь зогоож байсан энэ бугуйвч эзнийхээ нарийхан бугуйнд байхийг хараад тэссэнгүй гараас нь бариад авлаа. Яг энэ мөчид тэр 2-ын харц тулгарлаа. Анх чих дөжрөм чимээтэй диско танхимд зөгийн үүр шиг дүнгэнэлдэн, үүрээ хөндүүлсэн шоргоолж шиг хүн бужигнасан тэр их хөлийн газар шууд л харцийг нь булаасан тэр тунгалаг нүд, гэрэвшүү харц... Итгэл бүсгүйд битгий буу л даа гэж аяархан хэлээд гарыг нь барьсаар л байлаа. Хоромхон зуур нүүр нь улсхийсэн бүсгүй, цочихдоо гараа огцом татаж аваад Манайх Хайлаастанд ш дээ гэж шивнэх шахам хэлэв. Эндээс Хайлааст хүртэл зөндөө хол байгаа нь ямар их аз вэ гэж Итгэл бодлоо. - Чи бугуйвчаа хаясанаа хэзээ мэдсэн бэ? - Тэр дороо ч мэдээгүй л дээ. Эмээ надад өгсөн болохоор би их хайртай байдаг юм. Гэртээ ороод л гараа угаах гэсэн чинь бугуйвч байхгүй байсан. - Та 2 пласаас яагаад тийм хурдан гараад явчихсан юм бэ? Би бугуйвчийг чинь олонгуутаа хойноос чинь гараад гүйцээгүй... - Алтаа? чи хилэнцийн орд юмуу? - Үгүй. Би яагаад хилэнцийн орд байх ёстой юм? гээд Намуун инээд алдсанаа - Би үхрийн орд ш дээ. Ууртай болхоор нь хилэнцийн орд гэж байгаа юмуу гэлээ - Үгүй л дээ. Би чамайг олох гэж дэнүү удаан хайсан. Тэгээд яагаад шүрэн бугуйвч зүүдэг юм бол гэж бодоод л.. Хилэнцийн ордныхонд хамгийн ээлтэй чулуу нь шүр гэж сонссон юм. Би өөрөө хонины орд л доо. Чиний төрсөн өдөр хэзээ болдог бэ? - 5н сарын 1нд. Дээр үед майн баярын өдөр байсан ш дээ. - Би тэгвэл 4н сарын 12нд төрсөн. Бид 2 чинь 2 уулаа баярын өдөр төрсөн юм байна. Би монгол хүн сансарт анх ниссэн өдрөөр төрсөн. Аав намайг жаахан байхад Гагарины зурагтай тэмдэг цуглуулж өгдөг байж билээ. Ээж одоо тэр тэмдэгнүүдэд их дургүй байдаг юм. Тэр 2 салаад их удаж байгаа л даа. Залуу өөрийн эрхгүй санаа алдчихлаа. Түүний сэтгэлийн тэр гуниг Намуунд ч гэсэн нөлөөчихөв. Уг нь Итгэл хэзээ ч энэ сэдвийг хөндөх дургүй байдаг байлээ. Гэтэл энэ бүсгүйд болхоор бодож санаж, эмзэглэж явдаг бүхнээ ярьж, сэтгэл зүрхээ тэр чигээр нь нээчихмээр санагдаад байлаа. Машиных нь арын суудалд шигдэн явсан Намуун үсээ нэг илээд: - Чи аавтайгаа уулздаг уу? гэж асуулаа - Үгүй ээ. Аав одоо Польшд байдаг гэсэн. Уулзаагүй олон жил болж байна. Ээж амьдралаа ганцаараа авч яваа болохоор аавд их гомддог юм шиг байна лээ. Тэгээд би аавын тухай ярьдаг ч үгүй. Миний дүү охин л ээжээс аавын тухай асуугаад байдаг юм. Би ээж дүү 2 тойгоо байдаг. Миний дүү гэж хэл ам сугалчих шахсан нэг айхтар амьтан бий. Бас надаас дандаа мөнгө шаналгана хэмээн ярьсаар явлаа. Түүний тэр илэн далангүй, сая буух гэхэд нь гарнаас нь барьчихаад ширтсэн харц зэрэг нь бүсгүйд гүнзгий сэтгэгдэл төрүүлжээ. Итгэл яриагаа таслан толь руугаа харж: - Би дэндүү их яриад байна уу? Уг нь би тийм чалчаа амьтан биш л дээ. Чамд л хамаг юмаа яриад баймаар санагдах юм. Чи өөрийнхөө тухай ярь л даа гэж гуйсан өнгөөр хэлжээ. Бүсгүй толинд түүнтэй харц тулгарчихаад ичэнгүйрэн цонх руу нүүр буруулж: - Би аав, ээж 2 тойгоо байдаг. Энэ жил ажил хийчихээд дараа жил Анагаахд орно доо. Эмээ намайг эмч болгох дуртай байдаг юм гэхихээд түр түгдрэн чимээгүй боллоо.

- Өөрийнхөө тухай биш хүний өмнөөс худлаа ярих нь тийм ч амаргүй ажил болохыг ойлгожээ. Намуун багадаа юм юманд сонирхолтой аавынхаа нөлөөгөөр уран зурагт дурлаад зураач юмуу, загвар зохион бүтээгч болохыг мөрөөддөг байсан. Гэтэл хуучний үзэлтэй, багш ажилтай эмээ нь зээ охиноо эмч бол гэж их ятгана.

Харин ээж нь л өөрийнхөө мэргэжлийг охиндоо тулгасаар дийлсэн билээ. Нэг юм хийе л гэж бодсон бол тэр дороо ханцуй шамлан дайрдаг, хүссэндээ хүрч байж салдаг Нарангийн хүссэнээр л тэдний амьдрал явдаг болхоор аау нь "Манайх чинь эхийн эрхт ёс тогтсон айл шүү дээ" гэж ярьдаг билээ. Тэр 2 тийнхүү ард, урд суудлын дунд толиор дамжуулан харц солилцон яриа нь тийм ч сайн эвлэж өгөхгүй, тэгсэн мөртлөө ингээд л түг тагхийгээд толинд ширтэлцээд л яваад баймаар санагдах ажээ. Нэг л мэдхэд Хайлааст руу ороод иржээ. - Танайх яг хаана юм бэ? гэсэн Итгэлийн асуултанд бүсгүй бондгосхийтэл цочоод сэхээ орж - Хуучин эцэст, автобусны буудал дээр л зогсчих гэлээ. Энэ үеэр дууг нь хааж чичиргээн дээр тавьсан Намууны утсанд дуудлага ирэв. Анхнаасаа л баахан худлаа дүрд тоглочихсон хүн чинь нэг мөсөн л амьдрал дээр ядуухан охин болж жүжиглэх хэрэгтэй байлаа. Гэр хороололд суудаг, сургалтын төлбөрөө ч хийх чадваргүй айлын охин 9911-тэй дугаартай хамгийн сүүлийн үеийн Мотораллатай байна гэхэд хэн үнэмших билээ. Ер нь тэдний эмнэлгийн хэдэн асрагч дотроос Эрка гэдэг охин л ганцаараа 9977-той дугаартай луу гар баян нь билээ. Клипээ харвал Намуун руу Жавхаа дохиж байв. Бүсгүй утсаа салгаад сэмхэн цүнхэндээ хийлээ. Ашгүй Итгэл гар утсыг нь анзаарсангүй. Тэр эргэж хараад хуучин эцэс гэдэг чинь энэ мөн уу? гэлээ. Намуун сайн мэдэхгүй мөртлөө мөн мөн, би ингээд буучихъя хэмээн зогсоогүй байхад нь хаалганы бариул тэмтэчлээ. Итгэл хаалгануудаа түгжчихээд - Алтаа, энд битгий буу л дааа. Би хашааны чинь гадаа л буулгаад өгье.. Тэгээд 2-уулаа маргааш хэзээ уулзах бэ? Ер нь гэрийхэнд чинь утас бий юу? Чамтай яаж холбоо барих вэ? гэж нэхэл хатуутай асуув. Намуун толгой дээрээ тэгнэчихсэн нарны шилээ зүүгээд уруулаа хазлан чимээгүй болов. Тэр сандарсан үедээ ууруулаа хазалдаг зуршилтай. Тэгээд чичирхийлсэн хоолойгоор - Чи хаалгаа онгойлгочих л доо. Би энд л буучихъя. Манай гэрийхэнд утас байдаггүй ээ. Ажил руу л ярьж болно. Тэгэхдээ намайг бараг дуудаж өгөхгүй байх аа даа, чи тарахад хүрээд ирэхгүй юу гэхихээд нүүр нь бас л улайлаа. Итгэл яаж ч чадсангүй.. за за баяртай гээд хаалганыхаа түгжээг татлаа.

-Бүсгүйг буугаад явахад араас нь тэр ширтсээр хоцров. Нарийхан джинс турьхан биетэй, үсээ даруухан шуусан энэ жижигхэн цагаан охины юунд нь болж тэмүүлээд байгаагаа тэр ойлгохгүй л байлаа. Ойлгохыг ч үнэндээ хүссэнгүй. Уг нь Жака тэр 2 баян айлд хүргэн орж хурдхан шиг л хөл дээрээ босно гэж тоглоом шоглоомоор ярьдаг байсан.

Гэтэл Итгэл ингээд нэг л өдөр дурлалдаа жолоо алдууран Хайлаастанд амьдардаг жирийн нэг асрагч охинд хайртай болчих гэж. Түүнийг сая Алтаатай уулзах гээд бөөн баяр хөөртэй амьтан ажлаасаа гарахад Жака л ганцаараа дуу муутай их янзгүйхэн суусан билээ. Одоо цаашдаа ээж гэж нэг сөрөг хүчин гарч ирнэ. Яаж ч бодсон ээж нь хүүгээ сургууль соёл ч үгүй, амьдрал тарчигхан ийм асрагч охин дагуулаад очход баярлахгүй нь тодорхой.

-За хүү минь толгой хоосон их ганган эрвээхэй шиг юмтай суучихав даа. Тийм хүүхнүүд хүнд хань болдоггүй юм. За нэг их баян тарганаараа гайхуулсан айлын охин ч хэрэггүй. Эцэг эх нь нэртэй төртэй, хүнд илүүчилхээргүй, хүнээс ч гуйхааргүй, өөртэйгөө нэг зиндааны дундаж амьдралтай охин зүгээр шүү. Амьдрал их ядуу айлын хүүхэд бол ч бас л дэмий. Чи насаараа хадмынхыгаа чирч явах болно шүү гэж ээж нь ярьдаг билээ. Үнэндээ ч аавыг нь 10 гаруй

жилийн өмнө ээжээс нь салаад явчихад орон гэрээ толгойлон үлдэж, хүү охин 2-оо хүнээс дутаахгүй өсгөх гэж хамаг залуу насаа ганцаараа өнгөрөөж яваа ээж нь оргүй ч юм яриагүй нь мэдээж. Гэвч Итгэл одоо энэ бүсгүйгээс сэтгэлээ татаж авах хөг нь өнгөрсөн гэдгээ л тов тодорхой мэдэрч байлаа. Тэр машинаа асааж энэ бүх таагүй бодлоо үргээх гэсэн мэт нэг гүнзгийхэн санаа алдаад цонхоороо цухуйж Алтаа, маргааш болтол баяртай гэж хашгирлаа. Гэр хорооллын тоос шороотой гудамжаар торойтол алхаж явсан бүсгүй эргэж хараад гар даллав. Анхны уулзалт нь төлөвлснөөр нь болоогүй ч сэтгэл дүүрэн байв. Залуу өөрийн эрхгүй инээмсэглээд хөдөллөө. Намуун ч тоос манарган хөдөлж буй машины араас гар далласаар хоцров. Түүнд Итгэл үнэхээр таалагдаж байлаа. Анх тэр дискон дээр хараад бодсон шиг тийм танхил, эрх жаал биш байсан нь сайн хэрэг. Байгаа байдлаараа бол Итгэл Хасарыг бодвол жинхэнэ эр хүн байх нь. Гэтэл өөрөө түүнийг хуураад Алтаа асрагч, Хайлаастанд амьдардаг энэ тэр гээд жүжиглэж байдаг. Цаг харвал долоо өнгөрчихөж ээ. Гэртээ харьж хийх юм их байлаа. Тэр Итгэлийн машиныг далд оронгуут утсаа гарган аавынхаа жолоочийг дуудах гэснээ болилоо. Шал балай юм. Хайлаастанд юу хийж яваагаа Самбуу ахад тайлбарлах болно. Аягүй бол аавынх нь туслах Оргил яаж ийгээд нэг юм шиншилчихнэ. Больё. Тэгээд бүсгүй ирсэн замаараа гудамж уруудан явсаар такси барихаар шийдэв. Энд нээрээ амьдардаг байсан бол яанаа. Аймаар юм, ер нь энэ жүжгээ яаж дуусгах вэ? Гэхдээ бас сонирхолтой ч юмуу, боломжтой амьдралтай залуу, гэр хорооллын бүсгүй хоёр.

-Энэтхэг киноны дурлал шиг юм болох нь ээ. Ээж намайг энд ингэж явааг харах юм бол зугаатай юм болно доо гэж бодон такси хүлээж зогслоо. Түүний дэргэдхэн байх худгийг хэд ороосон урт очир үүсч эндхийн оршин суугчид ус чандмань эрднийн төлөө алалцахаа дөхөн шуугилдана. Гэтэл такси баригддаггүй ээ. Гэр хороололд такси барина гэдэг худгаас ус оочэргүй авахтай адил ховрын ховор юмны нэг ажээ. Ашгүй ганц золбин шар ирэв. Хайлаастаас хотын төв рүү хоосон явах нь хэмээн гонсгор явсан хөгшин жолооч Намууныг хараад дугуйнаасаа гал гартал тоормослон зогслоо. Машинд суугаад л тэр гар утсаа гарган Жавхаа руу залгав. 2 найз өнөөдрийн уулзалтын тухай ярьж баахан хөхрөлдөв. Намуун эмээгийнхээ хонох тул Жавхаа орж ирж яриагаа чөлөөтэй үргэжлүүлхээр болж 2 найз урт яриагаа дуусгасан юм. Түүнийг таксинаас бууж эмээгийнхээ чарлаа хонхыг дарж зогстол ээж нь залгав. Чи сүүлийн үед юу л хийгээд явнаа? Өнөөдөр бас гэртээ ирэхгүй юм биш биз дээ? гэхэд нь Жавхаагийн англи хэлний курсийн ажилд туслах гээд эмээгийнхээ хонох гэсэн юм гэж аргалаад хаалга онгойлгож өгсөн эмээгийнхээ хажуугаар зүтгэлээ. Тэгээд гутлаа сольж байхдаа өөрийнх нь тухай ямар нэг юм шиншилчихсэн шинжтэй байсан Сараа сувилагчийг гэнэт саналаа. Хэрвээ ээж нь нэг л сэжиг авчихвал учрыг нь олохоос нааш сална гэж байхгүй дээ. ажлаасаа гарчихъя гэхээр Итгэлд юу гэж хэлэх билээ гэдгийг бодох хэрэгтэй байдаг. Ядаж ганц долоо хоног аргалчихмаар байлаа. Асрагч Алтаа ганцхан өдрийн дотор баян айлын охин Намуун болоод хувирчихна гэдэг дэндүү утгагүй явдал байлаа. Удалгүй Жавхаа инээд алдсаар орж ирэв. Нүд нь гэрэлтэж үснийх нь ширхэг бүр гялалзаад байгаа мэт баяр хөөрөө нууж ядсан Намуухан ч найзийгаа өрөөндөө оруулаад буйдан дээр зэрэгцэн сууж аваад оноодрийн болсон яудалийг ёстой л өнгөтөөр ярьж гарлаа. Найзынх нь яриа Жавхаад эхлээд сонин байснаа гэнэт гуниг төрүүлчихэв. Яагаад? Уг нь түүний санаачилсан туршилт амжилттай болж шинэ үеийн үнсгэлжингийн дүрд хувирсан Намуун хан хүүгийнхээ зүрхийг булааж чадлаа. Уг нь энэ мөрөөдлийн залуу Жавхаагийнх байсан бол найзынхаа яриаг сонсож суухдаа сэтгэлд нь ийнхүү бауц хан атаархлын дөл манас хийхийг мэдэрч өөрөө бяц хан дургуйтсэв. Хэдэн сарын өмнө хэдэн сар ч гэж дээ яг 3-н сарын өмнө тэр хаягдахын гашууныг

ойлгосон. Тэр 2-ын хайр жинхэнэ хайр байсан үгүйг бүү мэд. Тэгээд ер нь энэ бол асуудлын гол нь биш шүү дээ. Хамгийн гол нь хүнд хаугдана гэдэг эмэгтэй хүний хувьд хамгийн гашуун зовлон байдгийг тэр мэдсэн. Тэр хор шар нь буцлахдаа Ганаагаас мянга дахин илүү баян илүү царайлаг залуутай хөтлөлцөн алхаж хайрын мсж бичэлцэн нүд үсийг нь энхрийлэн үнсэж хамаг халуун сэтгэлээ харамгүй өгөхсөн. Тэгээд тэр 2-ын тэр гал халуун хайрын тухай Германд байгаа Ганаа заавал олж сонсоосой. Эсүүл тэр амралтаараа ирээд санаандгүй тааралдаасай гэж тэр ямар их мөрөөддөг байлаа. Гэтэл тэр сайхан хайр өөрт нь ч биш найзад нь ирчихээд сэтгэлийнх нь гүнд бяц хан бяц хан атаартал төрүүлээд байдаг. Үнэндээ хамгийн анх дискон дээр хараад л Итгэл өөрт нь таалагдсан, гэтэл тэр сайхан залуу Жавхааг биш Намууныг хайрласан нь харамсмаар.

-Цаадах чинь чамайг хайлаастанд байдаг гээд нүүр буруурахгүй байгааг бодход үнэхээр хайртай юм аа. За би ч явья даа гээд Жавхаа хэлэхдээ хоолойных нь өнгөнд атаархал байгааг нуусангүй. Аль бага байхын л Жавхаад байхгүй юм бүхэн түнд л байдаг байсан. Өөрийн гэсэн өрөө, том том зөөлөн тоглоом, чихэвчний хөгжим, гоё гоё хувцас гээд л бурхан яагаад дандаа Намуунд илүү юм заяадаг юм бол?

- За байз л даа. Тэр орчуулсан юмаа аваад яв. Хүүе, би маргааш юу өмсөж явахыг зөвлөөд өгөөч гэж асуугаад Намуун босож суниав. Суниаж байгаа нь хүртэл жаргалтай харагдаж бана шүү гэж Жавхаа бодоод "би чинь яаж байна аа, найддаа атаархаж үхэх гээд, унтахдаа бурханд гэмшлээ өчихгүй бол нүгэл болох нь" хэмээн бодоод орчуулсан юмаа авч чи өөрөө л сонгочих, бид 2-ын вкус таардаггүй юм чинь гэхихээд дуу муутайхан гарч одлоо.

Жавхааг гарсны дараа Намуун цонхны дэргэд очин зогслоо. Тэнгэрт 15-ны сар гарчээ. Тэргэл саран мэлтийн гудамжны гэрэлтэй сүүн цагаан туяа нь сүлэлдэн гадаа сав саарал гэгээтэй байв. Орцны хаалга дуугаран сугандаа юм хавчуулсан Жавхаа хар гүйхээрээ гараад эргэж ч харалгүй яваад өгөх нь харагдав. Одоо Итгэл юу хийж байгаа бол. Намайг бодож байгаа бол уу? Лав л энэ том сарыг харж байгаа бх даа. Унтахынхаа өмнө утасдаад дуугий нь сонсох юм сан гэж бодсоноо гэнэт энэ бодлоосоо ичих шиг болж утсаа шүүрч аваад ээжрүүгээ залгалаа. Шөнийн 1 цаг болж байлаа. Аав ээж 2 нь хэдэн хүнтэй оройн зоог барьж яваа аж. Бид 2 оройтох юм шиг байна. Чи маргааш ээжрүүгээ яриарай аавтайгаа ярих уу? гэж ээжийгээ хэлхэд тэр баяртай гээд утсаа тасаллаа. Цаана нь олон хүний дуу шуугиан, хөл хөдөлгөөн сонсогдох нь том хүлээн авалт болж байгаа бололтой. Тэр 2-ын элдэв хүлээн авалт, хандив буяны зоог ямар дуусах биш дээ. Намуун тийм хөлтэй найр, олон хүн цугларсан газраар явах дургүй. Өрөөндөө ганцаараа зураг зурах юм уу, ном уншиж, эсвэл юм бодож суух нь хамаагүй тавтай санагддаг тул аав, ээжтэйгээ хамт явах дургүй гэртээ үлдэхийг илүүд үздэг хүүхэд билээ.

Уг нь өнөөдрийн энэ баяртай явдлаа ээждээ ярьсан бол сайхан байхсан. Гэвч ээж нь газар дээрх ганц охинтойгоо хэзээ ч тийм ойр дотно байсангүй. Яриад ч ойлгохгүй биз дээ. Юун Хайлааст, юун асрагч хийх. Хасар яасан бэ? гэх нь мэдээж юм чинь. Түүнд аав, ээж 2-ынх нь амьдрал нэг л сонин санагддаг юм. Гаравч оровч бие биенээсээ холдоно гэж үгүй. Гэртээ байхдаа ч өр төлбөр, гэрээ хэлэлцээр, маркетингийн хэлтсийн шинэ захирал, хил гаалийн татвар гэхчилэн ажлаа ярьж байдгаас нь болоод эхнэр нөхөр 2 биш ажил хэргийн түншүүд мэт санагдана. Аав нь яахав дээ уулзах хүн нь, хийх ажил нь барагдах биш. Гэтэл ээж нь нөхрөө үргэлж дагаж явах ямар хэрэг байна гэдгийг ойлгоход бэрх. Нэг удаа эмээ нь ээжийг нь зэмлэхдээ Юндэнгийн хажууд зангуу овс шиг наалдаж явахаар охиноо асраад орон гэрээ

өөд нь татахад яадаг байна аа гэж билээ. Нээрээ л ээж нь ааваас нь яг зангуу овс шиг зуурч явдаг хүн. Уг нь өглөө сайхан унд бэлтгээд охин нөхөр 2-оо үдэж өгөөд, орой ирхэд нь гэртээ хоол хийчихсэн гэгээ татуулаад сууж байдаг бол сайхан аа. Тэгээд бас тэдний тэр том байшинд Намуунаас гадна дахиад 2 охин байдаг сан бол хичнээн хөгжилтэй, өнөр өтгөн айл байх сан бол гэж боддог юм. Хэрэв тэднийх 3 байг гэхэд 2 хүүхэдтэй, Намуун нэг дүүтэй байсан ч болоосой. Гэтэл ээж нь мөнхөд мөнгө төгрөг, ажил хэрэг хөөцөлдөн, нөхрөө сүүдэр мэт дагасаар газар дээрх ганц охин нь гэрээсээ, эцэг эхэээ аажмаар хөндийрч байгааг, өсч өндийн өөрийн гэсэн бодолтой бүсгүй болж байгааг ч ажиглах сэхээгүй явсаар өдий хүрчээ. Жавхаад байдаггүй олон юм түүнд бий. Гэвч Намууны мөрөөдөөд ч бүтэхгүй олон юм найзад нь бий. Жавхаагийн ээж нь хүүхдүүддээ маш их анхаардаг, багаас нь сэжиг дугуйланд өөрөө хөтлөөд л явдаг байсан хүн. Тэднийх 3-н хүүхэдтэй. Түүний эрэгтэй, эмэгтэй 2 хөөрхөн дүү нь Намуунд байгаа бүхнээс үнэтэй мэт санагддаг юм. Гэтэл найз нь өөрийнхөө аз жаргалыг үнэлж мэдэхгүй, аав ээжийгээ мөнгөгүй хэмээн үргэлж сэтгэл дундуур явдгийг яана.

Намууний бодлоор мөнгө бол юу ч биш. Мөнгөөр худалдаж авч болдоггүй юм хичнээн их байдаг байхад хүсвэл хэн ч мөнгөтэй болж болно шүү дээ. Тэднийх Жавхаагийнхтай адил 2 идэхгүй, хоосон хонохгүй эгэл жирийн мөртлөө өнөр өтгөн айл байсан бол тэр одоогийнхоосоо хамаагүй илүү их аз жаргалтай байх сан. Намуун цонхны дэргэдээс холдож орондоо орлоо. Сэтгэлд хурсан хөнгөн гунигийг нь Итгэлийн тухай бодол гэрэлтүүлэн хөнгөн нойрслоо.

Маргааш нь тэнгэр уйлагнасан усан бороотой муухай өдөр байлаа. Урьд өдөр нь тэнгэр цэв цэлмэг, хотын утаат тэнгэрт одод чадахын хэрээр гялалзан, тэргэл саран мандаж байсан атал өнөөдөр тэнгэрт хаанаасаа нэвсийж навсайсан бараан үүлс хуралдан намрын усан бороо уйлагнуулчихсаныг бүү мэд. Намууны хичээл эрт тарав. Итгэл рүү утасдамаар л байлаа. Гэвч нэгэнт гэртээ утасгүй, гар утас ч үгүй гээд хэлчихсэн хүн чинь яах билээ. Зүүн бугуйндаа зүүсэн шүрэн бугуйвчаа ширхэг ширхэгээр нь эрхи мэт эргүүлсээр суулаа. Хичээлийн дараа э-мэйл хаягаа шалгах хэрэгтэй байдаг. Гэсэн ч Итгэлтэй уулзах яарсан сэтгэлдээ хөтлөгдөн ажил руугаа явлаа. Гар computer-аа авч яваа юм чинь даргынхаа өрөөнөөс гялс интэрнетд холбогддог хэргээ. Түүнд дуусах яагаа ч үгүй интэрнет каарт нь байж байв. Ангийнхаа Баку хэмээх нэг залуугийн машинаар Намуун эмнэлгийнхээ үүдэнд хүргүүлэв. Тэднийх эмнэлгийнх нь зэргэлдээ байшинд байдаг юм.

-Намуун аа, чи энд ажил хийгээд байгаа юмуу гэж түүнийг буухад нь Баку гээлдсэн үсээ тольдон улам өрвийлгөх зуур асуув.

-Үгүй яаж байна?

-Яахав дээ. Чи өчигдөр бас энд таксинаас бууж байхыг чинь би харсан. Машинаа яагаа бэ?

-Юун хэрэгт дуртай юм бэ. Надад энд ирэх хэрэг гараад байгаа. Машин ч яахав. Би ойрдоо баримааргүй бна.

-Чамд тариа олдох биш биз?

-За болиорой. Юу гэж надад олдох юм бэ. Чи бүүр тариулдаг болоо юу? гээд Намуун хаалгыг нь ууртай хаалаа.

Тэдний ангийн хэдэн залуус анаша татдагийг нь Намуун санамсаргүй мэдчихсэн юм. Урьд нь Хасартай үерхэж байхдаа нэг найзынх нь төрсөн өдрөөр энэ Бакутай тааралдхад мань хүн

хэдэн залуугийн хамт айлын хивсэн дээр мансуурчихсан нүд нь дуниартаад сууж байсан билээ. Уг нь ааш зан сайтай, хичээлдээ сайн хүүхэд байтал найзуудыгаа дагаад тийм үл бүтэх юманд орооцолдчихсонд нь Намуун харамсдаг юм. Маргааш нь тэр хичээл тарангуут Намууныг хоолонд оруулан байгаад урьд өдрийнхөө тэр эвгүй явдлыг хэнд ч хэлэхгүй байхыг гуйж билээ. Тэгхэд нь Намуун нууц хадгалхын хувьд айлтгүй, харин тийм дэмий юмнаас эртхэн татгалзаарай гэж гайгүй сайн ятгасан сан. Баку гартаа зүүсэн өнгийн утас имхэрдээд салбайчихсан бугуйвчархуу юмаараа оролдон суухдаа хүнд рок сонссоор байгаад нэг мэдхэд нисэх дуртай болчихсон юм. Ээж л битгий мэдчихээсэй. Бусад нь ч яахау. Даанч би энэ байдалдаа дэндүү дасчихаж. Гэхдээ биеэ татаж авахыг хичээнээ гэж байсан. Гэтэл биеэ татах нь битгий хэл судсандаа тарьдаг болтлоо хар тамхины нөлөөнд орчихсонд нь Намуун харамсаж байв. Хэрэв судсандаа хар тамхины найрлагатай тариа хийлгэж байгаа бол жинхэнэ архаг донтон болсон гэсэн үг. Аау, ээж нь энэ Бакуг дэндүү эрхлүүлчихсэн юм. Ховгүүдийг эцэг эх нь дэндүү дураар нь тавих юм даа гэж гунигтайхан бодсоор ажил руугаа оров. Түүнийг эмнэлэг рүү орж явахыг Сараа хүүхэн цонхоор харан

-Энэ Алтаа гуай чинь өдөрт л нэг өөр машинтай залуучуудаар хүргүүлж, авхуулаад гарч өгөө шив дээ. Чамайг би дураар нь дургуйлахгүй дээ хэмээн чанга хэлэв.

Ээлж солих болоогүй тул Намуун хувцасаа сольчихоод Ерөнхий эмчийн өрөө рүү шагайвал Чулуун эмч ашгүй байж байв. Намуун утсанд нь гар компютераа холбоод гялс э-мэйлээ шалгаадхая гэж гуйлаа. Мэдээж аавынх нь найз, бас өөрийнх нь хуйвалдагч түнш нь татгалзсангүй.

Яг гадагшаа гарах гэж байсан гэнэ. Намуун каартныхаа кодыг хийгээд интэрнэт-д холбогдчихсон сууж байтал гай болж Сараа сувилагч ороод ирэв.

-За, энэ чинь даргын өрөөнд орчихсон notebook мүүк залгачихсан их сууж байх шив дээ. Коридорын шалыг хэзээ угаах юм? хэмээн сэжигтэй харцаар цоо ширтэн, элгээ тэврэн зогсов. Намуун одоохон гээд сандран босохдоо гар утсаа унагачихлаа.

-Энэ чинь юу вэ? Чи чинь ажилд орохдоо гар утасгүй, гэртээ ч утасгүй гээд байсан биш бил үү. Яагаад утас мутас нуугаад байсан юм бэ? Чи ер нь энүүгээр юу шиншлээд яваа юм?

-Юу ч шиншлээгүй. Та ч намайг шиншлэх хэрэггүй гээд Намуун санд мэнд shut down хийж компютераа хаагаад бослоо. Тэр даргын өрөөг түгжээд шал угаахаар явж байхдаа тааруухан хэрэг боллоо. Энэ Саранчимэг чинь одоо Джэймс Бонд юмуу, хаашаа юм, юундаа хүн мөрдөөд байдаг байна аа хэмээн зэвүүцсээр байлаа. Харин Сараа хүүхэн дуслын тариа бэлтгэж зогсохдоо энэ Алтаа ямар учиртай амьтан бэ? тэр notebook, аймаар үнэтэй утас хэнийх бэ? Анх ажилд ороход нь нүд нь нэг л биш байсан юм аа. Цаанаа л нэг бардам, ихэмсэг, би заавал чиний нууцыг мэднэ дээ гэсэн зэвэргэн бодол толгойд нь эргэлдэх аж.

Эмэгтэй хүн нэг л хүнд дургүй нь хүрчихвэл зогсохыг мэдэхгүй өширхдөг. Тэр хүн өөрт нь ямар ч гэм хийгээгүй байсан ч хамаагүй. Ялангуяа өөрөөс нь ямар нэг юмаар хол илүү байх юм бол тийнхүү өширхөх хангалттай шалтгаан болдог билээ.

Сараа дуслын системээ бэлтгэхчээд гархад Алтаа тарианы өрөө цэвэрлэхээр зөрөөд орж ирэв. Тарианы өрөө дээд зэргийн цэвэрхэн байх ёстой. Битгий гурилдчихаарай, би ирж шалгана шүү гээд тэр Намуун руу эгдүүтэй харцаар ширвэчихээд гарлаа. Тэр жижүүрээс даргийнхаа өрөөний түлхүүрийг авч сэмхэн орлоо. Алтаагийн цүнх, computer 2 түрүүн

орхисон янзаараа байж л байв.

Зүйтэй. Ажаа нь одоо л учрыг нь олж хужрыг нь тунгаана даа гэж тэр бодоод цүнхнээс нь Моторолла маркийн чамин утас гарган ирэв. Унтраалттай байв. Пин код энэ тэргүйгээр асаачихлаа. Картны утас биш бололтой. Пондыг нь ухаж байгаад ээж хэмээн хадгалсан 9911-тэй дугаар олоод байтал хонгилд даргын дуу гарлаа. Сандарсандаа утсыг нь унтрааж ч амжсангүй цүнх рүү нь хам хум шургуулаад яаран гарахдаа

-Хулгайч шиг гэж өөрийгөө шоолон бодсон ч дотроо сэтгэл тэнэгэр байлаа.

Ээж нь 9911-тэй утастай байхыг бодоход баян айлын бандгар охин байх нь ээ. Тэгээд энд үлийгээ хийж шал угааж явдаг байна аа. Энэ л түүнд гайхалтай оньсого байв. Ямар ч гэсэн нөгөө дугаарыг өөрийнхөө утсанд тэмдэглэж аваад юу ч болоогүй юм шиг дуу аялан тарианы өрөө рүү алхав.

Тэр ажлаа дуусгаад өнөө утас руу хэд хэд залгатал авсангүй. Эсвэл салгачихсан байх аж.

Ямар ч гэсэн энэ сэхүүн амьтныг зүгээр орхихгүй дээ гэж бодсоор байв.

Сараагийн хувьд тэр computer, тэр утас бүгд мөрөөдхөөс цаашгүй зүйлүүд билээ.

Түүний хувьд амьдралдаа ганц ч мөрөөдлөө биелүүлж үзээгүй болохоор юм бүхэнд сэтгэл дундуур явдаг юм. Түүнийг товчхон тодорхойлох юм бол тун удахгүй ганц бие хөгшин хүүхнүүдийн эгнээнд шилжих гэж байгаадаа бухимдсан хүүхэн билээ. Одоо хэдийнээ 27 хүрчихсэн байтал түүнд нөхөр ч алга, хүүхэд ч алга. 2 өрөө байранд аав, ээж, дүү нартайгаа олуулаа, арай л бие биен дээрээ гишгэлэх нь холгүй шахам, чихэлдэн амьдрахаас залхаж гүйцсэн ч тусдаа гарах бодол нь бас л мөрөөдөл хэвээр үлдсэн.

10-аа төгсөөд Анагаахын их сургуульд элсэх гээд оноо дутсан. Ингээд эмч болох мөрөөдөл нь бүтээгүй, тэдний эмнэлэгт гуанзны угаагч, асрагч хийгээд хашаанд амьдардаг, цалин нь өөрийнхөөс нь хамаагүй бага, тэгээд хүн бүхэнд загнуулж явдаг мөртлөө өчүүхэн ч гутарч явдаггүй Цэвлээ, Ганаа, Отгоо гээд л өрөвдмөөр амьтад байж л байна шүү дээ. Гэхдээ тэдний амьдрал бол тэдний л амьдрал шүү дээ. Өөрийгөө дорой улстай харьцуулж доошоо ороод ч яах юм билээ. Гэтэл энэ Алтаа... анх ажилд орохдоо л таалагдаагүй. Хэдийгээр джинс, пүүз өмсөж даруухан хувцасласан харагдсан ч бүх юм нь чансаатай шал өөр харагдсан юм.

Нүднийх нь харцыг бол ярих ч юм биш, тэгтэл баян айлын охин байж. Тэгээд ямар юмаа хийж энд асрагч сувилагч нартай хутгалдан ажил хийж, элдвээр жүжиглэж явдаг байна аа. Хийх юмаа олж ядсан амьтан бэ? Сараа ямар ч байсан ээжид нь энэ тухай хэлэх л болно. Хэлж байж л санаа нь амарна. Бүр дургүй хүргээд байгаа юм гэж Сараа хүүхэн шүд зуун бодсоор...

Намуун цаг руугаа хялалзсаар арай гэж нэг юм б болголоо. Бараан үүлс тэнгэрээр нэг нэвсийж хотыг юу юугүй дараад унагачих гэж байгаа юм шиг энэ бүрхэг өдөр түүний сэтгэл зүрх далдын нэгэн баяр хөөрт автан гэгээ татах аж. Тийм ээ, удахгүй Итгэлтэй уулзана. Ингэж бодохоор өөрийн эрхгүй инээмээр санагдаж, түүнээсээ болж ганцаараа инээчихсэн зогсож байвал хүн намайг мэдрэл нь зүгээргүй галзуу охин гэж бодох байх даа гэж бодон тэр бодлоосоо бас л инээд нь хүрэх ажээ. Ер нь үе үе гэмгүйхэн галзуурах сайхан шүү дээ. Урьд нь барагдашгүй их, баршгүй хэцүү санагддаг байсан цэвэрлэгээний ажил өнөөдөр хийгээд л

баймаар амар, хөнгөн сангадах нь хачин. Түрүүхэн Сараа сувилагчтай даргын өрөөнд тулж сэтгэл тавгүйтсэнээ ч мартчихажээ. Ер нь муу юмыг мартаж байж л амьдрал сайхан байдаг эгэл үнэнийг тэр одоо л ойлгож байх шиг.

Ажилд ороод 22 хоног өнгөрчээ. Жавхаагийн толгойд яахаараа ийм сонин санаа орж ирдэг байна аа? энэ тэнэг тоглоомонд оролцохыг зөвшөөрөх хүртэл тэнэглэснийг бодоход Итгэл түүнд анхны харцаар таалагдсан байх нь ээ. Тийм ээ, таалагдсан болоод л тэр асрагч Алтаа болчихоод одоо яаж эргээд Намуун болохоо мэдэхгүй мангартаж зогсоо юм биш үү? Ямар ч байсан Намуун баян айлын охин гэж эцгийнх нь хөрөнгөнд биш, өөрт нь дурласан залуутай учирчээ.

Итгэлийн гар бугуйнд нь хүрхэд бүх биеэр нь тог цохих шиг болсныг саналаа. Хэдхэн вольтийн сулхан гүйдэл цохих шиг. Гэтэл урьд нь Хасарын гар биенд нь хүрэхэд ямар ч мэдрэмж төрж байгаагүйг сая л саналаа. Бүр хаалганы бариул, харандааны үзүүр хүрч байгаа юм шиг тийм л хөндий хүйтэн байдаг байж. Тэгхээр Итгэлд хайртай болсон байх нь.

Өнөөдөр Итгэл дахиад л гараас нь бариад авбал яах вэ? Өчигдрийх шиг хамаг бие салгалаад явчих болов уу?

-Алтаа, 1000 төгрөг зээлээч. 500 байсан ч яахав автобусны мөнгөгүй болчихож гэх дуунаар бодол нь тасарлаа. Түүнтэй нэг ээлжинд ажилладаг Отгоо гэдэг асрагч бүсгүй зогсож байв.

Намуун түүнийг хараад инээмсэглэнэ. Отгоотой тааралдах бүрд инээмээр санагддаг юм. Яагаад гэвэл Отгоо бол түүний учирч явсан хамгийн гэгээн сэтгэлтэй бас үргэлж инээж явдаг хүмүүсийн нэг. Нүднийх нь харц тув тунгалаг. Яг л бүртийх ч үүлгүй зуны тэнгэр шиг. Амьдрал нь гэж, зах зухаас нь сонссон хүн өмнөөс амиа тавьчихмаар дэнүү хүнд. Тэр их зовлонг энэ турьхан биендээ яаж дааж явдаг юм бол гэж гайхмаар ч тэр үргэлж инээж, баяр баясгалангаар дүүрэн явна. Хойд эцэг нь архи ууж шөнөжин агсам тавьдаг, ээж нь бөөрний өвчтэй хэвтэрт байдаг, 3-н дүү нь сургуульд сурдаг, 6-уулаа зуны дан байшинд суудаг гэж Намуун сонсоод Отгоог өрөвдөхөөсөө илүү биширсэн билээ. Намуун түрийвчээ яаран гаргаж 1000 төгрөг гаргаж өгөөд:

-1000 болох уу? 5000-ыг авах уу? гээд асуучихлаа. Отгоо инээд алдаад

-Яах юм бэ? Тийм их мөнгө авчихаад дараа нь өрөө төлөх гэж цалингүй хоцорно ш дээ. Одоо л гэхэд би 10 мянган өртэй, энэ мөнгөнөөсөө Жаагаад зуугийн дэвтэрнээс 2-ыг аваачиж өгнө. Манай тэр дүү онц сурдаг. Том болоод мундаг хүн болох байх гэж би боддог юм гэсэнээ -Чи яасан баян байх юм? Хүүе ээ өнөөдөр яасан хөөрхөн харагдаж байна гээч? Нүд чинь гэрэлтээд л... өчигдрийн гоё залуу чиний найз уу? Би тийм найзтай болох юм бол.. за за үг олдох нь явж ажлаа дуусгая... Мөнгө зээлүүлсэнд ёстой их баярлалаа гээд инээмсэглэн гарч одлоо.

Түүнийг гарсны дараа Намуун өөрөө ч инээмсэглэсээр байгаагаа мэдрэв. Ийм нэгэн гуниггүй хүний үр байх юм даа. 10-дугаар сар хаалга тогшиж байхад рэзин ултай зуны кэттэй инээгээд явж болдог л юм байна даа.

Гэтэл Итгэл.. угааж буй цонхны нь дор сигналдан түүнийг дуудав. Яг цонхон дор машин сигналдахыг догдлон буй зүрхнийхээ цохилтоор мэдрэв. Шагайж харвал Итгэл ирчихсэн

байлаа. Түүнийг шатаар нисэх мэт харайлгасаар гарч ирхэд тэр машиныхаа хаалгыг налчихсан зогсож байв. Учиргүй яаран гүйж явсан бүсгүй түүнийг хараад ичингүйрэн зогтусаад үсээ илэн духайсаар очлоо.

Итгэл өчигдрийх шиг үсээ босгож гээлдсэн, цамцтайгаа адилхан ногоон лак цацан солонгос киноны жүжигчид шиг хачин гоё амьтан иржээ. Дэргэд нь очингуут Hugo Boss сэнгэнээд явчихав. Бороо ч зогсож, чийг үнэртэнэ.

-Сайн уу?

-Сайн..

-Зургаа болохыг хүлээж цаг луугаа харсаар байгаад өдрийг өнгөрөөлөө. Өнөөдөр цаг ерөөсөө явж өгдөггүй ямар сонин өдөр вэ? гээд Итгэл машиныхаа урд хаалгыг онгойлгож өгөөд Намууны нүд рүү ширтэн:

-Чи урд суучих л даа гэж гуйлаа

-Энэ чинь хадам ээжийн суудал биз дээ?

-За тэг л дээ. Чамайг ард суучихаар би толь руу өлөлзөж яваад осол хийчихвэл яах юм бэ

-За тэхээс дээ гээд Намуун машин руу орохдоо сувилагч нарын өрөөний хөшиг аяархан хөдлөхийг нүднийхээ булангаар ажиглаад "Сараа гуай тагнаж байх шив дээ. Юм олж долоох л юм бол тагнатугай" гэж доогтойхон бодож суулаа. Тэр 2-ыг эмнэлгийн хашааны хаалгаар гарч явахад Отгоо нэг тортой юм барьчихсан хурдан хурдан алхан явснаа Намууныг машинд байхыг олж хараад инээмсэглэн гар даллав. Надтай хамт асрагч хийдэг охин, их хөөрхөн ааштай хүүхэд гэж Намуун хэлээд дуугай болов. Итгэл:

-Аанха хэмээн толгой дохиод хаазаа нэмлээ. Тэр 2-ын яриа эвлэрч амжаагүй л байлаа. Итгэл хөгжмөө асаахад рок хөгжмийн дуу нам гүмийг эвдлээ. Намуун рок сонсох дургүй гэхдээ энэ дуу нэг л танил, дурсамжийг нь хөндөх шиг санагдсан тул юу билээ гэж гайхширан ой ухаан бүрээ санах гэж оролдов.

-Арай чанга байна уу? Энэ Ramstein гэж хамталгийн Duh Haust. Анх чамтай танилцахад Lazer land-д энэ дуу явж байсан ш д. Тэгээд л би машиндаа энэ дууг дандаа тавьдаг юм.

-Нээрээ тийм байна, нэг л танил дуу санагдаад байсан юм гээд Намуун түүн рүү харахдаа "нээрээ надад хайртай юм байна, надтай танилцахад явж байсан дууг хүртэл ингэж санаж байдаг" гэж бодоход магнай хагартал баярлан, үнсмээр тийм дотно санагдахыг мэдрэв.

-Энэ дуунаас үүдэн ам ч хагарав. Манай 2 явсаар Тэнгисийн өмнө ирлээ. Итгэл аль хэдийн тасалбар авчихсан байж. Синема руу орохдоо тэр Намууны гараас хөглөөд шатаар өгсөв. Бүсгүй гараа татаж авах гээд дийлсэнгүй. Түүний гар дулаахан, бас чанга ажээ. Кино эхлэх арай болоогүй байлаа. Итгэл ундаа, попкорн авч ирээд Намуунд өгснөө үсийг нь илэн:

-Би чамайг өчигдөр шөнөжин бодсон. Тэгээд утсандаа дүүрэн мсж бичлээ. Гэтэл явуулах утас байдаггүй. Тэгээд өнөөдөр чамд энэ утсыг авсан юм. Авахаасаа битгий л дургүйцээрэй гээд Нокиа гаргаж өглөө. Намуун барьж байсан ундаагаа тавиад утсыг авсанаа инээгээд "Хэрэв би авахгүй гэвэл яахав?" гэснээ мсж-ийг нь нээж үзлээ. "Зулаа, миний хайр аа, би чамайг аймаар их санах юм. Одоо нэг саг болж байна. Би сарыг хараад зогсдог байна, чи сарыг харж байна уу?, Сайхан нойрсоорой миний хайр аа." Намуун түс хийтэл инээд алдаад:

-Чи шал буруу бичдэг юм байна ш дээ, цаг гэж бичхэд чинь TS гэж бичдэг юм биш үү? Тэгсэн саг гээд буриад аялгатай биччихсэн байгаа юмаа. Эсвэл чи буриад юмуу? Би тэгээд ээждээ энэ утсыг яаж авсан гэж хэлэх юм бэ? гэхэд Итгэл ийнхүү үг сүтгүй шоолсонд нь нилээд

гомдчихоод:

-За яахав дээ, хүнээс мөнгө зээлээд гээд л хэлчихгүй юу гэж ийш тийш сэлбэлзэн, толгой хаялж суув. Намуун ч гомдсонг нь мэдээд:

-Яасан, гомдчихсон уу? Би энэ утсыг чинь аВлаа. За юу? Урьд нь надаа бас нэг Нокиа байсан юм. Зарчихсан байхгүй юу. Яг мэдсэн юм шиг Нокиа авч өгсөнд баярлалаа. Итгэл гараас нь барьж нүд рүү нь ширтээд:

-Би өчигдөр чамайг санаад л баахан мсж бичсэн. Өчигдөр шөнө бараг унтаа ч үгүй. Өглөө хичээлдээ явахаасаа хамаагүй өмнө сэрчихсэн, ээж бүүр гайхаад л.. чи өөрийнхөө тухай надад ярихгүй юм уу? гэлээ.

Тийм ээ, тэр өчигдөр Намуунд өөрийнхөө тухай чин сэтгэлээсээ ярьсан. Аав нь салаад явсныг, ээж охин дүү 2-тойгоо байдгаа ярьсан. Харин Намуун нэрээ хүртэл худлаа хэлээд явж байгаа шүү дээ.

-Би чамд ярьсан ш дээ. Ээж ажил хийдэггүй. Аав манаач гээд. Би үхрийн ордных. Үхрийнхэн бусдын хайр хүндэтгэлийг хүлээсэн, хариуцлага ухамсарласан хүмүүс. Ойр дотныхондоо эелдэг зөөлөн ханддаг. Өөрийгөө сайн хянаж чаддаг. Ухаандаа захирагдахаасаа илүү зөн билэгтээ захирагддаг. Бусдаас санаа бодол, сэтгэл хөдлөлөө нуудаг. Баргийн юманд уурлахгүй боловч нэг уурлахаараа аймшигтай байдаг юм даа. Надад ордны зурхайн бүх шинж яг таардаг юм. Намуун ийнхүү ярьж байхдаа гараа Итгэлийн атгалтаас татаж авсангүй суусаар байгаагаа сая л мэдэрлээ. Энэ залууд гараа бариулчихсан ийнхүү суугаад л баймаар санагдах аж.

Эргэн тойрон өчнөөн хүн амьтан холхихыг анзаарахгүй суугаад л баймаар. Гэрэл киноны хонх дуугарч манай 2 хөтлөлцсөөр орлоо. Кино театр гэдэг хайртай хосыг нийлүүлэн суусаар нэг л мэдэхэд кино дуусч The End гэсэн бичиг нь гарч ирлээ. Киноны дараа Алтанзул болж жүжиглэсний гай гарч айлын гадаа бууж үлдэх боллоо.

Одоо яаяа гэхэв дээ, өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр гэгч л боллоо. Айл болгон хоолоо хийж хоолой хорсгосон утаа хөшиглөн, ноход дуу дуугаа авалцан хуцна. Итгэл хайртыгаа буулгаад хацар дээр нь зөөлөн илбээд - Баяртай. Мэссэж бичээрэй. Нээрээ мартаж шахлаа. Маргааш надад нэг зургаа аваад ирээрэй. Эсвэл одоо гэрээсээ гаргаад өгөх юмуу? гэхэд Намуун гараа занган - Хэрэггүй, хэрэггүй. Би маргааш хамгийн гоё зургаа өгье гэж Итгэл одоо л тэр айлын хашаа руу орчих гээд байгаа мэт сандрав. Тэгэхэд нь гэр, хашаанаасаа ичсэн юм байх гэж бодсон Итгэл машинаа асаагаад - За, тэгвэл баяртай. Маргааш би дахиад ажил дээр чинь очноо гэв. Үе үехэн сэвэлзэх салхинд түүнээс үнэтэй сүрчигний тааламжит үнэр зөөлөн анхилах аж. Намуун ногоон хаалгатай хүрэн хашааны үүдэн дээр гар даллан хоцорлоо. Гар утас аваад өгөхөд бараг надаас илүү ажиллуулж байдаг. Тэр хувцас хунар нь даруухан мөртлөө зохицолтой, цэвэрхэн, бас юун гоё үнэртэй ус түрхдэг юм бэ. Асрагч гэхэд латин үсгийн нийлэмжүүдийг тийм сайн мэдэж байдаг. Нэг л биш дээ гэж Итгэл гайхан бодож явлаа. Түүнийг машинаа тавьчихаад гэртээ ороход ээж нь гал тогооны өрөөндөө ганцаараа цайлж суулаа. Кинон дээр баахан попкорн идчихсэн болохоор Итгэл цагталан байсан тул нэг аяга жүүс хийж аваад өрөөндөө орлоо. - Миний хүү цайгаа уухгүй юмуу? гэсээр ээж нь араас нь даган орж ирэв. Түүнд ганцаараа баймаар байсан тул үгүй үгүй гээд хөгжмөө асаав. Нөгөө Духаст нүргэлэв. Энэ бол ээжийгээ өрөөнөөс гараач гэж соёлтойгоор шаардаж байна гэсэн үг билээ.

Сүүлийн үед өглөө хар үүрээр босоод л, байдгаараа гоёод л шөнө тэнэхээ болиод л энэ хүүхэд нэг л биш ээ. Ямар охинтой танилцсан юм бол оо? гэж ээж нь бодсоор гал тогооний өрөө рүүгээ орлоо. Итгэл ээжийнхээ араас харахдаа ээжид ингэхэд уулздаг хүн байдаг бол уу? Аавийг явснаас хойш өчнөөн жил өнгөрч байна шүү дээ гэж бодоод өрөвдөх шиг болжээ. Цолмон үүдний өрөөнийхөө толинд өөрийгөө зэрвэс хараад санаа алдсанаа гал тогооны өрөөндөө оров. Ганц бие эмэгтэй гал муутай нүд ганцаардлаасаа айсан харц, завьж, зовхиндоо суусан нарийхан нарийхан үрчлээснүүдийг харах ямар олиг байхав дээ. Хонх чарлуулсаар бөөн инээд хөөр болон орж ирэх охиноо хараад л тэр жаахан тайвшрав. Яаран сандран гутлаа солиод л гал тогооны өрөө рүү дайран орж ирсэн Навчаа охин гараа угаалгүйгээр тавагтай өргөст хэмх рүү дайрлаа. Өөр цагт бол тэр наад гараа угаагаач, ингэж байгаад шарлах нь хэмээн өргөст хэмхийг ам руугаа хийхээс нь өмнө булааж авах байсан. Гэтэл энэ удаа тэгсэнгүй - Миний охин суу, цаад ах чинь найз охинтой болчихсон юмуу? ээждээ үнэнийг нь хэлчих л дээ хэмээн шалав. Аавынхаа гялалзсан нүд, үрэлгэн хөнгөн занг дууриасан охин нь тас тас хөхрөөд - Нууцыг нь хэлчих юм бол та надад VOV-ийн юмнуудийг иж бүрнээр нь авч өгнө биз дээ хэмээн наймаалцсанаа - За за тоглосон юм, ах нэг охинтой уулздаг болчихсон юм шиг байна лээ. Би өнөөдөр ажил дээр нь очсон чинь гараад явчихсан байсан. Ах чинь цаг руугаа байн байн хараад 6-н цагт л гараад явчихдаг болсон ш дээ гэж Жака хэлж байна лээ. Би мэссэж явуулсан чинь хариу ирээгүй. Арай өдийд гэртээ ирчихсэн юм биш биз дээ гэснээ утас дуугарангуут ухасхийлээ. Удалгүй ах аа нөгөө Сэни ярья гэнээ гэх дууддаж *Байхгүй* гэж хэл гэх Итгэлийн уцаартай хариу сонсогдлоо.

Нөхрөөсөө салснаас хойш толгой нь их л сийрэг ажиллах болсон билээ. 6 цагт уулзах гэж явдаг гэдэг чинь ажил хийдэг хүүхэд байх нь ээ. Маргааш Итгэлийг дагадаг хэрэг гэж тэр бодож байцаа хэрчиж зогслоо. Хүү нь ээжийнхээ хийсэн байцаатай хуурганд нугасгүй дуртай атлаа тэр орой тавагтай хоолоо бараг тэр чигээр нь хөргөгчинд хийчихээд мэссэж бичсээр суугааг Цолмон ажиглалгүй өнгөрсөнгүй. Уг нь хам хум хоол идчихээд компьютер шагайж сууснаа найзуудтайгаа жаахан явж байгаад ирье гээд л гарч алга болдог сон. Эр хүн залуу насандаа зугаалж л яваг гээд тэр хүүгээ хорьдог ч үгүй. Бусад айлын хөвгүүд шиг архи ууж чихийг нь халууцуулах биш. Ээжээсээ мөнгө авах биш. Надад сайн хань таараагүй ч бурхан алт шиг хүү заяасан гэж тэр сэтгэлээ тайтгаруулдаг. Өдийд сургуулиа төгсч байх ёстой хүн ээжийнхээ дэлгүүрийн ажилд туслах гэж чөлөө аваад 2 жил зүтгэсний хүчинд тэднийх 2 өрөө байраа 4 өрөө болгож, эмэгтэй хувцасны дэлүр нь хөл дээрээ босч чадсан билээ. Цолмон уг нь хүүгээ эрдэмтэй хүн болгъё гэсэн мөрөөдөлтэй явдаг тул сургуулиас нь чөлөө авхуулах дургүй байсан. Гэтэл хүү нь *Ээж минь тэгэж ярьвал би тэр сургуульд чинь сурахгүй ч байсан яадаг юм Билл Гейтс дээд сургууль төгсөөгүй мөртлөө одоо дэлхийн хамгийн баян хүн болчихсон л байна. Таны геофизикч мэргэжил өнөөдөр хэрэг болж байгаа юм бол та яагаад дэлгүүр ажиллуулж байгаа юм? Миний оролцоогүйгээр энэ дэлгүүрийн ажил нэг их ирээдүйгүй* гэж билээ. Нээрээ л хүү нь Москвагаас Итали гутал зөөж байгаад Италийн нэг гутлын фирмийн гэрээт борлуулагч болж чадсан билээ. Тэр өнөөдрийн орлогоо бодчихоод зурагт асаан Оросын тв-ийн хэдэн суваг солин үзэж суутал цаг их л орой болчихсон байв. Сурсан зангаараа 2 хүүхдийнхээ өрөөгөөр орж хөнжлийг нь засаж, юмыг нь эмхлүүлэхээр бослоо. Итгэлийн хувьд энэ орой ёстой Hot msg-ний орой боллоо. Урьд нь тэр тохиолдлын амрагуудтайгаа ингэж оройжин мэссэждэж үзээ ч үгүй билээ. Их сайндаа л уулзах газраа бичиж явуулах ч юмуу, гэрийнх нь гадаа очоод хурдан гараад ир гэх ч юмуу, товчхон мэссэж бичдэг байсан. Юугаа бичдэг байна аа? шал нялуун юм гэж боддог нь ч яалаа. Ээжийгээ

өрөөгөөр нь шагайхад ч инээд алдчихсан хайртынхаа мэссэжийг уншиж хэвтсэн агаад ээждээ сайхан амрахыг хам хум өргөөд хариу бичих ажилдаа орсон билээ. Маргааш нь баасан гариг байлаа. Өчигдөрхөн тэнгэр хамаг муухай аашаа гаргаж байгаагүй юм шиг тув тунгалаг өглөө байлаа. Намуун Итгэлээс *сайхан амарсан уу? миний хайр аа? би хичээлдээ явах гэж байна, орой хуртэл бу* /Итгэл буе гэж бичиж чадахгүй буруу бичсэн юм шүү/ гэсэн мэссэж аваад инээмсэглэн бослоо. Өчигдөр тэр бүрхэг салхитай орой Хайлаастад Итгэлээр хүргүүлж оччихоод такси олдохгүй, арай гэж микро автобусаар харьж ирсэн билээ. Тэгэж яваад аавынхаа компаний нэг ажилтантай тааралдаж баларсан агаад өөрийгөө хараагүй байх гэж найдсаар буусан билээ. Намуун хотын төвд ирээд микро автобуснаас бууж таксидан баахан будилж яваад эзгүй гэртээ харьж иржээ. Гэрийн үйлчлэгч нь хоол хийгээд ширээн дээр орхиснийг мангас шиг ховдоглон идээд нохойгоо эрхлүүлэнгээ баахан мэссэж бичсээр нэг л мэдэхэд орондоо орох болчихсон байв. Эмээтэйгээ утсаар ярьчихаад э-майл-аа шалгачихаад хэвтсэн хойно ээж, аав 2 нь цувран ирцгээгээд ажлаа ярин маргалдаж байгаад оройтож унтсан нь түүний хувьд аз болов. Жавхаагаас Хаая хаая би их завгүй бна. Маргааш заавал уулзана шүү Хасар чамайг утасаа яагаад авахгүй байгаа юм бол гэж байсан за баая гэсэн мэссэж иржээ. Өнөөдөр эмээгийн дээ очвол эмээтэй заавал ямар нэг юм ярих болно, аягүй бол Жавхаа ороод ирнэ. Гэртээ бол өөр хэрэг. Цэлийсэн том байранд гав ганцаараа. Хашаан доторхи Банхар, гэрт байдаг Мики хавыг эс тооцвол ганцаархнаа, жинхэнэ эрх чөлөөг амтална гэсэн үг. Банхар гэснээс саяхан аавынх нь найз асар том монгол нохой бэлэглэсэн хэрэг. Намуун Итгэлийн захиснийг гэнэт санаад зургийн хэдэн зузаан цомгоо гаргаж ирээд эргүүлж гарлаа. АНУ-д сурч байхдаа, аав ээжтэйгээ Парист амарч байхдаа, Бээжинд, ээжтэйгээ Schweichar-г амарч байхдаа авхуулсан зургууд янз янзаараа байсан нь санаанд нь нэг л таарахгүй байлаа. Уг нь Синга-д авхуулсан уран сайхны зургууддаа тэр дуртай байдаг ч арай л гоёдох гээд байв. Тэгэж тэгэж Хөвсгөл нуурийн эрэг дээр аавынх нь авсан зураг гараад ирэв. Энэ л яг таарна гэж амандаа хэлээд цомгоос салган авлаа. Тийм ээ, яг таарна. Хэн нэгэн Алтанзул Хөвсгөлд амарсан гэхэд гайхахгүй шүү дээ. Нуурийн цэнхэр долгиос наадсан элсэн дээр Намуун инээмсэглэн суугаад аав нь яг мэргэжлийн зурагчин шиг л сайн буулгаж авчээ. Давалгаагаар наадагч шогч салхинд задгай богинохон үс нь хийсэн, өвдгөө тэврэн суугаа Намуун зураг авч байгааг ч мэдээгүй билээ. Харин бусад зургууд дээр нэг бол гэр нь, эсвэл машин нь гарчихсан эсвэл дандаа гадаадад авхуулсан байх ажээ. Өглөө Намуун нилээд оройтож сэрээд сандран бослоо. 1-р паараа тасалчихжээ. Яагаад сэрүүлгийн дуунд сэрээгүйг бүү мэд. Өчигдөр их л сэтгэл дүүрэн унтсан нь өглөө ийнхүү үхсэн мэт нам унтахад хүргэсэн бололтой. Цонхоо нээвэл нар дөнгөж мандаж байлаа. Тэдний хашааний таримал зүлэг мөнгөн хяруунд хучигдан цайрах нь дөнгөж мандаж буй нарны туяанд солонгороод дэндүү гоёхон харагдана. Тэр угаалгын өрөөнөөс гараад яаран хувцаслав. Уг нь Итгэлд гоё харагдмаар байсан ч цаг давчуу байсан тул өөрийнхөө өмсөх хамгийн дуртай битүү захтай цэнхэр цамцыг шүүрэн авч өмсөн, биед эвтэйхэн хуучин Levis жийнс углаад толинд харлаа

Үсээ ардаа шууж цэнхэр шигтгээтэй ээмэг зүүсэн чинь бүүр ч аятайхан болчих шиг санагдлаа. Эмэгтэй хүн өөртөө таалагдсан үедээ их л сэтгэл хангалуун байдаг ёсоор тэр инээмсэглэн толио шагнаад доошоо буув.

Тэр ердийн их дэлгүүрийн шилэн лангуунаас буугаад ирсэн үзмэрийн хүүхэн шиг учиргүй гоёхоос ичээд байдаг юм. Тэдний ангийн зарим охид өндөр өсгийт, костюм өмсөж хичээлдээ ирдгийг хараад түүний инээд хүрч өмнөөс нь нүүр хагарах шиг болдог аж. Түүнийг доод

давхарт бууж ирэхэд ээж нь босчихсон байв. Аавынх нь хэлдгээр ямар тахил нь буруу өргөгдсөн юм бүү мэд, энэ өглөө их л ааш муутай босжээ. Торгон халатаа намируулан нааш цааш алхлан үе үе нөхөр охин 2 руугаа хялалзан чи гэрийн бараа харах хүн үү үгүй юу? гэж Намуунийг загнав. Бодвол өчигдрийн маргаанд санасандаа хүрч чадаагүй биз. Аав нь халатаа нөмөрч, нойр ханаагүйгээс нүд нь сэмбийчихсэн ч хэзээний зангаараа сайхан ааштай сэрсэн бололтой охин руугаа нүд ирмэчихээд угаалгын өрөө оров. Ээж нь Мики хавыг тэвэрчихсэн өрөөнөөсөө гарч ирээд намайг гэрт ирэхэд баярладаг амьтан энэ нохой л байх шив хэмээн үглэнгээ гар утсаа авч компанийхаа хэн нэгнийг загнаж гарав. Намуун ч ширээн дээр байсан аяга жүүсийг залгилах зуур ээж одоо хар өглөөгүүр хэнийг загнадаг байнаа хэмээн бодсоор хичээлдээ гарч одлоо. Эдийн засгийн онолийн семинартай өдөр таарчээ. Мани хүн юу ч бэлтгээгүй боловч англиар уншсан хэдэн номын ачаар арай ч таг дуугүй суугаад байсангүй. Завсарлагаагаар ангийнхаа охидтой гуанзанд ундаа ууж байтал Итгэлээс мэссэж ирэв.

Өглөөний мэнд хүргье, өнөөдөр хоньны ордныхон болгоомжтой байх өдөр шүү орой болтол баяртай чамд маш их хайртай шүү баая гэснийг уншаад инээмсэглэхийг харсан ангийнх нь Номин гэдэг охин - Манай Намуунаа дахиад дурлчихаа юу? Хасартайгаа сайндаа юу? гэхэд нь л сая Хасар гэж нэг хүн түүний амьдралд байсныг санажээ. Одоо түүнд Итгэл байгаа юм чинь тэр өөдгүй амьтны тухай дурсахийг ч хүссэнгүй. Харин хичээлийнхээ дараа түүнийг ажил руугаа очихоор таксинд суухад яг араас нь аавынх нь туслах Оргил даган хөдөлснийг тэр мэдсэнгүй. Яаж ч мэдэх билээ. Ямар ардаа нүдтэй биш. Ажил дээрээ ирээд ногоон хувцасаа өмсөж аваад өдөр бүр хийдэг өнөө л ажлаа яагаад ч юм, нэг л баяр хөөртэй эхэллээ. Гайхалтай нь нөгөө Саранчимэг хүүхэн өнөөдөр түүнтэй тааралдсангүй. Орой ажил тарах үеэр хувцасны өрөөнд шуугилдан орж ирсэн хэдэн хүүхэн шинэ гар утсыг нь хараад бөөн шагшаан болцгоов. 0--сүүлийн үед чамайг улаан жийптэй ирж аваад байгаа ганган залуу өгөө юу? тэр ч харваас дэндүү дээгүүр зиндааны залуу байна лээ. За миний дүү ашиглуулаад хаягдана гэж нэг юм байдаг юм шүү дээ гэж Дука хэмээх сувьлагч хүүхэн атаархсан өнгөөр хэлэхэд бусад нь харин тийм, дэндүү дээгүүр сэвэх дэмий шүү. Зиндаа таарсан юмаа л олж авсан нь дээр гэгцгэв. Тэдний нүдэнд нэгнийгээ өөрсдөөс нь илүү гарахад өөрийн эрхгүй хүнд тордог атаархлын гал гялалзах ажээ.

Тэдэнтэй л адилхан микро автобусанд шахцалдан явдаг, хаа нэгэн газар хаалгач юмуу манаач, мужаан хийдэг эсвэл ажилгүй, хувцас муу царай дорой, хэн нэгэн Баагий, Чуукаатай биш ганган машин хөлөглөсөн, дэгжин залуутай уулзаж байгаагаараа Намуун атаа жөтөөг нь байж ядтал хөдөлгөчихжээ. Гэтэл цаашаа хараад яаран хувцаслаж байсан Отгоо л ганцаараа Намууныг өмөөрч - та нар одоо Алтаад атаархаад байгаа юмуу, тэр залуу нь жинхэнээсээ хайртай ч юм бил үү, та нар яаж мэдэж байгаа юм? Харж л байгаарай удахгүй энэ 2-ийн хурим болно доо гэхихээд хоолны үлдэгдэл хийсэн уутаа авч гараад явчихлаа. Хүнд хүчир амьдралдаа хэзээ ч гутардаггүй үргэлж гэгээ татуулан инээж явдаг тэр охины хэлсэн үг дэндүү үнэн үг байсан тул хэн ч юм хэлсэнгүй. Намуун ч юу ч болоогуй юм шиг за бүгдээрээ баяртай гээд гараад явчихав. Шатаар уруудаж явтал Дукагийн хэлсэн дэндүү дээгүүр сэвэх дэмий шүү гэсэн үг бодогдоод гэнэт түсхийтэл инээчихэв. Инээдтэй мөртлөө гунигтай юм. Хүмүүс бүгд л үхэх үйлтэй, уйлдаг, инээдэг, нэгэн цаг үед амьдарч байгаад л нэгэн үед цөмөөрөө шатаж дуусч буй лаа шиг унтраад газрын хөрсөнд шингэх мөртлөө яагаад ингэж бие биенээ дээгүүр, доогуур гэж ялгаж байдаг юм бол? Өнөөдөр жаргаж зовж амьдарч яваа энэ бүх хүнээс 100-н жилийн дараа бараг нэг нь ч амьд байхгүй шүү дээ. Бурхан Буддагийн сургаснаар бүх юм хоосон чанартай юм биш үү? Намуун гадаа гараад эмнэлгийн хашаан

доторхи модон сандал дээр суулаа. Итгэл замын түгжрэлд саатсанаа саяхан хэлсэн тул гадаа суун хүлээхээр шийдэв. Бүсгүй 10 дугаар сарын элч нь буугаагүй наранд нүд гялбан байж залуу улиасны тасраагүй үлдсэн нэг навчийг авлаа. Их бие нь шарласан ч иш ногооноороо байв. Тэр тасрах болоогүй навчийг тасалчихсандаа гэмшин хөл доороо хөглрөх ахан дүүстэй нь нийлүүлээд үүргэвчээ онгойлгов. Түүнийг ирэхээс өмнө өөрийнхөө гар утсыг шалгадаг хэрэг ээ. Дуут шууданд ээжийнх нь яриа үлдсэн байв. Намуун аа, юу хийгээд галзуурч яваа хүн бэ чи? Би одоо завгүй байна. Эмнэлэгт ажил хийж байгааг чинь сая л мэдлээ. Орой зугтаж алга болсны хэрэггүй шүү. Ээж нь их л уурлахаараа галзуурах гэсэн үгийг хэрэглэдэг билээ. Балай юм, энд ажиллаж байгааг мэдчихэж. Уурласан үед нь өөдөөс нь олон юм ярилгүй дуугүйхэн л байсан нь дээр. Тэгвэл нэг хэсэг цамнаж байгаад тайвширдаг хурц зантай, шинжлэх ухааны хэлээр бол их холерик хүн билээ. Нэгэнт ээж нь мэдчихсэн юм чинь Итгэлд хэлчихдэг юм бил үү? гэж тээнэгэлзэж суутал Итгэлийн машин хашааны хаалгаар ороод ирлээ. Өөрийг нь хараад баруун гараа өргөн даллах Итгэлийг хараад энэ бүх холион бантанг тайлбарлахад өөрийгөө бэлэн биш байгааг л мэдэрчээ. Тэр өөдөөс нь бас инээснээ гэнэт өөрийнхөө Мотороллаг яаран сандран унтраагаад үүргэвчнийхээ ёроол руу хаяад бослоо. Түүнийг машин руу очиход Итгэл нөгөө л Духастаа тавьчихсан сууснаа хаалгаа онгойлгож өглөө.

Намуун урьдынх шигээ бишүүрхсэнгүй хажууд нь суугаад урд толинд нь харж үсээ янзлаад - Наад дуунаасаа уйдаагүй байна уу? - Үгүй шүү, хэзээ ч уйдаагүй. Ингэхэд чи өнөөдөр дэндүү хөөрхөн харагдаж байна шүү гээд нүд рүү нь ширтэн хацрыг нь илснээ уруул дээр нь үнсээд авлаа. - Болиоч ээ. Намууний үсний уг хүртэл улайсан байв. Итгэл ийм зориг гаргачихсан хойноо царай нь бага зэрэг улайгаад машинаа асаалаа. Зам руу орсон хойноо тэр өнөөдөр юу хийх тухай Намуунаас асуулаа. Хүүхдийн паркад очъё гэж бүсгүй хэллээ. Паркад очоод нөгөө зургаа гарган Намуун Итгэлд өгөв. - Ёстой гоё гарсан зураг байна. За энийг чинь түрийвчиндээ хийнэ ээ гэхэд нь Намуун сандран - Би тийм муухай юмуу? - Яалаа гэж дээ Мэрилин Монрогоос хөөрхөн гэж сандран хэлээд түрийвчээ гаргаснаа өөрийнхөө зургийг гарган түүнд сарвайлаа. Тод цэнхэр цамц өмсөж их л донжтой гарсан зураг байв. - Надад ч гэсэн чи Бред Питтээс хөөрхөн залуу гээд Намуун хажуудаа унасан навчнаас авч толгой дээр нь унагаад босч зугатав. Энэ өдөр Итгэл Намууны зургийг янз янзаар авч хадгалав. Нэг мэдэхэд цаг 9 болж байгааг хараад Намуун харихаар яаран сандрав. Итгэл хоолонд орьё гэж хичнээн гуйгаад дийлсэнгүй. Намуунд энэ урилгаас татгалзах мундахгүй олон шалтгаан байлаа. Ээж нь бүгдийг мэдчихсэн болохоор одоо гэрт нь аянганы үүл хуралдчихсан байгаа. Түүнээс гадна зоогийн газар хэн нэгэн таньдаг хүн нь тааралдвал төвөг. За тэгээд Хайлаастад бууж харанхуйд үлдэх хамгийн дэмий. Манай 2 ам хуурайгүй ярьсаар Хайлаастад ирлээ. Нөгөө л цагаан худаг, ногоон хаалгатай хашааныхаа дэргэд Намуун бууж гэртээ орох гэж байгаа хүн болон хоцров. Итгэлийг машинаа хөдөлгөнгүүт тэндээс холгүй мухар гудамжны цаанаас нэгэн саарал Соната чимээгүйхэн гулсан одохыг тэр 2-ийн хэн нь ч мэдсэнгүй. Тэр машиныг манай дурлалт залуугийн ээж Цолмон барьж явлаа. Хүүгээ ямар бүсгүйд сэтгэл алдран гүйгээд байгааг мэдэх гэж ээж нь өнөөдөр Шерлок Холмс болох шахсан нь тэр. Дэлгүүрийнхээ хамаг ажлыг дүү хүүхэндээ даатгаад хүүгээ өдөржин дагаад мэдьё гэсэн юмаа мэдэж чадсан эх сэтгэлийн бөөн хямралд ороод буцаж яваа нь энэ.

Хоёрдугаар амаржихад анх дуугаа хадаан мэндэлсэн энэ 20-н жилд хүү нь ээжийнхээ урамыг ингэж хугалж байсан удаагүй.

Даанч дээ. сургууль соёл ч үгүй, нэг хувийн эмнэлгийн асрагч охинд ингэж хөл алдаж гүйх гэж дээ.

Гэр нь Хайлаастанд байхдаа яахав дээ.

Хүний энэ олон сайхан охид дотроос мэргэжил боловсролтой, хүн шиг амьдралтай хүүхэд олноогүй л юм байх даа, хүүгээ яаж татаж авах бэ? гэж тэр хүнд бодолд дарагдан явсаар хотын төвийн шуугиант гудамжинд орж ирэв.

Бодолдоо дарагдан яваад гэрийнхээ хажууд нохой дайрах дөхөөд ухаан оров.

Гар утас нь дуугарахад клипээ охин л залгаж байгаа бололтой.

Гэрийн нь утас байсан ч авсангүй. гараашнийхаа хаалганийг олно жолоого дэрлэн суусаар байв.

ямар ч байсан хуудээ ширүүлж болохгүй. эвтэйхэн аргаар л энэ охиноос салгах хэрэгтэй гэж бодсоноо дахин уур нь хүрчихэв.

Ийм үед ядаж үгийг нь сонсоод гангар гунгар ярьж суух хань үгүй дээ хачин их гуниглав. 6-н жилийн өмнө салсан нөхрөө амьдралаасаа арчин хаясан гэж бардам боддог Цолмон энэхэн мөчид дэргэдээ байхгүйд нь үнэнгээсээ харамсжээ. тэгснээ дүү хүүхэн рүүгээ залгав.

-За эгч сүртэй ш дээ. хүүхдүүд үерхэж байгаад л больно биз. Дөнгөж 20-той хүүхдүүд ямар суух гэж байгаа биш манай Итгэл янз янзын хөөрхөн охидтой хамт явж байгаад л боличихдог ш дээ гээд дүү нь тоосонгүй. гэртээ орж ирвэл хүү нь байсангүй. ахыгаа Жака-тай хамт гараад явсан гэж охин нь хэлээд ээжийнхээ царай руу гайхан харчихаад өрөөндөө оров.

Охиных нь өрөөнөөс чихэнд чийртэй хип хоп хөгжим сонсогдож жамаараа шинэхэн өдөр айлчлан ирлээ

Өглөө болоод нүдээ хялам хийлээ хэмээн үглэх нь хөгжимийн хэмнэлтэйгээ нэгдэн толгой руу нь модон алхаар аяархан аяархан нүдэх мэт . Наад хөгжимөө аяархан болгооч гэж тэр охиноо зандраад хүүгийнхээ өрөө рүү оров.

Ширээн дээр шинэ Nokia утасны хайрцаг , Mobicom-ын оютны дугаар худалдан авсан гэрээний цаас хэвтэнэ.

Үгүй ер, тэр охиндоо гар утас дугаартай нь авч огсон байх нь ээ. хэрэг явдал өөрийнх нь төсөөлснөөс илүү хурдан өрнөж байгаа байх нь. Тэр ганц хүүгээ мэдэлгүй яахав дээ. яахав Цолмон сайн georshyciskch байгаагүй , магадгүй сайн энхэр ч байгаагүй болоод л нөхөр нь өөр хүүхэн дагаад явсан байж болох юм. Харин тэр гайхалтай сайн ээж байж чадсангүй. Хүүгээ хэдэн настайдаа юу сонирхож, хэнтэй найзалж ямар хичээлдээ дуртай, ямарт нь дургүй байсанг тэр нэвтэрхий мэднэ. бүр хэзээ сэм сэмхэн гар хангалга хийгээд байх болсонг нь ч хэзээ тэр томоогүй зуршилаа орхисонг нь ч андахгүй мэднэ. тиймдээ ч тэр асрагч охинтой зүгээр нэг хөтлөлцөөд гүйж яваа юм биш гэдгийг нь мэдээд байлаа. гаднаа хөнгөн юм шиг харагдавч хүү нь юманд яаж шуухан чин сэтгэлээсээ ханддагийг нь ээжээс нь өөр хэн мэдэх билээ.

-Тийм ээ, хүү нь тэр охинд зүрх сэтгэлээ өгчээ. ямар сохор дурлал гэж ийм байдаг байна аа. яаж яваад Хайлаастын нэг муу асрагч охинтой зууралддаг байна аа, Өнөөдөр гар утас авч өгч бна, цаашдаа гутал өмд юу хэрэгтэйг нь авч өгөх нь гээч. гэтэл Итгэл чин оютан хүн болохоос биш ямар саятан биш.

Ид шилжилтийн насандаа эцэггүй болоод , оюутан болонгуутаа сургуулиа орхин байж энэ амьдралын төлөө зүтгэсэн биш үү?

Ядаж нэг амиа аваад явах чадалтай айлын охинтой л сууж үзээрэй гэж хичнээн хэлдэг билээ. аягүй бол цаадхи энэ гартаа ороод ирсэн энэ сайхан залууг дөнгөлж авах гээд жирэмсэн болчихно.

Аавийгаа явчихсаний дараа хүү нь нэг хэсэг дуу муутай бол хоолондоо муудан их л шаналж , нэг хэсэг үхлийн рокын хорхойтон хүртэл болж явсан. тэгээд ээждээ нэг удаа хүн яагаад хүүхдээ хаягддаг юм бэ? би лав том болоод үхсэн ч хүүгээ хаяхгүй гэж билээ. эцэггүй байхын зовлонг ухаан орсон хойноо амссан хүү нь тэр хүүхнийг хүүхэдтэй болчих юм бол уг дуугуй сууна гэдгийг ээж нь мэдэж байлаа.

Өнөө гар утасны хайрцаг, гэрээ 2-ыг уурандаа ширээн дээрээс авч хаяд гал тогооны өрөөндөө орж чанадаг кофе гарган отгон шиг чанаж уугаад сэтгэл нь овоо тайвширч охиндоо лаазтай мах будаагаар хачирлаж өгчихөөд хүүгээ хүлээлээ. байдаггүй. охин нь тооны даалгаврын бодлого шалгаад өгөөч гэхэд нь ойлгогдох ойлгогдохгүй хэдэн юм бувтанаад 00-ийн өрөөндөө орж баахан тамхи татаад орондоо оржээ. Тэднийх төв зам руу харсан цонхтой тул, машиний тасралтгүй дүнгэнээн давхилдан чимээ үл тасарна. нойр нь үл хүрнэ. тэгсэн мөртлөө бодол нь цэгцрэхгүй бухимдал нь багасахгүй л байлаа. гэтэл шөнө дунд 2 цагийн үед хүү ни дуу аялан орж ирээд гутлаа тайлаад л өрөөндөө орж түгжив.

Энэ орой Чимэдийнд бас Перс-ийн булангийн хямралхуу юм болжээ. Намууныг гэртээ ороход ээж нь ёстой л галтайгаа буух нь тэр. Үүдний өрөөнд Мики хав нь сагсагнан угтаж ирээд хөлд нь орооцолдсоноос болоод Итгэлийн өгсөн утсыг нуухаа ч мартчихжээ. Гутлаа тайлаад нохойгоо тэвэрсээр зочны өрөө рүүгээ ортол ээж нь хувцсаа ч солиогүй сууж байв.

-Чи чинь яаж галзуурч байгаа нь энэ бэ?

Үнэндээ Намуунд хэлэх үг олдсонгүй. шинэ ягаан ноолууран хослол, ягаан болор ээмэг, зүүлт, торгон алчуур, сайхан үнэртэй ус. ээж нь унэхээр өөлөх юмгүй сайхан харагдах боловч харц нь гэж яг л цасан гоо гүнжийн хойд эх л гэсэн үг.

Намууний дуугүй зогсоод байгаад ч тайвширсангүй. тийм намбалаг хатагтайд зохихгүй огцом хөдөлгөөнөөр буйдан дээрээс босч хажууд нь ирээд элгээ тэвэрсэнээ

-Багахан галзуураарай. энэ чин юу юм гээд өнөө Итгэлийн өгсөн гар утсыг хүзүүнээс нь шувт татан авлаа.

-Наадахи чинь миний утас.

-Чиний нөгөө утас хаана байгаа юм? хэзээдээ ийм хачин юм барьдаг болоов чи?

-Үүргэвчинд байгаа.

Яг энэ үеэр энэ чинь юу болоод эхнэрийн маань дуу хадаад байнаа гэсээр Чимэд орж ирэв. тэр хэзээнээс дуугаа өндөрсгөх дургүй, охин, эхнэр хоёроо ам муруйхад бүр ч таагүй байдаг билээ.

Намуун ээжийнхээ гараас утсаа шүүрэн авсан боловч ээж нь тэр дор нь булааж авлаа.

-Энэ галзуурсан охин танай найзтай хуйвалдаад эмнэлэгт нь асрагч хийж байсан байна. санхүүгийн хэлтсийн Баасан өчигдөр энийг Хайлаастын микро автобусанд сууж явахыг харсан байгаа юм. тэгсэн чин өнөө өглөө надад нэг хачин мэссэж ирлээ. Танай охин чинь Ачлал эмнэлэгт асрагч хийж байгааг дуулгачий ч гэх шиг. тэгэхээр нь Оргилыг явуулсан чинь үнэн байдаг байгаа.

Гэрийн эзэн буйдан дээр очиж суугаад

-Энэнд чинь болохгүй юм юу байгаан? Хүүхэд юм сонирхоо л биз. амьдрал таниад зүгээр юм биш үү? мини охин дээшээ гарч хувцасаа сольчих. 2-уулаа хоолны дараа сайхан ярилций гэлээ.

-Энийг чин харин өгөхгүй шүү гэж ээж нь заналтай хэлээд утсыг нь оосроор нь гартаа

ороолоо..

Намуун шатаар гишгүүр алгасан дээшээ гүйлээ. шал балай юм. аль эртний зохицуулах байсан юм. ороод Итгэл руу утасдая гэж бодсоор өрөөндөө орж орон дээрээ налмайн уналаа.

Өнөөдөр дэндүү хүнд өдөр байлаа. Итгэл руу яриж амжаагүй хэвтэж байтал чи өнөөдөр эмээгийн дээ ирэхгүй юмуу? гэсээр Жавхаа залгав. Асрагчаар ажиллаж байсныг ээж нь мэдсэнийг, Итгэлийн өгсөн гар утсыг хураалгаснаа, нөгөө муу сувилагч Сараа ээжид нь алтан хошуу хүргэснийг бүгдийг нь найддаа ярьж сэтгэл нь онгойлоо. ээж чинь маргааш гэхэд уурлахаа больно доо. харин Итгэлд яаралтай үнэнээ хэлсэн нь дээр дээ гэж Жавхаа зөвлөв. Итгэлийн гар руу залгавал салгачихажээ. Зай нь суучихсан биз. Гэр рүү нь залгавал нэг охин аваад ах ирээгүй байна. Та хэн бэ? гэхээр ни шуудхан тасалчихлаа. Нөгөө айхтар дүү охин нь бололтой. НИ Би бна. маргааш Тэнгис дээр 12 цагт уулзах уу? яаралтай ярих юм байна Намуун гэсэн Мессэж явуулчихав. Мессэж явчихсан хойноо баахан алдаа хийснээ мэдэв. Намууний дугаарийг Итгэл мэдэхгүй ш дээ. Түүнээс гадна Итгэлтэй анх танилцан цагаас хойш өөрийгөө Алтанзул гэж ойлгуулсан биш бил үү? гэтэл Намуун гэж тэр мэдэхгүй . Зулаа байна аа. НИ би утасаа хаячихлаа . Маргааш 14 цагт Тэнгис дээр уулзъя гэж дахин нэг мессэж явуулж байж санаа амрав. Дараа нь эмээ нь ярив. Ээж нь өдөр утасдаж загнасан бололтой. Хуйвалдагчийн дуугаар

-Миний охин одоо наад ажилаасаа гарчихгүй юмуу? ээж чинь өдөр их ууртай утасдаж байсан. эмээ нө ч мэдэхгүй л гэсэн шүү. дахиад ээжийгээ уурлуулаад хэрэггүй. Хичээл номоо хийж үз. Чамайг ингээд байвал дахиад USA явуулна гээд цамнаад байна лээ хэмээн хов хүргэлээ. эмээтэйгээ яриж дуусангуут өрөөнийх нь хаалгийг нууц дохиогоор тогшив. Аав нь хоолоо идэхгүй юм уу гээд тавиуртай юм баричихсан зогсох аж. Аав ни охиноо бүр бага байхаас нь ийнхүү 2 удаа чанга, 2 удаа зоолон тогших нууц дохиогоор өрөөнийх нь хаалгийг тогшдог байсан юм. Түүнийг ээжтэйгээ муудалцахаар нь ингэж хоолыг нь тавиур дээр тавиад өрөөнд нь авчирдаг нь ч аль хэзээний юм.

Итгэлтэй хамт хоолонд оролгүй ирсэн тул чоно шиг өлссөнөө сая л мэдэв. Жигнэсэн будаатай бифштекс л бололтой. Аав нь дээрээс нь бяслал, кимчи, дарсан мөөг гээд санаагаараа баахан хачир нэмээд иржээ.

--За тэгээд юу болоод байгааг аавдаа ярихгүй юмуу?

Намуун хоолоо том томоор нь үмхлэнгээ аавдаа бүгдийг ярьчихлаа. Ялангуяа Хасарын тухай, сонин дээр гарсан хүүхэндээ өөрийнх нь тухай юу гэж ярьж байсныг, хүмүүс баян айлын охин гэж ханддагт дургүйцдэгээс болж л энэ бүх будлианыг хутгаснаа, эмнэлэгт ажилласнаар хичнээн их юм ойлгосноо ярив..

Гэхдээ Итгэлтэй танилцсангаа л хэлсэнгүй өнгөрчээ. Охиныхоо хичээл хийдэг ширээг тохойлдон суугаа аав нь том гараараа духаа маажлан хөмсгөө атируулан сонсоно.

Тэгээд инээмсэглэн босч:

-За аав нь ойлголоо. Ээж нь яахав дээ, чамд санаа зовоод л амархан уурладаг хүн. Маргааш л уур нь гарчихна. Харин миний охин дахиад тэр эмнэлэгтээ ажиллахгүй биз дээ? гээд гарах гэхэд нь Намуун Отгоогын тухай ярьж, түүнд туслахыг гуйв. Аваас нь тусламж гуйсан хол ойрын хамаатнууд, элдэв хандив хүссэн хүмүүс зөндөө ирдгийг, гэр оронгүй бүх хүнд би тусалж чадахгүй гэж хэлэхийг нь мэдэж байсан ч Отгоод туслахыг аминчлан гуйлаа.

Аав нь зальтай инээмсэглээд

-Энэ тухай хоёулаа жичид нь ярилцана аа гээд өрөөнөөс нь гараад явчихав.

Зүгээр ч үгүй гарахдаа нүдээ ирмэсэн болохоор охиндоо татгалзахгүй гэсэн үг. Удалгүй тэр 2 саунд суухаар яваад өгөв. Баасан гаригийн орой бүр аав, ээж 2 нь найзуудтайгаа саунд сууж, бүтэн биений иллэг хийлгэдэг юм. Дараа нь далайн хоолны ч юм уу аль нэг үнэтэй ресторанд сууцгааж шөнө хагаслан ирцээнэ.

Харин Намуун тэр 2-ыг дагаж хэсэх дургүй. Гадаадад амрах бол өөр хэрэг л дээ. Элдэв найр цэнгээн хэсэхэд нь дагах ясны дургүйг нь мэдэх болохоор тэр 2 ч дагуулья энэ тэр гэдэг ч үгүй билээ.

Ингээд Намуун ганцаараа үлдэж, угаалгын өрөөндөө өөрийн гэсэн саундаа орон жаргаж байгаад унтжээ.

Тэр шөнөжин Итгэлийг зүүдлэв. Тэр яагаад ч юм компьютерийн дэлгэц дээрх шиг эцэс төгсгөлгүй хонгилоор яваад л байх юм, яваад л байх юм, тэгсэн мөртлөө тэр хонгилуудаар огтын танихгүй хүмүүс сүлжилдэнэ. Тэд бас л түүн шиг энэ эцэс төгсгөлгүй хонгилын үзүүрийг хайн бэдэрч буй бололтой, нүд нь шаналлаар дүүрэн. Гэтэл гэнэт Намууны зам дээр Итгэл гараад ирэх юм. Намуун түүнийг хараад гараа сунгахад нүүрнийх нь ганц ч булчин үл хөдөлнө. Яг л төмөр хүн мэт. Итгэл ээ, би байна гэж Намуун байдгаараа хашгирах гэтэл дуу нь үл гарна. Тэгээд л өнөөх нь яваад өгнө. Эргээд харахаар алга болчихно. Намуун тэр төгсгөлгүй муухай саарал хонгилоор явсаар дахин нөгөө нүүрний хувиралгүй, Итгэлтэй тулгарна. Маргааш нь бүсгүй хар дарсан уртын урт зүүднээсээ болоод толгой нь хүндэрчихсэн сэрж, нохойгоо дагуулаад гарлаа.

Зайсан толгойн хөшөө өглөөний манан дунд ганцаардсан удган мод шиг сүүтийн харагдана. Мики нохойны зангаар баярласнаа илэрхийлэн хөлийг нь ноцон тоглосноо, тээр хол яваа машин руу боргон гүйснээ хар хурдаараа эзэн рүүгээ чавхдан ирнэ.

Ээжээсээ Итгэлийн өгсөн гар утсыг авч чадаагүй тул өөрийнхөө утсанд хариу мессэж ирсэн байх гэж горьдсон нь талаар болов. Хүний сэтгэл гэдэг ямар тогтворгүй байдаг юм бэ. Өглөөний сэрүүн цэнгэг агаарт гараад толгой нь сэргэсэн ч Итгэлтэй уулзах юм сан, өчигдөр ярьж амжаагүй бүхнээ яриж сэтгэлээ онгойлгох юм сан гэж тэсгэлгүй хүснэ. Урьд нь хэзээ ч ингэж сэтгэл зүрхэндээ бүрэн захирагдаж явсангүй. Хасартай үерхэж байхдаа түүнийг ингэж цээж хөндүүрлэн санахийн амтат зовлонг эдэлж байгаагүйгээ л тодхон санаж байв.

Цаг 11 болж байлаа. тэдний амьдардаг тохилог хотхон бямба гаригийн өглөө аажуухан сэргээдэг тул хашаанаасаа гараад тэр хэнтэй ч тааралдсангүй.

Яг энэ үеэр Итгэл Зулаатайгаа ганц мессэжи-ийг солилцож чадсангүйдээ харамсан хотоос гадагшаа давхиж явлаа. Тэр шөнө компани дээрээ очин Жака, Баагий 2-той хамт захиалгат вэб хуудас хийх ажлаа бараг дуусгаад харьж явсан билээ.

Аль эрт Хайлаастад хайртыгаа хургээд буцаж явахад нь гар утасных нь цэнэг суучихсан тул Намууны мессэжийг уншиж чадсангүй гэртээ харьж шууд л нам унтаад өгчээ.

Гайхалтай нь нөгөө тасралтгүй урт саарал хонгил Итгэлийн зүүдэнд ч оржээ.

Хонгилын үзүүрт Зулаа гар сунган зогсох мөртлөө дуудахаар нь сонсох ч үгүй байснаа гэнэт алсран холдох ажээ.

Өглөө нь хар үүрээр Жака, Батбаяр 2 гэрт нь хүрээд ирэв. Баагийгийн өвөө нь өнгө орчихжээ. Угийн дуу цөөтэй дээрээ бүр таг дуугүй болчихсон Баагийгийн өмнөөс Жака хамаг учрийг нь ярив. Цаг 7 өнгөрч байлаа.

Ээж нь сандран өглөөний унд бэлтгэсэн боловч Итгэл аяга ус уугаад хиамтай талх бариад л

гарааш руугаа гарчээ.

Гар утас нь цэнэггүй тул тэр чигт нь орхив. Баагий ямар ч үед түүнд хамгийн найдвартай хань болдог байсан болохоор энэ хүнд үед нь уг дуугүй үйлчлэх ёстой.

Тэр 3-ыг 22-ын товчоогоор гарч явахад ч их хот нойрноосоо бүрэн сэрээгүй л байлаа

-Намуунийг хашаанийхаа гадуур Итгэлийг санан санан салхилж явахад манай 3-н залуу Баян-Өнжүүл орох замыг туулаад дуусч байв.

Жака замын турш ам хуурайгүй яриж, Баагий таг дуугүй дүнсийн, Итгэл Зулаагаа бодон, анх диско-н дээр учирсанаа, шүрэн бугуйвчийг хадгалан түүнийг эрж байснаа, эмнэлгийн хонгилд уулзсанаа, өчигдөр парк-аар хөтлөлцөн алхалж явснаа санан хурдан уулзах сан гэж тэсгэлгүй яарч явлаа.

Тэднийг хүрэх газраа очоод буухад их үд болж байв.

Хөдөөгийн бяцхан суурингийн тоос шороотой гудамжаар давхисаар Баагийгийн өвөөгийн гадаа буулаа.

Жаал хүүхдүүд гүйлдэн ирж өрхийг нь бүтээсэн гэрээс эмээ нь гүйхээрээ гарч ирээд ачийгаа тэврэн уйлна.

Замийн турш ус балгасан юм шиг дуугай явж, ганц ч нумлимс унагаагүй Батбаяр эмээгийнхээ элгэнд наалдан чангаар уйлав.

Тэднийг гэрт ороход зэргэлдээ сумаас Батбаярийн аав , ээж нь ч ирчихсэн гэр дүүрэн хүн шаагилдан байв.

Хоймын авдар дээр өвгөний зургийн өмнө зул асаан тавьжээ.

Итгэл маргааш нь л хот руу гараад давхичихна гэсэн бодолтой ирсэн ч өвгөнийг хөдөөлүүлээд даваа гаригийн өглөө явахаас өөр арга байсангүй. тэр өглөө нар битүүгээр өвгөнийг гаргаж, сумийн төвийн оршуулгийн газарт жижиг шовгор чулуутай нэгэн шинэ булш нэмэгджээ.

Өвөө амиддаа намайг үхэхэд оршуулж байна гэж битгий цэмэнт цутгаарай. бүрлээчдийн өмнөөс дотор давчдах шиг болох юм гэж захидаг байсан.

Өвөө минь хэдхэн хоногийн өмнө уулзахад л зүв зүгээр хашааныхаа гадаа ганц нүдний дуран бариад сууж байсан. хүү мин, энэ ирэх жил хэн ерөнхийлөгч болдог сон бол гээд л хэрэгт дурлаад улс төржөөд үлдсэн. одоо би ингээд өвөөгүй боллоо гээд л Итгэлийн мөрийг түшин хэсэг уйлав. Итгэл ч зун ирэхэд нь айлаас хонь гарган хүүгийн найзууд хэмээн хөл алдаж байсан өндөр өвгөн ингээд байхгүй болжээ. Одоо өт хорхойд идүүлээд тэр хүнээс бараг ю ч үлдэхгүй гэж бодохоос аймшигтай санагдан, хэзээ нэгэнт цагт ирэх үхлийн тухай бодолд өөрийн эрхгүй автлаа. Хэрэв сүнс гэж байдаг бол өвгөний сүнс Жака, тэр 2-ыг хараад баярлаж байгаа байх гэж бодохоос гэнэт жихүүдэс хүрнэ. хотоос ирсэн залуу лам оршуулгын дараа ном уншсаны дараа нэг нэг Липтон цай, айргийн шаазан, лаа, чүдэнз ганзагалсан мань 3 хот рүү хөдөллөө.

Тэднийг буцахад Баагийгийн эмээ хашаанийхаа гадна сүү өргөн бараа тасартал зогсохыг хараад Жака өнгөрсөн жил бурхан болсон эмээгээ дурсан уйлах дөхөж 2 найзыгаа гайхуулсан билээ. Тэр машины арийн цонхоор эргэн эргэн харж гар даллан явснаа

-Ямар эвгүй юм бэ. Яг манай эмээ шиг санагдчихлаа. Шарга морьтод өвөлждөг байсан юм манай эмээ. Биднийг очоод буцахад яг ингээд хараад л зогсдог сон. хотод ирээд манайд байгааг гэхээр агаар дутна гээд тэндээ байгаад байдаг. намайг өсгөсөн эмээ болохоор аав ээж 2-оос навс өмөөрнө. Эмээ санагдаад байдаг болхоор би Шарга морьт орох ёстой дургүй гэж

хоолой зангируулан ярьхийг сонсоод 2 найз нь тоглоом ч үгүй их гайхжээ. Жакаг хэзээ ч ийм сэтгэл уярам сэдвээр ярьж байхийг сонсоогүй юм чин.

-Манай Жака мөн үү энэ чин.. Чамайг ийм уяхан сэтгэлтэйг урьд нь би яагаад мэдсэнгүй бэ гэж Итгэлийг явуулахад

-За болиорой.. Би чинь хүн шүү. Хүүхнүүдэд нэг их хөл алдаж гүйхгүй, харин ээж эмээгээ бол хайрлана шүү гэлээ.

Энэ нь Итгэлийг дайруулсан үг байлаа.

-Миний амьдрал чамд хамаагүй. За ер нь чамд хол алдахаар хүүхэн тааралдаж яваа ч үгүй юм чин гэж Итгэл хэлэв.

-За юундаа уурласан юм. чи ер нь тэр охины юунд нь болсныг би ойлгохгүй байна. Нуру туруу гэж гайхуулах юм байхгүй. Нэг их хөөрхөн ч биш л хүүхэн. Тэгээд нүд хужирлах хөх, бөгс байхгүй. Ядаж гэр хорооллынх шүү гэхэд Итгэл машинаа тоормослон зогсоогоод

-Жаргалан гуай, амаа татахгүй бол алтан шанаа хүртээнэ шүү гэхэд урд суудал дээр дуугүйхэн явсан Баагий хүн өвөөгөө алдчихаад байхад та 2 болиоч гэж байж мань 2-ыг тайвшруулав

-За за уучлаарай. Уг нь чиний төлөө л хэлсэн ш дээ.. Найзыгаа гайгүй айлын хүргэн болоосой гэсэндээ л.. Тэрнээс гадна Итгэл ээ,, Тэр чин их сонин охин.. уржигдар Форд экспедишин уначихсан Чингисийн скай-ийн хашаанаас гарч явсан даа. би яг таньсан.. Худлаа гэвэл энэ Баагий ч харсан.. тийм биз дээ? чамд хачирхалтай санагдахгүй байна уу? гэж Жака асуулаа.

-Наадахь чинь юу яриад байгаа юм? гэж асуухдаа Итгэлийн хоолойд эргэлзсэн өнгө тод мэдэгдэж байлаа. тэр нь Жакагийн үг ортой юм байх байгаа гэсэн эргэлзээ байв.

-Мөн л байх шиг байсан. гэхдээ Жака чи энэ тухай Итгэлд хэлэхгүй гэж тохироо биз дээ хэмээн Баагий уурслаа.

-Зулаа, мөн ч байсан юу нь болохгүй байгаа юм? хамаатан садан, найзынхаа машинд суусан байж болно ш дээ гэж Итгэл хэлээд хаазаа нэмлээ.

-Өө за за, хүн болгонд Экспедишин унадаг хамаатан байдаг бол сайхан л юм. Тэр тусмаа Хайлаастын нэг асрагч охинд. Тэр чин зуун сая-ын машин гэдгийг чи сайн мэдэж байгаа ш дээ. Хачин санагдахгүй байна уу? Чи ч бүүр тоглогойгоо алдчихжээ. Хайран сайхан найз минь хэмээн шогширсноо уг нь ийм залуу байгаагүй л юм сан. Миний найз. Чи бодооч. За яахав. Тэр чинь экспедишин унаж яваагүй болог. Хүн андуурчээ гэж бодъё. Тэгвэл хүн яаж сохрохоороо тийм зүгээр нэг асрагч хүүхэнд ингэж ухаангүй дурладаг юм бэ? гэдгийг л гайхаад барахгүй юм.

Чи чин ээж, дүү 2-оо тэжээх ёстой хүн. Тийм айлын охиноор яах гэсэн юм бэ? Ээж чинь мэдчихвэл бөөн асуудул гарна даа. Манай ээж бол боогоод үхчихсэн. Цолмон эгч...

-За одоо боль. санаа тавьсанд баярлалаа. Ээжтэйгээ би учраа ололцож дөнгөнө. Би тэр охиныг хэнд ч доромжлуулахгүй. Ярианийхаа сэдвийг өөрчилчих гэж Итгэл ууртай хэлэхдээ найзынхаа үгийн үнэнийг ойлгож л байлаа.

Ээждээ Зулаагийн тухай яж хэлэх бэ гэсэн бодол тууний хайртайгаа учирсэн энэ жаргалтай одруудийг гутааж байгаа билээ. туунээс гадна Зулаагийн тухайд тийм ядуу айлийн охин гэхэд эргэлзэх юм оороо ч бас ажилагчихаад байгаа билээ.

гар утасийг тийм сайн ашиглаж байсан ни. тэр ихэмсэг тоомжиргүй харц, чанартай хувсас, ориг пууз, францэ духи анхилуулсан цэвэрхэн арис ни туунийг явч гэр хорооллийн хун биш гэдгийг илчлээд байдаг. тэгээд бас гэрийнхнийхээ тухай ярихаас булзааруулаад байгаа ни гайхалтай биш уу? ямар учиртай бусгүй ингэж зурх сэтгэлийг ни эзэмдчихсэн юм, буу

мэд.....

Хамгийн анх тэр нэгэн шөнө диско-н дээрээс олж хархад харц тулгарсан тэр хархан нүд л сэтгэлд нь хоргодчихсон. Түүний унагачихсан шүрэн бугуйвч , түүний тэр айсан янзаганых шиг харц, уулзах гэхэд эрвээхэй шиг үргээд алга болчихсон нь сэтгэлийг нь улам татчихсан хэрэг. Урьд нь бол тэр танилцъя гэж хүссэн л бол ямар ч бүсгүйг урдуураа өнгөрүүлж байгаагүй. Өөдөөс нь ирж наалдаад өвөрт нь ороод байдаг хүүхнүүд л байснаас биш Зулаа шиг зугатаад алга болохдоо сэтгэлийг нь шархлуулсан нь хэзээ ч тааралдаж яваагүй билээ. тэгээд бас тийм оньсого шиг зантай. ...

Итгэл нэг л мэдэхэд түүний тухай бодоод инээмсэглэчихсэн давхиж явлаа. Тэр 3-ын хотод орж ирэхэд үд өнгөрчихсөн байлаа. Жака, Баагий 2 өнөөдөр 3-н пар будаа гэсээр гэртээ буулаа. Баагий 2 найздаа баярласнаа хэлээд үүргэвчээ барьсаар орц руугаа толгой гудайн орлоо. Аав нь Төв аймгийн нэгэн сумын дарга хийдэг хөдөөний хүүхэд тул Баагий нагац ахындаа байдаг билээ. Харин Жака за усанд ордог хэрэг гэсээр буув. Тэр бол айлын эрх хүү, эцэг эх 2 нь дотоожноос нь эхлээд хамаг хувцсыг нь угаан элдэв салат хуурга хийж өгөн гэрийн ажилд гар ч хүргэдэггүй тул гангалаад л охин эргүүлж яавхаас өөр санаа зовох юм байх биш. Харин Итгэл гэрээрээ ч орсонгүй шууд л Зулаагийн ажил руу явлаа. гэнэт ажил дээр нь яваад очвол жинхэнэ сюрприз болох байлаа тэгээд ч гар утасных нь зай суучихаад хөдөө явах болсноо ч дуулгаж чадаагүй хэл сураггүй алга болсон хүн чин ганц хоёр сарнай, хайрцагтай чихэр аваад эмнэлэг дээр нь очив. Ядаж байхад баруун 4-н зам түгжирээд яарсан сэтгэлийг нь хясах шиг, бас шатахуун нь дуусаад шатахуун түгээгүүр дээр 5 мин алдаад хотод давхиж болох дээд хурдаар ажилийнх нь гадаа очив. Эмнэлгийн гадаа хүн машин ихтэй байлаа. Ид ажлын цаг байсан болохоор гаднаас нь сигналдаад нэмэргүй байсан тул ороод асуулаа. Гайхалтай нь Алтанзул ажилаасаа гарчихсан гэж жижуур өвгөн хэлэв. Зай нь суусан гар утсаа аль 5 өдрийн орой гэртээ орхисон чигтээ тул цагаан утсаар гар руу нь залгатал салгасан байв. 2-хон хоног хөдөө яваад ирэхэд ни ажлаасаа гарчихдаг гайхалтай хэрэг ээ. Гэр руу нь очихоор шийдэв. Хайлаастийн хуучин эцсийн худгийн хажуу дахь ногоон хаалгатай хурэн хашааний гадаа очлоо. энд Зулааг хургэж ирж байснаас биш ядаж хэнийх гэдэг айлыг нь асуугаагүйгээ сая л санав. Өдрийн цагаар сургуулийн ганц нэг хүүхэд явж харагдахаас гэр хорооллын гудамж эл хуль байх ажээ.

Худаг дээр ч хүн харагдсангүй. Зулаа нь гараад ирэх ч юм бил үү гээд сигналадав. гараад нөгөө төмөр хаалгийг ч нүдэв. хашаанд нь ямар цонх байх биш. Хаалгийг нь нүдэж зогсохдоо хашааны банзны завсраар харав. Ганц гэр модон амбаартай жижиг умгар хашаа байлаа. Удалгүй гэрээс нэг халзан туранхай өвгөн гарч ирээд

-Хэн бэ? Гэрлийн байцаагч уу гэж ууртай асуулаа. Итгэл хаалганаас холдон банзны нилээн том завсраар шагайн -Ахаа энд Алтанзул гэдэг охин байдаг уу гэв

-Юун Алтанзул манайд тийм хүн байхгүй. муусайн хулгайч нар худлаа юм асуусан болж хашаа өнгөлзөөд гэж загнаад зогсолтгүй боргох нохой руугаа алхах нь тэр.

-Ахаа., хажуугийн чинь хашаанд тийм хүн байдаг бол уу?

-Яасан салдаггүй хулгайч бэ, тийм хүн энд байхгүй гээд нөгөө хүн нохойгоо суллан тавив. Нөгөө нохой ч уяанаасаа алдуурангуут Итгэл руу сум шиг гүйн ирээд яах ийхийн зуургүй хашааны доогуур ухсан нүхээр толгой нь цухуйн хөлөөс нь зуугаад авах дөхөв. Манай дурласан залуу ч ум хумгүй зугатан машиндаа орон байж сая нэг амьсгаа авлаа.

Өглөө зам явахдаа Жакагийн хэлсэн бүхэн санаанд нь орж яахаа мэдэхээ болив. Ажил дээр нь очихоор гарчихсан, гар утасаа салгачихсан, гэрт нь ирэхээр тийм хүн байдаггүй. Яахаа ч мэдэхээ болиод дэмий л машинаа асаан хөдөллөө. Өнөөх ууртай өвгөн хашааны завсраар хялайн харснаа гэр рүүгээ оров. Нохой нь хашаан доогуурх нүхээрээ шургаад гарчихсан машиныг нь тойрон бургаж байлаа. Хайлаастын гудамжны нунтаг шороо манаран хөдөөгийн замын өлөн тоос дээрээс давхарлан дарлаа. Итгэл хотын төв руу давхиж явахдаа одоо хаачих юу хийхээ мэдэхгүй байлаа. Ямар ч гэсэн гэрээрээ орж хувцсаа сольж усанд орох хэрэгтэйгээ мэдэж байв. Байрныхаа гадаа машинаа тавиад гэртээ ороод шууд халуун шүршүүрт орлоо. Гарч ирээд өрөөндөө орвол дуу нь бяцхан зурвас бичиж орхиж ээ. -Ах аа таны гар утсыг цэнэглэсэн. Зулаа гэдэг эгч гар утсаа орхисон гээд мобизон-ны азын дугаар бичэж ээ. Юу болоод байгааг бүүр мэдэхээ болив. Зулаа яагаад өөрийнх нь өгсөн дугаарыг салгаад 9911-тай дугаартай болчихсон байдгийг бүү мэд

-Утас авч залгалаа. Ашгүй Зулаа мөөн. Утсаар ярьснаас уулзсан нь дээр 50 Цент кафе-д цагийн дараа гэж Зулаа хэлээд тасалчихлаа. Итгэл гэрийн утасаа тавиад хөшсөн мэт сууж байснаа гар утасаа залгав. Гар утасных нь дэлгэц дээр инээд алдсан Зулаагийн зураг дотрон гарч ирлээ. Тэр утасаа унтраачихаад асаах, дуудлага орж ирэх бүрд Зулаагийн зураг дэлгэц дээр нь тодордог билээ. Татварын байцаагтай уулзсан, бас вэб хуудас хийлгэж байгаа тухай Аянга мессэж бичиж ээ. Дуут шууданд яриагаа үлдээж болох л байсан. Ганц нэгжээр мессэж явуулчихсан нь хямд дусна гэдэг нь Аянгын тооцоотойн шинж. Баагийгийн өвөөгийн оршуулганд явдаг тэр өглөө Аянгын шүд өвдөөд хотод үлдсэн билээ. ямар ч байсан Зулаагийн тухай сураг гаргасан тул Итгэл ээжийнхээ үлдээсэн хоолыг халааж идээд гарлаа. Түүнийг компаныхаа өрөөнд очихож Жака ирчихсэн вэб хуудасныхаа сүүлчийн хувилбарыг дуусгаж байлаа. Удалгүй Аянга орж ирээд Заяатай тусдаа гарах болсноо дуулгав. Жака ч чихэвчний хөгжим сонссон хэмнэлд нь толгой хөлөө хөдөлгөн компьютер шагайн сууснаа чихэвчээ тайлаад тас тас хөхрөн -за манай сангийн сайд гэнэт баяжаад байр хөлслөх нь үү? гэхэд Аянга бохь зажлангаа

-Юун байр хөлслөх. Манай Тэмүүлэн дархань сургуульд орох болсон тэгэхээр би өрөөндөө ганцаараа байх болоод азны юм байхгүй юу. бодоод байсна чинь Зая бид 2 хамт байвал хамаагүй хэмнэлттэй юм байна та нар хараач гээд тооны машинаа гарган бид 2 уулзах гэж сард Тэнгис-д доод тал нь 6-н удаа кино үздэг, 2 хүний билет 5000төг, дээрээс нь нэг нэг ундаа 2000-аар авч л таарна. тэгэхгүй бол Заяа уурлаад намайг харамч нарийн гээд загначихдаг юм чинь. ингээд 7000-ыг * нь 6=560000 болж байгаа юм. За тэгээд Берлин бургерт бас 5-6 удаа орж дунджаар 6000-ыг идчихдэг гэхээр 36000. Би Заяаг хүргэж өгөх гэж өдөрт нэг удаа ирэх очихын 1000-аар такси гэхээр сарын 30000. нийтдээ зөвхөн уулзахын тулд сардаа 120000 төг үрчихдэг юм байна. За бэлэг чиколад энэ тэрийг оруулахгүйгээр шүү дээ. Хэрэв бид 2 манай өрөөнд тусдаа гарах юм бол энэ мөнгөө хэмнээд дээрээс нь сар бүр нэг цахилгаан бараа аваад байж болох юм байна. Манай гэр сургуулын хажууд болохоор унаанд мөнгө үрэхгүй, бас та 3-аас тусдаа гарсны бэлэг авнаа гээд инээлээ.

-Та 2 хамт байлаа гээд кино үзэхээ болохгүй шүү дээ. Хамгийн гол нь чи ийм нарийн хүн байж яах гэж найз охинтой болсын бурхан чиний нарийн занг шийтгэх гэж Заяаг илгээсэн байх аа гэж Жака хэллээ.

“Баян аав, ядуу аавд” баяжъя гэвэл илүү зардлаа хэмнэ гэсэн байдаг юм. Хэрэглээ чинь орлогоосоо давчихаад байвал хэзээ ч мөнгөтэй болохгүй. Найз охинтой байна гэдэг чинь бас хэмнэлт байхгүй юу. Чи бэлгийн хэрэгцээгээ хангах гэж янз бүрийн хүүхэн найрах гэж надаас 2 дахин их мөнгө үрдэг биз дээ? гэж Аянгыг хэлж дуусаагүй байхад Заяа орж ирсэн тул

бушуухан чимээгүй болж найзууд руугаа нүд ирмэв. Итгэл ярианд оролцоогүй бодолд автан сууж байлаа.

-За манай дарга яагаад ийм дүнсгэр байгаа юм бэ? гэж Аянгийг яриагаа дүйвүүлэхэд Заяа гүйж очин чихийг нь мушгиад чи сая юу юу гээд байсан бэ? би сонссон шүү гэхэд

-Ёо, ёо. өрхийн тэргүүнд хүрээд задарсан хүүхэн бэ. Яадаг юм, би хүүхэн эргүүлж мөнгө үрдэггүй нь үнэн биз дээ? гэхэд Заяа чихийг нь тавьж

-Ямар азаар манай Аянга ийм нарийн зантай болж төрөө бэ? Жака шиг үрэлгэн амьтан байсан бол баларлаа. Аянга чинь мөнгөө үрчихнэ гээд хүүхэн эргүүлдэггүй байхгүй юу гэхэд Жака

-Тэгвэл манай Аянга баяжихаараа гэнэт хүүхэмсэг болчих юм биш биз дээ гэж Заяаг цаашлуулахад

-Өө яалаа гэж манай энэ чинь баяжих тусмаа улам нарын болох хүн байгаа юм. Тэгэхдээ би бол алгыг нь тэнийлгэж дөнгөдөг байхгүй юу хэмээгээд үсийг нь сөргөөн илэх аж. Итгэл хийж байсан ажлаа орхиод Аянгад түрээсийн мөнгөө төлчихоод орлого зарлагын тайлан хийчихээрэй гээд гарч одов. Түүний дүнсийсэн царайг хараад Заяа нөгөө 2 руу асуусан харцаар харахад Аянга толгой сэгсэрч, Жака мөрөө хавчлаа. Түүнийг дөнгөж хаалгаар гарангуут Заяа хүүш ээ, Баагийгийн өвөө нас барсан юм уу? Итгэлийнх юм уу? гэж гайхан асуужээ.

Тэр болзсон газраа ирээд машинаасаа гаралгүй Зулааг хаанаас яаж ирэхийг харахаар машиндаа суусаар байлаа. 5 минутын дараа Зулаа шинэхэн цагаан спорт машинаар ирээд яг хажууд нь зогсоноо шилээ хаахдаа Итгэлтэй харц тулгарав. дугаар нь утасныхтайгаа ижил 0909. 2-уулаа зэрэг машинаасаа бууж тугжээд өөд өөдөөсөө харан зогсов.

-Юу болоод байгаа юм бэ? гэж Итгэлийг асуухад бүсгүй нүд рүү нь ширтээд

-Сайн явсан уу? гэж асуулаа.

-Сайн. чамд дуулгаж чадалгүй явчихсаад ирсэн чинь гэснээ

-би Хайлаастанд очсон гээд машин руу нь, нүүр рүү нь ээлжлэн хархад Намуун

-2-уулаа ороод ярья л даа гээд гараас нь хөтлөн алхлаа.

Тэр 2 гудамж руу харсан том шилэн цонхны дэргэд сууцгаав. Үйлчлэгч цэс авчирч өгөхөд Намуун түүнийг нь авсан ч үгүй

-2 капучино авчих уу гэж Итгэлээс асууснаа үйлчлэгчийг явангуут

-Хайлаастанд очоод тэр хашаанд намайг байдаггүй гэхээр гайхав уу?

Би чамд бүх үнэнээ хэлэх гэж бодож байсан чинь чи хөдөө явчиг байсан. Тэгээд яаж ч хэлэхээ мэдэхгүй байсан л даа. бас би.. айсан юм. Чи Алтанзулыг л хайрласан болохоос Намууныг биш.. намайг Намуун гэдэг. би МУИС-д эдийн засагчийн мэргэжилээр сурдаг гээд яриагаа таслан гартаа зүүсэн шүрэн бугуйвчаараа оролдон Итгэл руу харлаа. тэр харцанд асуусан, намайг ойлгооч гэж хүссэн, бас Итгэлийг хайрласан харц хослон байлаа.

-За тийм байж. яах гэж энэ бүх... жүжгийг зохиосон юм бэ? гэж Итгэл асуухдаа жүжиг гэдэг үгэн дээр түгдэрсэн нь учиртай. Тийм ээ. энэ бүх хугацаанд тэр жүжгэнд итгэчихсэн явсан цорын ганц хүн нь Итгэл байсан билээ. Үйлчлэгч хав халуун кофе авчирч тавилаа. Намуун кофе -ноос балгаад үсээ илснээ

-Чамайг надад үнэхээр хайртай эсэхийг л мэдэх гэсэн юм. Манай аав бензин импортолдог компанитай. Би ганц охин нь. Тийм болохоор хүмүүс намайг Намуун гэж хардаггүй. Чимид захирлын охин, баян айлын хүүхэд л гэж харьцдаг. Би энэ бүхнээс бүр залхаж гүйцсэн. хүн өөртөө байхгүй юмыг л мөрөөддөг байх л даа. Надаа мөнгө хэзээ ч сонин санагддаггүй. Эзгүй арал дээр мөнгөөр яах юм бээ, Тийм биз дээ? Тэгэд л хэрэв намайг жирийн.. тарчигхан айлын охин байсан бол чи хайрлах болов уу гэдийг мэдэхийг хүссэн юм. чамд бол тэнэг сонсогдож

байгаа байх л даа....

-Тэгээд би чамайг хайрласан ш дээ.. харин чи?

Би чамд хайртай гээд тэр Итгэлийн үсийг илбэн инээмсэглэв. Итгэл ч гарыг нь зөөлөн атгалаа. Ингээд учраа ололцсоны дараа Итгэл ч түүнийг Хайлаастанд амьдардаг, асрагч охин гэдэгт эргэлзэж байснаа ярихад Намуун бүрэнхий болсон хойно ганцаараа худгийн хажууд үлдчихээд ийм тэнэг юм сэдсэн Жавхаад, тэр тоглоомыг нь зөшөөрсөн өөрийгөө яаж харааж зүхсээр хартдаг байснаа яриж инээлдэв. Хамгийн хөгжилтэй нь өнөө өглөө Итгэл Намууныг хайж Хайлаастанд очоод айлын нохойд хөлөө зуулгах шахсан явдал байлаа. Манай Жакад энэ тухай яриж болохгүй шүү. Насны онигоонд орно гэж Итгэл хайртаасаа гуйлаа. Хөдөө явахийн өмнөх шөнө 2-уулаа ижилхэн зүүд зүүдэлцгээснээ ч мэдлээ. Яриандаа халсан 2 кофе-гоо уучихаад хэдэн аяга коктайль хэмж хоослов. 5 цагт ийшээ орж ирсэн 2 цаг ямар хурдан нисэн өнгөрөхийг анзаарсангүй. Нэг мэдэхэд 7 болж байв. Мань 2 кафе-наас хөтлөлцөн гарч ирэв. эмэгтэйчүүд ээ гэж, үлгэрт итгэж амьдардаг хүмүүс юм даа. бүх хүүхнүүд нэг л өдөр цагаан морь унасан хүлэг баатар ирж шидэт цайздаа аваачина гэж мөрөөддөг юм гэнэ лээ. Чи ингээд хуучин улаан жийп-тэй ханхүүтэй учирлаа даа гэж Итгэл хэлэв. Намуун хавчаар гарган салхинд арзайгаад байгаа үсээ боогоод

-Надад бол морьгүй, жийп-гүй байсан ч хамаагүй гэхэд Итгэл

-Эр хүн байж явган байх гэж уу? Тэр ч арай сэрүүднэ ээ. Хадмын гарыг харах гэж үү. Би чамайг Хайлаастын охин байсан ч амьдралынхаа төлөө зүтгэнэ л гэж бодож байсан гээд машиндаа суулаа. тэр 2 төв замаар урд хойноо орон давхилдлаа.

Итгэл түүнийг ажил дээрээ дагуулан очих найз нартайгаа танилцуулах гэсэн боловч Намуу “Өчнөөн худлаа жүжиглэхчээд гэнэт шал өөр хун болчихсон очиход эвгүй байна” гээд очсонгүй. Тэгээд ч хагас сайнд эмээ нь тэднийд айлчилж ирээд хариагүй байгаа тул гэр рүүгээ яарч байлаа. Итгэл түүнийг гэрт нь хүргэж өгөв. Зайсан толгойн өвөрт байх амьны сууцны хотхон буюу шинэ баячуудын хороололд Намууных байдаг аж.

Ширмэн хашааний гадаа 2-уулаа машинаасаа буулаа. Таримал бутны ёроолд хэвтэж байсан тэдний Банхар Итгэлийг хараад чимээгүй гүйж ирээд хайсны завсраар хуцав.

-Өө яасан мундаг том эд бэ. Хашаанаасаа гараад ирэх юм биш биз? Өнөөдөр чинь нохойд дайруулах даллага авчихсан өдөр байна. За би явлаа гээд сандарсан хүн болж далимдуулан Намууны уруул дээр удаан үнсчихээд тэр машин руугаа зугтав.

-Ямар зальтай амьтан бэ? Нохойгоор далимдуулдаг байна ш дээ гэж Намуун хэлсэн ч дуунд нь дургүйцсэн өнгө байсангүй. Тэр Итгэлийн машины урд шилээр шагайн

-Чи манайд ороод явахгүй юм уу?Эмээ л ганцаараа байгаа гэхэд Итгэл шилээ буулган хацрыг нь илээд

-Өнөөдөр би танайд ороход бэлэн биш байна гээд байшин руу нь нэг харчихаад давхин одлоо. Тэгснээ эргэн харахад Намуун машиныхаа дэргэд гар даллан зогссоор байх аж.

Би гэдэг хүн асрагч охинд дурлачихлаа гэж бодсон чинь том баяны охин дэгээдчихсэн байжээ. Эдний аавынх нь компаны шатахуун түгээгүүрийн сүлжээ хот даяар бий. Манай гэрийн хажууд ч байдаг. Байшин нь гэж ёстой дүнхийсэн тансаг эд байна даа. Дотроо ямар ч тансаг амьдардаг юм билээ гэж тэр бодож явлаа.

Ээж нь ийм баян айлын охинтой үерхэхийг бас л таашаахгүй л дээ. Гэхдээ хамгийн гол нь тэр Намуунд хайртай. Намуун ч өөрт би хайртай. Үүнээс бусад нь ёстой хэнд хамаатай юм бэ? буцах замдаа тэр ус нь татарсан Туулын урсгалыг гүүрэн дээрээс хэсэг харлаа.

Багадаа аавтайгаа Туул гол дээр ирж чулуу харайлган тоглодог байснаа санах.

Хайртай бүсгүйтэйгээ учирсан, алдчихлаа гэж айсан, дараа нь тэр нь өөртэй нь бараадхын аргагүй баян айлын охин байсныг мэдсэн энэ л өдөр тэр аавыгаа энгүй их үгүйлэн санаж буйгаа мэдрэх аж. Аав гэдэг хүн ийм л үед хүүдээ үгүйлэгддэг юм байна. Даанч тэр хүн хаа холийн Варшавт алхалж яваа. Хүүгээ дурсдаг ч уу, үгүй ч юм уу бүү мэд.

Усанд хаясан чулуу шиг таг чиг болчихоод удам залгах ганц хүүгээ яаж шүү явааг сонирхдог ч үгүй ни гомдмоор. Харин тэгэхэд Намуун, аав, ээжийнхээ тухай юу ярилаа. Өдөр шөнөгүй мөнгөний төлөө явдаг хүмүүс. Ялангуяа ээж эмэгтэй хүн гэдгээ мартчихсан. Ганц охиндоо дандаа өөрийнхөө бодлыг тулгадаг. Аав бол хамаагүй зөөлөн сэтгэлтэй, бас намайг ойлгодог юм. би аавдаа л илүү хайртай гэж байсан.

Түүнийг ажил дээрээ ирэхэд нөгөө 2-оос гадна Баагий ч ирчихсэн юмаа хийгээд сууж байв. Аянга дахиад нэг вэб хуудасны захиалга олж иржээ.

Заяа хичээлээ давтаж байгаа нэрээр Аянгийг манасаар суугаа харагдана. Итгэл за манайхан чинь 8 өнгөрч байхад бүрэн бүрэлдэхүүнээрээ зарим нь бүүр гэр бүлээрээ сууж байгаа нь ямар сайхан харагдаж байнаа гэсээр орлоо. Хэдхэн цагийн өмнө борооны хар үүл шиг барайсан амьтан гарснаа ийнхүү гэгээн Муза шиг инээсээр орж ирсэн Итгэлийг хараад нөгөө 4 харц солилцов. Тэд Итгэлийн шоглодогоор архигүй хамт олон болох уриатай улс. тэр ирэх замдаа авсан ундаануудаа гарган ширээн дээр тавиад Аянгыг дуудан орлого зарлагийн тооцоотой танилцав. Жака хамгийн түрүүнд Заяад, дараа нь өөртөө ундаа хийж залгилангаа -Манай даргө чинь яагаад гэнэт баян Намсрай шиг өгөөмөр загнаад байнаа гэхэд Итгэл дуугарсан ч үгүй, инээж л суув. Тэгээд

-Бид 4 энэ сард тооцоолсноосоо хамаагүй ашигтай ажилласан байна. Ялангуяа нягтлантай болсноос хойш орлого, зарлагын бүртгэл нарийн хөтөлд Өг болсон нь ч ийм ашигтай ажиллахад нөлөөлсөн. Анх 5 сарын өмнө байгуулагдахад Баагий, Жака бид 3 сая 500-н мянгаар эхэлсэн. Өнгөрсөн сард энэ мөнгөө нөхсөн. Энэ сараас эхлэн ашгаа олж эхэллээ. гэхдээ төмөр хаалга хийлгэх, өрөөгөө засуулах, тавилга авах гээд зардал их гарах юм шиг байна. Навсайсан өрөөнд ирсэн хэн ч дахиад шагайхгүй ш дээ гээд л баахан ажил яриад сарын ашгаа хуваажээ. Шинэ хаалга хийлгэх, өрөөий засвар хийлгэх, компьютер-ын сэлбэг авах зэрэг зардал зайлшгүй нөхцөлд үлдээх мөнгө, хуримтлал зэргээ авч үлдээд ашгаа хуваахад хүн бүрд хоёр хоёр зуун мянган төгрөг оногдсон ч бүгд баяртай байлаа. Тэгээд ашигтай ажилласан амжилтаа тэмдэглэхээр “Хан брой” руу 5-уулаа хөдлөх замдаа Намууны тухай яриу. Ачлал эмнэлгийн асрагч охин нь явж явж баян айлын охин байсныг сонсоод Жака л ганцаараа гайхсангүй

-Паласе дээр би тэр охиныг сайн харагүй л дээ гэж Заяаг хэлэхэд Аянга

-Аргагүй ш дээ. Намайг хардаад үхэх гэж байсан биз дээ хэмээн цаашлуулах аж.

-Би өнөө өглөө чамд хэлээгүй юу. Экспедишин хөлөглөчихсөн явж байсан гэж. Азтай хүн гэж шал өөр юм даа. Ингээд баян айлын хүргэн болчих гэж. Эсвэл чи анхнаасаа мэдэж байсан байх аа? хэмээн Жака санаа алдлаа.

-Надад бол тийм баян айлийн охинтой суухад харин ч дэмий. сүрдмээр ч юм шиг гэж Баагий хамгийн сүүлд дуугарав.

Найзууд “Хан брой” -д очоод л энэ сэдвээр ярьсаар сүүлдээ Итгэл залхаж гүйцлээ.

тарахынхаа өмнө Аянгыг тусдаа гарсныг тохиолдуулан өгөх бэлэгний мөнгийг Баагийг хураалгаад гэр гэр рүүгээ одоцгоожээ.

Итгэл санаанд оромгүй адал явдлаар дүүрэн өнгөрсөн энэ өдөр шалчийтлаа ядарснаа хариж явахдаа л мэдрэв. Шөнийн Улаанбаатарын замаар ийнхүү давхих үнэхээр урамтай. Замаар батгаж ядан багшралдах машин, тархины эд эсийг хэдэн саяаар нь үхүүлэх замбараагүй хөл

хөдөлгөөн тасарч хааяа нэг сүрхийн өнгөрөх ганц нэг таксинаас өөр торох саад үл үзэгдэнэ. Нойрсож буй их хотын дээгүүр нүүгэлтэн байдаг өтгөн утаа шингэрэн тэнгэрт түгсэн одод тодхон гялалзана. Итгэл FM сонсох гэтэл таалагдах юм алгаа. Тэгэхээр нь Намуунтай танилцсан нандин дурсамж болох оноох сүрдэм нүргэлсэн Дү Хаст-аа тавиад инээмсэглэн давхисаар гараашныхаа дэргэд ирэв. Түүнийг машинаа тавичихаад дуу аялан гэртээ орвол ээж нь унтаагүй хүлээж байлаа.

-Ээж унтахгүй яагаав гээд бохь зажилсаар гутлаа тайлахад нь ээж нь босч гал тогооны өрөөнийхөө хаалгыг налан гараа элгэндээ тэврэн зогсов.

Ингээд элгээ тэвэрчихээр ноцтой юм ярьдагийг нь мэдэх Итгэл ядарснаараа түрий барин бушуухан орондоо орохоор яаран

-Би унтлаа. Юм идэхгүй ээ. Нойр хүрээд яг үхэх ни хэмээн өрөө рүүгээ бултав. Хүүгээ ингээд орой ирэхэд голдуу л орондоо орчихсон байдаг, унтаагүй байлаа ч орыг нь засч өгөөд, толгойг нь илэн амар даа миний хүү гэхчилэн эрхлүүлчихээд нойрыг нь сэргээчихээс айн өлмий дээрээ гишгэлэн гараад хаалгыг нь аяархан хаачихдаг ээж нь энэ удаа ноцтой царайлан өрөө рүү нь дагаад ороод ирэв.

Тэгснээ орныхоо бүтээлгийг хам хум хуулан хөнжилдөө шургахаас өөр бодолгүй нойрмоглосон хүүгийнхээ орон дээр суугаад

-Миний хүү юун охинтой үерхээд байгаагаа ээждээ хэлэхгүй юм уу? гэж улаан цайм тулган асуулаа.

-Ээж, юу яриад байгаа юм бэ, надад тийм охин байхгүй гэж мань хүн бухаад, нүдэн дээрээ гараа тавин орны дэргэдэх шөнийн гэрлээ унтраахаар гараа явуулав. Хүүгийнхээ амьдралд оролцоод байдаггүй ээж нь өнөөдөр юу болсон юм гэмээр хэрэгт дурлаад байгааг гайхах сөхөө ч түүнд байсангүй.

-Ээж нь чамайг асрагч охин руу гүйгээд байгааг мэдсэн шүү

-Та хүн мөрддөг бол оо юу?

-Мини хуу ухаантай сан. Өөртөө тохирох аятайхан охин...

-Эмнэлгийн асрагч байхаараа надтай тохирдоггүй юм уу?

-Ямар өөдтэй айл хүүхдээ сургууль соёлд ч оруулахгүй асрагч хийлгэж байдаг юм. Гэр нь Хайлаастанд байдаг юм гэх чинь билээ. Би чамайг хангалттай дураар нь тавьсан одоо бол үгүй шүү.

Итгэлийн инээд нь хүрч байсан ч нойроо сэргээхээс айсандаа ээжийгээ цаашлуулсаар байгаад өрөөнөөсөө гаргачихав.

Би 20 гарчихсан хүн. Миний амьдралд битгий оролцоод бай. Би тэр асрагч охинтой чинь удахгүй сууна за юу. Одоо би унтаж болох уу ээж ээ? хүүгээ ингэж хэлэхэд ээж нь ганц ч үг дуугаралгүй шогширсоор гарав. тэр орондоо ороод унтах гэтэл нойр нь хаашаа ч юм хулжин одсон байлаа. Жижиг хүүхдийн зовлон жижиг, том хүүхдийн зовлон том байдаг гэдэг юутай үнэн үг билээ. Өнчин дэрэн дээр өнгөрүүлж буй ганц бие эмэгтэйн бүүдгэр амьдралынх нь гэрэл гэгээ болсон хүүгийнх нь байж байгаа царай энэ. Ямар ч байсан гар хумхин сууж болохгүй. Хуугээ яаж тэр охиноос нь холдуулах бэ гэж тэр түмэн арга сэдсээр үүр цайлгажээ. Үүр цайхийн алдад жаахан дугхийгээд сэрэхэд нь 7 өнгөрчихсөн байв. Сандран босч 2 хүүхдээ дуудан босгов.

Хэд хоног хэнээр ч дуудуулахгүй эртлэн босоод л төрөл арилжсан мэт байсан Итгэл өнөө өглөө бахи байдгаараа хэд хэд дуудуулан байж босоод шүүгээгээ онгичин баахан цамц гарган голж шилэн хуримын бэр мэт аашилж байснаа цайгаа ч уулгүй гарч одсон тул ээж нь өчигдөр

шөнийн сэдвээр дахин үг ч солиж чадсангүй. Итгэл ч тэр ярианаас илт зугатан гарч одсон нь ойлгомжтой байлаа.

Навчаа нь ээж миний богино ханцуйтай цагнаа цамцыг харсан уу, ээж юпка индүүдээд өг хэмээн элдэвт дайчилсаар арай гэж нэг юм хичээлдээ явж санааг нь амраав. Охиноо гарах гээд үүдний толинд харж зогсоход нь талдаа татчих санаатай.

-Цаад ах чин нэг асрагч охинтой үерхээд байна. Яаж тэрнээс нь салгадаг юм билээ хэмээн үг өдсөн чинь охин нь эргэж хараад тас ширвэн

-Юу нь болохгүй байгаа юм? Өөрт нь л таалагдаж байгаа бол та нээх салгах гээд байхдаа яадаг байна.

-Та одоо хүүхдүүдийнхээ хэрэгт оролцохоо боливол таарна гэхийгээд хаалга саван гарч оджээ. Нөхөртэй хүүхнүүд бол ханиа халамжилаад, түүндээ сайхан харагдах гэж гоёж гоодоод, хоёр биендээ эрхэлж туниад хүүхдүүддээ нэг их нялуураад байх нь ховор биз. Гэтэл Цолмон нөхрөө явснаас хойш санаж сарвайх юм нь хоёр хүүхэд нь л болсон тул тэр хоёрыгоо дэндүү эрхлүүлж, юм юман дээр ээжийнхээ гарыг харсан хүмүүс болгосноо мэджээ. Долдугаар ангийн охин байж Навчаа нь өөрөө хувцасаа угааж, индүүднэ гэж үгүй. Тэгсэн мөртлөө эцэггүй хүүхдийн толгой том гэгчээр үг сонсохгүй байх санаатай гэж бодохоос нэг талаар бухимдан, нөгөө талаар өдрөөс өдөрт өсч буй хүүхдүүддээ илүүдэж байгаа мэт санагдан гомдсоор ажил руугаа нойр дутуу сэтгэл гутруу гарчээ.

Намууны хувьд энэ өдөр дэндүү сайхан өдөр байлаа. Одоо тэр өөртөө итгэлтэй болжээ. Зөрөөд өнгөрсөн залуу бүхэн эргэн харахаар гойд гоолиг хөөрхөн биш ч гэсэн таалагдсан залуугийнхаа зүрх сэтгэлийг энэ л эгэл төрхөөрөө татаж сайхан хайрын эзэн болж чадсандаа, аавынх нь хөрөнгөнд биш өөрт нь зөвхөн өөрт нь татагдсан тийм үнэнч дурлалтай учрах хүсэл нь биелсэнд хязгааргүй их баяртай байлаа. Ямар сайндаа хичээл дээрээ нүд нь гэрэлтээд, байн байн гар утсаа гарган хайрын мессэж солилцоод байгаа нь татварын онолын багш дүнсгэр өвгөн хүртэл анзаарчихсан манай Намуун чинь хичээл дээр утас мутсаа оролдохгүй овоо хүүхэд байсан чинь өнөөдөр мессэж мастер болчихжээ хэмээн онигоонд оруулаад авав. Хичээлийн дараа гэртээ ирээд байтал Жавхаа бөөн дуу шуу болсоор тэднийд ирэв. Нов ногоон намирсан даавуун хослол өмсч, хөдлөх бүрд нь гялалзсан шилэн шигтгээ, ногоон хашаар чимэглэсэн урт ээмэг зүүж, өөрөө оёсон бололтой ногоон илгэн үүргэвч үүрсэн нь моодны сэтгүүлээс бугаад ирсэн загвар өмсөгч шиг л дэгжин харагдаж байв.

-Чи өнөөдөр ямар гоё харагдаж байнаа гэж Намууныг дуу алдан шагшихад муухай мушийгаад

-Баярлалаа. Яахав дээ. Ядарсан амьтан чаддагаараа л гоёчихоод явж байна. Уг нь ганц чамаас биш ганц ч болтугай эр хүнээс магтаалын үг сонсдог ч болоосой гэснээ баахан гомдол тавиж гарав. Тэгэнгүүт нь Намуун түүнийг чирэх шахам шатаар өгсөж өрөөндөө оруулав. Сайхан залуутай болчихоод ганц бие найзыгаа мартсан л гэнэ, хааяа нэг мессэж бичхэд яадаг юм л гэнэ. Тэгээд Намууны ширээн дээр тавиаатай Итгэлийн зургийг хараад

-За тэгээд хайрт чинь ямархуу залуу байна? Бид хоёрын жүжгээс болоод уурласан уу? хэмээн шалгаав.

Намуун ч түүний юм бүхэн нь таалагдагийг, асрагч болж жүжиглэсэнд нь уурлаагүй, харин ч хоёр биедээ улам хайртай болсноо яриу. Ийнхүү бүтэмжтэй сайхан байгаа хайр дурлалынхаа тухай, эсвэл золгүй явдлынхаа тухай найздаа хамаа намаагүй тоочдоогоороо л эмэгтэйчүүд

асар том алдаа хийдэг билээ. Намуун ч бүсгүйчүүдийн энэ алдааг давтаж байгаагаа мэдсэнгүй. Найзынхаа амьдралын нарийн ширийнийг гарын 5 хуруу шигээ нэвтэрхий мэддэг хамгийн дотны бүсгүй нь нэг л өдөр хамгийн том дайсан нь болон хувирч байсан түүх тоогүй олон. Энэ нь бүсгүй хүнийг өр нимгэн, ам сул атлаа баахан жөтөөрхүү зантай болгон бүтээсэн бурханы алдаа ч байж болох юм.

Найзынхаа яриаг инээд хөөр болон сонсч байсан Жавхаа сүүлдээ гуниглачихав. Герман яваад усанд хаясан чулуу шиг таг болсон Ганаагаас хариугаа авах төлөвлөгөө нь биелсэн юм алга. Охидууд сайхан хайртай учраад л байх юм. Ядаж л надад чинь пизлогийн хэрэгцээ гэж нэг юм байна шүү дээ. Би ямар авгайтай хөгшин хүнтэй явалтай нь биш. Гэр бүлтэй хүнтэй явах нь аймаар там нүгэл гээд л баахан гомдоллов. Жавхаа католик сүмийн цуглаанд хоёр жил явж байгаа бөгөөд Намууныг ч Ертөнцийн эзэнд итгүүлэх гэж оролддог нь инээдтэй

-Ийм сайхан өндөр гоолиг хүүхэн чин нэг л өдөр ханхүүтэйгээ учирна даа. ингэхэд чи тэр Ертөнцийн эзнээсэ сайн гуйгаагүй юмуу? залбираад гуйгаад байх юм бол есөн хүсэл биелдэг гээд л намайг ухуулаад байдаггүй бил үү? гэж Намуун хэлээд бүүр уурлуулчихав. Чи миний хамгийн сайн найз байж хүнийг ойлгохын оронд миний зовлонгоор тоглоом хийлээ. Тоглоом хийхдээ шашин шүтлэгээр минь дайрууллаа гээд л гомдоллон үглэж байснаа гадаа гарч тэдний хашаагаар зугаалаад дорхноо тайвширчихав. Жавхаа буцаж орж ирээд Энрику-ийн Хэръёо-г тавиад улам ч хөгжилтэй болчихов. Түүний энэ дуунаас Испиаан хүний халуун цус, аам омог шингэсэн хүчирхэг хоолой, амьдралын хамаг эрч хүч, хөгжил хөдөлгөөнийг илэрхийлсэн дууг сонсож мөрөөдлийн хөвгүүнээ ярих дуртай билээ. Тийм болохоор ч тэр үү түүнтэй нэр холбогдсон алдар цуутай хүүхнүүдийг өөлж муулж гарна. ялангуяа Оросын теннисчин Анна Курниковаг бүүр үзэхгүй. энэ мангар орос хүүхний юунд нь болдог байнаа. богинохон хөлтэй, хөл уртасгах мэс засал хийлгэсэн л юм байна лээ ш дээ гээд л. Өнөөдөр ч гэсэн Намууны өрөөний жижигхэн буйдан дээр хэвтэн гуурсаар жүүс сорж байснаа

-Хүүе ээ,би яг Энрику шиг гоё нүдтэй залуутай таарах юм бол ганц унтаад хаягдсан ч яахав гэж боддог юм гээд тас тас хөхрөв.

Бодоод байхад Итгэлийн найз Батбаяр Энрику-тэй яггүй адилхан давхраалаг гүнзгий хар нүдтэйг санаад Намуун түсхийтэл инээд алдчихав.

-За яав? юундаа инээсэн юм? Хүн үнэнээ сэтгэлээсээ яриж байхад чинь гэж Жавхаа намжирдлаа.

-Тийм залуу зааж өгөх уу?

-Хаана байна? гээд Жавхаа өндийгөөд ирэв.

-За за тоглосон юм. тэр чинь аймаар хүүхэмсэг гэсэн. чи тийм нөхөртэй болчихвол уурлаж үглэсээр байгаад цус харвачих биз гэлээ.

-Тийм сайхан нөхөртэй болчихвол яадаг юм, тэснэ ш дээ.

-За мөн залж байна аа. Тэгдэг бол сайхан л байна. Чи тэсэж тэсэж нэг л өдөр хайруулын тавгаар тархийг нь хага цохих байлгүй гэлцэн баахан хөхрөлдөв.

Намуун түүнийг дахиад уурлачихвал гомдол тавиад салахгүй гэж айсандаа Батбаыр бол яг Энрику шиг давхраатай тунгалаг нүдтэй гэж хэлэх гэсэнээ больжээ. Даанч дэндүү дуугүй, хөдөөний залуу болохоор Жавхаа шиг ам хэл нь дийлдэхгүй, тэгээд юм бүхнийг өөлж үглэж явдаг хүнтэй яаж таарах билээ. Яг тэр үед Итгэл утасдав.

Тэр хоёрын ярихыг Жавхаа атаархангүй сонсож сууснаа өрөөнөөс гараад явчихав. Итгэл Намуун хоёр цагийн дараа Тэнгист кино үзэхээр болов. Жавхаа зочны өрөөнд нь орж харандаагаар таталбар хийнгээ эмээтэй нь ярилцаж суугаад орж ирлээ.

-Та хоёрын нялуурч байх хооронд би шинэ коллекцын санаа олоод зарим загварынхаа эскизийг хийчихлээ ш дээ. хараач “манан“ гэдэг авангард загвар. Гэхдээ зоригтой хүн бол үдэшлэгт өмсөж болно гээд баахан загвар зурснаа үзүүлээд

-За за . Би ч найз майзтай болоогүй нь яамай. Тэгсэн бол ингээд л болзож бариад хамаг цагаа барчих юм байна. би сургууль руугаа буцлаа. Намрын гоёлд оролцохоор болсон гэв.

-Мартсанаас, чи ногоо навчин дресс-аа хийсэн үү? гэж Намууныг хувцасны өрөөнөөс толгой цухуйлган асуухад

-Хүүе ээ, Овоо ш дээ миний найз. Миний хийх гэж байсан загварыг мартаагүй санаж байдаг чинь. би хийчихсэн ш дээ. сургууль дээр байгаа. Чамд үзүүлэх гэхээр чи чинь нэг бол эрүүл мэндийн салбарт зүгээд нэг бол хайр дурлалын асуудлаар хөөцөлдөөд олодохгүй юм байна ш дээ хэмээн гомдоллов.

Тэр хоёр хотын төв явахаар гарав. Гэтэл Жавхаа тэдний цэцгийн мандлаас хэдэн цэцэг таслан авч ишийг нь нямбайлан янзлаад үүргэвчиндээ хийчихэв. тэгээд машинд орж суугаад

-Өнөөдөр чин Зоригийн нас барсан өдөр. Энэ цэцгийг хөшөөнд тавих гэсэн юм гэв.

Намуун юу ч хэлсэнгүй . Үнэндээ Жавхаа улс төр сонирхдог, нийгмийн идэвхээр түүнээс хавьгүй илүү амьтан билээ. Тэр хоёрыг Зоригийн хөшөөнд дээр ирэхэд хамгийн гайхалтай нэг явдал болов. Юу гэвэл нөгөө Энриүк шиг нүдтэй сайхан залуу Баагий бас Зоригийн хөшөөнд цэцэг тавьчихаад явах гэж байхтай тааралдчихав. Намуун түүнийг найзтайгаа танилцуулаад, та хоёр чинь ийм эсрэг тэсрэг зантай юм байж хоёруулаа улс төрийн идэвхитэй гэж хэлээд авлаа. Баагий чимээгүйхэн инээмсэглээд

-Зүгээр нэг улс төрийн идэвхитэй биш. Энэ хүнийг хүндэлдэг байхгүй юу гэлээ. Ямар нэгэн юмнаас дорхноо өө олж харчихаад элдэвээр шүүмжилэн байдаг Жавхаа л юу ч хэлсэнгүй.

Тууз, чимэглэл болсон сүрлэг цэцгэн хэлхээ, ёроолд тавиад Намуунаа явах уу гэлээ

-Энэ олон гоё цэцгэн дунд миний цэцэг дэндүү хогийн харагдаж байна уу гэж яагаад ч юм Баагийгаас асуув. Цаадахь нь Жавхаатай харц тулгарчихаад бушуухан нүд буруулаад

-Гол нь цэцэгний сүрэнд биш тавья гэсэн сэтгэлдээ л байгаа байх гэлээ.

-Яг үнэн гэж Жавхаа хэлээд машин руу алхав. хэдийгээр Намуун ажил руу нь дөхүүлээд өгий гэсэн ч Баагий явган алхах нь эрүүл мэндэд тустай гээд яваад өгөв.

-Баагий ёстой сонин залуу шуу. Хамгийн анх Итгэлт надтай уулзах гэж ирэхэд энэ Баагий дагаж ирээд нэг ч уг дуугаралгүй машинд байж байгаад явчихаж билээ. Хүнд хамгийн хэрэгтэй үед нь хань болчихоод тэрнийгээ их тус хүргэлээ гэж боддог ч үгүй тийм л залуу. тэгээд бас чимээгүй байж байснаа гэнэт ганц жинтэй үг хэлнэ. Ёстой сонин залуу гээд

Намууныг машинаа асаахад хойд шилээр нь Баагийгийн араас харсаар байсан Жавхаа

-Би дээр үед нөгөө дисконы маргааш танай эмээгийн байрний гадаа эд нартай тааралдахад энэ залууг яагаад анзаараагүй юм бол оо? Нүд нь яг Энрикүгийнх шиг гоё юм. Найз охинтой бол уу? гээд санаа алджээ.

Тэр хоёр төв замаас Энх тайвны гүүр тийш эргэх гэтэл зам түгжирээд сигналаа чих дүлийртэл хангинуулах машины овооролдоон дунд баахан зогсов.

-Би л хотын дарга байсан бол хамгийн түрүүнд энэ замыг өргөн болгоно. Ер нь анхнаасаа яах гэж ийм тэнэг хавчиг зам тавьдаг байнаа хэмээн Жавхаа үглэж суулаа. Намуун түүнийг сургууль дээр нь буулгачихаад номын санд хэсэг суув. Амьдрал нь дэндүү утга учиргүй өнгөрөөд байгаа ч юм шиг. ядаж ээжийнхээ шахалтаар банкны эдийн засагч гэж ямар ч сонирхолгүй мэргэжлээр сурдгийг хэлэх үү. Жавхааг л харахгүй юу. Өөртөө хувцас хийж өмсчихөөд Зоригийн хөшөөнд цэцэг тавиад явж байхад.. Хамгийн гол нь өөртөө хувцас хийж байгаадаа биш амьдрал нь зорилготой байгаа нь л атаархмаар санагдана.

Тэр Улаанбаатар зочид буудал орж бэлэн мөнгөний машинаас мөнгө авангаа ийнхүү элдэв бодолд дарагдан зогсож байтал

-Хүүе сайн уу? Хүү минь гэх танил дуу ард нь гарав. Эргээд харвал түүний ажиллаж байсан эмнэлэгт хэд хоног хэвтсэн Ёндон хэмээх хүн инээгээд зогсож байлаа. Намуун тэгэхэд нэг удаа өрөөнийх нь цонхыг арчих гэж өрөөнд санаандгүй ширээн дээр байсан илтгэлийнх нь англи орчуулгын дүрмийн алдааг засаж өгөхөд ийм чадалтай хүүхэд энд юугаа хийж байгаа юм? гэж асуухад нь Намуун их сургуулын эдийн засгийн ангид сурдгаа хэлээд энэ тухай эмнэлгийхэндээ ч хэлээгүй болхоор та хүнд битгий хэлээрэй хэмээн тохирсон юм. харин энэ эр түүнийг хувингаа бариад гарахад чи энд байх ёсгүй л хүн байна даа ах нь юм бүхэн байр байрандаа байхад дуртай гэж билээ.

-Миний дүү эмнэлэгтээ л ажиллаж байгаа юу? гэхэд нь толгой сэгсэрээд гарчихсан гэв.

-Тэгвэл манай банкинд ажиллаач гэж санал тавья гэхэд нь Намуун шууд л зөвшөөрчихлөө.

Түүний хэлсэн юм бүхэн байрандаа байхад дуртай гэсэн үг нь Намуунд их л таалагдсан болохоор ч тийм түргэн шийдвэр гаргасан байж болох юм. Ер нь тэр багаасаа л ингээд хэнтэй ч зөвлөлгүй нэг юм шийдчихдэг, тэгсэн мөртлөө амьдралынхаа гол гол асуудал дээр ээжийнхээ нөлөөнөөс гарч чадаггүй, тийм л хүн. хэд хоногийн өмнө Итгэлийн өгсөн гар утсыг ээж нь хурааж авчихаад маргааш нь учрыг нь баахан шалгаасан ч Намууны гөжүүд зан хөдлөөд хайрынхаа тухай ганц ч үг унагалгүй өнгөрсөн билээ. Хэдийгээр Намуун нууцаа дэлгээгүй ч ээж нь ингээд л нүдэн балай, чихэн дүлий үлдэх хүн биш. Өнөөх олби оготно шиг овжин бөгөөд үгнээс нь гарна гэж байдаггүй Оргил туслахаа явуулан Итгэлийн тухай хуучны До яамныхаас дутахгүй мөрдлөг хийж эхэлснийг Намуун мэдээгүй л байв.

Итгэлийн хувьд ээжтэйгээ энэ хайрынхаа тухай яриад, санаа бодлыг нь сонсоод байх хүсэл төрөхгүй, харин ч эсэргүүцэх тусам нь үерхлээ улам нандигнамаар тэрсүүд бодол төрөх ажээ. Тэгээд ч Намууныг асрагчаар ажилладаг ядуу айлын хүүхэд биш гээд үнэнийг нь хэлий ч гэж яарсангүй. Олны дотроос ганц бүсгүйг онцгойлон санаж тэмүүлэх, зүрх сэтгэлдээ хайрлан өмчлөх энэ шаналгаатай атлаа амттайхан мэдрэмжийг амьдралдаа анх удаа амсч байхад ээжтэйгээ ч бай бусад хэн нэгэнтэй энэ тухай бүх ард түмний санал агуулга гэдэг шиг яриж хэлэлцээд, сонжиж сортолзсон яриаг нь сонсохыг огт хүсэхгүй байлаа. Тэр дуусдаггүй ажилаа амжуулсаар Намууны сууж байгаа номын сан руу сэтгэл яаран хөдлөв.

Мессэж бичих юм уу, ярих гэснээ гэнэт очиж баярлуулъя гэж шийджээ. Машинаа номын сангийн үүдэнд тавьчихаад олон оюутан шуугилдсан танхим руу хайртыгаа харцаараа хайлаа.

Намуун тэртээ буланд цонхны дэргэд сууж байлаа. Урдаа гар компьютерээ дэлгэчихсэн мөртлөө үзэгнийхээ үзүүрийг хэмлэн их л идэвхитэйгээр номоо унших аж. Итгэл түүнийг хэсэг харж зогссоноо гар утас руу нь залгаж

-Бүсгүй, үзгээ хэмлэхээ болиоч. Олон нийтийн газар их эвгүй харагдаж байна шүү гэхэд Намуун алгаараа амаа таглан инээгээд

-Чи хаана зогсож байгаа юм бэ? гээд ийш тийш харан түүнийг хайгаад олсонгүй.

Итгэл ширээнүүдийн дундуур өндөр биеэ хэд нугалан мөлхөх шахан явсаар гэнэт сууж байсан ширээнийх нь доороос

-Ингээд гараас нь барьчихвал надаас зугатахыг чин харъя гээд хоёр гараас нь бариад авлаа.

Ёо ёо хүн цочоочихлоо гэх мөртлөө Намуун нүдэнд нь баярын оч гялалзах аж. Хоёуулаа номын сангаас хөтлөлцөн гарав. Гадаа бараан уул хэвсийн, жижигхэн жижигхэн цас хаялсан зэврүүн өдөр байлаа.

-Чи өнөөдөр ямар гоё харагдаж байгаага мэддэг ч болоосой гээд Итгэл хацар дээр нь үнсчихэв. Намуун энэ л уулзалтанд бэлтгэж хамгийн дуртай хувцаснуудаа өмссөн билээ. Туулайны арьсан захтай цав цагаан торгон савхин хүрэм, битүү захтай цагаан ноолууран цамц, дэгжин хийцтэй. Пацо Раббани-ын өмд. хүрэм цамцтайгаа хослуулан зүүсэн жижигхэн сувдтай цагаан алтан ээмэг, зөөлөн үнэртэй сүрчиг. бас үсээ цагаан өдтэй боолтоор сулхан боосон. Цагаан хувцас өмсөхөөр царайд нь гэгээ нэмээд хар нүд нь улам тодрох шиг болно. Хоёулаа машины зогсоол хүртэл хөтлөлцөн яваад өөр өөрийнхөө машины хажууд очиж зогсоод инээлдэв.

-Хоёулаа хаачих бэ? гэж Намууныг асуухад Итгэл

-Чиний очъё гэсэн газар руу л явъя гэлээ

-Эхлээд би гэртээ очоод машинаа тавьчиха тэгэх үү?

-Тааллаар чинь л больё

Төв замаар Намуун машины урсгал дунд их л сандарсан шинжтэй жолоогоо тас зуурчихсан явснаа гэрийнхээ тэндэх буйдхан зам дээр гарч ирээд Итгэлийг гүйцэж түрүүлэн хурдлав. Намуун машинаа тавих нэрээр Итгэлийг шалсаар байгаад гэртээ оруулчихав. Итгэлийг хашааны хаалгаар оронгуут зуудаг Банхар нь том сэгсгэр сүүлээ сохон хуцахад Намуун нохойгоо зандран Итгэлийн гараас нь хөтөлсөөр хаалган дээрээ очив. Хонх дуугарангуут гэрийн уйлчлэгч нь хаалга тайлж өгөв. Цаанаас нь эмээгийнх нь харваас хэрэгт дурласан илт өнгийн харах агаад жижигхэн цагаан хав юунаас дутах бэ жонгинотол хуцан гүйж ирэв.

Намуун Мики нааш ир гээд нохойгоо аваад гутлаа солих зуур

-Эмээ танилц, Итгэл гэдэг юм. компьютерын мэргэжлээр сурдаг хүүхэд. Танд харуулах гээд дагуулаад ирлээ гээд гарыг нь тавилаа. Харуулаад байхдаа яахав дээ гэж Итгэл бага зэрэг эгдүүцсэн ч хөгшинтэй мэндлэхээс аргаггүй байлаа.

-Сайн байна уу эмээ?

-Сайн сайн хүү мин. орооч гэж эмгэн нүдний шилэн дээгүүрээ харангаа хэлээд дөхөж суух аж. Итгэл гутлаа тайлахаас аргаггүй болов. Гэрийн үйлчлэгч нь улавч авчирч өгөв.

-Энэ эгчийг Дооёо гэдэг юм. Манай гэрийн үйлчлэгч

Үүдний өрөө нь жирийн угсармал айлын том өрөөг лав 4 нийлүүлсний дайтай уужим бөгөөд энд тэндгүй зөөлөн буйдангийн хослол тавьсан, европ маягаар тун ч донжтой тохижуулжээ. Хоёр давхар руу гардаг шатны дэргэдэх хүнхэр адарт Намууны багын зургийг томоос том угаалгаж хаджээ. Итгэлийг буйдан дээр суумагц Намуун эмээдээ түүнийг компьютерын мэргэжлээр сурдаг, гэртээ ээж дүү хоёртойгоо байдгийг товч танилцуулаад ээжийг асуувал ингэж хэлээрэй гэж байгаа юм шүү дээ эмээ. Манай эмээ ухаантай хэмээн цаашлуулаад Итгэлийг өрөөндөө хөтлөн оруулж хаалгаа хаав. Итгэл түүний өрөөнд орж л нэг овоо тайвширчээ. Нэг ханандаа багадаа зурсан зургуудаа зай завсаргүй нааж, үлдсэн 3-н ханандаа өөр өөр өнгийн цаас нааснаас үзэхэд эзэн нь нэлээд этгээд маягийн засахыг бодсон нь илт. Бас Намууны өөрийн бүтээлээс гадна хэд хэдэн уран зураг ханандаа өлгөжээ. Орны дэргэдэх том ханын тавилгыг Намууны өөрөө болоод аавынх нь энд тэндээс олж ирсэн элдэв сувинир, амьтны чихмэл, элдэв дүрсийн чулуу, этгээд хэлбэртэй үндэс гээд хачирхалтай цуглуулгаар чимснээс гадна маш олон ном өржээ. Орны эсрэг талын ногоон хана налуулан тависан жижигхэн буйданг тойруулаад түүний тарьсан том жижиг ваартай янз янзын цэцэг анхилам үнэр түгээнэ.

Харин гадаад дотоодын ганц ч од одонцорын зураг харагдсангүй.

-За яав. Аав ээжийг байх вий гэж бажигдав уу? Би гэдэг чинь ийм л дураараа бас өөрөө ч

заримдаа өөрийнхөө яах гээд байгааг ойлгодоггүй хүн ш дээ. Уг нь би зүгээр машинаа тавьчихаад л чамтай явъя гэж бодсон юм. Гэрийн хажууд ирэнгүүт чамайг эмээтэй танилцуулмаар санагдаад... Хачин зантай амьтан байгаа биз? гэж Намууныг хэлэхэд залуу үсийг нь илэн хоёр хацрыг нь гараараа барьж нүд рүү нь харж байснаа уруулд нь уруулаа аяархан хүргэлээ. Хайртай хүнтэйгээ үнсэлцэх ийм сайхан байдгийг аль аль нь анх удаагаа л мэдэрчээ. Намуун эхлээд эсэргүүцэн түлхэснээ нэг л мэдэхэд өөдөөс нь удаан гэгч нь хариу үнсээд энгэрт нь наалдлаа.

-Итгэл ээ, чи миний юунд ингэж татагдсан юм бэ?

-Юм юманд чин. ялангуяа нүдэнд чинь.

-Чи надад тийм их хайртай юмуу?

-Хайрыг хэмжиж болдог юм уу?

-Надад бол хэмжиж болох юм шиг санагдах юм. Чи надаас өмнө... үерхэж байсан уу?

-Үгүй, уулздаг байсан хүүхнүүд бол зондоо. гэхдээ хэнд нь ч хайртай болж байгаагүй. Харин чи?

-Нэг удаа үерхэж байсан. Тэрэнд ... би хайртай байгаагүй гэдгээ сая л мэдсэн.

-Яагаад боличихсон юм бэ?

-Тэрний тухай ярьмааргүй байна. Би чамаас тэр хүүхнүүдийн чинь тухай асуухгүй байхад... чи миний албумыг үзэх уу?

-Тэгий

Тэр хоёр Намууны хэдэн зузаан албумыг үзчихээд гарахад нар шингэж байв. Одоо Итгэл энэ бүсгүйн тухай хамаагүй ихийг мэддэг болжээ.

Тэр хоёр хамт кино үзэж анх удаа үнсэлцэв. Гэрэл унтраасан кино танхим гэдэг хэзээний хайртай хосуудын үнсэлцдэг газар юм чинь. Киноны дараа Итгэлийн машинаар гэр рүүгээ хүргүүлж явахдаа Намуун банкинд ажиллах болсноо ярин шөнийн хотоор салхи татуулан давхиж явахдаа үгээр хэлшгүй аз жаргалтай байлаа. Тэр хоёр Намууны гэрийн хашааны үүдэнд салж ядан нэлээд зогсоод аргагүй эрхэнд маргааш болтол баяртай гэгцгээгээд салав. Намрын жихүүн салхи салхилж байсан ч сэтгэлд нь гал асах мэт халуун хайр нь шатаж байсан юм.

Харамсалтай нь хоёр залуугийн сайхан үерхэлд хоёр талаас ээжүүд нь таатай хандсангүй. Итгэлийн ээж тэр өдөр найзуудтай нь уулзаж, Намууныг асрагч биш харин шатахуун оруулж ирдэг том компаний эзний охин гэдгийг мэдээд сэтгэл нь улам үймрэв. Баян айлын танхил охинтой амьдрах ч амар биш. Ер нь тэгээд тэр охин анхнаасаа ямар санаатай Хайлаастан амьдардаг, асрагч энэ тэр болж жүжиглэсэн юм бүү мэд. Цолмон бодох тUSAм сэтгэл дотроо хүүгийнхээ сонголтонд гонсойсоор байлаа

Харин Намууны ээж Наран тэр өдөр Итгэлийн тухай нэлээд юм мэдэж аваад харьжээ. Тэр нөхрийнхөө туслах Оргилд Намууны үерхээд байгаа залуугийн тухай мэдэж ирэхийг даалгасан юм. Оргил бол компанид болж байгаа явдал, ажилтнуудын тухай хов живийг эвтэйхэн дуулгачихдаг, хүний бөөр олоод ир гэсэн ч яаж ийгээд аваад ирж мэдэх овжин үлгэрт гардаг илбэт цурхай мэт дуулгавартай амьтан билээ. Аав нь хаяад явчихсан, ээж нь жижиг дэлгүүр ажилуулдаг, сард доод тал нь дөрвөн хүүхэн сольдог залуу. Сургуулиасаа хоёр жилийн чөлөө авч наймаа хийж байгаад энэ жил хичээлдээ орсон. Найзуудтайгаа хамтарч компьютерын шалихгүй үйлчилгээ явуулдаг Оргилын мэдэж ирснээс иймэрхүү гол гол парадоксууд нь Нарангийн уурыг нь хүргэчихэв.

Нөхөртөө энэ тухай ярихад нь нэг их тоосонгүй. Хүүхдүүд үерхэж л байна биз. сүйд болоод яах гэсэн юм гээд өөрийнхөө ярьдагаар шаариг цохихгүй яваад өгөв. Энэ нь Их хурлын

гишүүн, сайдаас өгсүүлээд хамтрагч түншүүдтэйгээ биллярд тоглож шөнө дөл болтол гэрийн бараа харахгүй гэсэн үг. Нөхрийнх нь энэ тоомсоргүй байдал түүнийг бүүр бухимдуулж, охин руугаа залгатал утас нь салгаастай байв. Яг тэр мөчид Намуун Итгэлтэй хамт кино үзэж гар гараа атлагтан сууж байсан юм чинь.

Сүүлийн үед охин нь улам л үгэнд нь орохоо байж, юу хийгээд байгаа нь мэдэгдэхээ больсонд Нарангийн сэтгэл маш их бухимдаж байлаа. Намуун Хасартай үерхэж байсан бол дээр сэн. Гэтэл элдэвээр шалтаглаж байгаад больчихсон. Уг нь Намуун хичээл номдоо тэртээ тэргүй нэг их шамдаад байх биш. Хасартай эртхэн шиг суугаад хүүхэд гаргачихвал дээр сэн гэж хүртэл тэр бодож байсан юм. Хэрэв зээтэй болчихвол сүүлийн үед нэг л өөрөөс нь хөндийрөөд байгаа юм шиг санагдах болсон нөхрийнх нь сэтгэл гэр рүүгээ эргэх юм биш үү. Хүүхэд том болж, амьдралын аар саар бэрхшээл арилсан дөчөөд насны гэр бүлд хямрал нүүрлэн, залуу цагт нь тэднийг нэгтгэж байсан үр хүүхдээ өсгөх, санхүүгийн хувьд хөл дээрээ зогсох гэсэн асуудлууд алга болдогоос аажимдаа бие биенээсээ хөндийрч эхэлдэг гэдгийг тэр мэднэ. Хос хоёрыг орой гаргасан хүүхэд дахин оройтуулж, гэр бүлд халуун дулаан амьсгал авчирдагийг ч танилуудаасаа дуулсан. Гэтэл одоо өөрийнх нь хүүхэд төрүүлэх хөг өнгөрсөн. Харин охиноос нь зээ гарчих юм бол шал өөр хэрэг. Нөхөр нь ганц охиндоо амь тавьдаг юм чинь.

Тэгээд ч ааш нь олдоггүй, дураараа охин нь эртхэн шиг хүнтэй суугаад хүүхэд гаргачихвал эрхбиш ухаан сууна биз. Намууныг Хасартай үерхэж байхад тэр ийм бодолтой байсан юм. Гэтэл бүх юм санаснаар нь болсонгүй. Аль залуу цагийн найз, одоо хэд хэдэн бизнест хамтардаг ганц найз Нансалмаатайгаа худ ураг боллоцох бодол нь талаар болчихлоо. Тэгснээ хаанаас олоод авсан юм, эцэгтээ хаягдсан нэг шалдан бандитай зууралдах гэж. Тэр гэртээ оронгуутаа л

-Ээж тэр Намуунтай үерхээд байгаа залууг мэдэх үү? гэж асуулаа.

Аанай л сонин уншаад улаан харандаагаар зурж суUSAн эмгэн охиноо ууртай байгааг гадарласан ч хэзээд зээ охиныхоо талд ордог зангаараа Итгэлийг магтаж гарав.

Харваас томоотой сайхан хүү харагдсан, сайхан ч мэргэжлээр сурдаг юм билээ. Хүү хүүхэд техникийн мэргэжилтэй байх зүгээр байдаг юм. Хүн нүднээсээ андашгүй байдаг юм гэхчилэн магтаж гарахад нь ээж ингээд хүүхэд доргиогоод байдаг юм. Өнөөдөр тэр нь бүүр манайд ирээ юу? Энэ охин ч дийлдэхээ болих нь ээ хэмээн үглэв.

Эмгэн ч мөчөөгөө өгсөнгүй

-Чи хэзээ байтлаа Чимэдтэй суухдаа надаас асууж байсан юм. Хүүхдийн амьдралд битгий оролцоод бай. Би ер нь гэртээ харих минь. Гэр оронтой хүн шүү муу ч гэсэн хэмээн дургүйцсэн тул ярианы сэдэв тэгсгээд өөрчлөгдсөн билээ.

Ээжийгээ гэртээ харилаа хэмээн айлгахад нь Наран аргаггүй бууж өгч, залуудаа нэртэй сайн багш явсан ээжийгээ ийнхүү хүүхдүүддээ тунирхсан ганц биеэ хөгшин болсонд нь гэнэт өрөвдөх сэтгэл оржээ.

Цагийн дараа Намууныг инээсээр орж ирэхэд ээж нь борооны хар үүл шиг барайсан амьтан сууж байв.

Ууртай байгааг нь зориуд анзаарагүй царай гарган нохойгоо салхилуулна гэсэн шалтгаанаар буцаад гарах гэсэн охиныхоо араас тэр

-Намуун хэмээн дуудлаа.

-Ээж яасан бэ? би Микиг гаргачихаад ирий л дээ гэж Намуун хэлэхдээ Итгэлийн тухай ярих нь гэж тааварлаж байлаа. Би тэрний чинь тухай мэднээ л гэнэ. Чи багахан шиг галзуураарай.

эртүүдийн тэр утсаар та хоёр надаас нуугдаж холбоо барьдаг байсан улс юм бий. Эцэггүй хүүхдийн толгой том гэдэг юм. тэрнээс арай дээр юм олдсонгүй юу гээд л ээж нь бууж гарав. - Яриа чинь дуUSAв уу? гэж Намуун асуугаад санаж бодож явдагаа ээждээ бүгдийг нь ярихаар шийдэж өмнөөс нь харан түшлигтэй сандал дээр суув. Өнөөдрийн их баяр хөөрийг нь ингэж гутаах гэж дээ. Ээждээ хайртайдаа ч биш энэ чинь миний л ээж шүү дээ гэсэн сэтгэлээр, бас багын хүлцэнгүй зангийн үлдэгдэлд баригдсандаа л аяг нь дагасаар бүр залхаж гүйцжээ. Одоо боллоо. Охин гүнзгий амьсгаа авснаа хоёр гараараа толгойгоо барьж -Та миний амьдралыг өөртөө таалагдсанаараа шийдэхээ боль.

Би одоо хорь хүрэх гэж байна. Та хэзээ намайг бодож байсан юм бэ? Цэцэрлэгт байхад намайг гэрт дандаа л ганцааранг нь цоожлоод алга болчихно. Би энэ хөшигнөөс гээд салхинд сэвэлзэн буй сиймгэр хөшиг руу заагаад хүртэл айж, тэр харанхуй өрөө рүү хүртэл харахгүй гэж нүдээ анин жорлон ордог, та хоёрын харьж ирэхийг хүлээсээр байгаад унтчихдаг байсан. Дараа нь сургуульд орох болсон чинь надаас ганц ч удаа саналыг минь асуулгүйгээр орос сургуульд оруулсан. Тэгээд найзуудаа ирэхээр нь яг циркийн сургуультай нохой шиг орос дуу дуулуулж, шүлэг уншуулж үзүүлэхийг шаарддаг байсан. Дараа нь үндсэн хичээлдээ муудах нь гэсэн нэрээр монгол сургуульд оруулахдаа бас л надтай яриагүй. Би багаасаа уран зурагт дуртай байсан. Гэтэл та хэнд ч хэрэггүй юм сонирхлоо гээд намайг зургийн дүгуйлангаас гаргасан. тэгээд зургаас холдуулах гэж, бас USA-д сурч байгаа найзууддаа гайхуулах гэж USA-руу явуулсан биз дээ?

Тэнд намайг ямар орчинд өнгөрснийг мэдэх үү? англиар бараг сайн уу, баяртайгаас өөр юм мэдэхгүй намайг аймаар хатуу Мормон шүтлэгтэй айлд суулгасан.

Тэр сургууль нь ч гэж хачин юм байсан. Дандаа хар шар арьстнуудын сурдаг, хар тамхи, sex сонирхдог хүүхдүүд...тэндхийн чийглэг уур амьсгалд нь миний хоолой ангинаас л болоод намайг буцаж ирсэн гэж бодож байна уу та? Би тэндээс залхаад буцаж ирсэн юм. Намайг USA-гаас ирэнгүүт та банкны санхүү гээд миний огт сонирхдоггүй мэргэжлээр сурахыг шаардсан. Нэгэнт намайг дуртай юмнаас минь хөндийрүүлчихсэн юм чин би үгэнд чинь ороод таныхаар болсон. Аа тийм, өөрийнхөө найзад баахан мөнгө зээлдүүлчихээд эргүүлж авах баталгаа болгох гэж намайг Хасартай үерхүүлсэн. Тэр нь ёстой өөдгүй новшийн амьтан. Та яагаад миний амьдралд дандаа оролцож, өөрийнхөө бодлыг л тулгаж, өөрийнхөөрөө л байлгах гэж зүтгэдэг юм бэ? Энэ бүхний эцэст чин би ямар ч амьдралын зорилгогүй амитан болчихоод байна. Би гэж хэн юм бэ? өөрийн гэсэн нэр мэр ч үгүй амьтан шиг баян айлын охин, аав нь том компаны эзэн гэсэн гэж хүмүүс ярихаар надад сайхан байдаг гэж боддог юм биш биз дээ? Миний дургүй хурч байна. Авьяастай сонирхолтой юмыг минь та дандаа хорьдог, сайханаа зангаа хөдлөхөөр миний карданд баахан мөнгө хийгээд л, гадаадаас үнэтэй хувцаснууд авчирч өгөөд л сэтгэлийг минь хуурчихдаг гэж бодоо юу? Баярлалаа. Би тэр өрөө дүүрэн хувцаснаас чинь бараг өмсдөггүй. Яагаад гээч? Надад бараг хэрэг болдоггүй байхгүй юу. Та нарын тэр мөнгө, компаны энэ тэр чинь надад хэрэггүй. Чиний л төлөө гэж хөрөнгө мөнгө цуглуулдаг гэж битгий л хэлж үзээрэй. Харин ганц дуу оруулж өгсөн бол би танд хамаагүй их баярлах байсан юм. одоо би өөрийнхөөрөө амьдармаар байна.

Явъя эмээ би танайд очлоо шүү гэж нэг амьсгаагаар баахан юм ярьчихаад өрөө рүүгээ гүйлээ. Ээж нь ю ч хэлж амжсангүй. эмээ нь ч юу ч хэлсэнгүй

-Ээж та бас явах гэж байгаа юм биш биз дээ? хэмээн эмээгээс нь асуух нь сонсогджээ.

Эмээ ю гэж хариулснийг тэр сонссон ч үгүй хичээлд өмсөх хэдэн хувцсаа цуглуулж цүнхэнд хийгээд шатаар галзуу юм шиг гишгүүр алгасан харайсаар гарч одсон аж.

Төрүүлсэн ганц охинтойгоо ийм харилцаатай болчих гэж.. Гомдол ч гэх үү цөхрөл ч гэх үү

нэгэн гашуун бүхэл юм хоолой өөд нь зураад явчихав. Гадаа гараашнаас Намуун машинаа гарган асаагаад хөдлөхийг сонссон ч тэр толгойгоо барин буйдан дээр суUSAАр байлаа. Биеийг нь төрүүлэхээс ухааныг нь төрүүлдэггүй гэж яасан үнэн үг бэ? Өдий хүртэл өөрийгөө тийм муу ээж байсан гэж бодож байл уу?

Үнэндээ гайхмаар сайн ээж биш л дээ. Даалгавар болгоныг нь хамт хийгээд л багш нартай нь 7 хоног бүр уулзаад л, ёсон шидийн дүгуйланд хөглөж аваачиж бүртгүүлээд л Намууны найз Жавхаагийн ээж багш хүүхэн шиг хүүхэддээ анхаарч чадаагүй нь үнэн. Гэхдээ л энэ амьдралдаа хийж бүтээсэн бүхэн нь энэ охинд л үлдэхгүй гэж үү? Цэцэрлэгт байхад нь дандаа ганцааранг нь орхидог байсан нь үнэн. Яах гэж тэгдэг байлаа гэвэл энэ компаныг л хөл дээр босгох гэж, хэнээс ч гуйхгүй, хэнээс ч цалин горьдохгүй амьдрах гэж нөхөртэйгээ хамт цаг наргүй зүтгэдэг байсных билээ.

Орос сургуульд охиноо өгөхдөө ч өөрийнх нь ирээдүйн төлөө л санаа тавьсан. Наран, Чимэд хоёуулаа монгол сургууль төгсөөд Орост сургуулид явахад хэлний бэрхшээл гэж том саад байсан. Охиноо унаган орос хэлтэй болгочъё гэж орос сургуульд оруулсан шүү дээ. Гэтэл Намуун монгол сургуульд орно гэж зүтгэн, муу сурсаар орос сургуулиас монгол руу шилжсэн.

Юугаа ч мэдэхгүй бага ангийн амьтан байж зураач болно гэж зүтгэхэд нь Наран дургүйцсэн. Яагаад тэр вэ гээч, эцэг эх хоёр нь ямар ч урлагийн дөргүй улс юм чинь энэ охины зураач болно гэж юу байхав. Хэрэгтэй хэрэггүй юманд цагаа үрж байснаас ганц бодлого бодож суUSAАн нь дээр л гэж бодоод дургүйцдэг байсан.

Гоё, Ван Гог гээд л агуу зураачдын хувь тавьлан галзуу төгссөнийг ч бодсон охиноо тийм хийсвэр юм хөөцөлдүүлэхгүй л гэж хорьсон шүү дээ. Хасарын хувьд гэвэл эцэг эх удам судрыг нь мэдэх, нүдэнд дулаахан залуу бас сайн найзынх нь хүү. Тийм хүүтэй охиноо үерхэхийг ямар ч эх дэмжих л байсан биш үү?

USA явуулсанд буруу юу байгааг бүр ч ойлгохгүй байлаа. Мэргэжлийн тухайд гэвэл өнөөдөр Монголд хамгийн ашигтай, цэцэглэж байгаа, нэр хүндтэй салбар юу байна, банк л байна шүү дээ. Тиймээс ганц охиноо банкир болоосой гэж бодсон. Энэ хүүхэд яахаараа ийм этгээд гажууд зантай болчихсоныг гайхаад гайхаад учрыг нь олохгүй юм. Ийм насны охид гоёхын тулд л амьд яваа мэт байдаг. Гэтэл Намуунд өрөө дүүрэн хувцас хэрэггүй гэж байх. Харин дүүгийн тухайд гэвэл энэ нь Нарангийн хувьд хамгийн эмзэг сэдэв. Намуун яагаад ээжийнхээ эмзэг газар руу нь хатгана бэ? Насныхаа залууд дахиад нэг хүүхэд төрүүлчих нь яав гэдэг бол түүний хувьд хэнд ч үл хэлж байгаагүй, сэтгэлдээ нууцлан сэм сэм шаналж явдаг ганц харамсал нь билээ. Хэрэв дахиад нэг хүүхэд байсан бол үнэхээр энэ гэрийн уур амьсгал шал өөр байх байсан. Хэдийгээр өөр хүүхэнд татагдаад, дахин нэг амьдрал зохиох гээгүй ч гэсэн нөхрийнх нь сэтгэл улам хөндийрөөд орон гэр рүүгээ яаран яаран ирэх шаардлага ч байхгүй мэт болчихсон мэт түүнд санагдах болсон. Хэрэв арваад насны хүүхэд байсан бол ядаж хүүхэдтэйгээ тоглох гэж, эрхлүүлэх гэж тэмүүлэх нэгэн бат бөх холбоос байх л байсан гээд бодохоор Наран өгүүлэшгүй их харамсдаг юм. Наран хэнээр ч зэмлүүлэх дургүй хүн. Гэвч ингээд бодоод байхаар Намууны үгэнд ортой ч юм нилээд байгааг үгүйсгэж чадсангүй. Газар дээрхи ганц охиноо хэзээ ингэж өөрөөсөө хүний юм шиг хөндийрчихсөнийг мэдэхгүй суугаа хүн нэрээ яаж ч сайн ээж байхав дээ. Ийнхүү охиныхоо хэлсэн бүгдийг санан санан нэг талаар бие өмөөрч, нөгөө талаар өөрийгөө сэмхэн зэмлэн суUSAАр зөндөө удчихжээ. Хэдхэн жил бизнес хийснийх хүнд үед гарах гарц олж, хамгийн зөв шийдвэр гаргахыг л тэр хүсдэг зантай. Бодож бодож охинтойгоо дахин энэ сэдвээр ярихгүй, харин аль болхоор эвтэйхэн ойлголцохыг оролдох, харин тэр үерхээд байгаа

хүүгийн хувьд харзанахаар шийджээ. Бас нэг чухал юм бол нөхөртөө өнөөдрийн болсон явдлыг дуулгахгүй байхаар шийдэв. Тэгэхгүй бол охинтойгоо хэл амаа ололцож чадахгүй энэ арчаагүй байдал нь нөхрийнх нь сэтгэлд бас л нэгэн сэв оруулах болно.

Унтлагын өрөөндөө орвол охиных нь дөнгөж мөлхөж байсан үеийн зураг нүдэнд тусна. Багадсан баривчтай, булцгар гартаа шажигнадаг тоглоом бариад байдгаараа инээсэн зураг. аав нь энэ зургийг өөрөө дарж, томиллолтоор Орос явахдаа тэр үеийнхний ярьдгаар подушкан дээр угаалган авчирч байсан юм. Нээрээ бодоод байхад охин нь дөнгөж төрж, Тэднийх шинэ байранд орж байсан тэр орь залуу үе нь хичнээн жаргалтай байж бэ? гэтэл тэр үед Наран өөрөө тийм их жаргалтайгаа мэддэггүй л байж дээ.

Тэгэхэд нөхөр нь охин эхнэр хоёртоо яаран ажлаа тарангуут гэртээ гүйж ирдэг байсан. Ирэхдээ түүнийг баярлуулах гэж заавал нэг амттан олж авчирна за миний юу авчирсныг таа даа гэдэг байж билээ. Охин нь ч тийм балчир өөдөсхөн амьтан байхдаа эцэг эх хоёроо явахад нь даган уйлдаг, тэр хоёрыг харах бүрдээ маасайн инээдэг, хичнээн өхөөрдөм байсан юм бэ? гэтэл одоо ээжийгээ яагаад тэгж муугаар бодож, сэтгэл харлуулсан үг хэлэх болов? Ер нь хүүхдийн ээж аавдаа өгсөн тэр хэмжээлшгүй их итгэл, хайр хэзээ яахаараа ор мөргүй юм шиг алга болдог юм бол? үүнд хэн буруутай юм бол? Наран шөнө бүхэн унтахын өмнө нүүрээ цэвэрлэн тос түрхдэг ёсоороо гоёлын ширээндээ суугаад ийнхүү түмэн бодолд дарагдана. Будаг шунхаа арилгасны дараа нас ахиж явааг нь хайр найргүй илчилсэн ядрангүй харц, суларч эхэлсэн арьстай эмэгтэй харагдана. Хүссэн бүхнээ амьдралаасаа авах гэж зүтгэсээр явтал нэг л мэдэхэд хорвоо ч түүнээс жавхалзсан сайхан залуу нас, эрч хүч, гоо сайхныг нь буцаан авч эхэлжээ. Наран минь чи хөгширч байна даа гэж өөрийн эрхгүй бодлоо.

Тэр энэ жил 45-тай. Хүмүүс өөрийг нь 40 хүрээгүй байх аа гэж хэлэхээр баярладаг ч өөрөөсөө хэзээ ч зугтаж чадахгүйгээ мэдэхтэйгээ хүн болохоор будгаа арилгасан үедээ хэнд ч царайгаа харуулахийг хүсдэггүй юм. Өдрийн цагт олны дунд бол яахав дээ, сайн чанарын гоо сайхны хэрэглэл, үнэтэй сайхан хувцас наснаас нь хамаагүй залуу болгож өөртөө итгэлтэй бардам харц, захирангуй чанга дуу нь түүнийг эрхэмсэг хатагтай болгон харагдуулдаг.

Гэтэл төрсөн ганц охиндоо адлагдан сэтгэлээр уначихаад, будаг шунх, хувцас хунар, ажил албаны багаа тайлсаны дараа өнөөдөр ийнхүү асуу яваа хөгширөлтийн хуй салхинд гүйцэгдэн алдсан эмзэг дорой зүрхтэй жирийн нэгэн эмэгтэй тольны өмнө сууж байлаа.

Гэтэл охин нь ч, нөхөр нь ч түүний дэргэд алга. Ингээд нэг л өдөр хөгширч ганцаардсан эмэгтэй боллоо гэж үү? хэмээн бодоод дэндүү сэтгэл жиндүүлсэн гуниг төрнө. Гадаа намрын дунд сарын уйтгарт салхи улин исгэрч тэнгэр муухай байлаа. Маргааш цас дарчихсан байх биз. Ийм л намрын уйтгарт шөнө нөхөр нь хаанаа юу хийж явааг ч мэдэх юм алга. ямар ч гэсэн ажлаа тараад өөрт нь яаран яаран ирэхээ болиод хичнээн жил болов доо.

Наран л өндрөөс олз хайн газрыг тас ширтэн эргэлдэх элээ мэт нөхрөө хаа явсан газарт нь дагасаар өөрөө ч залхаж гүйцсэн билээ. Бодвол Чимэд үүр цайхын өмнө л гэрийн бараа харж, хажуугаар нь орж хэвтээд нам унтах биз. Тэр за унтъя даа би чинь хэзээ ингэж их гиюүрдэг болоо бэ хэмээн бодоод нойрны эм авч уугаад орондоо оров.

Гэтэл хотын нөгөө захад нэгэн эмэгтэй нойр хулжаан хэвтсэн нь Итгэлийн ээж Цолмон байлаа. Тэр өнөө орой хүүтэйгээ үерхэж буй охины нь тухай ярилцан санаа бодлоо хэлсэн биш ийнхүү нойр нь хулжин одоод догшрон улих салхины чимээнд элдвийг бодсоор улам л сэргэчихжээ.

Хүүгээ орой их л сайхан зантай чихэвчний хөгжимөө сонсон толгойгоо дохилзуулсаар орж ирэхэд нь тэр хоолыг нь халаахаар гал тогооны өрөөндөө орсон юм. Гэтэл Итгэл чихэвчний хөгжимөө сонссон чигээрээ

-Ээж, би хоол идэхгүй шүү гээд угаалгын өрөөндөө орчихов.

Энэ нь түүнд гомдолтой л байлаа. Цолмонд цай хоолны дээжээ барих нөхөр байх биш.

Хүүдээ хоол тавиж, ирэхээр нь халааж өгөөд өдрийн болсон явдалаа ярилцан суух дуртайсан.

Гэтэл хүү нь тэр охинтой үерхэх болсноос хойш ээжийгээ тоохоо больжээ.

Орой дэлгүүрээ хаахад нь очиж тUSAлдагаа ч мартсан. Тэр санаа алдаад халаагч зууханд хийх гэж байсан тавагтай хуургыг хоргогч руу хийлээ. Хүүгийнхээ найз Жакатай өдөр уулзан “Цаадахь чин ямархуу охинтой үерхээд байгаа юм бэ” гэж асуухад нь мөрөө хавчаад Цоомоо эгч ээ, манай Итгэл баян айлд хүргэн орох гэж байгаа ш дээ. Намууны аав нь MGL Oil-ын эзэн юм байна лээ. Анхандаа ч тэр охин өөрийгөө Хайлаастанд байдаг, өөрийгөө асрагч энэ тэр гээд байсан. Манай хүн ч тэрнийг нь тоохгүй хойноос нь гүйгээд байсан юм аа. Бид нар хамт явж байгаад дискоон дээр танилцан юм гэж ярьжээ. Аз болоход түүнийг ажил дээр нь очиж Жакатай уулзахад хүү нь байсангүй. Сонссон зүйл нь түүнийг огтхон ч баярлуулсангүй. Харин ч тэр нь Хайлаастын асрагч охин байсан бол дээр байхгүй юу. Эр хүн бүсгүй хүнээс ямар нэгэн юмаараа дорой буурай байх шиг зовлон байхгүй шүү дээ. Өөр шиг нь жижигхэн дэлгүүртэй, 3-н ам бүлээ тэжээх төдий орлоготой хүн яаж маажганаад ч тэрбумаар ярих хөрөнгөтэй орлоготой зиндаанд ойртох ч үгүй юм чин. Өөртэйгээ адилхан дундаж сэхээтэн айлын хүмүүжилтэй, боловсролтой охинтой л суугайсаа гэж Итгэлд хичнээн хэлдэг байлаа.

Залуудаа хоёр хүүхдээ хурдхан шиг том болоосой гэж үглэхэд хурээлэнгийнх нь эрдэмтэн нарийн бичгийн даргын авгай миний дүү, чи нэг ийм үг дуулсан уу? Жижиг хүүхдийн зовлон жижиг, том хүүхдийн зовлон том байдаг, чи хүүхдүүдээ том болохоор ойлгоноо гэж байсан юм. Тэр бухимдсаар ажил дээрээ очив. Яадахад олон юм бодон бухимдаж яваад гарцан дээрээс хөдлөхдөө хүн мөргөчих шахаад бүр ч сэтгэл хямарчээ. Уг нь тэр машин барихаараа эмэгтэй хүний нямбай зангаар элдвийг бодохгүйг хичээн, гар утсаа хүртэл дуут шуудан дээр тавьдаг зантай.

Дэлгүүр дээрээ ирээд найзууд руугаа утасдан Итгэлийн үерхдэг охины эцэг эхийн тухай мэдэх юм байна уу хэмээн найзууд руугаа утасдав.

Гэтэл дэлгүүрийнх нь нэг худалдагч хүүхэн тэдний худын талын хамаатан болж таарав.

Амьдрал дорой нэг нь баян хамаатандаа хэзээ ам сайтай байлаа.

Манай Чимэд ах ч гайгүй хүн. авгай нь гэж айхтар хүүхэн бий дээ. Намуунаа багадаа хөөрхөн охин байсан. Одоо царай муутай болчихсон байна лээ. Тэгээд ёстой дураараа амьтан болсон гэсэн. USA-д сурч байгаад сургуулиа хаяад ирсэн. Наран эгчийн нэг найзынх нь хүүтэй үерхдэг юм гэсэн. Ээжтэйгээ Франц яваад ирэхдээ арван хэдэн мянган еврогийн хувцас авчирсан мөртлөө нэгийг нь ч өмсөөгүй гээд л бодчих. Гэр нь Зайсангийн тэнд хоёр-гурван давхар харш байдаг юм гээд л боль гэж зогсоотол нь ярьж гарав.

Ийнхуу тэр охины тухай сонссон дуулсан бухэн нь эхийн сэтгэлийг улам тугшээв. Хүү нь өнөө маргаашгүй л баян айлын хүргэн болчихоод нүд үзүүрлэгдэн доошоо орох гээд байгаа мэт бухимдана. Өдөр хэд хэд утасдахад дандаа утас нь салгаастай байв. Бодвол нөгөө охинтойгоо зугаалж яваа биз. Дараа нь яахав? 10-20 сая төгрөгөөр баян айлын охины ганц удаагын гоёлыг бэлтгэх бэл Итгэлд байхгүй шүү дээ. Хэдэн жилийн өмнө эцэг нь гэнэт яваад өгөхөд хүү нь ямар их сэтгэлийн зовлонд уналаа.

Гэтэл одоо хэтэрхий баян айлын охинтой үерхэж яах нь вэ дээ. Бас л сэтгэлийн зовлонд унах

болно гэж бодохоос тайван сууж чадахгүй байлаа. Түүнээс гадна Жакагийн хэлсэн үгийг л тэр яагаад ч сэтгэлдээ зөвшөөрч чадахгүй байв. Юу гэвэл тэр охиныг баян айлын хүүхэд гэд мэдээд хөөцөлдөн гүйсэн гэдэг үгийг санах. Тэр хүүгээ дотор нь орсон шиг биш юмаа гэхэд амьдралд яаж ханддаг, юу бодож явдагийг сайн мэднэ. Итгэл хэзээ ч баян айлын хүргэн болоод амар хялбар замаар хөрөнгөтэй больё гэж охиныг нь эргүүлэх хүмүүжилтэй хүн биш. Өнгөцхөн хархад хүү нь гоё ганган хувцсанд дуртай, аятайхан харагдсан охидыг эргүүлэн зугаацаж явдаг хөнгөмсөг хүүхэд шиг мөртлөө дотоод сэтгэл нь тийм биш. Эцгийнхээ гоё ганган юманд дуртай, уйдамхай занг дуурайсан мөртлөө ээжийнхээ аливаад үнэнч, чин сэтгэлээсээ ханддаг өөрийнхөө хүчинд итгэлтэй чанарыг бас шингээсэнд нь тэр баярлаж явдаг юм. Намуунаас өмнө Итгэл Жакаатай нийлчихээд долоо хоногт нэг өөр охин дагуулан, зоогийн газар, биллярд, саун хэсч явдаг байсан нь үнэн. Зарим хамаатнууд нь хүртэл Цолмонд энэ хүү чинь болохоо болих нь ээ. Тааралдах бүрд нэг өөр охинтой явах юм гэж ч хэлж байсан. Гэвч Итгэл хүн муутай, хүүхэмсэгтээ тэгээгүй. жинхэнэ амьдрал зохиох хайртайгаа учраагүй болоод л зугаалж явсан нь тэр. Хэрэв зүрх сэтгэлээ нэг л бүсгүйд өгөх юм бол тэр хөнгөмсөг хүүхнүүдийг дахин нэг нүдээрээ ч харахгүй гэдэгт ээж нь итгэлтэй байдаг юм. Харин одоо тэр хайртайгаа учирчээ. Даанч тэр нь ээжийнх нь хэлж захисаар байтал тэнцвэргүй баян айлын охин байж таарсан нь харамсалтай.

Цолмон хүүгээ усанд ороод гарч ирэхэд нь жүүс аягалж өгөөд яриа өдөв.

-Миний хүү тийм баян айлын охинтой үерхэж болж байгаа юм уу? Тийм эрхи танхил хүүхэд хэцүү дээ. Ээжийнхээ их л болгоомжтой эхэлсэн энэ яриаг үргэлжлүүлэх бодол Итгэлд алга бололтой. Хөгжмөө сонсон үсээ сэнсдсээр суув. Ээж нь дэргэд нь очоод чихэвчийг нь салгаад -Хүний үг сонсож байна уу, үгүй юу чи? хэнээ ууртай хэлсэнээ

-Чи чинь хэзээнээс ийм айхтар рок хөгжим сонсдог болчихоов? гэж түгшүүртэйгээр асуусан. Хүүгээ рок хөгжим сонсохоор ийнхүү сандран түгшдэг нь ч учиртай. Аавыгаа салаад явахад 7-р ангид сурч байсан Итгэл сэтгэлээр унан улаан рок болсон удаатай. Найзуудтайгаа нийлж орон сууцны доод хонгилын нэг өрөөг засч рок клуб болгоод шөнөжин үхлийн рок сонсч, нэг удаа оршуулгын газраар яваад хүний гавлын яс авчирахад нь ээж нь мэдэж түгшүүр авсан. Ээж нь ч тэгэхэд ёстой тэвчээр заан тэр хачирхалтай сонирхолоос нь холдуулж чадсан даа. Хүүгийнхээ түмбүүшигнээс гарсан траш рок хамтлагуудын хар дарсан зүүд мэт аймаар клиптэй хуурцгуудыг тэр эзгүйд нь тавиж үзээд үс нь босох шиг болсон.

Бас нэг удаа хүүгийнхээ сонсдог нэг дууны үгийг толь бичигтэй хамжин байж англи хэлнээс орчуулж хүртэл; үзсэн. Бурханы эсрэг босцгоож, үхлийг магтан дуулья гэх мэтийн галзуу хүний өдрийн тэмдэглэл гэдэг шиг л байж билээ.

Түүнээс хойш Итгэл рок нэг их сонсохоо больж, айлын хүүхэд рок сонссоор байгаад хар тамхинд орчихож гэнэ хэмээн ээжийгээ нэг удаа ярьхад ээж минь та намайг рокын фэн болчихно гэж айгаад байгаа юм уу даа. тэгэхэд чинь миний шилжилтийн нас байсан юм.

Одоо юу гэж хорь гарчихаад тийм юм сонирхож байх юм гэж тайвшруулж байсан юм.

-За, ээж та өнөөдөр яачихсан юм бэ? Би чинь залуу хүн. хаяа рок сонсолгүй яах юм. Та одоо Намууныг баян айлын хүүхэд гэхээр юу гэж бодоод байгаа юм. Хөлнийхөө хуруунд хүртэл алтан бөгж зүүсэн амьтан гэж бодоо юу. Аав нь баян болохоос тэр чинь жирийн нэг охин. тэгээд ч хүнээс ганц гутлын мөнгө ч хамаагүй салгачих юм сан гэж өөрөө эрчүүд өдөж явдаг хүүхнүүдийнх шиг өрөвдмөөр шунал байхгүй, юм үзэж нүд тайлсан охин байхгүй юу. Тэгээд ч бид хоёр маргааш нөгөөдөргүй суух гээд байгаа биш. Дөнгөж үерхэж эхлэж байхад чинь сүржигнээд байх юм. яршигтай юм гээд босоод явчихсан.

Тэр рок хөгжмөөс хойш ээж хүү хоёрын дунд ийм үл ойлголцол, толхилцоон бараг гараагүй

юм сан. тэр босч нойрны эм уугаад цаг харвал шөнийн нэг цаг өнгөрч байлаа. Нөхрөө явахад сэтгэлээ хатамжилан хоёр үр минь байхад би ганцаардахгүй гэж өөрийгөө тайтгаруулж байсан сан. Гэтэл одоо цагаа тулахад ганцаараа юм гэдгээ тов тодхон ухаарав.

Хүүхдүүд нь том болоод өөрсдийнхөө амьдралыг хөөн одоход ганцаараа үлдэх нь. Тэгэхээр өөрийгөө бодох цаг болжээ гэж гунигтай бодоод шөнийн гэрлээ унтраав.

11-р сар гарч цас лавсан орсон өдөр. Намуун нэгэн банкны маркетингийн хэлтэст хагас өдрөөр ажиллах болсоор нэг л мэдэхэд 20 хоночихсон байв. Улаанбаатарын утаа улам л өтгөрөн Богд уулын оройд өвөл эртийн цас цайран цаашлах цагийн хүйтэн жавар үлээнэ.

-Мань хүн ээжтэйгээ муудалцсанаас хойш эмээдээ хань болно гэсэн нэрээр гэртээ бараг харихаа больжээ. Маргааш нь өглөө хичээл дээрээ сууж байтал ээж нь утасдан өдрийн хоол хамт идье гээд урьдынхаасаа нэг л өөр, өөрийгөө буруутгасан ч юм шиг, охиноо улам хөндийрөхөөс айсан ч юм шиг аядуу өнгөөр ярихад нь их л өрөвдөн үдийн хоол хамт иджээ.

Харамсалтай нь ямар ч үед санасан юм нь бүтээд ирэх юм бол цаашлан барьцаа ахиулах гээд байдаг Наран Хасартай сая уулзлаа, та хоёр үерхэлээ сэргээж болохгүй юм уу гэснээс болж охиноо дахин уурлуулчихжээ. Ээжээ, тантай дахин энэ сэдвээр яримааргүй байна. Харин таны ч миний ч уур гарахаар би гэртээ харинаа гэчихээд гараад явчихсан юм. Уг нь банкинд ажиллах болсноо ээждээ хэлж баярлуулахаар очсон ч уулзалтын төгсгөл таалагдаагүй тул тэр тухайгаа цухуйлгасан ч үгүй.,

Харин аавдаа утсаар энэ мэдээгээ дуулгажээ. Ямар ч үед охиноо дэмждэггүй юмаа гэхэд амьдралд нь оролцоод байдаггүй Чимэд харин энэ удаа Миний охин маркетингийн туршлагаа зузаатгаад өөрийнхөө компанид ажиллах юм байгаа биз дээ гэсэн нь бас л Намуунд таалагдсангүй.

Түүний хувд аавынхаа компанид ажиллана гэдэг бодол хэзээ ч төрж байгаагүй нь учиртай. Хаа явсан газарт нь түүнийг хүсээгүй имэж болж явдаг оноох том компаны захирлын охин гэсэн нэрнээс залхаж гүйцсэн хүн тэнд очоод ажиллахаар юу болох билээ.

Захирлын охин гэж хэлэгдэж, хүмүүсийн худлаа зусардсан, атаархсан харцан дунд яаж ажиллах юм бэ?

Нэгэнт л аавынх нь компани юм чинь сайн ажиллалаа гээд магтуулах нь утгаггүй, муу байлаа гэхэд хэн бодитой дүгнэх юм бэ?

Энэ амьдралд өөрийн гэсэн хувь заяатай төрж, Намуун гэсэн өөрийнхөө нэрээр дуудуулж явах юм сан гэсэн мөрөөдөл нь аавын компанид ажиллах юм бол бүр мөсөн нурна гэсэн үг. Тэнд ээж нь байхад л хангалттай, Хувийнхаа компанид ажиллаж байгаа юм байж, өрсөлдөгч хүүхэнтэйгээ яг адилхан ажил хийгээд, захирлуудын зөвлөлд төсөл хэлэлцүүлээд, аавыгаа ерөнхийлөгчөө гэж дуудаад л, хэлтсийн даргадаа загнуулаад л байдаг романтик явдал Кореа кинонд л гардаг байх. Гэртээ нэгэн дээвэр дор цуглардаггүй шахам хүмүүс компанидаа гурвуулаа хамт ажиллана гэдэг хэмжээ нь хэтэрсэн хэрэг биш үү? гэж тэр аавдаа хэлэхдээ гомдчих болов уу ч гэж бодсонгүй.

Гэтэл аав нь түүнийг үгэнд гомдоогүй юм байлгүй өөрийгөө илэрхийлэх гээд байгаа юм биз дээ? аяндаа энэ бодол чин өөрчлөгдөх байлгүй, охин минь... гэжээ. Чимэд бол ямар нэгэн юмыг өөрийнхөө санаснаар болгох гэж зүтгэдэггүй хүн. Үүгээрээ ээж нь байсан бол охиныхоо бодлыг нь ямар ч хамаагүй аргаар өөрчилж, өөрийнхөө компанид ажиллуулах гэж чадах бүхнээ хийн, ёстой үзэж тарж, үсэрч наалдах байсан. Харин аав нь тиймгүй.

Намуун л үгүй гэсэн бол за за гээд л орхино.

Тэгсэн мөртлөө цаг хугацаа өнгөрөх тусам аавынх нь шийдвэр л зөв байжээ гэдэг нь улам

батлагддаг билээ. Харин энэ удаа л битгий тэгээсэй гэж Намуун залбирч байлаа. Давахгүй гэсэн даваагаараа гурав давна гэсэн үгэнд аав нь их дуртай. Намууныг анх ээж нь ямар ч бэлтгэлгүйгээр орос сургуульд оруулахад аав нь чи хагас жилийн дараа энэ хүүхдийг монгол сургуульд л оруулдаг байж гэж амаа барина даа гэсэн нь яг үнэн болж ихэнх хичээл дээрээ муу гарсан охиноо монгол сургуульд шилжүүлэхээс аргагүй болсон билээ. бас 10-н жилийн өмнө Намуун дүүтэй болох дөхсөн юм. Тэгэхэд тэднийх энэ компанаа хараахан байгуулаагүй, эхнэр нөхөр хоёр яаманд ажилладаг байсан үе. Бүл нэмэх болсондоо гурвуулаа баярлаж байтал Наран Японд жилийн хугацаатай суралцах болоод ур хөндүүлчихсэн юм. Гэртээ үргэлж тайван байдаг Чимэд тэгэхэд их л уурлан Чи арай гэж олдсон үрийнхээ амыг тасалсандаа насаараа толгойгоо шааж явна даа гээд хаалга саван гарч одсон юм. Хэд хоногийн өмнө ээж нь эмээд нь Тэр жил Япон явахын оронд хүүхдээ төрүүлчихдэг л байж гэж харамсах юм... гэж хоолой зангируулан ярьхыг Намуун сонссон юм.

Тийм ээ, аав нь юмийг яг голоор нь хэлчихдэг хүн. Тэгвэл Намуун нэг л өдөр би өөрийнхөө компанид ажиллая гэж шийдэх нь ээ. Намуун бол зарим үед юу хүсээд, яах гээд, юу хийх гээд байгаагаа ч мэдэхээ больж, энэ учир нь олдохгүй аашиндаа өөрөө ч дэндүү их шаналдаг.

Магадгүй эхлээд өөрийгөө юу чаддаг, хэн бэ? гэдгээ таних гэсэндээ л ингэдэг байж болох юм. Аавынх нь хэлснээр хэзээ нэгэн цагт Намуун компанидаа ажиллаж болох л юм. Ямар ч гэсэн одоо л биш. Эмнэлэгт асрагчаар ажилласан ганцхан сард Намуун хүн аз жаргалтай амьдрахын тулд зорилготой байх ёстойг ухаарсан нь хамгийн том олз болсон юм. Энэ удаа ч шинэ ажил түүний амьдралыг хавьгүй илүү сонирхолтой, зорилготой болгожээ. Сүүлийн хэдэн хоногт залуучуудийн дунд ВИЗА картны хэрэглээг нэмэгдүүлэх төслийн шинэ санаа олох уралдаанд оролцох гээд Намуун толгой нь ямагт завгүй явах болжээ.

Түүний ажилладаг банкны картны төвд өдөрт дунджаар 10-н карт шинээр нээдэг, жилдээ 400-ч хурдэггүй гэсэн үг. Тиймээс шинэ төсөл санаачилж хэрэгжүүлснээр картны борлуулалтыг хэд дахин нэмэгдүүлэх ёстой байлаа.

11 сар бол Улаанбаатарын залуучуудийн жинхэнэ шоу-ний сар билээ. Эндээс л Намуун нэгэн шинэ санаа олжээ. Энэ сард болдог рок, поп-ийн хамгийн том шоу-г ивээн тэтгэж, тасалбарт нь карт эзэмших эрхийн үнийг шингээх юм бол нэг л өдөр 5000-аас доошгүй хэрэглэгчтэй болж болох юм. Төслөө хийхийн тулд хэд хэдэн диаграмм зурах хэрэгтэй болсон тул тэр өнөөдөр ажлаа тараад Итгэлтэй хамт хийхээр болжээ.

Туунийг Итгэлийн ажил дээр очиход М4-ийнхэн ид ажилтай сууцгааж байв. Монголд зочлох жилд зориулсан вэб хуудас хийх шалгаруулалтанд оролцох гээд завгүй сууцгааж байгаа нь тэр. Намуун гаднаас жавар дагуулан

-за манай 4-н Гейтэс вэб хуудсаа дуусч байна уу? гэсээр оров. Тэр ажилд орсноосоо хойш машинаа барихгүй байгаа тул нэлээд холоос алхаж ирэхдээ голдоо ортол даарснаа дулаан газар орж ирээд л мэдэв. түүний мэндчилгээнд Баагийг дуугуйхэн толгой дохин, Аянга тооний машинаасаа нүдээ салгалгүй давгүй ээ гэж, харин Жака за даа, бид мэт нь ялж чадах юм уу даа гэсээр компьютерын араас босч ирэн хариулахад Итгэл чи бүүр даарчихаж, цай уу гээд ус буцалгагч руу очингоо Жака чи битгий бүтэлгүй юм яриад бай. Ингэж бодоод байвал яаж манай загвар шалгарах юм бэ? гэж ууртай хэлэв.

-Жака гуай, битгий сөрөг энэрги тараагаад байгаарай гэж Аянга хэлээд тооний машинаа тачигнуулна. Амжилтанд хурэхийн тулд Сэтгэл зүйн энэрги чиглэл буюу СЭЧ-тэй байх тухай Итгэлийн ярьсаныг хамгийн сайн ойлгосон нь Аянга билээ.

Итгэл янз бүрийн менежерийн ширээний номнууд, хэрхэн амжилтанд хурч тургэн баяжих тухай зөвлөгөө, номлол унших хоббитой. Аянга ч яаж хурдан баяжих бэ, яаж зардалаа хэмнэх бэ гэж л бодож явдаг тул гаднаас нь харахад тэмээ ямаа шиг шал өөр энэ 2 залуу баяжих мөрөөдлөөрөө л нэгэн зүгт харж, нэгэн зорилгод нэгдэж чаддаг билээ. Анх Итгэл 2 найзтайгаа нийлж компьютерын уйлчилгээний ажлаа эхлэхдээ тамга ч угуй, татварт буртгуулэхээс айгаад компани ч болоогүй байсан ч олсон хэдэн төгрөг нь ямар ч тооцоогүй алга болоод ирээдуй нь нэг л бурхэг байсан. Гэтэл нэг өдөр Баагийгийн танил Аянга аавынхаа компьютерыг засуулах гэж ирэхдээ тэдний орлого зарлагийг нь буртгэж өгсөн юм. Удалгүй тэр 3-тай Аянга ч бас найзлах болж цаашид том М4-ийг байгуулжээ. Компанидаа нэр өгөх гээд цахим юм уу компьютер гэсэн уг орсон шинэ нэр олох гэж толгойгоо гашилтал бодоцгоогоод чадсангүй. ярисаар байгаад 4-үүлээ Америкын тэрбумтан Билл Гейтэсийг шүтдэгээ мэдэцгээжээ. Анхандаа 3-хан хуучин ширээ тавьсан түрээсийн жижигхэн өрөөгөө хэзээ нэгэн цагт Микрософт шиг тив дамнасан том том компани зэрэгт хурнэ гэж төсөөлөхөд ч инээдтэй санагдаж байсан ч Форд моторс саравчинд анхны машинаа угсарч байсныг дуулаад сэтгэл нь хамаагүй тайвширцгаажээ. юм л бол Гейтэсээс жишээ авч байдаг Итгэл нэг өдөр Микрософт байшингийн подвалд байрлаж байсан тухай уншаад ирээдүйдээ илуу итгэлтэй болсон билээ. Мани 3 компанидаа өөр өөрийн гэсэн үүрэгтэй, өөр өөрийн имэж-тай. ямар ч юмний өнгө зохицолыг хамгийн сайн мэдэрдэг Жака дизайнер-ын үүрэгтэй байхад програмчлал-ын хичээлдээ толгой цохидог Баагий ажлын голийг нугалдаг бол, хэзээд шийдвэр гаргаж чаддаг Итгэл толгой компьютер бую захирал, тоолж болдог бухнийг тооцож явдаг Аянга санхүүчийн уурэгтэй.

Намуун Итгэлийн хийж өгсөн цайг аваад тэдний ажлыг үймүүлэхээс айн нэг сандал авч чимээгүйхэн суулаа. Ажлаа хийгээчээ гэж түүнийг хичнээн шаардсан ч Итгэл гарыг нь дулаацуулах нэрээр зэрэгцэн суугаад мөрөөр нь тэвэрчихэв.

-өчигдөр интэрнэт ухаж суугаад янзийн гоё нэг сайт оллоо гэж Жакаг яриаг өдөөд дуртай сэдвээ хөндөж байгаа нь илхэн өрвийлгөж босгосон усээ илээд

-та нарт бүгдээрэнд нь би э-майл-ээр явуулсанаа хэлэхээ мартчихаж. Курниковогийн чармай нуцгэн зураг. янзийн гоё хүүхэн юм аа хэмээн ярьж байтал Заяа орж ирэн цунхээ тавингуут Жакаг очин цохиод

-даанч тийм байх аа. Аяндын э-майл хаяг руу орсон чин тэр заваан орос хүүхний зургийг явуулчихсан байгаа юм даа хэмээн хашгирахад Аянга хоолой засан дохио өгөв. Бүсгүй сая л энд Намуун байгааг анзаарч

-өө сайн уу? чамайг харсангүй. энэ хэдэн юмтай маазарсаар байгаад мэндлэхээ ч мартчихдаг юм гэхэд

-чи хэзээ мэндэлж байсан юм. хэн нэгнийг загнаад л орж ирдэг биз дээ?

гэж Баагий ам нээхэд Жака харин тийм, нээх соёлтой амьтан шиг гэхэд бүгд инээлдэв. Заяа анх Намуунтай танилцахдаа баян айлын охины дэргэд доошоо орчих бий гэж болгоомжлон биеэ барьдаг байснаа больжээ.

Тэд 10 цагийн үед тарж, Итгэл Намуун 2 юмаа хийхээр улдэв. мани 2 хоюулханаа улдэнгүүт нэг хэсэг өдрийн сониноо ярилцан тэврэлдэж суугаад өнгөрсөн жилийн карт борлуулалтын диаграммийг хийж эхэлтэл Итгэлийн ээж сандран утасдав. Дуу охин нь утасаа салгаад өдөржин алга болчихсон гэнэ. Намуун тэр 2-ийн үерхэлд ээж нь таагүй ханддаг тул Итгэл түүнийг гэрт нь хүргэж өгөх гэтэл зөвшөөрсөнгүй дүүг чинь олоход би тусалъя л даа гэсээр хамт гэр руу нь гарчээ. өвлийн эхэн сарын жихүүн шөнө байлаа. Өдрийн орсон цас

гудамжны гэрэлд гялалзан, даарсандаа хурдан хурдан алхах хүмүүсийн амнаас өтгөн цагаан уур гарна. Жаварт удаан зогссон машины бээрсэн мотор уухилан байж арайхийн аслаа.

Хэдийгээр өөрөө гэрт нь очъё гэсээр ирсэн ч яг босгонийх нь өмнө ирээд Намууны зүрх туулайных мэт тугшин цохилов. Миний хүү юу гэх эмэгтэй хүний сандруу дуу гарч хаалга онгойлоо.

Цолмон анхандаа хуугийнхээ цаана байсан бусгүйг харсангүй. Хаалганыхаа түгжээг мулталаад цааш эргэн утасаа авах зуур

-цаад сэгсгэр юм чин энэ орой болтол хаачдаг байна аа? ядаж гар утасаа салгачихсан.

цээжний мах урчих юм аа гэснээ хуугээ ирмэн хажуу тийш болоход нь л сая үерхдэг охиныг нь харжээ.

Богинохон нэхий дээл , жинсэн өмдтэй турьхан охин хацраа ягааруулан мэндлэхэд сандарч гуйцэв. Утасаа буцааж тавьчихаад хүү рүүгээ нэг зэмлэсэн, Намуун руу нэг учирласан харц чулуудан

-за сайн уу.. миний охин? би энэ Итгэлийг ганцаараа ирсэн юм байх л гэж бодоод... энэ ингээд Урьдчилж хэлэхгүй хүн дагуулаад ирдэг.. хэмээн олон юм нэгэн амьсгаагаар хэлэхдээ тэр охин өөрийнх нь төсөөлж байснаас тэс өөр нэг л аятайхан илүү дутуу маяггүй , бас харц нь шал хүүхдээрээ байсанд сэтгэл нь хөнгөрөөд явчихлаа.

-зүгээр ээ. би л дуу нь алга болчихсон гэхээр нь дагаад ирсэн юм. та найзууд руу нь ярьсан уу? хэмээн асууснаа Итгэл руу харж

-чи утас руу нь мессэж бичих. ээж загнахгүй гэж байна. хаана байгаагаа яаралтай мэдэгд. яг одоо хариу бичвэл ах нь 10000-аар шагнаана шуу хэмээн санал гаргав. Навчаа охин ч мөнгөний сургаар удалгүй ах руугаа мессэж бичин зусланд хамт амарсан найзынхаа төрсөн өдөрт очсоноо, 1-дүгээр хороололд байгаагаа бичжээ. Итгэл Намуун 2 явж Навчааг авчирав. Намуун гарахдаа та Навчааг битгий загнаарай. маргааш л зүгээр хэлнэ биз. тэгэхгүй бол үнэнээ хэлхээ больчихно хэмээн захьсан нь өөрийнхөө 13 насний зөрүүд араншинг мартаагүй яваагийнх. Тийм насний охидын занг сайн мэддэгийнх байлаа. Иийнхүү дураараа охин дүүгийнх нь ачаар Намуун Итгэлийн ээжтэй нь танилцан, цаг оройтсон тул эмээгийнхээ дагуулан очиж хонуулчихав. Намууныг өөрийнхөө түлхүүрээр хаалгаа торхийтэл онгойлгоход эмээ нь сэрж босох гэснээ 2 хүний шивнэлдэхийг сонсоод эргээд хэвтчихжээ. Тэр 2-ийн анхны шөнө төсөөлшгүй сайхан өнгөрчээ. Ютай ч зүйрлэмгүй оргил мөчийн дараа тэврэлдэн хэвтэж байхдаа Намуун Урьд нь түүний амьдралд нэг залуу байсныг Итгэлээс нуусангүй. Тийм ээ, туунд цорийн ганц эр хүн байсан. Тэр нь Хасар байсан. Хайртай л юм чинь Түүнээс юугаа ч нуухгүй гэж бусгүй бодсондоо Итгэлд энэ тухайгаа анхны шөнөө л ярьчихсан юм. Итгэл харин чамтай танилцах хуртэл надад зөндөө олон хүүхэн байсан. гэхдээ би ихэнхийх нь нэрийг санадаг ч угуй. би чамаас өмнө хайр гэгчийг амсаагүй явсан. энэ үнэн шуу. хайр, sex 2 шал өөр ойлголт юм гэдгийг одоо л мэдлээ гээд үнэнээ хэлсэнд чинь баярлалаа гэсэн. Дараа нь.... Итгэл унаад өгөв. Намуун түүний цээжийг дэрлэн удтал сэрүүн хэвтэж байгаад нэг л мэдэхэд амттайхан нойрондоо дарагдан нам унтчихжээ.

Харин өглөө яагаачгүй эрт 5 цагт залуу бүсгүйгээс түрүүлэн сэрлээ. Гадаа үүр тэмдэгрэх бүдэгхэн гэрэл өрөөг гэрэлтүүлнэ. Энэ өрөө Намууны ээж, нагац эгч нарын өрөө байсан нь одоо түүнийх болсон ажээ.

Хуучний мебель орний эсрэг талын хананд өвөө нь 30-аад жилийн өмнө Оросоос авчирч охидынхоо өрөөнд хадсан дэлхийн газрын зураг, бичгийн ширээн дээр тавьсан бяцхан глобус, дүүрэн ном өрсөн тавиур гээд он удаан жилийг үдсэн хуучны сэхээтэн айлын цөөхөн хогшилыг тодхон гийгүүлнэ.

Энэ өрөөнд байсан 2 орыг гаргаснаас өөр бараг юуг ч өөрчлөөгүй. Номын тавиурын доод давхарт Намууны авчирсан Сони маркын жижиг хөгжим, олон диск, хуурцгууд л хамгийн шинэ эдлэлүүд биз. Эмээ нь энэ бүхнийг солих шинэ тавилга авахаас дургүйцдэгээс гадна Намуун ч өвөөгийнх нь амьд ахуй үеийг санагдуулсан энэ нандин зүйлсийг хэвээр нь байлгах дуртай юм.

Намууны эмээ 6-30д сэрдэг гэсэн. Тиймээс эмээгээс нь түрүүлж сэрээд гэр рүүгээ гарч алга болохын тулд гар утасныхаа сэрүүлгийг 5-50д тавьжээ. Хайртайгаа учирахаас өмнө ээжийн эрх хүү байхдаа Итгэл энэ утасны сэрүүлгийг яаж ч жингэнэж, хангинаж, шагшрах чимээнд сэрнэ гэж гонж байсан билээ.

Гэтэл хамаг амьдралыг нь орвонгоор нь эргүүлсэн хайр хэмээх энэ зүрхэнд тусдаг шүдний өвчин ийнхүү навч сэрчигнэх, салхи исгэрэх, даавуу сүрчигнэх төдийхэн чимээнд ч сэрдэг соргог амьтан болгон хувиргажээ. Намуун гараа дэрлээд түүний мөрөнд толгойгоо наан нам унтаж байх аж. Зүүн гарынх нь бугуйнд нөгөө хайртай шүрэн бугуйвч харагдана. Нүд нь давхраагүй болохоор сэрүүн байхад нь сайн ялгарч харагддаггүй болохоос нялх унаганых шиг шиг урт хар сормуустай ажээ. Хүзүү нь нарыхан булбарайхан арьстай, хацар нь цонхоор тусах бүдэгхэн гэрэлд цайран, уран нарийхан хөмсөг тодхон зураих нь хараад л баймаар хөөрхөн. Урьд нь Итгэл олон бүсгүйн өвөрт сэрж байсан ч ингэж хайр нь хүрч, зүрх сэтгэлийн хамгийн нандин утсыг нь хөндөж байсан нь ганц ч үгүй. Ялангуяа энэ намаржин залхтал нь утасдан нойтон хамуу шуг зууралдсаар байгаа Сэнигийн өвөрт сэрэхдээ тэр бүсгүйн байдгаараа ангайн унтаж буй амнаас нь өчигдөрийн уусан пиво, татсан тамхиных нь үнэр холилдон хамар сэтлэм эвгүй үнэр үлээж байсанд ой гутсандаа үсрэн босоод баяртай ч үгүй гарч одсоноос хойш дахин уулзаагүй бултсаар яваа юм.

Тэр Намууны уруул дээр аярхан үнсээд хувцаслан сэмхэн гарч одлоо. Тэдний үүдийг аярхан хаахдаа Итгэл бусгуйчуудийн ёртонцод хийсэн аяллынх нь хамгийн суулчийн зогсоол энэ гэдэгт бат итгэж байлаа.

Энэ өдрөөс хойш Цолмон хуугийнхээ үерхэлд дургуйцэж чадахаа болив.

Харин Хасар л Намууныг зүгээр л мартчихаж чадахгүй байлаа. Сонин дээр гарсан тэнэг зурагнаас болж бараг суй тавьчихсан байсан бусгүйгээ алдаж ирэдүйгээ баллаж хаялаа. Тэр хачин годгоносон юмаа хаяад Намууныг очиж аргадаач гээд л ээжийгээ углэхэд төбөгшөөж яршигтай юм хэмээн зугатаж байв. Гэтэл суулдээ ээжийнхээ хэлдэгээр ногоо годгоносон охиноосоо өөрөө уйдан Намууныг үгүйлж эхэлдэг байна шүү. Намуунтай хамт өнгөрөөсөн тэр өдрууд, үерхэж тоглож байсан цаг мөчүүдэд туунд хайртай байснаа өөрөө мэдээгүй гэж уу?

Эсвэл зүгээр дасал болчихсон юм болов уу? гэдэг асуултанд хариулж ул чадах мөртлөө л түүнийг үгүйлэх нь сонин. Энэ хуухдийг хүмүүжуулэхдээ би дэндүү их алдаа хийжээ. Манай Хасар миний нөлөөнд хэтэрхий ороод хүүхэн зантай болчихлоо гэж ээж нь ярьдаг нь үнэний хувьтай ажээ. Хасар ийм хүүхэн зантайдаа өөртөө анх удаа уур нь хурэв. Ёр нь Намуунтай үерхэж байхдаа л бодож байсан. Яг л баян нөхөр мөрөөддөг хүүхэн шиг. Гэхдээ юу нь болохгүй байгаа юм бэ? гэтэл зүгээр нэг ангийн хөөрхөн охиноос болж хамаг төлөвлөгөөгөө

нураачихдаг. Намууны найз Жавхаатай өчигдөр интэрнэт кафе-д тааралдсан биш Намууныг ийнхүү эргэн саначихав уу гэтэл үгүй. Гэхдээ мартаж гэж өөрийгөө албадаж явсан бүх дурсамж нь тэр уулзалтаас болж сэрхийтэл санагдан энэ бүхнийг эргэцүүлэхэд хүрсэн нь үнэн.

-Намуун сайн биз дээ?

-Ёстой сайн байгаа. Итгэл нь дажгүй гоё залуу. Намуунд хачин их хайртай.

-Миний мэндийг хургэчихээрэй.

-Чи чинь нэг хэсэг ФМ-ийн суваг бүхнээр мэндчилгээ дайгаад байснаа яагаад таг болчихоов? Одоо ч өнгөрсөн биз дээ гээд Жавхаа аальгүйтэн тас тас хөхөрсөн. Түүнтэй уулзсаны дараа л тэр Намууныг буцаан авахын тулд бүхнийг хийхээр эргэлтгүй шийдсэн. Бодоод байхад түүнд тусалж чадах ганц хүн бол тэдний аавын туслах Оргил билээ. Оргил гэж тэр овжин залуу мөнгөний төлөө юу ч хийхээс буцахгүй хүн гэдгийг тэр мэднэ. Гар утас руу нь залгавал удаан дуудуулж байж авлаа.

-Сайн уу? би Хасар байна. юу байна ?

-Аа гологдсон хүргэн уу? хи хи хи. би танд юугаар туслах бэ?

-Чамтай уулзах хэрэг байна. хэзээ уулзах бэ?

-Гологдсон хүргэн энэ тэр гэж тоглосон шүү. Хөгшөөн битгий уурлаарай. мань нь завгүй байна. Нөгөөдөр өдрийн хоол хамт идэх үү?

-Зүгээр ээ, зүгээр. ер нь яаралтай уулзмаар л байна. за яахав тэгье. нагаадөр шуу.

-Ок.

Оргилтой уулзаад яриагаа юнаас эхлэх бэ? Намуунтай яваад байгаа тэр өндөр амьтаныг яаж холдуулах бэ? туслаач гэх уу? эсвэл гайгүй мөнгөний ажил байна гэх уу? хэдэн төгрөг хэрэгтэй болох бол? 2-3 саяас наашгүй дээ. за яахав. Намууныг эргүүлээд авч чадвал тэр зэргийн мөнгө юу ч биш. Ээжээс хэдийг авчихаж болно. Гэхдээ нэг саяас хэтрэхгүй. Улдсэнийг нь олохдоо машинаа барьцаанд тавьчихаж болно. Ёрөөсөө ганц нэг найзаасаа авсан ганц нэг зуун ногооны өрөө ч төлчье. Нэхээд яршигтай юм. Ингээд л Хасар хадгаламж зээлийн хоршоо руу гарч одов.

Харин Оргилын хувьд захирлын гологдсон хүргэн ямар санал тавихыг тэр сонирхохгүй биш сонирхож л байлаа.

Гэхдээ өөрөөс нь ямар нэг юм гуйх гэж байгаа нь тодорхой байсан.

Тэгэхээр юу гэдэг билээ? авах хүн бөхийж, өгөх хүн гэдийдэг гэгчээр бага зэрэг үнэд орох нь зөв гэж тэрхэн дотроо шийджээ.

Түүнээс гадна тэдний өрсөлдөгч компани нэгэн менежер бас сонирхолтой санал тавиад тархи толгой нь завгүй байсных билээ.

2 өдрийн өмнө тэр залуу ирж Оргилийг хоолонд уриад компанихаа шатахууний

борлуулалтын хуснэгтийг олж өгвөл сайн шагнана гэжээ. Энэ бол осолтой санал байлаа.

Тэдний компани санхүүгийн хэлтэсийн компьютерууд маш нууц тулхууртэй байдаг. ялангуяа тэр борлуулалтын дун мэдээ зөвхөн ерөнхий нягтлангийн компьютерт л байдаг тул бусад нягтлангууд ч сайн мэдэхгүй. Гэвч тэр .. амласан мөнгө нь 2 захирлын хаалгийг сахиад жилд авах цалингийнх нь нийлбэрээс ч хавьгүй их байсан тул оролдоод узые гэсэн хариу өгчээ.

Тэгээд Хасарийг утасдах үед хэрхэн ерөнхий нябо-гийн компьютерын нууц кодыг тайлахаа бодож сууж байжээ.

Оргил мөнгөнд үнэр байдаггүй гэсэн зарчмийг баримталдаг хүн. түүний гадаад байдлаас нь хэн ч дотоод санааг нь гадарлахад бэрх. Нэвт шувт ширтэн давхраагүй бор нүд, өтгөн хөмсөг,

дунд зэргийн нуруутай, үсээ ямагт богино халимаг болгон засуулж төсөлнө.

Дуугаа хэзээ ч өндөрсгөхгүй, ямар ч хүнийг ярьж байхад нүд рүү нь ширтэн тэгье, ойлгоё, би танд яаж туслах бэ гээд л чихэн дээр цэцэг ургатал эвлэгхэн ярихаас гадна, үснийх нь тэр буурьтай засалт, чанга ч биш, дорой ч биш нэгэн жигдхэн дуу, цав цагаан цамц, толийтол нь индүүдсэн костюм энэ бүхэн нийлээд хэнд ч туйлийн их сэтгэл төрүүлэхээр харагдуулж чаддаг.

Харин доотод сэтгэлийг дуранддаг Эхо аппарат байдагсан бол ийм хар залуугаараа санаа нь хав хар болчихсон найдваргүй этгээд гэдгийг нь мэдэж болохсон билээ.

Бур оюутан байхдаа дадлага хийх гэж энэ компанд ирээд дүр үзүүлж чаддаг гайхам авьяасаараа үндсэн ажилтан болж үлдсэн түүхтэй.

Үлдэх үлдэхдээ эхнэр нөхөр 2 захирлын туслах болчихсон л зайтай аавын хүү билээ. ялангуяа эмэгтэй хүний занг муугүй мэдэх тул өөрийнхөө ярьдагаар Наран захирлын тархийг базаж чаджээ. Түүнд төрснөөсөө илүү биш юм гэхэд дутуугүй итгэдэг Наран ямар сайндаа л охиныхоо найз залууг судлах уурэг өгч байхав. Гэтэл хумсаа нуусан муужгай мэт санаа муутай энэ залуу яваандаа Намуунтай сууж хургэн нь болоод хөрөнгөнд нь эзэн суух бодол өвөрлөж явдгийг өөрөөс нь өөр хэн ч үл мэднэ.

Тууний энэ алсийн төлөвлөгөөнд номер нэг дайсан нь Нарнгийн шууд ивээлд багтсан, багийн найзийнх нь хүү Хасар байсан бол одоо тэр нь замаас зайлсан.

Гэхдээ олон ааштай Намуун Хасарыг угаас нэг их тоодоггүй байсан бол Итгэл тэр охины сэтгэл зурхийг татчихсанаараа илуу аюлтай гэж тооцоолоод байгаа юм. Намуун бол олон ааштай, эрх дураараа боловч цаанаа өөрийн гэсэн бодолтой толгойг нь амархан эргүүлчихэж болохгүй охин гэдгийг ч Оргил сайн мэднэ. Бодвол Итгэлийн тухай л асуух гэж байгаа биз. өөр ч юм байж магадгүй. Тэр тэнэг амьтантай холбоотон болж Итгэлийг замаасаа зайлуулсан ч болно. Харин түүний дороо босс гэж нэрлэдэг Чимэд захирал туслахдаа Наран шиг тэгж уушиг, зүрхээ нээж хамаг нууцаа даатгана гэдэг гонж.

Ажилсаг гавшгай, хөл хөнгөн чих зөөлөн залуу эрэгтэй туслахдаа сэтгэл хангалуун байдаг ч өрөмдөх мэт нэвт шувт ширтсэн хүйтэн нүд нь огт таалагддаггүй тул нарийн ширийн юмаа Оргилд мэдэгдэхийг хүсдэггүй.

За энэ ч яхав. Санхүүгийн албаны толгой компьютерт яаж нэвтрэх бэ гэдэг нэгдүгээр асуудал болоод байв.

Маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушиг дээр гэдэг. Борлуулалтын нэгдсэн дүнгийн хүснэгт алдагдсанийг чөтгөр ч мэдэж чадахгүй. Ялангуяа захирлын туслах бөгөөд ерөнхий зохицуулагч Оргил түүнийг хулгайлан өрсөлдөгч компанд дамжуулсныг хэрвээ байдаг бол дээд бурхан тэнгэр л гадарлах байх. Туунд амралтын өдрөөр ганц нэг зул өргөж, хүрд эргүүлээд тал засчихаж болох байлгүй хэмээн бодоод инээмсэглэв.

Энэ өдөр Чимэд захирал Москва явчихсан, Наран худалдаа уйлдвэрийн яам руу гарсан тул Оргил нэлээд завтай сууж байлаа. Тэр бодож бодож ерөнхий нягтлан Оюунчимэгийн тухай дэлгэрэнгүй мэдэж авахаар шийдлээ. Тэгэхээр боловсон хучнээс анкетыг нь олж авах хэрэгтэй. Дотуур холбоогоор боловсон хүчний Базарханд хүүхэн руу залгав.

-за Базар аа, юутай байна даа? түүний энэ нялуун дуу тэр дүүхэлзсэн биетэй, нөхөргүй хуухэнд шууд таалагдсан нь мэдээж.

-за захирлын туслах юу хэрэгтэй болоов?

-Нараа захирал санхүүгийнхны анкетыг аваад хэдэн юм тэмдэглээрэй гэсэн юм. үдийн цайнаас өмнө гаргаад өгвөл их л хэрэг болох гээд байна, ок?

-тэгэлгүй яхав. Оргил анкет авах гэж Базархандын өрөөнд орохдоо саяхан гарсан шинэ сэтгүүл аваачиж тал засахаа мартсангүй.

-Өө баярлалаа. Санхүүгийнхныг курсд явуулах гэж байгаа юмуу? будаж дэрвийлгэсэн сормуусаа дэрвэлзүүлэн хэрэгт дурласнаа нуулгүй ширтэх хүүхний өөдөөс Оргил өнөөх үл цавчрах нүдээрээ харан

-Мэдэхгүй ээ. Захирлууд л мэдхээс биш би чинь будааний хүүхэд ш дээ гээд дотроо

“Гайгүй байлгүй, яах гэж байгаагаа бас чамд хэлэх юм” хэмээн зэвуурхэв.

Оюунчимэг 35 настай, нөхөр, 2 хүүтэй. Төрсөн он сар өдөр хүүхэд, нөхрийнх нь төрсөн өдөр, нэрс гээд л хамаг юмыг нь тэмдэглэж аваад, 10 мин дараа тэр анкетуудыг буцааж өгөв.

Ажил тарсны дараа эндээс л хэд хэдэн хувилбар гаргаж байгаад Оюунчимэг хатагтайн компьютерийг нээнэ дээ.

Ерөнхий нябо бол бусад хүүхнүүд шиг элдэвт дурлан, хов жив яриад байдаггүй, нөхөр дэгээдчих санаатай илүү харж явдаггүй, ажилдаа дэндүү сайн, нягт нямбай, дажгүй царайлаг хүүхэн байдаг. Компаний цэвэр ашиг, орлого, зарлагийг 2 захирлаас гадна ганцхан Оюунчимэг л мэднэ.

Гэвч ажилынхаа гол гол тоо баримтын талаар ганц ч илүү үг дуугарна гэж үгүй. Тэгэхээр компьютерт нь халдахаас өөр арга байхгүй гэсэн үг. Оюунчимэг улирал бүр татварын албанд өгөх хуурамч тайлан, захирлуудад зориулсан жинхэнэ тайлан 2-ыг гаргадаг. Чимэд захирлын бичиг цаасыг эмхэлж байхдаа Оргил тэр жинхэнэ тайланг үзчих санаа байдаг боловч олддоггүй юм.

Хэрэв одоо тэр жинхэнэ тайланг олчих юм бол зүгээр нэг борлуулалтын хүснэгтээс илүү үнэ хүргэн зарчихаж болно шүү дээ. Тэр тайланг орсолдогчид нь татварт өгчих юм бол хэрэг ч мандана даа.

-Гааль дээрээс сураг байна уу? Оюунааг миний өрөөнд дууд гэсээр Наран орж ирлээ. Оргил сая л Компанийнх нь эсрэг төсөөлхийн аргагүй хорон санаа өвөрлөн суугаагүй хүн шиг үсрэн босож эзгүй хойгуур нь утасдсан хүмүүсийн нэрс, гааль дээр ирчихээд байгаа шатахууны тухай илтгэхээр өрөөнд нь дагаж орлоо. Оргилийг гарахад ерөнхий нябо үг дуугүй толгой дохиод зөрөн орлоо. Бодвол гаалийн татварт төлөх мөнгөний шилжүүлэг дээр гарын үсэг зуруулах гэж байгаа биз. Ажил тарсний дараа Оргил хийх юм ихтэй хүн болж нэлээд удаан суугаад 8 болсон хойно санхүүгийн өрөө рүү орлоо.

Өчигдөр нэг салангийнх нь хаясан түлхүүрийг олж аваад сэмхэн хувилуулчихсан хэрэг.

Ерөнхийлөгчийн компьютерыг хурдхан асаалаа. 2 хүүгийнх нь нэр, товчилж дууддаг байж болох нэрс, нөхрийнх нь нэр гээд пассвордыг нь тайлах гэж удаан ноцолдсоний эцэст 4-үүлэнгийнх нь төрсөн он сарын нийлбэрээр компьютерт нэвтэрч чадлаа. Санхүүгийн программ дээрх олон файл-ууд дунд өнөөх үнэт хүснэгтийг хайж гарлаа. Арай гэж борлуулалтын хэдэн хүснэгт олоод байтал цахилгааны хучдэл багасан анивалжаж байснаа гэрэл пархийн унтарчихлаа. Компьютер ч таг. Мань хүн хав харанхгуйн дунд хараал тависаар асаагуур халааснаасаа авч гэрэл гаргав.

Баларсан юм. ток баригчид нь залгаагүй компьютерыг яаран асаасан байв.

Хурдлахгүй бол жижүүр ороод ирнэ. Энд ямар нэг юмаа орхиогүй гэдэгтээ итгэлтэй болсны дараа сэмхэн гарч хаалгыг нь цоожлоод өөрийнхөө өрөөнд донгож ороод суутал жижүүр гар чийдэн барисаар шагайв.

-Тог тасарчих юм. Явахаас гэж тэр цовоо дуугаар өгүүлээд палитогоо өмслөө.Гарах хаалган

дээр маркетингийн албаны 2 залуутай тааралдсан нь бүр ч сайн болов. Тэр 2 компьютер тоглоом тоглосоор оройтсоноо ярин, ток баригч залгаагүй бол компьютер шатах байж. тэр тасрахын өмнө хучдэл айхтар үелзсэн гэгцгээж байв.

Маргааш нь ч хэрэг мандлаа. Ерөнхий нябогийн компьютер зад шатжээ. Шатах шатахдаа харданд нь байсан бүх мэдээлэл утсан байв. Тэр өдөр ерөнхий босс дөнгөж ирснийг хэлэх үү, улирлын тайлангаа татварт өгөх бараг сүүлчийн өдөр тулчихсан байтал компьютер дотор устчихсан гэнэ. Бүх компьютерыг унтраагаад явдаг мөртлөө яагаад өчигдөр санхүүгийн албаны толгой компьютер асаалттай, тэгсэн мөртлөө ток баригч залгаагүй байсан нь гайхалтай.

Урьд нь энэ компанид хэзээ ч ийм бүтэлгүй явдал тохиолдож байсангүй. Оргил идэвх гарган хэд хэдэн сайн засварын газар руу утасдан, манай ерөнхий уг нь мундаг нямбай хүн дээ хэмээн шогширч тэр мэдээллийг сэргээж болохгүй юм байх даа гэж үглэн өөрөө хамаг хэргийн эзэн биш юм шиг болж өгвөл тэр компьютерыг нь засуулаад захиралд оноо авчих юм сан гэж ичих ч үгүй бодож байлаа. Харин нөгөө хүснэгтийг зарж хэтэвчээ зузаатгах нь худлаа болжээ. 2 ч засварчин ирсэн боловч хард нь бүрэн шатсан байна, авч яваад оролдоод үзий гэсэн ч захирлууд зөвшөөрсөнгүй. Компаний санхүүгийн хамаг нууцийг хадгалсан тэр компьютерыг гадагш нь хамаагүй гаргах нь аюултай хэрэг байв.

Намуун яг энэ өдөр 3-н үеийн намтраа бичих болоод аавтайгаа яаралтай уулзах гэж ирэхэд нь хэрэг мандчихаад байхтай таарчээ. Итгэл гадаа машинд суугаад үлдсэн байв. Аавынхаа өрөөндөө байгаа гэдэгт итгэлтэй байсан Намуун үүдэнд нь сууж байсан Оргилтой толгой дохиод л хаалга руу нь зүтгэв.

-Захирал санхүүгийн өрөөнд байгаа. Би утсаар хэлчих уу? Оргилийг ингэж хэлэхэд нь сая л түүний байгааг анзаарсандаа Намууны инээд хүрэв.

-Зүгээр, зүгээр. би өөрөө очоод уулзая.

Тэр санхүүгийн өрөө нь аавынх нь өрөөний хажууханд байдаг юм чин энүүгээр утасдуулаад байхдаа ч яахав дээ. Ээж нь байхгүй байгаа бололтой.

-Учрыг нь олох л болж дээ гэсээр санхүүгийн өрөөнд зогсож байв. Намуун ямар нэгэн юм болсныг ойлгов.

Ердийн үед бол аав нь ажилтнуудаа өрөөнд нь дуудаж л уулздаг хүн. Харин хааяа заал авч сагс тоглохдоо л ажилтнуудтайгаа чи бидээ хүрэн инээж хөхөрч байдаг юм. Гараа өмднийхөө халаасанд шургуулчихсан нэг компьютер руу тонгойж зогссон аав нь түүнийг хараад өө миний охин, алив өрөөнд орий гэсээр гараад ирэв.

-Аав юу болоов?

-Баларсан юм. манай санхүүгийн албаны толгой компьютер шатчихсан юм байх. найдвартай хүнээр яаралтай засуулмаар байна. миний охин ямар ажилтай явна?

-3-н үеийн намтар бичих болоод юм асуух гэсэн юм. Харин компьютерыг чинь би нэг хүнд үзүүлчих үү? Намуун аав руугаа залижин нүдээр харав. Нэг хүн гэдэг нь нөгөө үерхээд байгаа залуу нь бололтой гэдгийг аав нь гадарлаж л байлаа. Өнөөг хүртэл үерхчихээд Итгэл Намууны эмээтэй л танилцанаас биш, аав ээжтэйг нь нүүр тулан уулзаагүй л яваа ажээ. Ээж нь мэдээж Итгэлд тал муутай байгаа. Аливаа гэрийн эзэгтэй нь тал муутай хандаж байвал тэр айлын хаалга түүний хувьд хаалттай байдаг юм чин. Нэг л өдөр ээжийн ааш нь зөөлөрч Итгэлийг гэрийхэнтэйгээ танилцуулчихна гэж найдаад Намуун ч нэг их хичээсэнгүй өнөөдрийг хүрсэн юм.

-Залуу хүний толгой сийрэг байдаг. Үзүүлий дээ. гадагш нь хамаагүй зөөлгөж болохгүй

доторхи мэдээлэл нь манай компаний санхүүгийн нууц юм шүү.

Намуун ч гадаа машиндаа сууж байсан Итгэлийг санхүүгийн өрөө руу хөтлөн орлоо. Энэ компьютертай л залгаатай юм шиг цагийн мөнхөд ард нь суугаад компаний хамаг мөнгөний эргэлтийн судсыг атгаж суудаг ерөнхий нябо бүүр царай алдаж гуйцжээ.

-Миний дүү наад компьютерийн чинь хардыг сэргээж болох нь уу? ажилын үеэр хийж байгаа юмандаа хамаг анхаарлаа хандуулчихдаг зангаараа Итгэл түүний асуултанд хариулсан ч үгүй компьютерын тархи зүрх нь болсон хөөрхий процессорыг ухаж гарлаа. Тэгснээ ард нь зогссор байгаа нябо руу эргэн харж

-Горьдлого байх шиг байна аа гэж баярлуулаад гар утасаараа Баагийг дуудав. Тэр 2 нийлээд ажиллаж эхэлсэн бол орчноо ч мэдрэхээ больдог тул Намуун 3-н үеийн намтараа бичихээр аавынхаа өрөөнд орлоо. Үүдэнд нь нэг их ажилтай хүн шиг дүр үзүүлэн суусан Оргил уншиж суусан цааснуудаасаа харц салган

-Миний хэрэг болоогүй биз? гэхэд нь Намуун зүгээр л толгой сэгсрээд өнгөрөв. Түүнд Оргил хэзээ ч таалагдаж байгаагүй, төрөлхийн бууны нохой мэт санагддаг юм. Ширээнийхээ ард утсаар ярин маадагж суусан аав нь удалгүй яриагаа дуусгаад

-За нөгөөхүн чин манай компьютерыг сэхээх нь уу? гэж аав нь бага зэрэг хошигносон өнгөөр асуугаад охиныхоо дэргэд суув.

-Горьдлого байна гээд нэг найзтайгаа хамт ухаад сууж байна.

-Банкинд ажиллах таалагдаж байна уу?

-Миний төсөөлж байснаас хамаагүй илүү сонирхолтой. Урьд нь би ээж та 2-т атаархдаг байсан. Тэгээд хэзээ нэгэнт цагт ажилдаа та 2 шиг дуртай байж чадах болов уу гэж боддог байсан. Одоо бодоход та 2 зөвхөн мөнгөний төлөө ажилдаггүй юм байна.

Дуртай ажилаа хийх чинь жинхэнэ кайф-тай байдаг юм байна. Виза кардны борлуулалтыг огцом осгох маркетингийн төслийн уралдаанд миний төсөл шалгарсан.

-Сайн байна. ээжтэйгээ хэл амаа ололцох гэж байна уу?

Намуун багын зангаар аав руугаа духайгаад намтар бичих цаасаа гаргахаар хавтасаа ухаж гарав. аав нь том дуугаар инээснээ за тэр компьютер ухаж байгаа хүмүүс дээр очоод ирий гээд гараад явчихав.

Тэгэнгүүт нь ажлын өрөөнийх нь ард байх амралтын бяцхан өрөөнийх нь хөргөгчнөөс хүйтэн жүүс гарган залгилав.

Чимэд ажил хийж байна гэж биеэ зовоолгүй инээж, хөхөрч хошигноод суудаг мөртлөө хамаг юм нь ид шидийн юм шиг бүтчихсэн байдаг хүн.

Ямар ч үед уурлаж бухимдах нь ховор. Өөрт нь дургүй зарим хүн түүнийг жулик амьтан гэж сэм муулцгаадгийг сонсоод тоодог ч үгүй. Залуудаа шүлэг зохиодог, хөрөг таталбар хийх дуртай байсныг нь Намуун дууриагаад л багадаа зураач болно гэж зүтгэдэг байсан биз.

Ажлынхаа өрөөнд монголынхоо нэртэй зураачдийн ажлуудыг авч өлгөх дуртай. Тийм болохоор нь Намуун аавынхаа өрөөнд орох дуртай.

Энд нэг л аядуухан, гэгээн өнгө бүрэлдэж, урлагийн бяцхан сүмд орсон мэт сэтгэгдэл төрнө. Заримдаа бухимдсан үедээ уран зургуудыг хараад суухаар дорхноо тайвширчихдаг юм.

Удалгүй аав, ээж 2 нь хамт ороод ирэв. Ээж нь охиноо хараад баярлаж байгаа нь илт инээн

-Манай зөрүүд охин сууж байх чинь. Алив үнсье гээд хацар дээр нь үнсэхэд Намуун дуртай гэгч нь үнсүүлсэндээ өөрөө ч гайхав.

Урьд орой нь эмээ нь түүнийг хичээлээ хийж суухад нь хажууд нь сууснаа миний охин одоо том болчихлоо. ээжтэйгээ сайхан эвтэй баймаар юм. 25 хүрсэн хойноо чамайг гаргах гэж яаж зовсон гээ. Хүндрэлтэй төрсөн юм шуу дээ. Бидний багад эхийнхээ өөдөөс муухай харсан хүнийг ч даж давшгүй нүгэлтэнд тооцдог байлаа. би шүтлэггүй явсан мөртлөө л энэ үгэнд итгэдэг байсан юм гэж баахан ярьж байгаад гарсан.

Намуун ч орондоо орсон хойноо хэд хоногийн өмнө ээждээ арай л хатуу уг хэлчихсэнээ ойлгож гэмших сэтгэл төрсөөр унтсан билээ.

Харин аав нь ээж, охин 2-ын тийн эв найртай, нуур нугас шиг байгааг хараад баярласан нь илт, түрүүнээс хойш дуугарсаар байгаа утасныхаа дэлгэц рүү нэг хяламхийгээд унтрааж тавьснаа

-Энэ 2 залуу чин сийрэг толгойтой улс байх шиг байна. Шөнөжин суугаад хард-ыг нь сэргээчье гэж байна гээд их л маадгар сууна.

Намуу ч компьютер засч байгаа 2-ын хажууд очиж жаахан суугаад орой хоол авчирч өгөхөөр болж аав ээжтэйгээ хамт гарцгаажээ. Өөрийнх нь хийсэн балгийг засахаар № 1 өрсөлдөгч Итгэл хүрээд ирсэнд хамгийн их барайсан хүн нь Оргил байлаа. Мань эр тэр харданд байгаа материалаас ганц ч үсэг битгий сэргээсэй гэж дотроо залбирсаар харьсан ч маргааш ирэхэд нь горьдлого нь талаар болсон байлаа

Итгэл ерөнхий нябогийн компьютерыг бараг засч ардын баатараар тодорчихоод явчихсан байв. Хамгийн гол нь босс-ийн сэтгэлд ирээдүйн хүргэн нь бараг 100% нийцэн бололтой.

Ажилдаа ирэнгүүтээ энэ мэдээг сонсоод

-Даанч сийрэг толготой залуу байх шиг байсан юм. бас өөрийн гэсэн бизнестэй гэж байгаа. Ийм залуучууд цаашаа их явна даа. Чи хүүхдийн хэрэгт багахан шиг оролцож бай л даа гэж энхэртээ хэлэх нь сонсогджээ.

Сийрэг толгойтой цаашаа их явна даа гэдэг нь түүний их үнэлсэн хүндээ хэлдэг үг нь билээ. Наран ч эсэргүүцэж юм хэлсэнгүй. Түүнд охиных нь эсрэг өөрчлөлт л сонин байлаа. Намуун Урьдийнх шигээ цаг ямагт уйтгарлаж, олон аашлах нь багасан жинхэнэ бүсгүй хүний намба суух шинж орснийг нь тэр өнөөдөр л гэнэт ажиглажээ. Ашгүй дээ. Охиноо тийм ааштай болсонд нь өөрөө л буруутай гэж сүүлийн тэр хэд хоног сэм гэмшиж явсан. Гэтэл одоо л сэтгэл онгойх шиг болов. Гэхдээ Намуунд өөрөөс нь илүү энэ өндөр залуу л ингэж хүчтэй нөлөөлчихлөө гэж үү?

Гэтэл Оргил энэ залуугийн тухай юу гэлээ? 7 хоногт нэг хүүхэн сольдог, эцэг нь хаяад явсан гэсэн. Эцэг нь хаясанд өөрийнх нь буруу гэж юу байхав. харин тэр хүүхэн сольдог нь? ямар ч гэсэн Оргил ортой л юм хэлсэн байх ёстой. гэлээ гээд яахав харж л байхаас. Нэгэнт л энэ залууг охин нь сонгосноос хойш. Тэгэхгүй бол охиноо алдсантай адилхан, магадгүй үүрд гомдоох байсан юм бил үү?

Намуун өглөө нь Итгэлтэйгээ яриад нөгөө компьютер-ийг засаж чадсаныг нь сонсоод саяхан маркетингийн төслийн уралдаанд шалгарснаасаа хамаагүй илүү баярлав. Итгэл чадлаа. Энэ бол ганцхан тэр компьютерыг засаж чадсандаа ч биш хайртай залуу нь толгойныхоо ачаар аав , ээжид нь өөрийгөө хүлээн зөвшөөрүүлж чдлаа гэсэн уг. Өөрсдөө унаж босож байж хөл дээрээ зогссон болохоор тэр 2 ийм л зүтгэлтэй чадвартай залуусд дуртай байдаг юм. Харин Итгэл Баагийг байгаагүй бол би ч ганцаараа барахгүй юм билээ гэсэн нь Түүнд бүр ч их таалагдав. Тийм ээ. Итгэл бол өөрийгөө хоосон магтагч, худлаа дүр үзүүлэгч биш. Намуун тийм зантай хүнийг үзэж ч чаддаггүй. Итгэлтэй танилцанаасаа хойш түүний олон сайн чанарыг нь таних тусам Намуун улам сэтгэл татагдаж байлаа. Хамгийн анх дискон дээр Итгэл Түүнээс уучлалт гуйхаар ирэхэд нь тэгж ухаангүй зугцанаа бодход инээд хүрмээр. Одоо бол

охидын харц унагасан энэ сайхан залуугийн зүрх сэтгэлийг ганцхан харцаар тэгж хүчтэй татаж чадсаныгаа хувь заяаны бэлэг л гэж боддог болжээ.

Тэр угаалгын өрөө рүү орж таатайхан суниагаад толинд харав. Сэтгэл санаа дээд зэргийн өөдрөг байгаа болхоор өөртөө ч их таалагдаж байв. тэгээд толь руугаа харан сэтгэл дүүрэн инээмсэглэхдээ толь минь надаас сайн энерги шингээж аваад л байгаарай. дараа нь намайг сэтгэл гутруу байх юм бол энэ энерги чамаас цацарна гэж бодон шүдээ угааж гарав. Өнөөдөр хичээлийн дараа ажилтай, тараад Итгэлтэйгээ уулзана гэж бодохоор амьдрал юутай сайхан бэ? Өглөөг ингэж таатай угтаж чадвал бүтэн өдөр сэтгэл өөдрөг байдаг ажээ. тэр өдрийн хичээл яажшуухан өнгөрснийг ч анзаарсангүй нэг л мэдэхэд тарж байлаа.

Брээк-ээр Жавхаа Итгэл-ээс зөндөө мессэж иржээ. Орой нь Жавхаа сургууль дээрээ намрын цоллекц узуулэх тул заавал ирээч гэж мөргөн гуйжээ. Мөргөн гуйх гэнэ шүү. Ажилаа тараад Итгэлийг дагуулаад очихоор шийдлээ.

Итгэл ч шөнөжин компьютер ухаж нойргүй хоносон мөртлөө хичээл дээрээ Урьдийнх шигээ үүргэлэх ч үгүй байгаадаа өөртөө их гайхаж байлаа. Урьд нь түүнийг дурласан Шакэспэрэ гэж хочиж л байсан Жака найз охиныхоо аавын компани дээр шөнөжин компьютер засч хоноснийг нь Баагийгаас сонсоод хүргэн хүү хүчтэй гэдэг нь үнэн юм байна гэж би найзыгаа хараад л ойлголоо хэмээн явуулж байв. Тэднийг хичээл тараад ажил дээрээ очиход Аянга болсон явдалыг сонсоод Жака шиг марзаганах шалтаг болгосонгүй

-Тэднийх чинь Намууны аавын компани байлаа гээд үнэ халсгүй ажил хийлгэнэ гэж байхгүй ш дээ. та 2 арай мөнгө аваагүй юм биш биз дээ? гэв.

Итгэл Баагий 2 мөнгөний тухай юу ч ярилцаагүй компьютерыг нь засчихаад ирсэн тул сая л санасан мэт харц солилцов.

-За арай ч дээ. за яахав. Итгэл ирээдүйн хадмынхаа юмыг гэж бодсон юм бол Баагий үнэ хөлсгүй ажилласан юм уу? Ингэж болохгүй дээ. юм бүхэн үнэ хөлстэй байх ёстой. Ямар ч танилдаа төрсөн ээж чин ч байсан хийж өгөх гэж байгаа ажлынхаа хөлсийг эхлээд тохиролцож сур гээд л Аянга сургаж гарав. Үүнийг нь Жака Аяндын монитарзмийн онол хэмээн шоолдог аж.

-Арай ч дээ. чи ээждээ ганц юм хийж өгчихөөд мөнгө нэхдэг гэж үү? хэмээн Баагийг ундууцхад Аянга

-Хийж өгчихөөд биш хийж эхлэхээсээ өмнө. ээжээсээ яагаад нэхэж болохгүй гэж. Жишээ нь манай ээж принтер янзлаад өг гэвэл би хэдэн төгрөг юм бэ гэж асууна. Тэр чинь ээж л хэрэглэдэг болохоос цаад эзэн нь төрийнх. Би яхаараа төрд үнэгүй зарагддаг юм бэ?

-За за . тэгвэл Ажилынх нь юмыг хийж өгвөл мөнгө нэхнэ гээч дээ

Энэ үер мэдсэн юм шиг компьютерын эзэн ерөнхий нябо нь утасдан нэхэмжлэхээ явуулчих гэжээ.

Аянга ч мөнгөний сургаар нэхэмжлэхийн маягт гарган бөглөөд уухайн тас гарч одлоо. Итгэл Намуунтай мессэж бичэлцэн энэ ярианд бараг оролцон ч үгүй. Аянгийг гарангуут Заяа орж ирснээ

-Сайн байцгаана уу? Хөвгүүд ээ. Аянга хаачаа бэ? Дөнгөж сая л ажил дээрээ байна гэж байсан

-Танай нөхөр л болсон хойно мөнгөний хойноос явсан гэж Жака хариулав.

-Аан гадуур ханиад их байна. та нарт усанд уусгадаг Витамин Ц авчирлаа. гэхдээ мөнгөө

өгөөрэй. Хүүе Итгэл ээ, Намуун та 2 чинь 2-уулаа мобинзо-той биз дээ? тэгээд юу гэж мессэж бичээд байгаа юм бэ?

-Энэ 2 шиг халуун дээрээ байгаа хүмүүст мессэж бичэх нь гоё байдаг байлгүй гэж бас л Жака өмнөөс нь хариулаад

-манай ашигтай зовлогоо булангийн хотлогч бас ямар Витамин аваад ирээв? чалх сэргээгч витамин алга уу? хэмээн марзаганав.

Зая үргэлж тэдэнд болон Аянгад крантний усыг шүүхгүй уувал ходоод мууддаг гэнэ, хиам утсан маханд нитрийн давс их байдаг болхоор хорт хавдар болдог гэнэ, Мах иддэггүй амьтад хамгийн урт настай байдаг гэнэ, бүгдээрээ махнаас гарья гэхчилэн хөтлөгч зөвлөгөө өгдөг тул ашигтай зөвлөгөө булангийн хөтлөгч гэдэг нэр авчээ.

Тэдний хувьд хичээлийн дараахь ажлийн өдөр нь иймэрхүү хөгжилтэй бөгөөд амархан өнгөрдөг билээ.

Харин Аянгийг Намууны аавын компаниас мөнгөө авхаар очих үеэр Оргил, Хасар 2 орой уулзахаар тохирч байв. Уг нь тэр 2-ын уулзах ёстой өдөр маргааш байсан ч үйл явдлын өрнөл яархаас аргагүй байлаа. Оргил Компанийнхаа санхүүгийн нууц тоо баримтийг өөр компанийханд хулгайлж өгөх гээд бүтэлгүйтсэн нь Итгэлд олз болсон билээ.

Ингээд л тэр Итгэлийг замаасаа зайлуулахад Хасартай хамтрахаар шийдэв. Хасар ч тийм санаатайгаар л өөртэй нь уулзах гээд байгаа нь мэдээж.

Гэхдээ түүн шиг дутуу ухаантай амьтан Оргилтой хамтарснаар дараагийн дайснаа бэлтгэж байгаагаа яаж мэдэх билээ.

Ажил тарсны дараа мань 2 хүн цөөтэй зоогийн газар уулзав. Нэг грушик пиво захиалаад л ажил хэрэгтээ оржээ. Дэргэдээ Намууныг олж авмаар байна. Тэр Итгэл гэдэг амьтныг замаасаа зайлуулахад туслаач гээд Хасар сая төгрөг амлав.

Оргилын хөх инээд хүрчээ. Тэр мушийн инээгээд өнөөх өрөмдөх мэт хурц нүдээрээ Хасарын нүүр рүү таг харснаа

-Энэ ажилдаа намайг тусалж чадна гэж яагаад бодоов? гэж асуув.

-Чамайг чадна гэж би мэдэж байна

-Нуулгүй хэлэхэд хөгшөөн, мөнгө чин бага байна. Нөгөө талаар Наран захирал чамд талтай байдаг болохоор л би чамд туслах гээд үзье.

Удаан ч ярилцангүй. Мани 2 Итгэлийг ямар нэгэн хилс хэрэгт унагах, тэгэхийн тулд үүнийг хийж чадах найдвартай хүн олох, гэхдээ тэр хүнийг Оргил олоод дараа нь Хасар өөрөө биечлэн уулзаж захиалга өгөхөөр тохиролцоод салав. Долоо хоногийн дотор Хасар мөнгө нэмэж бүрдүүлэх, Оргил нөгөө хүнийг олчихсон байх ёстой байлаа.

Мөнгөнд үнэр байдаггүй гэж үздэгтэйгээ адилхан зорилгодоо хүрэхэд арга хамаагүй гэж Оргил боддог хүн. Тиймээс ч өөртөө хэрэгтэй хүмүүсийн жагсаалт хөтөлдөг ажээ. Хасартай уулзсанаах дараа тэр гэртээ хариад нөгөө дэвтэрээ эргүүлж гарлаа. Ээжийгээ дөнгөж 18-тайд бутач хүү нь болон төрөөн Оргил өвөө, эмээтэйгээ Баянхошуунд осчээ. Ээж нь түүнийг 6 настайд хүнтэй сууж, байртай болоод ирж авах гэтэл тэр очсонгүй. Ээжийнх нь дагуулж ирсэн хойд эцэг хүүд нэг л зэвүүн хүнийрхүү санагдсан тул өвөөгийн дөө үлдэхээр шийдсэн юм. Тэгэхэд дөнгөж 6 настай байж ямар зөв шийдвэр гаргаж чадсанаа тэр гайхдаг юм. Сүүлд нь сургуульд орсон хойноо Оргил нэг удаа орондооо сэрүүн хэвтэж байгаад ээж, эмээ 2-ынхоо яриаг сэм сонсчихсон юм.

-Би хүүгээ аваачаагүй нь зөв болсон байна лээ. ээж минь

-За яав?

-Цогоо нэг удаа халамцуудаа чиний бэлтрэг чин цаанаа л нэг чонон санаатай. Харц нь хүртэл

хүүхдийнх шиг биш зэвүүн санаатай гөлөг байгаа юм энэ тэр гэж хэрүүл өдөөд байсан. Хамт байдаг бол ад үзэх шинжтэй хэмээн ярьхыг сонсоод хөнжил дотроо гараа хазан хойд эцгээ занан хэвтжээ.

Одоо хойд эцгийнх нь жирийн нэг дундаж айл. Эх нэгтэй дүү нар нь ахаасаа нэг л хөндий өссөн тул Оргил өөрийгөө ганцаараа хүн гэж үзнэ. Өвөө нь өнгөрсөн жил өөд болсон тул эмээтэйгээ 2-уулахнаа 5-н ханатай гэртээ нам гүмхэн товхийтэл амьдарна.

Одоо миний хүү сайн эхнэр авчихвал болоо доо гэж эмээ нь ярьдаг ч Оргилын бодол өөр. Хэдийгээр 2 хүнд бол зайтай, саруулхан ч өөрийн гэсэн ганц тусадаа булан ч байхгүй Монгол гэрт эмээгийнхээ дэргэд яаж хүүхэн авчирах юм бэ? тэгээд ч эхнэр аваад л хүүхдүүд төрөөд эхэлнэ. Хамаг цалингаараа зээлийн байрны хүү төлөөд л гар хоосон үлдэнэ.

Ингэж залуу насаа онгороохийг тэр хүсэхгүй байлаа.

3-н жилийн өмнө тэр дээд сургууль төгсөөд ангиараа Хандгайтад өдрийн амралтанд явжээ. Маргааш нь идэх ч юм үгүй мөнгө ч үгүй, уух архи ч үгүй болсон бөөн амьтныг ангийнх нь Билгүүн амралтын хажууханд байх зусландаа урьж аваачихжээ. Тэгэхэд л Оргил амидралдаа гутрах шиг болсон. Билгүүн тэр 2 сайн найзууд байлаа. Оргил Түүнээс бүх талаар илуу, оютаний эрдэм шинжилгээний шилдэг оютанаар шалгардаг, Билгүүн шиг их мөнгө гарийн салаагаараа урсгадаггүй, архи уудаггүй, тамхи татдаггүй тэглээ гээд юу хожив?

Цаашид ч амьдралаас юу хожих юм бэ? тэдний 3-н давхар нарш, гадаахь усан сан,

Тэдний 3-н давхар харш, гадаахь усан сан, ангийнх нь 20 гаруй амьтныг элбэг багтаах уужим цэлгэр зочний өрөө өөрийнх нь насаараа амьдарсан өөвгөр эсгий гэртэй харьцуулахад даанч шударга биш санагдсан.

Түүнээс хойш Оргил баяжихыг улам хүсэх болсон. Гэхдээ яаж ч шударга ажиллаад хэдэн төгрөгийн цалин авсан ч энэ насандаа ядаж тийм харшийн эзэн болж чадахгүйгээ мэдээд баян айлын хүргэн болох нь зөв зам гэдгийг ойлгосон. Тэгээд дараа нь их мөнгөтэй болоод улс төрд орно. Ямар нэгэн юмийг үнэхээр чин сэтгэлээсээ хүсэх л юм бол бүтэн гэж тэр бат нот итгэдэг юм. Тэгэхээр Хасарын мөнгийг ашиглан Итгэлийг замаасаа зайлуулаад Намуунтай суух л болно. Намуун бол зүгээр нэг тэнэгхэн охин биш л дээ. Гэхдээ л би хүсэх юм бол Намуун миний эхнэр болох л болно гэж тэр бодон дэвтэрээ онгичсоор нэг хэрэгтэй хүний утас олов.

Тэр бол олон жилийн өмнө зусланд хамт гардаг байсан ах хүү билээ.

Саяхан нэг тааралдахад шоронгоос дөнгөж гарлаа гээд явж байсан. Оргил түүнийг дараа хэрэг болж магадгүй гэсэндээ хоолонд урьж 5000 төг өгөөд гэрийн утсыг нь аваад салсан нь зөв болж. Маргааш нь ах хүү руу утасдаад л бүх юм ок.

Хэд хоногийн дараа нэг зуслангийн ах хүү нь Оргилд буурал Доржоо гэдэг хамийгаа зааж өгчээ. Хүн шантаачлах, гүтгэх, ер нь тиймэрхүү төрлийн захиалгыг цэвэрхэн гүйцэтгэхчидэг, гэхдээ нэг л холбоотой болчихвол эргээд салахад хэцүү хүн гэдгийг ч бас сануулжээ.

Тийм чухал уулзалтыг ганцхан Хасарт найдахын аргагүй тул тэр хамтай нь уулзахаар Оргил хамт очив. Мань 2 гэмт хэргийн ертөнцөд нөлөөтэй тахал амьтаны сургаар булиа биетэй, баргил дуутай, биеэрээ дүүрэн шивээстэй, хос кэанс-тай хүний дүр зурагласан нь оносонгүй. Нөгөө айхтар хүн нь був буурал богинохон халимагтай, бараг үрчлээгүй толигор царай, гонгиносон дуутай, гаднаас нь хараад хэдэн настайг нь тогтооход бэрх сонин эр байх аж. Хамгийн гайхалтай нь тэр хүний ёлтгоносон жижигхэн нүд нь хаашаа хараад байгаа нь мэдэгдэхгүй ярилцагчтайгаа хэзээ ч харц үл тулгарна. Оргил түүнийг ганц хараад л амаргүй

амьтантай учирсанаа ойлгов. Тэгээд одоо яая гэхэв. Шинэ танил нь ч тэднийг урт удаан оршилгүй ярихийг хүссэн болохоор ямар зорилготойгоо товчоон шиг ойлгуулах үүргийг бас л Оргил өөртөө авчээ. Гэхдээ ярианы завсартаа захиалга өгч буй эзэн нь Хасар байгаа юм, би бол ердөө л зуучлагч гэсэн шүү гэдгээ хэд хэд цухуйлгаад авлаа. Дараагийн ундаа буурал Доржоо хэргийг яаж бүтээх планаа Хасарт танилцуулаад Урьдчилгаа авахаар тохиров.

-Та 2-ын хүссэнээр тэр залууг эвгүй юмтай хутгачихаж болноо. гэхдээ үнэ хөлсөө шууд тохирьё. Би 5-н саяас нэг ч төгрөгөөр бага мөнгө авахгүй гэж эцэст нь Доржоо хэллээ. Холбоотой 2 залуу энэ тоог сонсоод өөд өөдөөсөө харав. Хасарт ердөө л 3-н сая төгрөг байгаа. Ийм осолтой зуучлалынхаа шанд Оргил Хасараас 1 сая төгрөг нэхээд байдаг. Гэвч Хасар толгой дохичихоод гар барьцгаав.

Оргилын хувьд бол яг энэ мөнгө нэхэж буй хэдэн өгүүлбэрийг ханцуйдаа нуусан бичил диктопоноор бичиж авсандаа сэтгэл хөнгөрөөд зоогийн газраас гарч иржээ.

7 хоног нисэх мэт өнгөрчээ. Энэ өдрүүд Хасар, Оргил 2-ийн хувьд сэтгэл хоёрдон шаналсан хүнд өдрүүд байлаа. 11-дүгээр сар гарсан ч Улаанбаатарын жавар чангарах гэж төдийлөн яарахгүй байгаа бололтой. Хааяа нэг цас хаялчихаад илч муутай наран ээсэн шаргал өдрүүд налайсаар. Намуун Итгэл 2 бие биедээ улам татагдсаар. хэн нь ч хаа нэгтээ 2 өөдгүй амьтан нийлчихээд хар сюрприсэ бэлтгэж байгааг гадарласан ч үгүй.

7 хоног нисэх мэт хурдан өнгөрөв. Хар санаа эзнээ отно гэгчээр энэ хэдэн өдөр Хасар Оргил 2-ын хувьд хийх гэж сэдсэн юмандаа сэтгэлийн дотоод шаналал эдлэн сэтгэл түшиглэн эргэж буцан эргэлзсэн өдрүүд боллоо. Шаварт унасан шарын эзэн Хасар Доржоотой уулзан планыг нь сонсоод урьдчилгаа төлөөд Оргилтой уулзав. Доржоо энэ хугацаанд объект буюу Итгэлийг муугүй судлаад хилс хэрэгт орооцолдуулах нь зөв гэж шийджээ.

План ёсоор нэг өдөр ажлийн өрөөнөөс нь Итгэлийн гар утас, өрөөсөн бээлийг нь урьдчилан хулгайлуулна. Тэр өдрийнхөө орой нь Итгэл руу нэгэн компаний менежер гэж өөрийгөө танилцуулан утасдаж томоохон ажил байна. 10-р хороололд уулзъя гэж тохирно. Энэ уулзалт аль болохоор орой байх ёстой. Итгэл ихэнх тохиолдолд ийм ажлийн уулзалтанд ганцаараа буюу Батбаяртай л явдаг. Гэхдээ энэ удаа Итгэл ганцаараа ирвэл сайн. 2-уулаа байсан ч тэр 2-ыг тохирсон газарт нь ирэхэд нь хэдэн гарйн бүлтэй хэдэн залуус нүдийг нь боож хүлээд 3-н цагийн дараа суллаж тавина. Энэ хооронд хэдэн жижиг гарууд ямар нэгэн ломбард тоноод хэргийн газарт Итгэлийн бээлий, гар утсыг орхино.

-Оргио, энэ хулгайч чин хэрэг бишдээд ирвэл бид 2-ыг мартчих юм биш байгаа гэж Хасар итгэл муутай асуусан нь тун ч сулхан эр болохыг нь илтгэн Оргилын инээдийг хүргэж байлаа. Гэвч нүүрний хувирлаа сайн нууж чаддаг Оргил үүнийгээ мэдэгдсэнгүй. Том шавар аягатай шар айраг чимэнгээ

-Зүгээр зүгээр. Надад тэрний эсрэг хэрэглэх юм бас бий шүү хэмээн тайвшруулавч дотроо бол энэ ч хөөрхий, зайлуулахад амархан амьтан байна даа гэж доогтойхон бодож суулаа. Тэгээд ч Хасар тэр буурал этгээдэд 2 сая төгрөг төлчихсөн болхоор ухрах газаргүй болжээ. Буурал Доржоо ажил хэрэгч эр ажээ. Төлөвлөсөн ажилаа эхлэхдээ ганц ч хоног алгуурладаггүй хүн гэсэн нь үнэн байв.

Дахин 5 хоногийн дараа тэнгэр муухайран бүүдийсэн нэгэн өдөр ажилаа эхэлсэнээ мэдэгдэн Хасар руу ярилаа.

Итгэл энэ өдөр гар утасаа ажил дээрээсээ алдчихсандаа их л гайхав. Энэ өдөр хол ихтэй байсан болхоор нэг нь авчихаж дээ гэж бодоод Намуунтай уулзахаар гарсан ч сэтгэлдээ нэг л

мууг зөгнөөд байсан боловч хайртыгаа хараад сэтгэл нь сэргэж энэ тухай таг мартжээ.

Тэр 2-ыг пизза-ны газарт хооллоод хөтлөлцөн гарахад өдөржин бүүдийж дүлэгнэсэн тэнгэрээс цас хаялж байлаа. Цаг 9 болох гэж байв.

-Хулуутай пизза чин онцгүй эд байна. Махтай нь юм уу, холимгийг нь авч байя гэснээ Итгэл лавсан орсоор буй цасанд дарагдсан машинаа хараад

-Машинаа хурдан асаая. мотор нь хөрч байгаа байх гээд машин руугаа алхахад Намуун гудамжны гэрэлд үлгэрийн мэт будран орж байгаа цасыг инээмсэглэн харж алган дээрээ тосон зогссоноо

-Би бороо, цас орхиод гудамжаар алхах дуртай. 2-уулаа жаахан алхах уу? гэж эрхлэнгүй хэлэв. машинаа онгойлгож байсан Итгэл

-2-уулаа дараа цасанд зугаалья. Би нимгэн яактай гарчихсан чинь даараад байна. Тэгээд ч би 9:30-д 10-р хороололд нэг хүнтэй уулзах ёстой. нэг ажил санал болгоод байгаа юм гээд машиндаа орж асаалаа. Алган дээрээ цасан ширхэгүүд хайлахыг харж зогссон Намуун ч дурамжхан ирж суугаад

-Энэ их цасанд замын халтиргаа хачин байгаа даа. Чи маргааш тэр хүнтэйгээ уулз л даа гэв.

-Би орой утасаа алдчихсан одоо холбоо барих аргагүй болсон. тэр хүн хүлээгээд байгаа байх гэж хэлэхдээ Намууны хориглоод байгаа, өөрөө түрүүхэн нэг л муу совин татаад байсныг санасан ч тэгсгээд яриандаа халаад мартчихсан Намууныг гэрт нь буулгаад 10-р хороолол орохоор давхиж явлаа.

Давхих ч гэж дээ, зам гэж мөсөн гулгуурын талбай болж хувирсан тул мөлхүүлж л явлаа. саяхан Намуунтай үнсэлцэн уруул нь халуу шатах шиг одоо ч зөөлөн уруул нь мэдрэгдсээр... цас улам лавсан орсоор байлаа.

Цаг орой болсон ч замын хөдөлгөөн багасаагүй, удаашруулсан хөдөлгөөнд орсондоо уцаарласан жолооч нар сигналдан араасаа аажуухан мөлхөх машинууд нь мөсөн дээр халтирахаас айж бээцийсэн хүмүүс мэт харагдана.

Аз болоход хотын төвөөс холдох тусам замын хөдөлгөөн сийрч байлаа.

Гэтэл баларсан юм болов. Дөнгөж Сонсголонгийн гүүр гараад л машин нь таг зогсчихлоо.

Жака ч юмуу, Баагийг дуудъя гэтэл гар утсаа алдсанаа санав. Итгэл хараал тавиад дэмий л гарч хамрыг нь сөхөж үзээд ямар ч онош тавьж чадсангүй буцаж машиндаа орж асаах гэж баахан оролдов. Тэгж тэгж мотор нь хүржигнэн ассан ч хөдөлсөнгүй. Замаар цөөхөн машин сүнгэнэн өнгөрч, явган хүний замаар даарч бээцийсэн хүмүүс хурдан хурдан алхацгаах боловч түүнд тусалчихмаар нохой ч харагдсангүй.

Ядаж өвлийн эхэн сарын энэ хүйтэн шөнө цагаан утастай хүн ч үл харагдана. Машинаа орхиж яваад утас олж ярья гэхээр ойр хавьд утастай баймаар газар ч нүдэнд торохгүй аж. ингэсээр 12 болчихов.

Тэгтэл ашгүй нэгэн эргүүлийн цагдаатай таарч 5000-аар тэргээ харуулж байхаар тохирч нэлээд хол харагдаж байгаа нэгэн байгууллагын жижүүр дээрээс утасдахаар явжээ. Итгэл тэр байшингаас Жака руу утасдан дуудаад буцаж ирэхдээ 30 мин зарцуулжээ. Санаандгүй явж байгаад 5000 төгрөгтэй болсон цагдаа их л баярлан идэвхитэй гэгч нь станцаараа ярин сууж байв. Тэр 2 нэрээ мэдэлцэн танилцах завдал ч болсонгүй. Харин станцаараа яриж байснаас нь сонсоход түүнийг Борхүү гэдэг бололтой.

-одоо хүн ирээд чирж хөдөлнө гэсээр байтал лав дахиад цаг шахуу болох нь дээ. би ч чамд хань болоод сууж баймаар л байна. Тэгсэн чинь дарга дуудаад явахаас. Итгэл санаандгүй

тааралдсан замын хань нь цасан дунд бараа тасрахыг харсаар хоцрохдоо түүнтэй дахин уулзах юм шиг санагдаад байв. Удалгүй Жака аавынхаа машинаар ирж энэ үдшийн адал явдал шувтарсан билээ.

Гэтэл андуурсан байжээ. Өдөр хичээл тарах үеэр нь Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэс дээр дуудуулсан байлаа.

Гайхалтай юм. Хүн болсоор цагдаад дуудуулж явсах түүх байх биш.

Өчигдөр алдсан гар утсыг минь олсон юм бол уу? гэтэл хэн ч утас алдсаныг нь цагдаад мэдэгдээгүй байдаг. Түүнээс дутуугүй гайхсан Жака, Баагий 2 хань болж хамт очив. Хэрэг бүртгэгч дэслэгч Болд гэж өөрийгөө танилцуулсан залуу Итгэлийг дуудаж оруулаад -За урьд шөнө 00 цагийн хооронд хаана явснаа тодорхой яриарай гэж тулган асууснаа эрх, үүрэг ч гэх шиг юм тайлбарлан байцаалт авах юм болов.

-Би тэр үеэр 10-р хороололд явж байсан. Ах аа, яалаа гэж намайг байцааж байгаа юм бэ?

-Сэжигтэн учраас. Чи тэнд юу хийж явсан юм бэ? Сансарт тэгээд хэдэн цагт очсон бэ?

-Би ягаад сэжигтэн болдог юм бэ? Яах гэж Сансарт очих юм?

-Асуултыг нь би тавина. Ломбард ухах гэж очсон юм биш үү?

-Юу? Миний машин эвдрээд би 10-р хороололд цаг гаруй зогсоод дараа нь гэртээ харьсан.

-Гэрч бий юу?

-Байна. Жака гээд манай найз

-Та 2 нийлж ломбард ухсан уу?? гэж дэслэгч доогтой хэлээд Итгэлийн гар утсыг гарган ширээн дээр тавьж бичгийн машинаа тогших аж.

Урьд шөнө нь Сансарт нэгэн ломбардыг дээрэмдээд хэргийн газарт Итгэлийн гар утас, өрөөсөн бээлийг аваачиж хаясан байжээ.

Мобиком дээрх бүртгэлд нэр хаяг нь тов тодорхой байдаг юм чинь...

Ингээд л Итгэл ломбард дээрэмдсэн хэргийн сэжигтэн болоод хоносон байх аж.

Жакаг өнөөх дэслэгч гэрч гэж авч хэлэлцсэн ч үгүй. Ганцхан цагийн дотор захирамж гаргуулаад Итгэлийг 72-т суулгаж орхилоо. 2 найз нь цагдаа Борхүүгийн эрэлд гарч, гэрийнхэн нь, Намуун ирцгээж бөөн юм болов.

Машин тонож байгаад баригдсан, авгайгаа зодсон гэхчилэн дөрвөн үл бутэх амьтантай хамт нэгэн давчуухан өрөөнд Итгэлийг хийгээд цоожилжээ.

Хэн түүний утсыг хулгайлсан байх вэ? Яах гэж очиж очиж Итгэлийг хэрэгт оруулав? Яаж ч бодоод хариулт олсонгүй. Ямар ч гэсэн өчигдөрийн уулзъя, ажил байна гээд байсан этгээд энэ хэрэгт хамаатай болж таарах нь. Машин нь хэрэв эвдэрээгүй бол тэр Итгэлийг барьж хаа нэг газар хориод энэ хэрэгт тулхчихээд гэрчгүй үлдэх байж. Гэвч яагаад заавал Итгэлийг сонгов?

Ямар ч гэсэн сандрах хэрэггүй. Нэгэнт тэр ломбард дээрэмдээгүй юм чинь учир нь олдож л таараа.

Харин ч эр хүн нэг удаа ийм газарт ороод үзчихсэн байхад зүгээр ч юм биш уу гэх зэргээр өөрийгөө тайвшруулна.

Асуудал хэнд ч тулгардаг хэрэв өөрт нь тохиолдоод байгаа энэ хачин явдлыг асуудал гэж үзэж болох юм бол...

Асуудлыг шийдэхэд амжилт эсвэл бүтэлгүйтэл байх нь зөвхөн таны сэтгэл зүйн чиглэлээс хамаарах тийм ээ. СЭЧ-тэй байхыг тэр үргэлж хичээдэг шүү дээ...

Биеэ барь. Сэтгэл хөдлөлө хяна. Хувь заяагаа өөрөө шийд. болж байна аа. Тэр хоригдож эхлэнгүүтээ л биеэ барьсан. Хаалга, үүдийг нь балбан цагдаа нарын уурыг хүргээгүйг бодоход биеэ ч сайн барьсан. Харин хувь заяагаа удирдах гэдэг нь одоо хэрэгжүүлэхэд хэцүү л юм.

Бурхан хэзээд энэрэнгүй. Намуунтай учирсныгаа бурханы бэлэг гэж бодож явдаг болохоор энэрэнгүй байж магадгүй л юм.

Итгэлийн одоогийн нөхцөлд тохирох эсэхийг хэлэхэд хэцүү аж. Эцэст юу гэж байдаг билээ? Аливаа азгүй явдалд амжилтын, магадгүй бүр их амжилтын үр байж болно. Ийм нөхцөлөөс амжилтын үр хэрхэн гаргаж авах тухайд бодох цаг нь одоо л лав биш болов уу?

Иймэрхүү байдлаар элдэвийг эргэцүүлсээр 72-т өнгөрөөх нэг өдрөө баржээ.

Түүний хувьд Бусниэсс-ийн амжилтанд хурэх тухай олон ном уншсан нь одоо л ийм үед хэрэг болж зарим чухал үгс нь санаанд орж байдлыг цэгнэж дүгнэлт хийхэд нь тус болж байлаа. Айх юм. Намуун юу гэж бодож байгаа бол? Тэр 2-ын үерхэсэн энэ богинохон хугацаа ийм сорилт тулгарсан цагт бие биедээ итгэхэд хангалттай байж чадах болов уу?

Ээж нь хамаг л танил тал руугаа утасдан гуйж, Намуун яах ч учраа олохгүй байлаа. хайртдаа яаж ч тусалж чадахгүй энэ арчаагүй байдалдаа шанална.

Харин Оргил Намууны ээжид цэвэрхэн гэгч нь алтан хошуу өргөчихөөд оны шилдэг оюутан дээрэмчин байв уу? гэсэн мэдээлэл сонинд гаргах ажлыг бас л төвөггүйхэн амжуулаадхав.

Харин Хасар л эвгүйрхсэн байлаа. Итгэлийг хэрэгт орууллаа гээд Намуун өөрийг нь тоох юм бол уу?? Хэрэв Оргилтой хуйвалдаж тэр залууг хэрэгт гутгах ажлыг зохион байгуулсан нь илэрвэл яана? гэвч Оргилын зөвлөснөөр маргааш нь Наран руу утасдан Намууныг асуусан хүн болж байснаа Нараа эгч ээ, Намууны найз залуу нь дээрмийн хэрэгт орооцолдсон юм уу? сонин дээр гарчихсан байна гэж манай найз хэлэхээр нь үзсэн чинь үнэн байх шиг гээд санаа зовсон хүн болж харамслын хэдэн үг хэлээд утасаа тавьжээ. Наран өчигдөр Оргилыг тиймэрхүү юм хэлэхэд нь ажилдаа дарагдаад мартчихсанаа санаад сонин шүүрэн аваад нүдэндээ ч итгэсэнгүй. Урьд шөнө охин нь унтаж чадахгүй нохойгоо салхилуулж байна гэж гарч орон холхиж, байн байн утсаар яриад байсныг гэнэт саналаа.

Сүүлийн үед үргэлж баяр хөөр дүүрэн, ажилдаа ч, хичээлдээ ч дуртай байх болсон Намуун өчигдөр яагаад ийм царай муутай байв? Тэгэхээр охиных нь найз залуу тийм булай хэрэгт орооцолдсон нь үнэн байх нь ээ?

Тэр сонинг шүүрэн авч нөхрийнхөө өрөө руу орон

-Өвгөөн, Намууны нөгөө үерхээд байгаа залуу чинь дээрмийн хэрэг хийчихсэн гэнэ. Чи энэ сонинг хараач, үнэн юм болов уу?

гэсээр ширээн дээр нь сонингоо шидэхэд

-Аль сонингийн худлаа үнэн юм сараачихыг тэр гэх бэ дээ. Биш байлгүй гээд тоосон ч үгүй. харин Наран эргэлзсээр л байлаа. Гэвч гэртээ хариад эмээгээ налан таг дуугүй суух охиныхоо шаналсан царайг хараад юу ч хэлсэнгүй гэсч өнгөрөв. Харин Чимэд өөрийнхөө өмгөөлөгчийг Итгэлд туслуулахаар болсонд охин нь овоо сэргээд иржээ. Зовлон хүнийг нэгтгэдэг юм болохоор энэ айлынхан тэр орой их л эвтэй найртай байж билээ.

Маргааш нь Намуун өмгөөлөгчөөр дамжуулан Итгэлд шүрэн бугуйвчаа өгуулжээ. Өөрөөр түүндээ яаж туслахаа мэдэхгүй байв.

Жака, Баагий 2 хотын бүх цагдаагийн хэлтсээр Борхүү нэртэй цагдаа хайсаар 3-ыг олж, 2-той

нь уулзсан боловч тэд Итгэлийн машиныг манасан тэр цагдаа биш байв. Харин 3 дахь нь хувийн ажлаар хөдөө явчихжээ.

Энэ хооронд Итгэлийн хоригдох 72 цагийн 3-ний 2 нь онгорчихов.

Гэтэл энэ хэргийн гол зохион байгуулагчдын дунд үүссэн маргаан санамсаргүйгээр Итгэлд ашигтай тийшээ эргэхэд бэлэн болсон байлаа.

Тохиролцсон ёсоор бол Хасар буурал Доржоод улдсэн 3-н саяийнхаа 2-ийг өгөх цаг нь болжээ. Гэвч тийм их мөнгө олдсонгүй, машинаа нэгэнт барьцаанд тавчихсан. Ээжээсээ мөнгө авчихсан. Гэтэл мөнгийг нь өгөхгүй бол хүн хорлох гэсэн биш өөрөө гэмт хэрэгтнүүдийн гарт орчих гээд байдаг. Оргилд энэ тухайгаа хэлбэл

-Зүгээр зүгээр. Цаадахдаа таны 5-н саяар энэ ажлыг ах нь амжуулчихна. Доошоо нэг ч төгрөг буухгүй шүү гэсэн ярианы бичлэг чинь байгаа. Тэрийг цагдаад өгчихөж болноо шүү гээд хэлчих хэмээн уг зааж өгөв. Харин буурал Доржоо бол мань 2 шиг жулдрайнуудаас дутуу сэтгэх толгой биш байжээ. Анх Хасар Оргил 2-той хийсэн уулзалтаа бичил камераар бичээд авчихсан байснаа Итгэлийн хэргийг шалгаж буй өмгөөлөгчид хүлээлгэчихгүй яахав.

Ийнхүү Итгэлд дээд тэнгэр туслав уу, СЭЧ-ийнх нь энэргы хэрэг болов уу. Ямар ч гэсэн баривчлагдсаныхаа 70 дахь цагийг ч дуусгалгүй суллагдаж, захиалгаар хүн гүтгэсэн зохион байгуулалттай хэрэгт Хасар Оргил 2 ороогдон хэргийн учир ч тайлагджээ.

Энэ бүхний эцэт хамгийн их шаналж хоцорсон хүн Намуун л байлаа.

Итгэл өөрөөс нь болж хэрэгт орох дөхлөө шүү дээ. Харин Итгэл надад итгэж байсанд чинь баярлалаа. Чиний төлөө энэ зэргийн үнэ төлөлгүй яахав дээ гэсэн. Харин Наран охиндоо цаад залуу чинь хэрэг хийхдээ ч буцахгүй хүн юм биш уу? Хасар л хамаагүй дээр байсан юм. Ямар буруугүй хүний гар утас тэндээс олддог юм гэхчилэн санаж бодсоноо хэлчихээгүй тэссэндээ залбирч байлаа. Хэрвээ тэгээд хэлчихсэн бол охиныхоо зовж шаналж байхад нь мартахын аргагүй гомдоох байж.

Та надад дандаа өөрийнхөө бодлыг тулгаж байдгаа болиоч гэж тэр орой Намуун хэлж байсан.

Үнэн л юм байна. Хэрэв тэр тэнэг үгийг хэлсэн бол бас л өөртөө тэрхэн үед төрсөн бодлыг тулган дараа нь амаа барих байж.

Энэ хэргээс хойш 2 залуугийн үерхэлийг 2 гэрийхэн нь бүрэн хүлээн зөвшөөрчээ.

Одоо Итгэл ирээдүйн хадмындаа орж гарах болсноор барахгүй оройтвол хоночихдог ч болжээ. Тэр хоригдож байхдаа аливаа азгүй явдал амжилтын, магадгүй бүр их амжилтын үр байж болно гэсэн үгийг санаж, амжилтын үрийн тухай бодох цаг биш гэж бодож байж билээ. Харин тэдний найз нараас Жака, Жавхаа 2 л энэ дотно үерхэлд нь бага зэрэг сэтгэл дундуур явах болжээ. Ажлын дараа Аянга, Итгэл 2 болзоондоо яаран гарцгаахад Жака за ганц биеэрээ муу Баагий бид 2 л үлдэх шив дээ. 2-уулаа гоонь залуучуудын клуб байгуулах уу? гэнэ. Гэвч хүүхэн эргүүлэхэд Баагий Итгэл шиг гар нийлж чадахгүй болохоор даанч урамгүй. Ёстой л айхын бараа, идэхийн нэмэр юм биз дээ. Заяа ч чи мөрөөрөө л мөөмөө хөхөөрэй. Наад Баагий чинь чам шиг хүн биш. Битгий хүүхэд уруу татаад бай хэмээн үг хаяна.

-Яг үнэн. Эр хүний дотор эмээл, хазаартай морь багтдаг гэгчээр наадах чин улс төрч болохыг мөрөөддөг хүн. Чамаас болж ирээдүйн мэдээлэл холбооны технологийн яамны сайд хүүхэн шуухны элдэв паянд орооцолдохыг хэн мэдэх юм? хэмээн Итгэл явуулна

Харин Жавхаагийн хувьд Намуун найз залуутай болсноос хойш их л ганцаардах болжээ.

Шинэ жил болох гээд Жавхаа сургуулынхаа оюутнуудын дунд зарласан гоёлын дресс-ний

уралдаанд оролцох загвараа олж нэг загвар өмсөгч охиноос хэмжээ авч байлаа. Гэтэл ширээн дээр байсан нэг зургийг тэр охин авч харангуутаа л чи энэ Итгэлийг таньдаг юм уу? ёстой жинхэнэ Дон Жуан гээд л бодчих. Ноднин манай найз Сэни, Жавзаа 2-той долоо хоног л явсан гэж байгаа юм. Уг нь саак гоё залуу л даа. Сэни-тай авхуулсан зургийг нь ч би харж байсан. Итгэл тэгээд чиний юу юм бэ? хэмээн шалгааж гарав.

Энэ бол Жавхаагийн хувьд чих соотойсон сонин мэдээ байлаа. Юу чиний 2 найзтай тэгээд зэрэг явж байсан юм уу?

-Бараг л зэрэг шахуу. Сэниг хаячихаад л Жавзаатай долоо хоног унтаад бас больчихсон гэсэн. Жавхаа Намууны өмнөөс эхлээд уурлав. Тэгснээ баярлах ч шиг. Намуун Итгэлийгээ юу юу гээд л магтаад байлаа? Бараг нөгөө муу Хасараас нь дээрдэхгүй л амьтан байсан байна ш дээ. Сурсан юмыг сураар боож болдоггүй гэдэг биз дээ? Одоо ч гэсэн нэг тийм урт хөлтэй, ухаан богинотой охинтой Намуунаас далдуур сэвж явдаг юм бил үү?

Гэтэл Намуун юу гэж байлаа? Жавхаа л болсон хойно нэг удаа би хэнээс дутуу болохоороо ингэж ганцаардаж явдаг юм бэ. Гоёж гангалаад л байх юм. Нэг ч аятайхан залуугийн нүдэнд торохгүй. Чи яаж Итгэлийг ингэж өөртөө татчихваа? гэхэд Намуун байгаа байдлаараа л. Энүүхэндэ гэхэд эрчууд энгийн даруухан, элдэв хуурамч чимэггүй, өөрийн гэсэн онцлогтой хүүхнүүдийг л сонирхдог юм шиг ээ. Итгэл намайг үсээ боож байгаарай. Урт үс задгайлсан охиноос бур залхаж гүйцсэн гэдэг юм. Чи ч гэсэн усээ өөрчлөөд үзээч гээд л сургаал айлдаад байл уу?

-Алив битгий хөдлөөд байгаач. Хэмжээгээ буруу авахуулах гээд хэмээн тэр үглэснээ

-Хүүш ээ, чи надаа тэр зургаа аваад ирж чадахгүй юу? гэхэд нөгөө охин дуртай нь аргагүй зөвшөөрөв.

Маргааш нь нөгөө зургийг Жавхаа гартаа оруулж чадав. Тэгээд Намууны ажил дээр хэрэг болгон очиж, гэр рүү нь хамт очлоо. Найз нь шинэ жилийн өмнөх өдөр Хонг Конг руу явах болчихлоо гэсээр Намуун хамаг сонингоо хаман ярьж гарчээ. Хонг Конгд болох банкны маркетингийн семинарт Намууныг оролцуулах болжээ. Энэ тухай сонсоод Жавхаа нэг хүнд хэтэрхий ихдэхээр азтай байгаа юм биш уу? гээд хэлчихэв.

--яасан? юу нь ихдэхээр гэж?

-зүгээр л тэгээд хэлчихлээ. чи битгий уурлаарай. би өнөөдөр нэг ийм зураг оллоо. Оллоо ч гэж дээ. Найздаа сэрэмжлүүлээрэй гэж хүн өгсөн юм л даа. Итгэл чинь Дон Жуан гэж байна ш дээ.

Энийг Сэни гэдэг гэнээ. энэ Сэни-тэй 7 хоног явж хаячихаад найзтай нь бас л явсан гэж сонслоо. Янзын хүүхэн байгаа биз? Итгэлийн гэрийхэн нь ч мэддэг гэсэн гээд нөгөө зургийг гаргаад өгчихөв. Энэхэн мөчид тэр найзынхаа аз жаргалд атаархсандаа л ийм алхам хийснээ өөрөө ч мэдсэнгүй.

Намуун зургийг авснаа царай нь хувираад хойд талыг нь эргүүлж харав. Үүрд чамтай шүү гэж балаар бичсэн байв.

-Хасар бас л нэг ийм загвар өмсөгчтэй... гэснээ Жавхаа амаа хамхисан ч оройтжээ. Уг нь ингэж хэлэх хэрэггүй л байсан юм.

Намуун уурандаа зургийг хэдэн хэсэг болгон ураад

-Чи хаанаас энэ зургийг олж ирэв? Надад яагаад үзүүлж байга юм? гэж хоолой зангируулан асуув. Жавхаа хэрэггүй ч юм боллоо, үзүүлдэггүй л байж гэж тэрхэн зуур бодоод

-Зүгээр л.. юу ч гэх бэ дээ. чамд үзүүлэх хэрэгтэй л гэж бодсон юм.

-Баярлалаа гээд Намуун өрөөндөө ороод хаалгаа түгжив.

Жавхаа хойноос нь очихын ч хэрэггүй гэж мэдэж байв. Намуун түүнийг явсны дараа Итгэлийн дүү Навчаа руу утасдан Сэни гэдэг хүүхнийг мэдэх эсэхийг нь асуув.

-Манайх руу утасдаж л байдаг юм гэж Навчаа хэлжээ.

Ядахад энэ орой Итгэл гэрт нь ирнэ гэхчээд алга. Нмауун хойноос нь утасдсан ч үгүй. Итгэл ийм хүүхэмсэг амьтан байсан юм уу? Бас л нэг загвар өмсөгч гэж Жавхаа яагаад хэлэв? Итгэл энэ эрээ цээргүй гуя хасаа гаргасан хүүхэнтэй юун янаг халуун тэврэлдсэн юм бэ? гэж бодохоос уур нь хүрч утасдахад нь ч авсангүй.

Тэр Сэни-тэйгээ ярина биз.

Маргааш нь ч тэр Итгэлд нүүр өгсөнгүй. Ажил тараад аавынхаа жолоочийг дуудан гэртээ хүргүүлэв. Итгэл хойноос нь баахан дагаж давхиад гэрийнх нь үүдэнд зогсоход нь бүсгүй хараагүй юм шиг гүйгээд орчихов.

Намуун юунаас болоод уурласныг залуу бодоод бодоод олсонгүй. Харин Навчаа охин л ахынхаа дүнсийчихээд өрөөндөө суугаад байхаар нь Намуун эгчтэй муудалцчихаж хэмээн тааварлаж

-Ах аа, арай нөгөө Сэни гэдэг хүүхэн чинь Намуун эгчид элдвийн юм ярьсан юм биш байгаа? Өчигдөр Намуун эгч надаас Сэни гэж хэн байдаг юм бэ? гээд асуугаад байсан гэх нь тэр.

Итгэл утсаа шүүрэн аваад залгавал Намуун гар утсаа унтраачихжээ. Гэр рүү нь ярихаар дийд дийд.. ажил дээр нь очихоор уулзалтын өрөөндөө гарч ирэхгүй. Тарахаар бие хамгаалагчтай машинд суугаад яваад өгнө. 3 хоног өнгөрсөн ч учраа олж чадалгүй байсаар Намуун Хонг Конг руу нисчихжээ.

Намууныг явсны дараа Итгэл Жавхаагийн сургууль дээр очиж уулзав. Яагаад ч юм Жавхаа өөрийг нь хараад хулчийх шиг болсон нь Итгэлд гайхалтай санагдав. Гэвч тэр тоймтой юм хэлсэнгүй.

--Сэни гээд нэг хүүхэнтэй авхуулсан зургийг чинь Нмауун үзчихсэн юм биш үү? Дүү чинь бас тэр хүүхнийг мэдэж байна гэсэн. Гэхдээ Намуун явахдаа надтай уулзаагүй ш дээ гэснээс өөр юм хэлсэнгүй. Итгэл түүнтэй уулзаад буцахдаа Жавхаа гэж нэг юм үймүүлчихсэн юм шиг байна даа хэмээн бодож явлаа.

Маргааш шинэ он гарах гэж байдаг би ч гэж би. Яах гэж хөөрцөглөж тийм зурах хөрөг авахуулж солирсон юм бол? хэмээн өөртөө уур нь хүрнэ.

Түүнд энэ удаагийнх шиг уйтгартай шинэ жил тохиолдож байсныг санахгүй байв.

Сургуулийнхаа шинэ жилд үзэгдчихээд л М4-ийнхэнтэйгээ ч ресторанд суусангүй. Цаг тутамд и-мэйл хаягаа шалгавч таг. Намуун ч яг өөртэй нь адилхан байгаа гэж бодохоос хойноос нь Хонг Конг нисчихмээр санагдана. 12 дугаар сарийн 30-ний орой дүүдээ гацуурыг нь засч байхдаа л овоо сэтгэл нь сэргэжээ. Аав нь явчихсанаас хойш Итгэл л дүүдээ гацуурыг нь чимэж, цонх, хаалган дээрээ Санта Клаус, Мики хулгана, Доналд дак гээд амьтдыг зурж баярлуулсаар зургаан шинэ жилийг уджээ.

31-ний өдөр Итгэл шинэ жилийн бэлэг авхаар Их Дэлгүүрт орлоо. Хэдийгээр муудалцсан ч гэсэн Намуундаа хамгийн түрүүнд бэлэг авлаа. Намуун үнэтэй бэлгэнд дургуйг мэдэх болохоор жижигхэн чихмэл тугал авч хүзүүвчинд нь тэнгэрийн өнгөт индранал шигтгээтэй зүүлт углав. Индранал бол түүний ээлтэй чулуу. Намуун үхрийн ордных болохоор бяцхан тугал авсан хэрэг. Алгын чинээхэн тэр цагаан тугал индранал хузуувчиндээ гялалзуулан амьгүй нүдээр өөдөөс нь ширтэхэд Итгэл гунигтай инээмсэглээд ээж, дүү 2-тоо бэлэг авахаар

хол тавих зайгүй холхилдсон хүмүүсийн дундуур зутгэлээ. Дараа нь Их Дэлгүүрээс гараад нэг л мэдэхэд Намууных руу явж байв. Гэрт нь очвол мэдээж аав ээж нь байсангүй. Хүлээн авалтанд явчихсан байв. Гэрийн үйлчлэгчид нь бэлгээ өгөөд Намууны дэрэн дээр тавичихаарай гэж захив. Орой нь түүнийг гэртээ байж байтал Жака Баагий 2 ярьж ятгасаар дагуулан гарав. 3-уулаа шөнөжин диско-доод үүрээр шинэ он гарсан хойно буцаж ирэхдээ Итгэлийн сэтгэл нэлээд сэргэчихсэн байлаа. Дүү нь дэрэн дээр нь Harry New Year гэсэн бяцхан ил захидал тависныг дэлгэвэл ах аа, танд шинэ оны мэнд хүргэе. Би танд ааваас илүү хайртай шүү гэжээ. Дүүдээ баярлан орондоо орж хэвтлээ. Шинэ он гараад хэдэн цаг өнгөрсөн ч гадаа хөөрүү хөршүүд нь оргилуун дарс буудуулан, гэрэлт пуужин харвасаар байх чимээнд зүүрмэглэв.

Итгэл шинэ оны анхны өдөр бараг үд дунд босов. Ээж дүү 2 нь айлд зочлохоор явжээ. Баахан салат таваглаж зурагтын өмнө суулаа. Утас нь шинэ жилийн мэнд хүргэсэн мессежээр дүүрчээ. 1 цагийн үед хонх жингэнэв. Дурангаар ч харалгүй нээгээд нүдэндээ итгэсэнгүй. Намуун инээмсэглэн зогсч байв.

-Шинэ жилийн мэнд хүргэе

Итгэл шууд л тэврээд авлаа. 2-уулангийнх нь нуд нулимсаар дүүрчээ.

-Би чиний бэлгийг авсаан. Ёстой их таалагдсан

-Тийм уу? Зөрүүд бяцхан үхэр минь?

-Би чамд бэлэг авсан. Минийхтэй яг ижилхэн шүрэн бугуйвч гээд Намуун цэнхэр туузаар ороосон жижигхэн хайрцагтай юм өгөөд

-Би нөгөөдөр ирэх байсан юм. Тэгсэн чинь чамайг санаад баярын хөтөлбөрт нь оролгүй онгоцонд суучихсан. Миний суусан онгоцны тал суудал нь хов хоосон ирсэн. Аргагүй ш дээ. Яг шинэ он гарах гэж байхад. Надтай зэрэгцэж суусан ази эмээ ч их гунигтай явна.

Хайрттайгаа муудаа юу? би чиний нүднээс бүхнийг харж байна. Тэр чинь их сайн залуу юм. Яг одоо чамд бэлэг авч байна. Чиний ээлтэй чулууг оролцуулаад. Чи түүнд итгэх л юм бол насаараа аз жаргалтай амьдарна гэсэн. Мэргэн эмээ байгаа биз? Тэгээд гэртээ ирсэн чинь дэрний хажууд чиний бэлэг байж байсан. Аав ээж эмээ 3-т ганц ганц үнсүүлчихээд л чам руу хүрээд ирлээ. Би чамд дэндүү хайртай болохоор л тэгж хардсан байх.

Тэгсэн мөртлөө цаг минут бүр чамайг л бодож байсан шүү. Дараа нь бодоод байсан чинь чи намайг асрагч гэж гололгүй бүтэн сар эрж хайсан байж хуурч мэхлэх байсан гэж уу? гэж бодохоор би шал тэнэг юм. Ер нь би зөрүүд зангаа дийлдэггүй, жаахан олон ааштай ийм л хүн... чамаас хол байхдаа л ямар их хайртайгаа ойлгосон шүү..

-Одоо болноо. Тийм их юм ярисны хэрэггүй. Ингээд л тэврэлдээд байя 2-уулаа

Асар их хайртай хүмүүст үг ярихгүйгээр ойлголцох үе байдаг шүү дээ. Тэр 2-ийн тэврэлдсэн гарын бугуйнд ижилхэн шүрэн бугуйвчнууд зүүлтэй байлаа..

ТӨГСӨВ

Хавсралт.

Б.Баасанжаргал : Улиралын онцлох өнгө

Хөх тэнгэрийн, цэлмэг оронд

Хаврын улирал айлчлахад

...Хөлдсөн мөс урсгалаар солигдон цэнхэртэж

...Хөх цэнхэр яргуй нь нүд баясган дэлбээлж

...Хөхрөн униартах уулс цасан хучлагаа гээх

...Хөөрүү хаврын өнгө нь цэнхэр юм болов уу даа

Зүлэг ногоон, уудам оронд

Зуны улирал айлчлахад

...Завшаант улиралын ачаар ногоон хүнсээ зэхэж

...Зугаатай амралтаараа сурагчид өглөөжин ногоорч

...Завгүй ажилчидын амралт нь ногоон гэрлээр олдох

...Зугаатай зуны өнгө нь ногоон юм болов уу даа

Наран шаргалтах, нэртэй оронд

Намрын улирал айлчлахад

...Нүнжиг шар тостой намрын айрагтай найр үргэлжилж

...Нэн шаргуу малчид нь шарлахаас хадлангаа урьтаж

...Нэл алтаар шаргалтах тариан түрүү боловсрох

...Налгар намрын өнгө нь шар юм болов уу даа

Өнөтэй цайрах, цастын оронд

Өвлийн улирал айлчлахад

...Өөдрөг цагаан сэтгэлээр сурагч оюутанууд хичээллэж

...Өнгөтэй цагаан сараа угтан өнө бүгдээр бэлтгэж

...Өдөр мэт цагаан шөнүүд нь сарны цаснаас гэрэлтэх

...Өлчир өвлийн өнгө нь цагаан юм болов уу даа

Улаанбаатар хот. 2008 он.

Эх сурвалж:

Формат, фонт зэргийг бага зэрэг янзалж pdf
хэлбэр уруу хөрвүүлсэн:

www.bairbeh.mn
www.bbaasanjargal.blogspot.com
The Weatherman
<http://weatherman.blog.banjig.net/>